

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР

“Иргэний нисэхийн ерөнхий газар”-ын  
санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн  
шалгалтын материал

Шалгалтанд хамрагдсан хугацаа: 2012-2016 онууд,  
2017 оны эхний 9 сар

Шалгалт эхэлсэн: 2017.11.08  
Шалгалт дууссан: 2017.12.20

Шалгасан: Санхүүгийн хяналт шалгалтын  
улсын ахлах байцаагч:

Мэргэжилтэн

О.Энхжаргал

Н.Батбаатар

Б.Гантулга

Улаанбаатар хот  
2018 он

# МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

## САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР

### ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

#### Нэг. ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО, БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Сангийн Сайдын баталсан удирдамжийн дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын 2012-2016 онууд, 2017 оны эхний 9 сарын үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Иргэний нисэхийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Төрийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, журам, дүрэм, заавар, аргачлалыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байдалд үндсэн баримт, материалд тулгуурлан хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, давтан гаргахгүй байх арга замыг тодорхойлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд чиглэгдлээ.

Шалгалтыг Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Санхүүгийн хяналт шалгалтын хэлтсийн санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч О.Энхжаргал, Н.Батбаатар, мэргэжилтэн Б.Гантулга, Зам, тээврийн хөгжлийн яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Л.Оюунбилэг нар 2017 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн ажлын 30 хоногт хийж гүйцэтгэв.

Энэ удаагийн шалгалтаар Нийслэлийн прокурорын газрын 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 631 дүгээр прокурорын зөвшөөрөлөөр “ИНЕГ-ын албан тушаалтан нь 2011 оны 3 дугаар сараас 2016 оны 3 дугаар сарын хооронд тус газрын Худалдаа хөгжлийн банк дахь валютын 499021602 тоот харилцах данснаас гүйлгээний утга тодорхойгүй 26 удаагийн гүйлгээгээр Испани улсын es-5700491500042710383419 дугаарын данс руу 1,509,583 евро буюу 3,622,000,000 төгрөгийг шилжүүлэн завшиж Улсын онц их хэмжээний хохирол учруулсан гэх гомдол мэдээлэлд

- Испани улсын INDRA компанитай 2010 оноос хойш байгуулсан бараа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ, гэрээний гүйцэтгэл, төлбөрийн даалгавар, төлбөр шилжүүлсэн баримт зэрэг бусад шаардлагатай мэдээлэл агуулсан баримт бичиг, эд зүйл,
- ИНЕГ-аас 2010 оноос хойш иргэн, байгуулага, албан тушаалтанд орон сууцны хөнгөлөлтөнд олгосон урамшуулал, тусламж, бусад зээл, мөнгөн тусламж олгосонтой холбоотой баримт бичгүүдийг

ИНЕГ-аас 2017 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн дотор гаргуулан авах шаардлагатай байх тул энэ талаар гаргасан мөрдөгчийн саналыг хүлээн авах нь зүйтэй” гэсэн тул Худалдаа хөгжлийн банк дахь валютын 499021602 тоот харилцах дансны 2012-2016 он, 2017 оны эхний 9 сарын баримтууд хамрагдаагүй болно.

Иргэний нисэхийн ерөнхий газрын эрхэм зорилго нь Иргэний нисэхийн болон нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалт хийх, нислэгийн хөдөлгөөний удирдлага, холбоо, навигацийн техник тоног төхөөрөмжийн үйлчилгээ, нисэхийн мэдээлэл хангалт, нисэх буудал, газрын тусгай үйлчилгээ үзүүлж, үндэсний эдийн засгийн хувь нэмэр оруулахад оршино гэжээ.

ИНЕГ нь хуулиар олгогдсон эрхийн дагуу, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн хувьд төрөөс Иргэний нисэхийн талаар зайлшгүй хэрэгжүүлэх дараахь чиг үүрэг, үйлчилгээг хэрэгжүүлэн ажилладаг байна. Үүнд:

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр тусгагдсан асуудлыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах
- Иргэний нисэхийн талаарх Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах
- Агаарын хөлөгт нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ үзүүлэх
- Агаарын хөлгийн нислэгт холбоо навигацийн хангалт үйлчилгээ үзүүлэх
- Нисэх буудлын газрын тусгай үйлчилгээ үзүүлэх
- Иргэний нисэхийн салбарт нисэхийн болон нислэгийн аюулгүй байдлыг хангасан үйлчилгээ үзүүлэх
- Мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мэргэжлийн сургалтыг зохион байгуулах
- Төрийн захиргааны төв байгууллагаас шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлэх
- Иргэний агаарын хөлгийг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлийн гэрчилгээ олгох
- Иргэний нисэхэд дагаж мөрдөх стандарт, заавар, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг хангах зэрэг үндсэн үүргүүдийг хэрэгжүүлдэг байна.

ИНЕГазар нь “Иргэний нисэхийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж эрх зүйн орчин бүрдүүлэх, иргэний нисэхийн болон аюулгүй байдлыг хангах” чиглэлтэй “Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар” гэж Улсын бүртгэлийн 2005 оны 10 дугаар сарын 21-ний 000125468 дугаар гэрчилгээнд бүртгэгдсэн бөгөөд Засгийн газрын 2012 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэж тодорхойлогдсон байна.

ИНЕГ-ын санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагааг санхүүгийн “Макс” программаар боловсруулан санхүүгийн тайланг бэлтгэн Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, дагалдан гарсан журам, аргачлалыг баримтлан “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт” /УСНББОУС/-д нийцүүлэн санхүүгийн тайланг гаргасан байна.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР ҮАГГ-ААС ТУС ГАЗРЫН 2012-2016 ОНУУДЫН ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ:

- ИНЕГ-ын 2012.12.31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланд аудит хийж “Зөрчилгүй санал дүгнэлт”-ийг өгсөн бөгөөд нийт 2,015.8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж 1,325.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, Гадаад авиа компани болон дотоодын компаниудтай 7,400.6 сая төгрөгийн авлагын тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаад албан шаардлага өгсөн байна.

- ИНЕГ-ын 2013.12.31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланд аудит хийж “Хязгаарлалттай санал дүгнэлт”-ийг өгсөн бөгөөд нийт 10,967.9 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж 3,509.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, Гадаад авиа компани болон дотоодын компаниудтай 7,400.6 сая төгрөгийн авлагын тооцоо нийлж баталгаажуулаагүй, ЗТЯ-ны 5 ажилтанд томилолтын зардал 39.1 сая төгрөгийг, СЗСЦогцолборын ажилчдад үр дүнгийн шагнал цалин олгохдоо 2013 оны сүүлийн хагас жилээс хойш ажилд орсон ажилтнуудад 18.3 сая төгрөгийг тус тус олгосон зэрэг нийт 7,458.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн байна.

- ИНЕГ-ын 2014.12.31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланд аудит хийж “Хязгаарлалттай санал дүгнэлт”-ийг өгсөн бөгөөд нийт 12,060.6 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж 1,986.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, Засгийн газрын 2007 оны 349 тоот тогтоолыг зөрчин ИНЕГ-ын газар албадын 12 дарга нарын автомашины сэлбэг, шатахуунд 89.6 сая төгрөгийн зөрчилд акт тогтоосныг барагдуулж, 2013-2014 оны дансны авлагын өсөлтийн зөрүү болох 9,895,0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлагыг өгсөн байна.

-Тус газрын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар: 1,041.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, Зам, тээврийн яамны ажилтнуудын гадаад томилолтын зардалд 66.6 сая төгрөгийг олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон ба 2015.12.31-ний өдрөөрхи санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн гээд “Зөрчилгүй санал дүгнэлт” өгсөн байна.

-Тус газрын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар: 12,960.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс 1 жил ажилласан ажилтанд олгосон сургалтын төлбөрийн тэтгэмж, түрээсийн төлбөрийг дутуу зэрэг нийт 7.3 сая төгрөгийн зөрчилд акт тогтоож, 10,348.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 2,604.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж “Хязгаарлалттай санал дүгнэлт” өгчээ. Мөн Монгол улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 101 дүгээр тогтоолоор 2015 оны 1,462.6 сая төгрөгийн ногдол ашгийг

төвлөрүүлээгүй байсанд Үндэсний аудитын газар акт тогтоосоныг 2017 онд барагдуулсан байна.

**ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНААС ХИЙСЭН ШАЛГАЛТ:**

Зам тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 9 дүгээр сард баталсан удирдамжийн дагуу байгуулагдсан ажлын хэсэг Иргэний нисэхийн ерөнхий газар болон Нислэг техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах албаны үйл ажиллагаанд шалгалт хийж Зам тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаар хууль эрх зүй, хүний нөөц, технологи, санхүү, хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд 14 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

**НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭСЭЭС ХИЙСЭН ШАЛГАЛТ:** Нийслэлийн нийгмийн даатгалын хэлтэсээс тус газрын 2013-2014 оны санхүүгийн баримт, нийгмийн даатгалын тайлан, захирлын тушаал, хөдөлмөрийн гэрээ, бусад санхүүгийн баримтад үндэслэн Нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилтийг шалгаж нэр бүхий 8 хүнд 6,092.1 мянган төгрөгийн хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос 1,279.3 мянган төгрөгийн шимтгэл, 639.7 мянган төгрөгийн алдангийг төлүүлэхээр акт тогтоосныг барагдуулсан байна.

**НИЙСЛЭЛИЙН ТАТВАРЫН ГАЗАР БОЛОН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ШАЛГАЛТ:** Нийслэлийн татварын болон Хан-Уул дүүргийн татварын хэлтэсээс ИНЕГазрын 2008-2012 оны албан татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж 21,409,184.7 мянган төгрөгийн зөрчилд 2,105,846.2 мянган төгрөгийн нөхөн татвар, 631,753.9 мянган төгрөгийн торгууль, 683,338.9 мянган төгрөгийн алданги нийт 3,420,939.0 мянган төгрөгийн төлбөр ногдуулсаныг ИНЕГазраас Нийслэл болон Татварын ерөнхий газрын дэргэдэх Татварын маргаан таслах зөвлөлд тус тус гомдол гаргаж Татварын маргаан таслах зөвлөлийн актаар тогтоосон төлбөрийг 1,036,485.6 мянган төгрөгөөр багасгаж 14,797,822.0 мянган төгрөгийн зөрчилд ногдуулсан 2,384,453.4 мянган төгрөгийн төлбөрийг төлүүлэхээр шийдвэрлэсэн байна. ИНЕГазарт дээрхи төлбөрийг эс зөвшөөрч шүүхэд хандсан байна. Монгол улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2015 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 80 дугаар тогтоолоор Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн 2014 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 465 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2015 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 75 дугаар магадлалыг тус тус хэвээр үлдээж 1.4 тэрбум төгрөгийг хүмүүсээс суутган авч улсын төсөвт төвлөрүүлэхээр шийдвэрлэснийг байгууллагаас барагдуулсан байна.

**Гурав. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ, ОРЛОГО, ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ,  
ҮР ДҮНГИЙН ТАЛААР:**

Тус газар нь арилжааны банкуудад байршуулсан 21 данс, төрийн сангийн 7 дансаар дамжуулан мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээг хийж ирсэн байна. Арилжааны болон төрийн сангийн банкинд байршуулсан данснуудын оны эцсийн үлдэгдлийг

хүснэгтээр харуулбал: 2017 оны эцсээр мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 59,957.0 сая төгрөг байна.

/сая төгрөгөөр/

д/д	Банкнүүдын нэрс	Дансны дугаар	Мөнгөн ий төрөл	Харьяалаг дах газар	Гүйлгээний утга	2012 он		2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он		
						Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		
1	Төрийн сан	900028020	Төгрөг	ИНЕГазар /Агентлаг	Урсгал үйл ажиллагаа	0,0	0,0	0,0	0,0	0,0	0,0	0,0		
	Төрийн сан	900096222	Төгрөг		Барьцаа хөрөнгийн данс	1,521.1	842.0	Хаагдаад 900028413 данс болов						
	Төрийн сан	900028413						1,967.5	1,911.3	1,560.6	1,338.3			
	Төрийн сан	100900028305	Төгрөг		Хөрөнгө оруулалт	429.5	49.6	0,0	0,0	0,0	0,0	0,0	0,0	
	Төрийн сан	100900028371	Төгрөг		Захиалагчийн хяналт								255.0	
	Төрийн сан	900028405	Төгрөг		Техник хяналт	91.6	114.8	0,0	0,0	0,0	0,0	0,0	0,0	
	Төрийн сан	100900028351	Төгрөг		Барьцаа								1,113.0	
2	ХХБанк	499021602	Доллар	Үйлдвэрлэлийн алба	ИНЕГ үүсгэн байгуулах үед нээгдсэн	1,802.3	609.8	1,669.8	7,863.9	5,454.0	3,660.7	5,459.9		
		499133504	Төгрөг			77.2	58.9	108.9	5,338.1	64.5	14.3	588.5		
3	Голомт банк	2001006626	Доллар					1,444.0	1,081.3	9,375.1	2,765.4	4,609.4	1,196.6	
		2001002396	Төгрөг			10.5	654.9	4,199.0	1,477.0	184.5	1.4	8,336.6		
4	Төрийн банк	106700147187	Доллар			2013 онд нээгдсэн			58.6	67.2	1,376.2	5,132.2	264.1	
		106000035721	Доллар									3,609.8	1,134.0	
		106700147179	Төгрөг						3,375.8	1,510.9	0.3	13.7	0.5	
		109000072141	Төгрөг									46.9	3.2	
		1060000035700	Төгрөг											
		1060000035713	Төгрөг											
5	Улаанбаатар банк	2603031646	Доллар			Уг дансыг ашигладаггүй, үлдэгдэлгүй боловч хаагдаагүй данс	2015.03.17-нд нээсэн				3,477.2	14,344.8	6,696.9	
		2603031645	Төгрөг						8,116.1	0.9	8,147.4			
6	ХААН банк	5038023734	Төгрөг	2010 онд нээсэн	70.8		188.9	0.3	0.3	0.3	0.3	0.4		
7	Капитрон банк	3008015332	Төгрөг	2017.06.09 өдөр нээгдсэн								13,231.7		
		3008015333	Доллар									0.1		
8	Капитал банк	2000022230	Төгрөг	төгрөг			171.4	Хаагдсан						
		2000022600	Доллар	доллар			11.3	Хаагдсан						
9	Богд банк	8001006669	Доллар	2016.12.21-нд нээгдсэн								8,055.0		
		8001006651	Төгрөг									7,325.0		
10	Чингис хаан банк	5101000081	Доллар	2016.12.28-нд нээгдсэн								0.0		
		5101000080	Төгрөг								1,246.2	6,163.7		
11	Бэлэн мөнгө		Төгрөг		7.5	1.1	1.0	4.2	19.0	0.2	24.7			
			Доллар		3.4	0.8	0.8	0.06	0.6	0.6	15.9			
Дүн						4,013.7	4,147.6	12,463.0	27,548.1	23,018.8	42,074.9	59,957.0		

Нийт арилжааны болон төрийн сангийн банкны 28 дансуудад доорхи дарга, нягтлан бодогч нар нэг, хоёрдугаар гарын үсгийг зурж хөрөнгө, мөнгийг захиран зарцуулж иржээ.

д/д	Нэгдүгээр гарын үсгийг				Хоёрдугаар гарын үсгийг			
	Хугацаа	Томилсон шийдвэр	Овог нэр	Албан тушаал	Хугацаа	Томилсон шийдвэр	Овог нэр	Албан тушаал

1	2010.03.31-2012.12.08	МУ-ын ЗГ-ын 163-р тогтоол	С.Батмөнх	ИНЕГ-ын дарга				
2	2012.12.08-2013.03.16	МУ-ын ЗГ-ын 164-р тогтоол	С.Буяндалай	ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	2012.01.01-2013.07.25	ИНЕГ-ын даргын 2013.07.25-ны Б/88 тушаал	Д.Алтанцэцэг	Ерөнхий нягтлан бодогч
	2013.03.16-2014.02.21	МУ-ын ЗГ-ын 101-р тогтоол		ИНЕГ-ын дарга				
3	2014.02.22-2015.04.13	МУ-ын ЗГ-ын 57-р тогтоол	Т.Лхагвасүрэн	ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	2013.07.25-2015.04.16	ИНЕГ-ын даргын 2013.07.25-ны Б/89 тушаал	М.Энхмаа	Ерөнхий нягтлан бодогч /3 сар туршилт/
4	2015.04.14-2015.09.14	МУ-ын ЗГ-ын 139-р тогтоол	Ц.Эрдэнэбилэг	ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч		ИНЕГ-ын даргын 2013.10.24-ний Б/121 тушаал		Ерөнхий нягтлан бодогч
5	2015.09.14-2016.08.31	МУ-ын ЗГ-ын 374-р тогтоол	Г.Нямдаваа	ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	2015.04.16-одоог хүртэл	ИНЕГ-ын даргын 2015.04.16-ний Б/67 тушаал	Н.Наранцэцэг	Ерөнхий нягтлан бодогч
6	2016.08.31-2016.11.02	МУ-ын ЗГ-ын 77-р тогтоол	Л.Бямбасүрэн	ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч				
	2016.11.02-одоог хүртэл	МУ-ын ЗГ-ын 134-р тогтоол		ИНЕГ-ын дарга				

Иргэний нисэхийн ерөнхий газар нь 2016 онд 282.2 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөөс 187.2 тэрбум төгрөг /хуримтлагдсан элэгдэл хасагдсан дүн/-ийн үндсэн хөрөнгө, 95.0 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй байна. Эргэлтийн хөрөнгөөс 59.9 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө, 44.1 тэрбум төгрөгийн тооцооны хөрөнгө /авлага/, 5.6 тэрбум төгрөгийн бараа, материалын үлдэгдэлтэй бүртгэгджээ.

Нийт активын 66.3 хувь нь эргэлтийн бус хөрөнгө /үндсэн хөрөнгө/, 33.7 хувь нь эргэлтийн хөрөнгө байна. Нийт эргэлтийн хөрөнгийн 46.5 хувийг авлага эзэлж байна. Нийт пассивын 3.8 хувь нь өр төлбөр байх ба өр төлбөрийн 77.7 хувь нь богино хугацаат өр төлбөр байна.

ИНЕГ-ын жилийн төлөвлөгөөг Зам, тээврийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2012 оны 12/13, тодотгосон 89/352 тоот тушаалуудаар "ИНЕГ-ын үйлчилгээний албадын 2012 оны орлого зардлын төсөв"-ийн орлогыг 106,536.5сая төгрөгөөр, нийт зарлагын дүнг 78,090.0 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлого 45,246.5 сая төгрөг, 2013 оны 32/93, тодотгосон 246/258 тоот тушаалуудаар "ИНЕГ-ын үйлчилгээний албадын 2013 оны орлого зардлын төсөв"-ийн орлогыг 120,467.2 сая төгрөгөөр, нийт зарлагын дүнг 68,150.3 сая төгрөгөөр, 2014 оны 50/51 тоот тушаалаар "ИНЕГ-ын харьяа үйлдвэрлэл, үйлчилгээний албадын 2014 оны төсвийн орлого зардлын төлөвлөгөөний"-ийн орлогыг 137,398.5 сая төгрөгөөр, нийт зарлагын дүнг 69,479.5 сая төгрөгөөр, 2015 оны 87/64 тоот тушаалаар "ИНЕГ-ын харьяа үйлдвэрлэл, үйлчилгээний албадын 2015 оны төсвийн орлого зардлын төлөвлөгөөний"-ийн орлогыг 174,304.8 саятөгрөгөөр, нийт зарлагын дүнг элэгдлийг хасан 75,826.4сая төгрөгөөр, 2016 оны 121/181, тодотгосон 141/223 тоот тушаалуудаар "ИНЕГ-ын харьяа үйлдвэрлэл, үйлчилгээний албадын 2016 оны төсвийн орлого зардлын төлөвлөгөө"-ний орлогыг 189,059.8 сая төгрөгөөр, нийт зарлагын дүнг 85,972.7 сая төгрөгөөр, 2017 оны 43/75 тоот тушаалаар "ИНЕГ-ын харьяа үйлдвэрлэл, үйлчилгээний албадын 2017 оны төсвийн орлого зардлын төлөвлөгөөний"-ийн орлогыг 258,119.1сая төгрөгөөр, зарлагын дүнг 113,198.2 сая төгрөгөөр тус тус баталсан байна. Агентлагийн



2012, 2013 онуудын төсөв гүйцэтгэл нэгдсэн тайланд тусгаж нэгтгэдэггүй байсныг 2014 оноос нэгдсэн тайланд тусган тайлагнадаг болсон байна.

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн 1256-MON/SF/, 1370-MON/SF/ тоот төслүүдийн зээлийн эргэн төлөлт болох 2012 онд 6,635.7 сая төгрөг, 2013 онд 6,522.5 сая төгрөг, 2014 онд 5,183.9 сая төгрөг, 2015 онд 2,870.8 сая төгрөгийг төсөвт төлөх навигацгийн орлогоос тооцсоноор татварын өмнөх цэвэр ашгийг нэмэгдүүлсэн байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2012–2016 онууд, 2017 оны 3 дугаар улирлын байдлаарх эдийн засгийн үзүүлэлтүүд, үр ашиг, ногдол ашгийн төлөлтийг доорхи хүснэгтүүдээр харуулбал:

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2012 он			2013 он			2014 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /хэтрэлт, хэмнэлт/
	<b>Нийт зарлагын дүн</b>	<b>78,090.0</b>	<b>74,985.0</b>	<b>(3,105.0)</b>	<b>84,300.3</b>	<b>82,315.0</b>	<b>(1,985.3)</b>	<b>84,955.3</b>	<b>81,365.0</b>	<b>(3,590.3)</b>
	Мөнгөн зардал	62,452.0	59,750.7	(2,701.3)	68,150.3	66,893.2	(1,257.1)	69,479.5	66,304.0	(3,175.6)
	Мөнгөн бус зардал	15,638.0	15,234.3	(403.7)	16,150.0	15,421.8	(728.2)	15,475.8	15,061.0	(414.8)
	<b>Нийт орлого</b>	<b>106,536.5</b>	<b>123,592.0</b>	<b>17,055.5</b>	<b>120,467.2</b>	<b>151,979.8</b>	<b>31,512.6</b>	<b>137,398.5</b>	<b>178,761.1</b>	<b>41,362.6</b>
	Өнгөрөлтийн нислэгийн орлого	83,500.0	97,007.2	13,507.2	93,834.5	116,942.7	23,108.2	108,003.7	145,579.5	37,575.8
	Буулт, хөөрөлтийн нислэгийн орхлого	5,695.6	6,945.7	1,250.0	6,896.4	7,958.8	1,062.4	7,457.8	8,563.5	1,105.7
	Зорчигч үйлчилгээний орлого	6,540.8	7,648.6	1,107.8	7,840.8	9,348.8	1,508.0	8,614.1	9,016.7	402.6
	Бусад орлого	10,800.0	11,990.5	1,190.5	11,895.4	17,729.5	5,834.1	13,323.0	15,601.4	2,278.4
	Санхүүжилтийн зардал								28,551.3	
	Үндсэн хөрөнгө борлуулсны гарз									
	Санхүүжилтийн орлого								32,195.1	
	Үндсэн хөрөнгө борлуулсны олз									
	Агентлагийн зардал							3,707.6	3,643.8	
	Улсын төсөвт төвлөрүүлсэн навигацгийн орлого	45,246.5	38,610.8	(6,635.7)	58,246.8	56,783.8	(1,463.0)	67,919	68,016	97.1
	АХБ-ын зээл, зээлийн хүүгийн төлөлт		6,635.7	6,635.7		6,522.5	6,522.5		5183.9	5,183.9
	Татвар төлөхийн өмнөх ашиг		9,995.3			12,880.9			29,380.0	
	Орлогын татварын зардал		2,644.4			4,525.8			8,710.1	
	Татварын дараах цэвэр ашиг		7,351.8			8,355.1			20,669.9	
	Ногдол ашиг		2,573.2			1,410.7			1,735.1	

ИНЕГазар системийн хэмжээгээр 2012 онд 123,592.0 сая төгрөгийн орлоготой, 74,985.0 сая төгрөгийн зардалтай, 7,351.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж улсад 45,246.5 сая төгрөгийн навигацгийн орлогыг, 2013 онд 151,979.8 сая төгрөгийн орлоготой, 82,315.0 сая төгрөгийн зардалтай, 8,355.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж улсад 63,306.3 сая төгрөгийн навигацгийн орлогыг, 2014 онд 178,761.1 сая төгрөгийн орлоготой, 81,365.0 сая төгрөгийн зардалтай, 20,670.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж улсад 73,200.0 сая төгрөгийн навигацгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн байна.

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2015 он			2016 он			2017.09.30		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /хэтрэлт, хэмнэлт/
	Нийт зарлагын дүн	75,826.4	91,816.2	15,989.8	85,972.7	101,322.1	15,349.3	65,836.1	77,825.7	11,989.6
	Мөнгөн зардал	75,826.4	75,725.2	(101.2)	85,972.7	85,405.4	(567.3)	65,836.1	65,824.5	(11.6)
	Мөнгөн бус зардал	-	16,091.0	16,091.0	-	15,916.7	15,916.7	-	12,001.2	12,001.2
	Нийт орлого	174,304.8	195,544.3	22,239.5	189,059.8	235,248.3	46,188.4	194,054.0	210,852.1	16,798.2
	Өнгөрөлтийн нислэгийн орлого	143,598.8	164,286.5	20,687.7	161,619.7	192,541.1	30,921.4	173,312.8	181,713.9	8,401.1
	Буулт, хөөрөлтийн нислэгийн орлого	8,365.0	8,507.0	142.0	8,978.9	11,044.5	2,065.6	6,362.5	9,109.6	2,747.1
	Зорчигч үйлчилгээний орлого	8,120.8	8,869.8	749.0	8,803.9	9,324.1	520.2	7,004.2	8,613.9	1,609.8
	Бусад орлого	14,220.1	14,881.0	660.9	9,657.4	22,338.5	12,681.1	7,374.5	11,414.8	4,040.3
	Санхүүжилтийн зардал		14,059.6			15,007.6			11,324.5	
	Үндсэн хөрөнгө борлуулсны гарз					3,522.6			1,074.5	
	Санхүүжилтийн орлого		17,498.7			23,414.8			16,417.8	
	Үндсэн хөрөнгө борлуулсны олз					37.2			1,074.5	
	Агентлагийн зардал	3,500.2	3,439.0	(61.2)	3,065.6	3,065.6	0.0	2,412.3	2,358.8	(53.5)
	Улсын төсөвт төвлөрүүлсэн навигацгийн АХБ-ын зээл, зээлийн хүүгийн төлөлт	98,478.4	95,629.2	(2,849.2)	103,087.1	115,844.4	12,757.3	108,133.7	102,773.4	(5,360.3)
	Татвар төлөхийн өмнөх ашиг		9,098.9			19,938.0				
	Орлогын татварын зардал		4,223.5			6,608.1				
	Татварын дараах цэвэр ашиг		4,875.4			13,329.9				
	Ногдол ашиг		1,462.6			3,999.0				

ИНЕГазар системийн хэмжээгээр 2015 онд 195,544.3 сая төгрөгийн орлоготой, 91,816.2 сая төгрөгийн зардалтай, 4,875.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж улсад 98,500.0 сая төгрөгийн навигацгийн орлогыг, 2016 онд 235,248.3 сая төгрөгийн орлоготой, 101,322.1 сая төгрөгийн зардалтай, 13,329.9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж улсад 115,844.4 сая төгрөгийн навигацгийн орлогыг, 2017 оны эхний 9 сарын байдлаар 210,852.1 сая төгрөгийн орлоготой, 77,852.7 сая төгрөгийн зардалтай, улсад 102,773.4 сая төгрөгийн навигацгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн байна.

Төрийн өмчийн хорооны доорхи тогтоолуудаар ногдол ашгийг тооцон төлсөн байна. Ногдол ашгийн төлөлтийг хүснэгтээр харуулбал:

д/д	ТӨХ-ны тогтоолын огноо, дугаар	Цэвэр ашиг /мян.төг/	Ногдол ашиг тооцох хувь	Тооцсон ногдол ашиг /мян.төг/	Шилжүүлсэн огноо	Шилжүүлсэн мөнгөн дүн /сая.төг/
1	ТӨХ-ны 2013.06.19-ний өдрийн №402 тогтоол	2012 оны-7,351,834.26	35	2,573,141.9	2013.06.28	2,573.2
2	ТӨХ-ны 2014.05.01-ний өдрийн №232 тогтоол	2013 оны-9,404,700.0	15	1,410,710.0	2014.06.16	1,410.7
3	ТӨХ-ны 2015.09.10-ний өдрийн №572 тогтоол	2014 оны-20,670,100.0		1,735,050.0	2015.09.10	1,735.1
4	ТӨХ-ны 2016.10.20-ний өдрийн №101 тогтоол	2015 оны-4,875,349.5	30	1,462,604.9	2017.12.30	1,462.6
5	ТӨХ-ны 2017.04.18-ний өдрийн №117 тогтоол	2016 он-13,329,966.0	30	3,998,989.8	2017.06.19	3,998.9

Монгол улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 101 дүгээр тогтоолоор 2015 оны 1,462.6 сая төгрөгийн ногдол ашгийг төвлөрүүлээгүй байсанд Үндэсний аудитын газар акт тогтоосоньг 2017 онд барагдуулсан байна.

ИНЕГ-ын 2012-2014 онуудын үйлдвэрлэл үйлчилгээний орлогын гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2012 он			2013 он			2014 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт

1	Агаарын навигацийн үйлчилгээний орлого /өнгөрөлтийн орлого/	83,500.0	97,007.2	13,507.2	93,834.5	116,942.7	23,108.2	108,003.7	145,579.5	37,575.8
2	Хэвлэх цехийн орлого	25.0	23.5	(1.5)	20.0	25.2	5.2	40.0	32.7	(7.3)
3	Сургалтын төв орлого	15.0	19.5	4.5	15.0	22.8	7.8	40.0	25.5	(14.5)
4	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны/о	80.0	87.1	7.1	-	98.5	98.5	90.6	93.9	3.3
5	Холбоо навигаци бодит ажиглалтын үйлчилгээний албаны/о	221.0	262.0	41.0	221.0	216.9	(4.1)	200.0	201.9	1.9
6	Нислэгийн мэдээлэл хангалтын албаны/ор	9.0	12.0	3.0	10.0	23.5	13.5	23.0	3.5	(19.5)
7	Оношилгоо, хэмжил зүйн лабораторийн/ор	30.0	33.5	3.5	30.0	38.2	8.2	38.0	37.4	(0.6)
8	Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт зохицуулалтын алба/ор	200.0	221.8	21.8	200.0	212.8	12.8	-	-	-
9	Валютын ханшийн орлого /бодит/	2,805.5	759.9	(210.8)	673.3	4,045.4	7,321.1	3,420.9	1,951.6	2,928.7
10	Валютын ханшийн орлого /бодит бус/		1,518.9			2,745.6			3,516.0	
11	Хүүгийн орлого		83.7			442.9			592.7	
12	Бусад орлого		232.3			760.5			289.4	
13	Борлуулалтын хорогдол ба буцаалт		(188.5)	(188.5)	-	(196.1)	(196.1)	-	(426.1)	(426.1)
ДҮН		86,885.5	100,072.9	13,187.4	95,003.9	125,378.9	30,375.0	111,856.2	151,897.9	40,041.7

**"Чингис хаан" Олон улсын нисэх буудал**

1	Буулт хөөрөлтийн орлого /дотоод/	5,567.8	507.62	1,224.1	452.6	493.8	41.2	505.0	362.7	(142.3)
	Буулт хөөрөлтийн орлого /гадаад/		6,284.27						6,288.3	7,323.2
2	Зорчигч таксийн хураамж /дотоод/	6,433.1	832.03	1,096.6	664.1	788.4	124.3	896.1	602.9	(293.2)
	Зорчигч таксийн хураамж /гадаад/		6,697.74						7,057.0	8,442.7
3	Гадаад ВИП, Бизнес танхимын хураамж	531.7	684.01	152.3	594.3	744.6	150.4	788.7	864.5	75.8
4	Хүзүүвчний орлого	582.0	753.78	171.8	618.5	837.6	219.1	732.9	944.2	211.2
5	Гаалийн баталгаат агуулах, ачаа тээш хадгаламжийн орлого	820.0	1,014.32	194.3	804.3	963.5	159.2	977.1	1,067.6	90.5
6	Бүртгэх цэгийн түрээсийн орлого	731.0	623.79	(107.2)	912.7	555.1	(357.6)	631.9	462.6	(169.3)
7	Зорчигч хамгаалагч	40.0	47.06	7.1	39.5	50.7	11.2	47.7	63.8	16.1
8	Онгоц зогсолтын/ор	75.0	72.70	(2.3)	106.6	139.7	33.1	73.6	137.8	64.2
9	Ачаа шуудан хамгаалалтын орлого	65.0	64.40	(0.6)	60.7	76.4	15.6	65.2	95.7	30.4
10	Онгоц хамгаалалт/ор	6.0	3.23	(2.8)						
11	Үнэмлэх борлуулсны орлого	60.0	55.33	(4.7)	53.4	50.0	(3.4)	57.8	66.2	8.4
12	Бусад орлого	80.6	89.79	9.2	40.9	113.9	73.0	55.5	105.4	49.9
13	Борлуулалтын хорогдол ба буцаалт		(65.81)	(65.8)		(32.0)	(32.0)	-	-	-
Үйл ажиллагааны орлого		14,992.2	17,664.3	2,672.1	17,692.9	20,547.7	2,854.8	19,193.5	21,096.1	1,902.6
14	Байрны түрээс	585.6	569.0	(16.6)	483.7	550.8	67.1	523.4	750.2	226.8
15	Валютын ханшийн орлого /бодит/	35.0	15.6	(19.4)	16.4	0.0	(16.3)	28.4	3.1	(25.4)
16	Валютын ханшийн орлого /бодит бус/		12.0	12.0		2.8	2.8		17.5	17.5
17	Худалдаа	23.0	20.2	(2.8)	10.6	23.5	12.9	35.0	68.2	33.2
18	Мэдээлэл үйлчилгээний орлого	1.0	1.8	0.8	1.8	0.7	(1.1)	1.8	1.7	(0.2)
19	Машины хураамж	12.0	3.5	(8.5)	29.1	204.0	175.0	210.1	197.0	(13.1)
20	Самбарын түрээс/ор	100.0	168.8	68.8	147.6	206.7	59.1	171.0	221.8	50.8
21	Буянт-Ухаа рестораны орлого	655.1	781.9	126.8	1,007.8	719.1	(288.8)	-	703.9	703.9
22	Хүү, торгуулийн орлого	15.0	18.9	3.9	1.3	55.3	54.0	5.8	14.4	8.7
23	Бусад орлого	67.0	42.5	(24.5)	3.5	3.8	0.3	5.8	6.8	1.1
Үйл ажиллагааны бус/ор		1,493.7	1,634.1	140.4	1,701.9	1,766.7	64.9	981.2	1,984.5	1,003.3
ДҮН		16,485.9	19,298.3	2,812.5	19,394.8	22,314.4	2,919.6	20,174.7	23,080.6	2,905.9

**Газрын тусгай үйлчилгээний алба**

1	Онгоц Үйлчилгээ/орло	1,514.6	2,240.7	726.1	2,713.3	1,860.6	(852.7)	2,038.7	1,646.5	(392.2)
2	Шатахуун тээвэр/ор	845.4	803.4	(42.0)	875.0	763.0	(112.0)	885.5	420.2	(465.3)

3	Нийтийн тээвэр/ор	10.0	5.8	(4.2)	15.0	53.0	38.0	24.0	91.0	67.0
4	Тээврийн бус орлого	30.0	38.6	8.6	25.7	17.8	(7.9)	10.0	9.1	(0.9)
5	Борлуулалтын хорогдол ба буцаалт	-	(0.176)	(0.176)			-	-	(5.6)	(5.6)
	<b>ДҮН</b>	<b>2,400.0</b>	<b>3,088.3</b>	<b>688.3</b>	<b>3,629.0</b>	<b>2,694.4</b>	<b>(934.7)</b>	<b>2,958.2</b>	<b>2,161.2</b>	<b>(797.0)</b>
<b>Сэргээн засах амралт</b>										
1	Рестораны орлого	165.0	241.8	76.8	170.0	262.4	92.4	257.5	278.7	21.1
2	Зочид буудлын орлого	80.0	88.8	8.8	82.0	176.1	94.1	179.6	184.7	5.0
3	Буфетын орлого	40.0	48.3	8.3	41.0	41.5	0.5	65.7	44.0	(21.8)
4	Биллярдын орлого	5.0	11.9	6.9	5.0	11.6	6.6	11.5	14.7	3.1
5	Эмчилгээний орлого	100.0	138.1	38.1	1,582.9	396.6	(1,186.2)	777.6	297.9	(479.7)
6	Бусад орлого	5.0	5.5	0.5		13.6	13.6	450.7	2.7	(448.0)
	<b>ДҮН</b>	<b>395.0</b>	<b>534.3</b>	<b>139.3</b>	<b>1,880.9</b>	<b>901.9</b>	<b>(978.9)</b>	<b>1,742.7</b>	<b>822.6</b>	<b>(920.1)</b>
<b>Орон нутгийн нисэх буудлууд</b>										
1	Буулт, хөөрөлтийн нислэгийн орлого	127.9	153.76	25.9	155.5	141.7	(13.7)	165.6	155.9	(9.7)
2	Зорчигч үйлчилгээ/ор	107.7	118.81	11.1	119.7	117.7	(2.0)	143.2	136.0	(7.2)
3	Газрын техник үйлчилгээний орлого	47.7	127.84	80.1	283.4	219.4	(64.0)	358.0	250.0	271.2
4	Бүртгэх цэгийн орлого	-	1.98	2.0		4.1	4.1		39.1	
5	Вип-ийн хураамж/ор	-	0.02	0.0					-	
6	Шатахуун тээвэрлэлт/о	33.9	147.83	114.0		16.4	16.4		-	
7	Зогсолтын орлого	-	0.03	0.0		0.0	0.0		1.9	
8	Хүүгийн орлого	-	0.55	0.6		2.3	2.3		9.4	
9	Бусад орлого	53.0	47.43	(5.6)		188.5	188.5		328.8	
10	Борлуулалтын хорогдол ба буцаалт	-	(0.083)	(0.1)			-	-	(122.2)	(122.2)
	<b>ДҮН</b>	<b>370.1</b>	<b>598.2</b>	<b>228.1</b>	<b>558.6</b>	<b>690.2</b>	<b>131.5</b>	<b>666.8</b>	<b>798.9</b>	<b>132.0</b>
	<b>НИЙТ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>106,536.5</b>	<b>123,592.0</b>	<b>17,055.5</b>	<b>120,467.2</b>	<b>151,979.8</b>	<b>31,512.6</b>	<b>137,398.6</b>	<b>178,761.1</b>	<b>41,362.5</b>

ИНЕГазар системийн дүнгээр 2012 онд 123,592.0 сая төгрөгийн орлого олж төлөвлөгөөнөөс 16.1 хувь буюу 17,055.5 сая төгрөгөөр давж биелжээ. Орлогыг бүтцээр нь авч үзвэл:

- Өнгөрөлтийн нислэгийн орлого 16.2 хувь буюу 13,507.2 сая төгрөг
- Буулт, хөөрөлтийн нислэгийн орлого 21.9 хувь буюу 1,250.0 сая төгрөг
- Зорчигч үйлчилгээний орлого 16.9 хувь буюу 1,107.8 сая төгрөг
- Бусад орлого 11.0 хувь буюу 1,190.5 сая төгрөгөөр тус тус давж биелжээ.

Нийт орлогын 78.5 хувийг өнгөрөлтийн нислэгийн орлого, 5.6 хувийг буулт, хөөрөлтийн нислэгийн орлого, 6.2 хувийг зорчигч үйлчилгээний орлого, 9.7 хувийг бусад орлого эзэлж байна.

2013 онд 151,979.8 сая төгрөгийн орлого олж төлөвлөгөөнөөс 26.1 хувь буюу 31,512.8 сая төгрөгөөр давж биелжээ. Орлогыг бүтцээр нь авч үзвэл:

- Өнгөрөлтийн нислэгийн орлого 24.6 хувь буюу 23,108.2 сая төгрөг
- Хөөрөлт буултын нислэгийн орлого 15.4 хувь буюу 1,062.4 сая төгрөг
- Зорчигч үйлчилгээний орлого 19.2 хувь буюу 1,508.0 сая төгрөг
- Бусад орлого 49.0 хувь буюу 5,834.1 сая төгрөгөөр тус тус давж биелжээ.

Нийт орлогын 76.9 хувийг өнгөрөлтийн нислэгийн орлого, 5.2 хувийг буулт, хөөрөлтийн нислэгийн орлого, 6.2 хувийг зорчигч үйлчилгээний орлого, 11.7 хувийг бусад орлого эзэлж байна. 2013 оны орлогыг өмнөх оны орлоготой харьцуулбал 22.9 хувь буюу 28,387.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь валютын ханшийн өөрчлөлт болон нислэгийн тоо нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Тус газар 2014 онд 178,761.1 сая төгрөгийн орлого олж төлөвлөгөөнөөс 30.1 хувь буюу 41,362.6 сая төгрөгөөр давж биелжээ. Орлогыг бүтцээр нь авч үзвэл:

- Өнгөрөлтийн нислэгийн орлого 34.8 хувь буюу 37,575.8 сая төгрөг
- Хөөрөлт буултын нислэгийн орлого 14.8 хувь буюу 1,105.7 сая төгрөг
- Зорчигч үйлчилгээний орлого 4.7 хувь буюу 402.6 сая төгрөг
- Бусад орлого 17.1 хувь буюу 2,278.4 сая төгрөгөөр тус тус давж биелжээ.

Нийт орлогын 81.4 хувийг өнгөрөлтийн нислэгийн орлого, 4.8 хувийг буулт, хөөрөлтийн нислэгийн орлого, 5.1 хувийг зорчигч үйлчилгээний орлого, 8.7 хувийг бусад орлого эзэлж байна. 2014 оны орлогыг өмнөх оны орлоготой харьцуулбал 17.6 хувь буюу 26,781.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

ИНЕГ-ын 2015-2016 онууд, 2017 оны 3 дугаар улирлын үйлдвэрлэл үйлчилгээний орлогын гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2015 он			2016 он			2017.09.30		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Агаарын навигацийн үйлчилгээний орлого /өнгөрөлтийн орлого/	143,598.8	164,286.4	20,687.6	161,619.7	192,541.1	30,921.4	173,312.8	181,713.9	8,401.1
2	Хэвлэх цех							22.5	66.7	44.2
3	Буулт, хөөрөлтийн навигацийн орлого	-	-	-	600.0	985.1	385.1	-	-	-
4	Сургалтын төворлого	25.0	26.9	1.9	30.0	31.5	1.5	22.5	32.6	10.1
5	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба/ор	90.0	90.0	-	90.0	78.0	(12.0)	67.5	47.0	(20.5)
6	Холбоо навигаци бодит ажиглалтын үйлчилгээний алба/ор	205.0	233.2	28.2	220.0	231.7	11.7	165.0	212.5	47.5
7	Нислэгийн мэдээлэл хангалтын алба/орлого	-	7.9	7.9	-	8.6	8.6	-	20.0	20.0
8	Оношилгоо, хэмжил зүйн лаборатор орлого	40.0	25.8	(14.2)	25.0	29.6	4.6	22.5	21.2	(1.3)
9	Валютын ханшийн орлого /бодит		940.0		-	4,184.4	4,184.4		766.1	
10	Валютын ханшийн орлого /бодит бус	4,643.9	3,666.6	1,028.9		6,603.6	6,603.6	1,162.9	1,510.4	1,994.6
11	Хүүгийн орлого		772.5		-	555.5	555.5		761.3	
12	Бусад орлого		293.7		928.5	917.3	(11.2)		119.8	
13	Борлуулалтын хорогдол ба буцаалт	-	(242.1)	(242.1)	-	(156.2)	(156.2)	-	(60.9)	(60.9)
	<b>ДҮН</b>	<b>148,602.7</b>	<b>170,100.8</b>	<b>21,498.1</b>	<b>163,513.2</b>	<b>206,014.4</b>	<b>42,501.3</b>	<b>174,775.7</b>	<b>185,210.6</b>	<b>10,434.8</b>

"Чингис хаан" Олон улсын нисэх буудал

1	Буулт хөөрөлтийн орлого /дотоод/	264.4	268.1	3.7	80.5	361.4	280.9	218.1	357.1	139.1
	Буулт хөөрөлтийн орлого /гадаад/	7,928.3	8,154.1	225.8	8,220.4	9,609.3	1,388.9	6,031.1	8,677.1	2,646.0
2	Зорчигч таксийн хураамж /дотоод/	650.0	433.1	(216.9)	550.0	553.1	3.1	391.9	575.3	183.4
	Зорчигч таксийн хураамж /гадаад/	7,316.0	8,373.3	1,057.3	8,173.9	8,719.7	545.8	6,527.1	7,990.2	1,463.0
3	Гадаад ВИП, Бизнес танхимын хураамж	730.0	897.2	167.2	910.0	873.2	(36.8)	539.0	1,530.3	991.3
4	Хүзүүвчний орлого	810.6	891.9	81.3	784.0	966.0	182.0	705.3	869.2	164.0
5	Гаалийн баталгаат агуулах, ачаа тээш хадгаламжийн орлого	950.0	918.7	(31.3)	850.0	1,004.4	154.4	635.0	897.2	262.2
6	Бүртгэх цэгийн түрээс/ор	550.5	394.8	(155.7)	500.0	428.5	(71.5)	310.0	566.2	256.2
7	Зорчигч хамгаалагч	50.0	68.8	18.8	60.0	73.1	13.1	41.5	66.1	24.6
8	Онгоц зогсолторлого	130.0	159.1	29.1	50.0	462.4	412.4	123.0	309.2	186.2
9	Ачаа шуудан хамгаалалтын орлого	75.0	103.3	28.3	90.0	109.6	19.6	52.0	99.3	47.3
10	АҮШ-ийн үйлчилгээний орлого АБХА				-	24.3	24.3	-	-	-
11	Зорчигчтой сумалгааны хамгаалалт ГУАХА				-	8.0	8.0	-	-	-
12	Аэродром бохирдуулсны орлого				-	13.9	13.9	-	-	-
13	Үнэмлэх борлуулсон ор	50.0	55.6	5.6	50.0	53.3	3.3	45.0	53.8	8.8

14	Бусад орлого	79.6	71.4	(8.2)	283.0	4.2	(278.8)	7.2	28.5	21.3
15	Борлуулалтын хорогдол ба буцаалт	-	(41.0)	(41.0)	-	(160.5)	(160.5)	-	(1,158.0)	(1,158.0)
<b>Үйл ажиллагааны орлого</b>		<b>19,584.4</b>	<b>20,748.3</b>	<b>1,163.9</b>	<b>20,601.7</b>	<b>23,103.8</b>	<b>2,502.0</b>	<b>15,626.2</b>	<b>20,861.5</b>	<b>5,235.3</b>
13	Байрны түрээс	900.0	847.3	(52.7)	700.0	810.3	110.3	596.0	630.7	34.7
14	Валютын ханшийн орлого /бодит	2.0	1.8	(0.2)	5.0	94.6	89.6	74.7	6.2	(68.5)
15	Валютын ханшийн орлого /бодит бус		12.3	12.3		462.5	462.5		186.4	186.4
16	Худалдаа	50.0	51.3	1.3	50.0	39.4	(10.6)	22.5	14.6	(7.9)
17	Мэдээлэл үйлчилгээ/ор	1.5	90.0	88.5	15.0	124.7	109.7	56.3	70.1	13.9
18	Машины хураамж	200.0	201.8	1.8	290.0	312.7	22.7	184.5	316.5	132.0
19	Самбарын түрээс орлого	230.0	318.2	88.2	200.0	382.5	182.5	225.0	212.1	(12.9)
20	Буянт-Ухаа ресторан/о	700.0	619.0	(81.0)	750.0	472.9	(277.1)	310.0	345.4	35.4
21	Хүү, торгуулийн орлого	14.4	25.0	10.6	10.0	59.2	49.2	7.0	160.0	153.0
22	Торгууль, хөнгөлөлтийн ашиг				-	0.113	0.1	-	-	-
23	Бусад орлого	40.0	88.2	48.2	3.0	48.6	45.6	3.6	12.0	8.4
<b>Үйл ажиллагааны бус орлого</b>		<b>2,137.9</b>	<b>2,255.0</b>	<b>117.1</b>	<b>2,023.0</b>	<b>2,807.4</b>	<b>784.4</b>	<b>1,479.6</b>	<b>1,954.0</b>	<b>474.4</b>
<b>ДҮН</b>		<b>21,722.3</b>	<b>23,003.3</b>	<b>1,281.0</b>	<b>22,624.7</b>	<b>25,911.2</b>	<b>3,286.4</b>	<b>17,105.7</b>	<b>22,815.5</b>	<b>5,709.8</b>
<b>Газрын тусгай үйлчилгээний алба</b>										
1	Онгоц үйлчилгээний/ор	1,648.6	1,742.5	93.9	1,733.4	1,816.9	83.6	990.7	1,396.6	405.9
2	Шатахуун тээвэрорлого	583.6	343.3	(240.3)	253.6	419.6	166.1	370.0	489.6	119.6
3	Нийтийн тээвэр орлого	55.0	92.6	37.6	40.0	76.6	36.6	45.0	52.3	7.3
4	Тээврийн бус орлого	10.0	-	(10.0)	10.0	13.2	3.2	-	12.3	12.3
<b>ДҮН</b>		<b>2,297.3</b>	<b>2,178.4</b>	<b>(118.8)</b>	<b>2,036.9</b>	<b>2,326.3</b>	<b>289.4</b>	<b>1,405.7</b>	<b>1,950.8</b>	<b>545.1</b>
<b>Сэргээн засах амралт</b>										
1	Рестораны орлого	300.0	241.5	(58.5)	240.0	170.8	(69.2)	165.0	114.3	(50.7)
2	Зочид буудлын орлого	200.0	170.9	(29.1)	100.0	127.9	27.9	112.5	112.5	0.0
3	Буфетын орлого	45.0	41.9	(3.1)	45.0	37.9	(7.1)	22.5	24.3	1.8
4	Биллярдын орлого	15.0	8.4	(6.6)	15.0	3.7	(11.3)	-	-	-
5	Эмчилгээний орлого	440.0	162.5	(277.5)	-	-	-	-	32.7	32.7
6	Хөдөлгөөний орлого				-	177.4	177.4	75.0	198.6	123.6
7	Бусад орлого	-	11.9	11.9	-	6.0	6.0	-	5.7	5.7
<b>ДҮН</b>		<b>1,000.0</b>	<b>637.2</b>	<b>(362.8)</b>	<b>400.0</b>	<b>523.7</b>	<b>123.7</b>	<b>375.0</b>	<b>488.2</b>	<b>113.2</b>
<b>Орон нутгийн нисэх буудлууд</b>										
1	Өнгөрөлтийн орлого	-	0.054	0.054	-	-	-	-	-	-
2	Буулт, хөөрөлтийн нислэгийн орлого	172.3	84.851	(87.449)	78.0	88.7	10.7	113.3	75.3	(37.9)
3	Зорчигч Үйлчилгээ/орло	154.8	63.366	(91.481)	80.0	51.3	(28.7)	85.2	48.5	(36.7)
4	Газрын техник үйлчилгээний орлого	355.4	125.816	(229.573)	326.9	132.4	(194.6)	193.4	113.4	(79.9)
5	Бүртгэх цэгийн орлого	-	4.559	4.559	-	5.7	5.7	-	3.6	3.6
6	Вип-ийн хураамж/орлого	-	-	-	-	-	-	-	-	-
7	Шатахуун тээвэрлэлт/о	-	-	-	-	-	-	-	102.3	102.3
8	Зогсолтын орлого гэрээт	-	-	-	-	-	-	-	24.1	24.1
9	Хүүгийн орлого	-	8.542	8.542	-	9.5	9.5	-	5.3	5.3
10	Бусад орлого	-	338.738	338.738	-	185.1	185.1	-	16.4	16.4
11	Борлуулалтын хорогдол ба буцаалт	-	(1.330)	(1.330)	-	-	-	-	(1.9)	(1.9)
<b>ДҮН</b>		<b>682.5</b>	<b>624.6</b>	<b>(57.9)</b>	<b>484.9</b>	<b>472.6</b>	<b>(12.3)</b>	<b>391.8</b>	<b>387.1</b>	<b>(4.7)</b>
<b>НИИТ ДҮН</b>		<b>174,304.8</b>	<b>196,544.3</b>	<b>22,239.5</b>	<b>189,059.8</b>	<b>235,248.3</b>	<b>46,188.4</b>	<b>194,054.0</b>	<b>210,852.2</b>	<b>16,798.2</b>

Тус газар 2015 онд 196,544.3 сая төгрөгийн орлого олж төлөвлөгөөнөөс 12.7 хувь буюу 22,239.5 сая төгрөгөөр давж биелжээ. Орлогыг бүтцээр нь авч үзвэл:

- Өнгөрөлтийн нислэгийн орлого 14.4 хувь буюу 20,678.8 сая төгрөг
- Хөөрөлт буултын нислэгийн орлого 1.6 хувь буюу 142.0 сая төгрөг
- Зорчигч үйлчилгээний орлого 9.2 хувь буюу 748.9 сая төгрөг
- Бусад орлого 4.6 хувь буюу 660.9 сая төгрөгөөр тус тус давж биелжээ.

Нийт орлогын 83.6 хувийг өнгөрөлтийн нислэгийн орлого, 4.3 хувийг буулт, хөөрөлтийн нислэгийн орлого, 4.5 хувийг зорчигч үйлчилгээний орлого, 7.6 хувийг бусад орлого эзэлж байна. 2015 оны орлогыг өмнөх оны орлоготой харьцуулбал 9.9 хувь буюу 17,783.2 сая

төгрөгөөр нэмэгдсэн байна. 2015 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны борлуулалтын орлого төлөвлөснөөс 22,239.5 сая төгрөгөөр давж биелэсэн байна.

ИНЕГазар 2016 онд 235,248.3 сая төгрөгийн орлого олж төлөвлөгөөнөөс 24.4 хувь буюу 46,188.4 сая төгрөгөөр давж биелжээ. Орлогыг бүтцээр нь авч үзвэл:

- Өнгөрөлтийн нислэгийн орлого 19.1 хувь буюу 30,921.4 сая төгрөг
- Хөөрөлт буултын нислэгийн орлого 23.0 хувь буюу 2,065.6 сая төгрөг
- Зорчигч үйлчилгээний орлого 5.9 хувь буюу 520.2 сая төгрөг
- Бусад орлого 231.3 хувь буюу 12,681.1 сая төгрөгөөр тус тус давж биелжээ.

Нийт орлогын 81.8 хувийг өнгөрөлтийн нислэгийн орлого, 4.7 хувийг буулт, хөөрөлтийн нислэгийн орлого, 4.0 хувийг зорчигч үйлчилгээний орлого, 9.5 хувийг бусад орлого эзэлж байна. 2016 оны орлогыг өмнөх оны орлоготой харьцуулбал 19.7 хувь буюу 38,704.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Монгол улсын агаарын зайд үйлдэгдсэн нислэг, зорчигчдын тоо

Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
Өнгөрөлтийн нислэгийн тоо	82,626	85,689	87,117	90,686	99,210	110,951
Олон улсын буулт, хөөрөлтийн нислэгийн тоо	6,363	6,735	6,741	6,430	6,726	7,921
Орон нутгийн буулт, хөөрөлтийн нислэгийн тоо	11,103	9,744	6,437	4,556	4,956	5,673
Олон улсын зорчигчийн тоо	758,841	781,459	764,738	765,924	790,459	728,718
Орон нутгийн зорчигчийн тоо	340,024	325,245	254,364	189,943	232,586	242,406

Өнгөрөлтийн нислэгийн орлого жил бүр өсөж байхад орон нутгийн буулт, хөөрөлтийн нислэгийн тоо болон зорчигчдын тоо буурсан үзүүлэлттэй байна.

ИНЕГ-ын харьяа албадуудын 2012 – 2014 онуудын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төгрөгөөр/

Албадуудад	2012 оны			2013 он			2014 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
<b>ДҮН</b>	<b>106,536.5</b>	<b>123,592.0</b>	<b>17,055.5</b>	<b>120,467.2</b>	<b>151,979.8</b>	<b>31,512.6</b>	<b>137,398.5</b>	<b>178,761.1</b>	<b>41,362.6</b>
"Чингис хаан" ОУНБ	16,485.9	19,298.3	2,812.5	19,394.8	22,314.4	2,919.6	20,174.7	23,080.6	2,905.9
Газрын тусгай үйлчилгээний алба	2,400.0	3,088.3	688.3	3,629.0	2,694.4	(934.7)	2,958.2	2,161.2	(797.0)
Сэргээн засах амралт	395.0	534.3	139.3	1,880.9	901.9	(978.9)	1,742.7	822.6	(920.1)
Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба	83,580.0	97,094.3	13,514.3	93,834.5	117,041.2	23,206.7	108,094.3	145,673.4	37,579.2
Техник хангалт, навигацийн үйлчилгээний алба	221.0	262.0	41.0	221.0	216.9	(4.1)	200.0	201.9	1.9
Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба	9.0	12.0	3.0	10.0	23.5	13.5	23.0	3.5	(19.5)
Оношилгоо хэмжилзүйн лаборатори	30.0	33.5	3.5	30.0	38.2	8.2	38.0	37.4	(0.6)
Нисэхийн сургалтын төв	15.0	19.5	4.5	15.0	22.8	7.8	40.0	25.5	(14.5)
Нисэхийн аюулгүй ажиллагаа, хяналт зохицуулалтын алба	200.0	221.8	21.8	200.0	212.8	12.8	-	-	-
Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн алба	2,830.5	2,429.8	(400.7)	693.3	7,823.5	7,130.2	3,460.9	5,956.2	2,495.3
Орон нутгийн нисэх буудлууд	370.1	598.2	228.1	558.6	690.2	131.5	666.8	798.9	132.0
Баян-Өлгий аймаг дахь нисэх буудал	46.1	50.7	4.6	50.8	58.0	7.2	58.4	91.6	33.2

Баянхонгор аймаг дахь нисэх буудал	23.5	37.6	14.1	37.6	40.0	2.4	40.1	37.5	(2.6)
Булган аймаг дахь нисэх буудал	13.3	3.1	(10.2)	-	11.6	11.6	-	16.7	16.7
Завхан аймаг дахь нисэх буудал	15.9	36.2	20.3	36.2	62.1	25.9	67.7	46.1	(21.6)
Говь-Алтай аймаг дахь нисэх буудал	25.2	26.8	1.6	26.5	45.7	19.2	46.7	39.7	(7.0)
Дорнод аймаг дахь нисэх буудал	46.2	75.5	29.3	75.5	71.2	(4.3)	80.3	146.3	66.0
Дундговь аймаг дахь нисэх буудал	1.8	10.1	8.3	1.5	-	(1.5)	-	12.7	12.7
Сүхбаатар аймаг дахь нисэх буудал	5.4	7.0	1.6	6.7	22.6	15.9	7.0	8.3	1.3
Хөвсгөл аймаг дахь нисэх буудал	36.0	99.8	63.7	78.7	99.5	20.8	78.7	154.3	75.6
Хэнтий аймаг дахь нисэх буудал	1.7	2.8	1.0	1.7	5.0	3.3	-	4.2	4.2
Ховд аймаг дахь нисэх буудал	56.0	74.4	18.4	82.9	64.7	(18.2)	93.0	71.6	(21.4)
Өмнөговь аймаг дахь нисэх буудал	53.0	107.6	54.6	99.5	121.4	21.9	121.4	69.3	(52.1)
Өвөрхангай аймаг дахь нисэх буудал	6.3	12.9	6.6	7.1	8.0	0.9	3.5	6.0	2.5
Тосонцэнгэл суман дахь нисэх буудал	1.7	7.0	5.2	7.0	18.3	11.3	7.9	14.4	6.5
Увс аймаг дахь нисэх буудал	37.8	46.9	9.1	46.9	62.2	15.3	62.2	80.2	18.0

ИНЕГ нь системийн хэмжээгээр орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн боловч 2012 онд үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн алба 400.7 сая төгрөгөөр, Булган аймаг дахь нисэх буудал 10.2 сая төгрөгөөр, 2013 онд Газрын тусгай үйлчилгээний алба 934.7 сая төгрөгөөр, Сэргээн засах амралт 978.9 сая төгрөгөөр, Техник хангалт, навигацийн үйлчилгээний алба 4.1 сая төгрөг, Дорнод аймаг дахь нисэх буудал 4.3 сая төгрөгөөр, Дундговь аймаг дахь нисэх буудал 1.5 сая төгрөгөөр, Ховд аймаг дахь нисэх буудал 18.2 сая төгрөгөөр, 2014 онд Газрын тусгай үйлчилгээний алба 796.9 сая төгрөгөөр, Сэргээн засах амралт 920.1 сая төгрөгөөр, Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба 19.5 сая төгрөгөөр, Оношилгоо хэмжилзүйн алба 0.5 сая төгрөгөөр, Нисэхийн сургалтын төв 14.5 сая төгрөгөөр, Баянхонгор аймаг дахь нисэх буудал 2.6 сая төгрөгөөр, Завхан аймаг дахь нисэх буудал 21.6 сая төгрөгөөр, Говь-Алтай аймаг дахь нисэх буудал 6.9 сая төгрөгөөр, Ховд аймаг дахь нисэх буудал 21.4 сая төгрөгөөр, Өмнөговь аймаг дахь нисэх буудал 52.1 сая төгрөгөөр тус тус тасалсан байна.

ИНЕГ-ын харьяа газар, албадуудын 2015 – 2016 онууд, 2017 оны 3 улирлын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая. төгрөг/

Албадуудад	2015 он			2016 он			2017 оны 3 улирал		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
<b>ДҮН</b>	<b>174,304.8</b>	<b>196,544.3</b>	<b>22,239.5</b>	<b>189,059.8</b>	<b>235,248.3</b>	<b>46,188.4</b>	<b>194,054.0</b>	<b>210,852.2</b>	<b>16,798.2</b>
"Чингис хаан" Олон улсын нисэх буудал	21,722.3	23,003.3	1,281.0	22,624.7	25,911.2	3,286.4	17,105.7	22,815.5	5,709.8
Газрын тусгай үйлчилгээний алба	2,297.3	2,178.4	(118.8)	2,036.9	2,326.3	289.4	1,405.7	1,950.8	545.1
Сэргээн засах амралт	1,000.0	637.2	(362.8)	400.0	523.7	123.7	375.0	488.2	113.2
Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба	143,688.8	164,376.4	20,687.6	162,309.7	193,604.2	31,294.5	173,380.3	181,760.9	8,380.6



Техник хангалт, навигацийн үйлчилгээний алба	205.0	233.2	28.2	220.0	231.7	11.7	165.0	212.5	47.5
Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба	-	7.9	7.9	-	8.6	8.6	-	20.0	20.0
Оношилгоо хэмжилзүйн лаборатори	40.0	25.8	(14.2)	25.0	29.6	4.6	22.5	21.2	(1.3)
Нисэхийн сургалтын төв	25.0	26.9	1.9	30.0	31.5	1.5	22.5	32.6	10.1
НААХЗАлба	-	-	-	-	4.1	4.1	-	-	-
Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн алба	4,643.9	5,430.7	786.8	928.5	12,104.7	11,176.2	1,185.4	3,163.4	1,978.0
<b>Орон нутгийн нисэх буудлууд</b>	<b>682.5</b>	<b>624.6</b>	<b>(57.9)</b>	<b>484.9</b>	<b>472.6</b>	<b>(12.3)</b>	<b>391.8</b>	<b>387.1</b>	<b>(4.7)</b>
Баян-Өлгий аймаг дахь нисэх буудал	71.1	92.7	21.6	71.1	62.8	(8.3)	43.5	64.8	21.3
Баянхонгор аймаг дахь нисэх буудал	37.2	14.2	(23.0)	15.8	15.6	(0.2)	0.4	14.4	14.0
Булган аймаг дахь нисэх буудал	-	17.9	17.9	-	1.9	1.9	2.2	2.4	0.2
Завхан аймаг дахь нисэх буудал	32.0	33.3	1.3	32.8	40.2	7.4	23.1	27.4	4.3
Говь-Алтай аймаг дахь нисэх буудал	46.7	15.6	(31.1)	18.5	23.0	4.5	15.1	10.2	(4.8)
Дорнод аймаг дахь нисэх буудал	105.4	67.1	(38.3)	46.0	37.7	(8.3)	44.0	18.3	(25.7)
Дундговь аймаг дахь нисэх буудал	-	6.5	6.5	-	5.0	5.0	2.0	1.3	(0.7)
Сүхбаатар аймаг дахь нисэх буудал	7.2	3.9	(3.3)	3.6	1.9	(1.7)	2.7	1.1	(1.6)
Хөвсгөл аймаг дахь нисэх буудал	97.4	68.9	(28.5)	66.0	73.9	7.9	51.9	52.4	0.5
Хэнтий аймаг дахь нисэх буудал	3.4	4.2	0.9	3.1	0.9	(2.2)	1.4	2.3	0.9
Ховд аймаг дахь нисэх буудал	99.0	110.6	11.6	99.0	79.6	(19.4)	88.7	72.5	(16.2)
Өмнөговь аймаг дахь нисэх буудал	90.1	53.9	(36.2)	46.9	48.9	2.0	47.8	45.4	(2.3)
Өвөрхангай аймаг дахь нисэх буудал	7.1	4.3	(2.7)	3.5	5.8	2.3	2.0	2.3	0.3
Тосонцэнгэл суман дахь нисэх буудал	8.7	3.2	(5.5)	3.1	3.5	0.4	1.7	1.7	-
Увс аймаг дахь НБ	77.3	128.1	50.8	75.5	71.9	(3.5)	65.5	70.6	5.1

2015 онд Газрын тусгай үйлчилгээний алба 118.8 сая төгрөгөөр, Сэргээн засах амралт 362.8 сая төгрөгөөр, Оношилгоо хэмжил зүйн лаборатори 14.2 сая төгрөгөөр, Баянхонгор аймаг дахь нисэх буудал 23.0 сая төгрөгөөр, Говь-Алтай аймаг дахь нисэх буудал 31.1 сая төгрөгөөр, Дорнод аймаг дахь нисэх буудал 38.3 сая төгрөгөөр, Сүхбаатар аймаг дахь нисэх буудал 3.3 сая төгрөгөөр, Хөвсгөл аймаг дахь нисэх буудал 28.5 сая төгрөгөөр, Өмнөговь аймаг дахь нисэх буудал 36.2 сая төгрөгөөр, Өвөрхангай аймаг дахь нисэх буудал 2.7 сая төгрөгөөр, Тосонцэнгэл суман дахь нисэх буудал 5.5 сая төгрөгөөр, 2016 онд Баян-Өлгий аймаг дахь нисэх буудал 8.3 сая төгрөгөөр, Дорнод аймаг дахь нисэх буудал 8.3 сая төгрөгөөр, Сүхбаатар аймаг дахь нисэх буудал 1.7 сая төгрөгөөр, Хэнтий аймаг дахь нисэх буудал 2.2 сая төгрөгөөр, Ховд аймаг дахь нисэх буудал 19.4 сая төгрөгөөр, Увс аймаг дахь нисэх буудал 3.5 сая төгрөгөөр, 2017 оны 3 улирлын байдлаар Говь-Алтай аймаг дахь нисэх буудал 4.8 сая төгрөгөөр, Дорнод аймаг дахь нисэх буудал 25.7 сая төгрөгөөр, Сүхбаатар аймаг дахь нисэх буудал 1.6 сая төгрөгөөр, Ховд аймаг дахь

нисэх буудал 16.2 сая төгрөгөөр, Өмнөговь аймаг дахь нисэх буудал 2.3 сая төгрөгөөр тус тус тасалсан байна.

Үйлдвэрлэл үйлчилгээний урсгал зардалд 2012 онд 78,090.0 сая төгрөг төсөвлөснөөс 74,985.0 сая төгрөгийг зарцуулж батлагдсан төсвийг 3,105.0 сая төгрөгөөр, 2013 онд 84,300.3 сая төгрөг төсөвлөснөөс 82,315.0 сая төгрөгийг зарцуулж батлагдсан төсвийг 1,985.3 сая төгрөгөөр, 2014 онд 84,955.3 сая төгрөгийг төсөвлөснөөс 81,365.0 сая төгрөгийг зарцуулж батлагдсан төсвийг 3,590.3 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

ИНЕГ-ын 2012-2014 онуудын төлөвлөгөө зардлын гүйцэтгэл

ҮЗҮҮЛЭЛТ	2012 он			2013 он			2014 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт
ИНЕГ-ын харьяа төвийн салбар болон үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын бараа материалын үлдэгдэл 2012 оны эхэнд 346,045.3 мянган төгрөг байсан бол, тус онд 1,121,117.0 мянган төгрөгөөр нэмэгдэж 945,077.8 мянган төгрөгөөр, 2013 онд 477,789.5 мянган төгрөгөөр нэмэгдэж 656,083.3 мянган төгрөгөөр, 2014 онд 452,251.2 мянган төгрөгөөр нэмэгдэж 441,533.3 мянган төгрөгөөр тус тус хасагдаж 2014 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар 354,228.6 мянган төгрөгийн үнэлгээ бүхий бараа материал үлдэгдэлтэй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

№	Дансны нэр	2012 он			2013 он			2014 он			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Конторын зориулалттай материал	223,272.5	1,084,952.8	870,459.6	437,765.8	410,467.6	594,580.8	253,372.6	389,152.6	383,558.2	258,967.1
2	Сэлбэг хэрэгсэл	87,164.4		36,567.0	50,597.4		5,051.2	45,546.1	6,318.0	2,688.0	49,176.1
3	Түүхий эд материал	10,649.2	5,313.0	7,655.4	8,306.8	6,517.5	6,448.1	8,376.2	5,884.4	6,709.8	7,550.9
4	Сэлбэг хэрэгсэл /Хэвлэх/	1,829.7	11,829.5	11,374.1	2,285.1	13,471.9	12,857.2	2,899.7	14,951.7	13,407.1	4,444.4
5	Бусад материал	23,129.3			23,129.3			23,129.3	957.0	957.0	23,129.3
6	Лабораторийн сэлбэг, материал					28,032.8	17,846.2	10,186.5	17,843.9	17,069.8	10,960.6
7	Бэлэн бүтээгдэхүүн		19,021.5	19,021.5		19,299.5	19,299.5		17,143.3	17,143.3	
	<b>Нийт</b>	<b>346,045.3</b>	<b>1,121,117.0</b>	<b>945,077.8</b>	<b>522,084.5</b>	<b>477,789.5</b>	<b>656,083.3</b>	<b>343,510.7</b>	<b>452,251.2</b>	<b>441,533.3</b>	<b>354,228.6</b>

ИНЕГ-ын харьяа төвийн салбар, Үйлдвэрлэлийн газрын бараа материал 2015 оны эхэнд 354,228.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, тус онд 604,931.9 мянган төгрөгөөр нэмэгдэж 766,837.7 мянган төгрөгөөр хасагдсан, 2016 онд 434,466.1 мянган төгрөгөөр нэмэгдэж 374,086.8 мянган төгрөгөөр хасагдсан, 2017 онд 228,833.7 мянган төгрөгөөр нэмэгдэж 275,047.7 мянган төгрөгөөр тус тус хасагдаж 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 206,488.2 мянган төгрөгийн үнэлгээ бүхий бараа материалын үлдэгдэлтэй байгааг хүснэгтээр харуулбал:

№	Дансны нэр	2015 он			2016 он			2017.06.30			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Конторын зориулалттай материал	258,967.1	530,637.6	646,143.5	143,461.2	356,866.6	301,871.2	222,410.0	176,713.6	223,040.8	176,082.7
2	Сэлбэг хэрэгсэл	49,176.2	10,084.7	51,199.3	8,061.5		5,402.6	22,088.2	19,681.2	17,667.1	24,102.3
3	Түүхий эд материал	7,550.9	8,747.2	10,088.9	6,229.2	14,445.9	12,471.1	8,204.0	8,058.7	9,959.4	6,303.2
4	Сэлбэг хэрэгсэл /Хэвлэх/	4,444.4	15,783.5	16,629.1	3,598.8	19,698.3	16,815.0				
5	Бусад материал	23,129.3	1,020.0	50.0	24,099.3		145.9				



6	Лабораторийн сэлбэг, материал	10,960.7	13,046.7	17,134.5	6,872.8	16,697.8	10,623.4			
7	Бэлэн бүтээгдэхүүн		25,612.4	25,612.4		26,757.5	26,757.5		24,380.3	24,380.3
	<b>Нийт</b>	<b>354,228.7</b>	<b>604,931.9</b>	<b>766,837.7</b>	<b>192,322.9</b>	<b>434,466.1</b>	<b>374,086.8</b>	<b>252,702.2</b>	<b>228,833.7</b>	<b>275,047.7</b>

### Тав. ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ТАЛААР:

ИНЕГ-ын 2012-2017 онуудын үндсэн хөрөнгийн хөдөлгөөний талаар.

Үзүүлэлтүүд	/сая.төг/							
	Бусад, барилга, байгууламж	Машин, тоног төхөөрөмж	Тавилга, эд	Тээврийн хэрэгсэл	Компьютер, дагалдах хэрэгсэл,	Бүгд дүн	Биет бус хөрөнгө	Дуусаагүй барилга
<b>2012 он</b>								
Эхний үлд.	134,873.1	68,976.9	5,388.1	16,799.9	5,485.6	231,523.6	2,529.9	26,347.1
нэмэгдсэн	9,526.8	10,770.1	146.5	947.2	869.3	22,259.9	1,660.5	29,635.4
хасагдсан	7,017.9	575.8	200.9	163.0	245.9	1,192.7	-	23,601.9
<b>2013 он</b>								
нэмэгдсэн	7,445.8	10,987.9	409.9	1,424.3	733.7	21,001.6	3,066.0	4,295.1
хасагдсан	333.4	4,540.1	345.6	1,145.7	631.8	6,996.5	0.7	20,653.8
<b>2014 он</b>								
нэмэгдсэн	3,450.8	19,704.5	111.4	1,131.3	1,706.7	26,104.7	3,066.0	4,295.1
хасагдсан	81.2	134.3	267.7	242.8	257.0	983.0	550.0	8,000.6
<b>2015 он</b>								
нэмэгдсэн	8,108.5	2,410.5	330.6	945.3	324.1	12,119.0	97.9	315.8
хасагдсан	4,490.2	2,355.7	136.7	129.4	166.8	7,305.9	13.6	82.3
<b>2016 он</b>								
нэмэгдсэн	13,034.3	4,557.4	660.5	1,455.8	886.1	20,594.1	353.6	1,227.4
хасагдсан	4,351.6	5,952.8	745.9	933.4	633.4	12,617.1	61.1	498.4
<b>2017.09.30</b>								
нэмэгдсэн	68.3	1,043.0	481.4	170.7	507.5	2,271.0	9,206.2	29,042.0
хасагдсан	27.6	429.7	422.0		373.1	1,252.4		
Эцсийн үлд.	164,567.4	107,933.2	4,832.0	20,239.4	7,954.6	305,526.3	9,206.2	29,042.0

Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 2012 оны эхэнд 134,873.1 сая төгрөгийн бусад барилга, байгууламж, 69,976.9 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 5,388.1 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 16,799.9 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 5,485.6 сая төгрөгийн компьютер, дагалдах хэрэгсэл, нийт 231,523.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байжээ. мөн 2,529.9 сая төгрөгийн биет бус хөрөнгө, 26,347.1 сая төгрөгийн дуусаагүй барилгын үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд 22,259.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна. Энэ онд нэмэгдсэн томоохон хөрөнгө оруулалтын нэг нь Монгол улсын Засгийн газар, Япон улсын Засгийн газар хооронд байгуулсан гэрээгээр Иргэний нисэхийн ерөнхий газрын нисэхийн аюулгүй байдлыг хангах зорилготойгоор нарны зайн 741 кВт-ын цахилгаан станцыг буцалтгүй тусламжаар барьж байгуулан хүлээлгэн өгсөн байна.

Уг нарны цахилгаан станцыг 514,509,476 иений өртөгтэйгээр барьж дуусган хүлээлгэн өгсөн бөгөөд, хөрөнгийг орлогод авахдаа Монгол банкны 2012 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн ханшаар тооцож төгрөгт шилжүүлэн 8,504.5 сая төгрөгөөр орлого авч үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгажээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд буй болсон нийт 10,387.6 төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авч, өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр 5,027.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч бэлтгэжээ.

ТӨХ-ны 2013 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 05 тоот тогтоолоор 76.3 сая төгрөгийн балансын үнэ бүхий 32 нэр төрлийн 54 ширхэг тоног төхөөрөмж, тавилга эд

хогшлыг Зам тээврийн яаманд балансаас балансад шилжүүлж хүлээлгэн өгч акт үйлдсэн байна. ТӨХ-ны 115, 648, 380, 655, 424, 562 тоот тогтоол, 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 3/2005 тоот, 2012 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 3/2021 тоот, 2012 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 3/2407 тоот албан бичгийн дагуу данснаас хасаж байгууллагын ӨХБЗ-ийн дүгнэлтийг гаргуулан ТӨХ-нд хүргүүлсэн байна.

Биет бус хөрөнгийн дансанд Барилгын бүртгэлийн программ, Бүртгэл хяналтын программ, AFTI Нислэгийн мэдээний программын шинэчлэлт, AIROCON 2100 нислэгийн төлөвлөлтийн программ, AIS Нислэгийн төлөвлөлтийн программын шинэчлэлт зэрэг программ хангамжууд хийгдэж бүртгэгдэн ашиглах хугацааг 4 жилээр тогтоон элэгдүүлсэн байна. Дуусаагүй барилгын хувьд 4 аймгийн гэрэл суултын тоног төхөөрөмж нийлүүлэх, Говь-Алтай аймгийн НБ-д хатуу хучилттай хөөрч буух зурвас байгуулах /Заабар ХХК/, Завхан аймгийн НБ-д хатуу хучилттай хөөрч буух зурвас байгуулах /Хурдны зам ХХК/, Локаторын барилга, тоног төхөөрөмж барьж, суурилуулах /Бодь интернэйшнль ХХК/, Бүсийн нислэгийн удирдлагын байр барих /Үүрэг трейд ХХК/, Чингис хаан ОУНБ-д хүзүүвч барих ажил, /Гацуурт ХХК/ зэрэг улсын төсвийн хөрөнгөөр баригдаж буй ажлууд дуусаагүй байгаагийн гадна, өөрийн хөрөнгөөр хийгдсэн зохиогчийн хяналт хийх, зарим гэрээт ажлууд ондоо багтаагүй үргэлжилсэн байна.

2013 оны эхэнд 284,971.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан бол тайлангийн жилд 7,445.8 сая төгрөгийн барилга байгууламж, 10,987.9 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1,424.3 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 409.9 сая төгрөгийн тавилга эд хогшил, 733.7 сая төгрөгийн компьютер, бусад хэрэгсэл, 20.1 сая төгрөгийн бусад хэрэгсэл нийт 41,082.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Үүний дотор 14.7 сая төгрөгийн барилга байгууламж, 523.1 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 80.9 сая төгрөгийн тавилга эд хогшил, 14.2 сая компьютер, бусад хэрэгсэл, нийт 632.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр авсан байна.

Тайлант онд 27,650.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хасагдсан бөгөөд 333.4 сая төгрөгийн барилга байгууламж, 4,540.1 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1,145.7 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 345.6 сая төгрөгийн тавилга эд хогшил, 631.8 сая төгрөгийн компьютер, бусад хэрэгсэл, 20,653.8 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг тус тус үнэ төлбөргүйгээр шилжүүлжээ. Үндсэн хөрөнгийн дахин ангилалаар 512.7 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 94.3 сая төгрөгийн тавилга эд хогшил, 13.4 сая төгрөгийн нийт 620.3 сая төгрөгийн хөдөлгөөн хийгдэж жилийн эцэст 298,403.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй болсон байна.

Биет бус хөрөнгө 2013 оны эхэнд 4,190.4 сая төгрөг байсан бол 857.9 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч орлогод авч бүртгэсэн, 700.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлж, 5,047.6 сая төгрөгийн биет бус хөрөнгөтэй болжээ.

2014 оны эхэнд 303,451.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан бол 33,465.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгджээ. Үүнд: Барилга, байгууламж 3,450.8 сая төгрөгөөр,

машин тоног төхөөрөмж 19,704.5 сая төгрөгөөр, тээврийн хэрэгсэл 1,131.3 сая төгрөгөөр, компьютер, бусад хэрэгсэл 1,706.7 сая төгрөгөөр, тавилга эд хогшил 111.8 сая төгрөгөөр, биет бус хөрөнгө 3,066.0 сая төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Тайлант онд 8,984.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хасагджээ. Барилга байгууламж 81.2 сая төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 134.3 сая төгрөгөөр, тээврийн хэрэгсэл 242.8 сая төгрөгөөр, компьютер бусад хэрэгсэл 257.0 сая төгрөгөөр, тавилга эд хогшил 267.7 сая төгрөгөөр, биет бус хөрөнгө 550.0 мянган төгрөгөөр тус тус хасагдсан боловч, дуусаагүй барилгын үлдэгдлийн дүнг 8,000.6 сая төгрөгөөр хорогдуулан бүртгэжээ.

Мөн барилга байгууламж 81.2 сая төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 126.4 сая төгрөгөөр, тээврийн хэрэгсэл 148.1 сая төгрөгөөр, компьютер техник хэрэгсэл 207.9 сая төгрөгөөр, 234.8 сая төгрөгөөр нийт 798.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хасчээ. Машин тоног төхөөрөмж 7.9 сая төгрөгийн, тээврийн хэрэгсэл 94.7 сая төгрөгийн, компьютер техник хэрэгсэл 49.1 сая төгрөгийн, тавилга эд хогшил 32.8 сая төгрөгийн, 550,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн хөдөлгөөн хийсэн байна.

Дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд 2012.05.31-нд онд эхэлсэн Аэродромын зам 14,795.8 сая төгрөгийн /Говь-Алтай аймаг/, БНХУ-ын төвийн барилга 2011.08.10-нд эхэлсэн 11,285.5 сая төгрөгийн, бусад дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд 2,021.2 сая төгрөгийн нийт 28,102.6 сая төгрөгийн зардлыг дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд бүртгэжээ.

Төрийн өмчийн хорооны 2014 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 416 тоот тогтоолын дагуу 169 нэрийн 135,433,2 мянган төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг ОУНОШБ барих төсөл хэрэгжүүлэх нэгжид балансаас балансад шилжүүлжээ.

Мөн Төрийн өмчийн хорооны 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 3/3465 тоот албан бичгээр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дах заалт, 31 дүгээр зүйл, Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 5.7 дахь заалтыг үндэслэн ашиглалтын хугацаа дууссан, элэгдээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон 580,787,2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлахыг зөвшөөрсөн тул байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналттайгаар хэрэгжүүлж ажилласан байна.

Дуусаагүй байгаа томоохон зам, барилга угсралтын болон тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, тохируулгын ажлуудын талаар:

Заабар ХХК-ийн гүйцэтгэж байгаа Говь-Алтай аймгийн НОБ-д хатуу хучилттай хөөрч буух зурвас барих ажил, Хурдны зам ХХК-ийн гүйцэтгэж байгаа Завхан аймгийн "Доной" НОБ-д хатуу хучилттай хөөрч буух зурвас барих ажил, Увс, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл зэрэг 4 аймгийн НБ-д гэрэл, суултын тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах ажил /"ESDER Eix Pty" компанийн гүйцэтгэж байгаа/. Бүсийн нислэг, хөдөлгөөний удирдлагын

төвийн барилга угсралтын ажил “Үүрэг трейд” ХХК гүйцэтгэж байгаа зэрэг улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлууд он дамжин хийгдэж байна.

2015 оны эхэнд 291,717.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан бол тайлангийн жилд 12,119.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн бөгөөд Үүнд: барилга байгууламж 8,108.5 сая төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 2,410.6 сая төгрөгөөр, тээврийн хэрэгсэл 945.3 сая төгрөгөөр, тавилга эд хогшил 330.6 сая төгрөгөөр, компьютер, бусад хэрэгсэл 324.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Үүний дотор 1,175.3 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг өөрийн хөрөнгөөр худалдан авч бэлтгэн, 228.0 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлэн авчээ.

Тайлант онд 7,305.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хасагдсан бөгөөд 531.4 сая төгрөгийн барилга байгууламж, 2,355.7 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 42.9 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 163.7 сая төгрөгийн тавилга эд хогшил, 166.8 сая төгрөгийн компьютер, бусад хэрэгсэл, нийт 3,261.6 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасчээ.

Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 479 тоот тогтоолоор Жаргалант сэргээн засах сувилалын “Ханрим” зочид буудлын барилгыг /дагалдах хөрөнгийн хамт/ 4,430.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг “ОБЕГазарт”, Төрийн өмчийн хорооны 2015 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 243 тоот тогтоолоор 4,022.9 сая төгрөгийн хөрөнгийг “МИАТ” ТӨХК-д тус тус балансаас балансад шилжүүлсэн, мөн ТӨХ-ны 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 707 тоот тогтоолоор ИНЕГ-ын харъяа нисэх буудлуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 321.5 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Балансаас балансад 3,958.8 сая төгрөгийн барилга байгууламж, 86.5 сая төгрөгийн, нийт 4,045.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэн байна.

Тус байгууллага нь төсвийн жилийн эцэст 158,493.1 сая төгрөгийн барилга байгууламж, 105,243.8 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмж, 19,567.1 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 5,408.6 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 7,817.8 сая төгрөгийн компьютер, бусад хэрэгсэл, нийт 296,530.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй болсон байна. Дуусаагүй барилгын дүн 28,102.6 сая төгрөгийн гүйцэтгэл өртөгтэйгээр бүртгэсэн байна.

2016 оны эхэнд 291,717.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан бол тайлангийн жилд 12,119.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн бөгөөд Үүнд: барилга байгууламж 8,108.5 сая төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 2,410.6 сая төгрөгөөр, тээврийн хэрэгсэл 945.3 сая төгрөгөөр, тавилга эд хогшил 330.6 сая төгрөгөөр, компьютер, бусад хэрэгсэл 324.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Үүний дотор 1,175.3 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг худалдан авч, 227,984,672 төгрөгийн тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлэн авсан байна.

Тайлант онд 7,305.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хасагдсан бөгөөд 531.4 сая төгрөгийн барилга байгууламж, 2,355.7 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 42.9 сая

төгрөгийн тээврийн хэрэгсэл, 163.7 сая төгрөгийн тавилга эд хогшил, 166.8 сая төгрөгийн компьютер, бусад хэрэгсэл, нийт 3,261.6 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасчээ.

Тус байгууллага нь төсвийн жилийн эцэст 158,493.1 сая төгрөгийн барилга байгууламж, 105,243.8 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмж, 19,567.1 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 5,408.6 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 7,817.8 сая төгрөгийн компьютер, бусад хэрэгсэл, нийт 296,530.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй болсон байна. Дуусаагүй барилгын дүн 28,102.6 сая төгрөгийн болсон байна.

2017 оны жилийн эхэнд 304,507.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан бол тайлант оны 3 дугаар улирлын байдлаар 2,271.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн бөгөөд Үүнд: барилга байгууламж 68.3 сая төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 1,043.0 сая төгрөгөөр, тээврийн хэрэгсэл 170.7 сая төгрөгөөр, тавилга эд хогшил 481.4 сая төгрөгөөр, компьютер, бусад хэрэгсэл 507.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Үүний дотор 1,019.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авчээ. Барилга байгууламж 40,671.0 сая төгрөгөөр, машин, тоног төхөөрөмжийг 650.1 сая төгрөгөөр, тээврийн хэрэгсэл 170.7 сая төгрөгөөр, тавилга эд хогшил 59.5 сая төгрөгөөр, компьютер, бусад хэрэгслийг 98.2 сая төгрөгөөр тус тус худалдан авчээ.

Үнэ төлбөргүйгээр 27.6 сая төгрөгийн барилга, байгууламж, 392.9 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 421.9 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 409.3 сая төгрөгийн компьютер бусад хэрэгсэл нийт 1,251.8 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авч бүртгэсэн байна. Харин 4 нэрийн 1,252.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хасагджээ. Үүнд: 27.6 сая төгрөгийн барилга, байгууламж, 429.7 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмж, 422.0 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 373.1 сая төгрөгийн компьютер, бусад хэрэгслийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр балансаас балансад шилжүүлжээ.

Тус байгууллага нь тайлант хугацааны эцэст 164,567.4 сая төгрөгийн барилга байгууламж, 107,933.2 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмж, 20,239.4 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 4,832.0 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 7,954.6 сая төгрөгийн компьютер, бусад дагалдах хэрэгсэл зэрэг нийт 305,526.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй болсон байна.

Оны эхэнд 29,022.1 сая төгрөгийн гүйцэтгэл өртөгтэй дуусаагүй барилга, объект байсан бол 19.9 сая төгрөгөөр нэмэгдэж 29,042.0 сая төгрөг болсон байна.

Биет бус хөрөнгө оны эхэнд 8,489.7 сая төгрөг байсан бол 716.5 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч 9,206.2 сая төгрөгийн хөрөнгөтэй болжээ

### Зураа. АВЛАГА, ӨР ТӨЛБӨР, ТҮҮНИЙ НАСЖИЛТЫН ТАЛААР

Тус газар нь 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 57,676.0 сая төгрөгийн авлагатай, 16,247.5 сая төгрөгийн өр төлбөртэй байна. Нийт авлагын 2.4 хувь нь урьдчилж төлсөн зардал/тооцоо, 82.5 хувь гадаад, дотоодын авиа компаниас авах авлага эзлэж байгаа бол нийт өр төлбөрийн 14.2 хувь нь хойшлогдсон татварын өр эзлэж байна.

**2.1. Авлага:** Авлага нь 1 жилийн дотор төлөгдөх авлага, хоорондын тооцооны /системийн/ авлага болон урьдчилж төлсөн зардал, урьдчилж төлсөн тооцооноос бүрдэж байна. Авлагыг анхны дүнгээр нь хүлээн зөвшөөрч, гадаад байгууллагын авлагад ханшийн зөрүүг сар бүр Монгол банкны ханшаар тэгшитгэн тооцож, бүртгэлд тусгадаг. Нийт хөрөнгийн дүнд авлагын эзлэх хувь 2012-2017 онд байнга өссөн үзүүлэлттэй байна. Хүснэгтээр харуулбал:

<i>/сая.төгрөг/</i>						
Дансны нэр	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
Дансны авлага	24,869.6	27,047.2	36,942.2	35,945.4	38,316.3	47,557.4
Татвар НДШ-ийн авлага			393.2			354.9
Бусад авлага	1,314.5	979.7	5,911.9	15,935.2	5,630.0	8,380.4
<b>Авлагын дүн</b>	<b>26,184.2</b>	<b>28,026.9</b>	<b>43,247.3</b>	<b>51,880.5</b>	<b>43,946.3</b>	<b>56,292.8</b>
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	928.6	1,109.2	182.1	1,277.1	163.7	1,383.2
<b>Нийт дүн</b>	<b>27,112.8</b>	<b>29,136.1</b>	<b>43,429.5</b>	<b>53,157.6</b>	<b>44,109.9</b>	<b>57,676.0</b>

ИНЕГ нь нэгдсэн тайлангаар 2012 онд 26,184.2 сая төгрөгийн, 2013 он 28,026.9 сая төгрөгийн авлагатай байсан бол 2014 онд 43,247.3 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 35.2 хувиар, 2015 онд 51,880.4 сая төгрөг болж өмнөх оноос 16.7 хувиар өссөн, 2016 онд 44,109.9 сая төгрөг болж өмнөх оноос 15.0 хувиар буурсан боловч 2017 оны 3 дугаар улиралд 28.1 хувиар өсчээ.

*Нийт авлагыг харьяа байгууллагуудаар үзүүлбэл:*

№	Харьяа байгууллага	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017.9.30
1	ИНЕГ-ын үйлдвэрлэл	18,570.4	19,366.4	28,267.3	36,314.0	28,833.9	41,916.4
2	Агентлаг	15.1	18.0	4.5	24.9	25.1	50.3
3	Чингис хаан ОУНБ	6,790.6	7,924.9	13,059.3	13,686.2	13,956.4	13,200.7
4	Газрын тусгай үйлчилгээ	711.2	612.4	1,719.6	1,672.9	912.3	830.0
5	Нислэг үйлчилгээ төв	51.4	28.6	188.9	148.4	24.8	57.9
6	Сэргээн засах сувилал	44.0	21.1	27.3	30.1	55.4	46.4
7	Баян-Өлгий		6.6		0.0	18.0	30.9
8	Баянхонгор		3.9				1.90
9	Булган	0.1			0.6	0.1	2.96
10	Говь-Алтай		3.5	0.4	2.0	4.1	6.72
11	Дорнод		17.7	0.0	0.2	0.6	5.91
12	Дундговь	0.3			0.1	0.4	0.9
13	Завхан		2.3		0.0	3.1	3.0
14	Өвөрхангай	0.3	0.3			1.3	1.0
15	Өмнөговь		3.9		0.0	22.7	32.8
16	Сүхбаатар	0.4	0.7		0.1	0.1	1.4
17	Увс	0.1	8.9			26.2	40.87
18	Хөвсгөл		6.1		0.3	21.3	21.7
19	Ховд		1.7		0.3	40.1	35.6
20	Хэнтий				0.4	0.4	0.0
21	Хөшигийн хөндий						5.5
22	Тосонцэнгэл НБ						0.2
	<b>Авлагын нийт дүн</b>	<b>26,184.2</b>	<b>28,026.9</b>	<b>43,267.3</b>	<b>51,880.5</b>	<b>43,946.3</b>	<b>56,292.8</b>

Дээрхи хүснэгтээс харвал 2012-2017 онд нийт авлагын 65.6-70.9 хувийг ИНЕГ-ын үйлдвэрлэлийн салбарын авлага, 25.7-31.8 хувийг Чингис хаан ОУНБ-ын авлага, 2.1-4.0 хувийг Газрын тусгай үйлчилгээний албаны авлага, 0.4-0.8 хувийг аймгуудын нисэх буудлын авлага эзлэж байна. Нийт авлагын дийлэнхи хувийг эзлэж байгаа ИНЕГ-ын үйлдвэрлэлийн албаны авлагын 43.7-78.0 хувийг гадаадын авиа компаний авлага, 13.3-18.0 хувийг дотоодын авиа компаниас авах авлага эзлэж байна.

Харин "Чингис хаан" ОУНБ-ын авлага нь системийн нийт авлагын 25.7-31.8 хувийг эзлэж байх бөгөөд авлагын дийлэнхийг буюу 87.1-96.0 хувийг Дотоодын авиа компаниудаас авах авлага эзлэж байна. Аймгуудын нисэх буудлууд нийт авлагын дүнд багахан хувийг эзлэж байгаа боловч Ховд, Увс, Өмнөговь, Баян-Өлгий, Хөвсгөл аймгуудын Нисэх буудлууд 22.7-40.1 сая төгрөгийн авлагатай байна.

ИНЕГ-ын Санхүүгийн нэгдсэн тайланд гадаад, дотоод авиа компаниудын өнгөрөлтийн болон хөөрөлт буултын авлагыг Дансны авлага дансаар бүртгэсэн бол, гадны харилцагч байгууллага болон ажилчдаас авах авлагыг бусад авлага дансаар бүртгэлд тусгасан байна. */Хүснэгтээр харуулбал/*

Авлагын төрөл	/сая.төгрөг/					
	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017.09.30
Гадаадын авиакомпаниас авах авлага	13,668.1	15,377.0	18,553.6	16,132.2	20,809.8	32,357.4
Дотоодын авиакомпаниас авах авлага	11,201.5	11,670.1	18,388.6	19,813.1	17,506.5	15,200.1
<b>Дансны авлага</b>	<b>24,869.6</b>	<b>27,047.2</b>	<b>36,942.2</b>	<b>35,945.4</b>	<b>38,316.3</b>	<b>47,557.5</b>
Гадны байгууллагаас авах авлага	1,267.7	944.7	6,201.3	15,876.0	5,574.4	8,325.9
Ажилчдаас авах авлага	46.8	35.0	103.8	59.2	55.6	54.5
Татвар НДШ-ийн авлага						354.9
<b>Бусад авлага</b>	<b>1,314.5</b>	<b>979.7</b>	<b>6,305.1</b>	<b>15,935.2</b>	<b>5,630.0</b>	<b>8,735.3</b>
<b>Нийт авлага</b>	<b>26,184.1</b>	<b>28,026.9</b>	<b>43,247.3</b>	<b>51,880.5</b>	<b>43,946.3</b>	<b>56,292.8</b>

2017 оны нийт авлагаас Гадаад авиа компаниас авах авлага 57.5 хувийг, дотоод авиа компаниас авах авлага 27.0 хувийг, гадны харилцагч байгууллагаас авах авлага 14.8 хувийг, бусад авлага 0.7 хувийг тус тус эзлэж байна.

2.1.1 Гадаадын авиакомпаниас авах авлага:ИНЕГ-ын гол орлого нь Монгол Улсын агаарын зайг дамжин өнгөрч байгаа гадаадын авиаконд үзүүлсэн өнгөрөлтийн нислэгийн /навигаци/ орлого байдаг байна. Гадаад авиакомпаниас оруулах энэхүү орлогыг тооцооны дансанд хуваарьт нислэг үйлдэж буй авиаконд, хуваарьт бус нислэг үйлдэж буй авиаконд, нислэгийн үйл ажиллагаа эрхлэхээ больсон буюу ОХУ-ын дампуурсан авиаконд авах авлага гэж ангилж бүртгэсэн.

#### Гадаадын авиа компаниудаас авах авлагын нэгтгэл

Үзүүлэлт	Хуваарьт нислэг /гэрээт/ үйлддэг авиакондийн авлага		Хуваарьт бус нислэг үйлддэг авиакондийн авлага /Гэрээт бус/		Нислэг үйлдэхээ больсон авиаконд /ОХУ-ын дампуурсан/		Гадаадын авиа компаниас авах нийт авлага	
	\$/мянган	сая.төгрөг	\$/мянган	сая.төгрөг	\$/мянган	сая.төгрөг	\$/мянган	сая.төгрөг
2012 он	7,074.5	10,091.6	495.1	689.2	2,074.11	2,887.4	9,643.7	13,668.1
2013 он	6,037.4	10,241.5	1,035.8	1,713.0	2,069.1	3,422.5	9,142.3	15,377.0
2014 он	6,934.1	13,253.8	762.0	1,436.0	2,049.1	3,863.8	9,745.2	18,553.6
2015 он	5,262.0	10,718.5	461.4	921.0	2,250.9	4,492.8	7,974.4	16,132.2
2016 он	6,452.4	16,292.6	437.1	1,088.1	1,377.4	3,429.1	8,266.8	20,809.8
2017.09.30	10,676.6	26,311.8	1,075.7	2,651.0	1,377.4	3,394.5	13,129.8	32,357.4

Гадаадын авиа компаниас авах авлага 2012-2017 онд жил бүр 1,668.9 -11,427.6 сая төгрөг буюу 12.2-54.5 хувиар өсч байгаа нь эргэлтийн хөрөнгийн эргэлтийг удаашруулах эрсдэлийг үүсгэх боловч авлагын 66.6-79.0%-ийг хуваарьт нислэг үйлддэг гэрээт авиа компаниудын авлага эзлэж байгаа нь эргэж төлөгдөх магадлалтай, эрсдэл багатай авлага эзлэж байна.

Харин төлөгдөх магадлал багатай найдваргүй эрсдэлтэй авлага нь нислэг үйлдэхээ больсон авиа компаниас авах авлага гадаад авиа компаниас авах нийт авлагын 2012 онд 21.1 хувийг, 2013 онд 22.3 хувийг, 2014 онд 20.8 хувийг, 2015 онд 27.8 хувийг, 2016 онд 16.5 хувийг, 2017 онд 10.3 хувийг тус тус эзлэж байна.

#### 2.1.1.1 Хуваарьт нислэг үйлддэг гадаадын авиакомпаниуд:

Эдгээр авиакомпаниуд нь өвөл, зуны тогтмол нислэг үйлдэх зөвшөөрөл авснаар сард 2 удаа тогтмол нислэг үйлдэж төлбөрийг 15-20 хоногт барагдуулдаг найдвартай, эрсдэл багатай гэх боловч энэхүү авлага нь дараагийн тайлант хугацаа дамжсан үлдэгдэл ихтэй байна. Дээрхи авлага нь 2012 онд 37 авиа компанитай холбоотой 7,074.5 мянган ам.доллар, 2013 онд 40 авиакомпанитай холбоотой 6,037.43 мянган ам.доллар, 2014 онд 42 авиакомпанитай холбоотой 6,934.12 ам.доллар, 2015 онд 42 авиакомпаний 5,262.03 мянган ам.доллар, 2016 онд 45 авиакомпаний 6,452.38 мянган ам.долларын, 2017 онд 47 авиа компаний 10,676.6 мянган ам.долларын авлагын үлдэгдэлтэй байна. Дээрхи авлагаас 2012 онд 186.2 мянган ам.долларыг, 2013 онд 1,700.4 мянган ам.доллар, 2014 онд 1,387.0 мянган ам.доллар, 2015 онд 8,808.4 мянган ам.доллар, 2016 онд 4,983.8 мянган ам.долларын дутуу төлөлтөөс хуримтлагдсан болон өмнөх оны авлагын үлдэгдлийг барагдуулж ажиллажээ.

2.1.1.2 Хуваарьт бус нислэг үйлддэг гадаадын авиакомпаниас авах авлагын талаар: Хуваарьт бус нислэг үйлддэг гадаадын авиакомпаниудын хувьд жилийн турш тогтмол нислэг үйлддэггүй, тухайн үед нислэг үйлдэх зөвшөөрөл хүсдэг ба өөрөөр хэлбэл өвөл, зуны хуваарьт ордоггүй, захиалгаар цөөн тооны нислэг үйлддэг. Хуваарьт бус нислэг үйлддэг авиакомпанитай холбоотой үүссэн авлага нь 2012 онд 84 авиа компаниас 510.8 мянган ам.доллар, 2013 онд 100 авиакомпанитай холбоотой 1,035.8 мянган ам.доллар, 2014 онд 88 авиакомпаний 1,413.4 мянган ам.доллар, 2015 онд 40 авиакомпаний 461.4 мянган ам.доллар, 2016 онд 36 авиакомпаний 2,124.0 мянган ам.долларын, 2017 онд 2,651.0 мянган ам.долларын авлагын үлдэгдэл тус тус бүртгэлтэй байна. 2015-2016 онд хуваарьт бус нислэг үйлддэг гадаадын авиакомпаний авлагыг бууруулах, өмнөх онуудын төлөгдөөгүй төлбөрийг барагдуулах талаар Гадаад хэргийн яам болон Монгол Улсад суугаа элчин сайдын яамдуудад албан тоот хүргүүлэн 34,143.03 ам.доллар буюу 67,9 сая төгрөгийг барагдуулсан байна.

2.1.1.3 Нислэг үйлдэхээ больсон авиакомпаниас авах авлага: Гадаадын авиакомпаниас авах авлагын нэг хэсэг нь нислэгийн үйл ажиллагаа эрхлэхээ больсон буюу дампуурсан авиакомпаниудаас авах өөрөөр хэлбэл найдваргүй авлага байна. Эдгээр авлага нь 1997-2005 онуудад хуримтлагдан бүртгэгдэж дээд тал нь 20 жилийн насжилттай байна. Үүссэн шалтгаан нь Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдээд навигацийн төлбөрөө төлөөгүйгээс хуримтлагдсан авлага. Дампуурсан авиа компаний авлагын үлдэгдэл 2012 онд 28 авиа компаний 2,887.4 мянган ам.долларын, 2013 онд 28 компанитай холбоотой 2,069.1 мянган доллар, 2014 онд 28 авиа компаний 2,049.1 мянган ам.доллар,



2015 онд 30 авиа компаний 2,250.9 мянган ам.долларын, 2016 онд 13 авиа компаний 1,377.4 мянган ам.доллар байсан бол 2017 онд 1,377.4 мянган ам.доллар буюу 3,394.5 сая төгрөгийн авлага бүртгэгдсэн байна.

- Дээрхи авлагаас “Abakan Avia” компанийг “Royal Flight Airlines” авиакомпани авч, нислэгийн үйл ажиллагааг нь сэргээн нислэгийн зөвшөөрөл хүсэх үед өмнөх авиакомпаний авлагыг барагдуулахыг шаардснаар 63,289.13 ам.долларын авлагыг 2013-2015 онд үе шаттайгаар барагдуулсан байна.

- 2015 онд ОХУ-ын “Aerosvit”, БНХАУ-ын “Jade Cargo Ltd” авиакомпаний үйл ажиллагаагаа зогсоосон тухай мэдээллийг үндэслэн 245,081.80 ам.долларын авлагыг данс хооронд шилжүүлж дампуурсан авиакомпаний авлага нэмэгдсэн байна. 2016 онд “ОХУ-ын Transaero” авиакомпани нь 2015 оны 8 сараас хойш нислэгээ зогсоосон тул 577.4 мянган долларын авлагыг дампуурсан авиакомпаний дансанд шилжүүлэн бүртгэсэн байна. Мөн ОХУ-ын 16 авиа компаний мэдээллийг интернетээс авч Гадаад хэргийн яамаар дамжуулан ОХУ-ын Хууль зүйн яаманд албан бичгээр хандан тухайн авиакомпаниудын дампуурсан ба татан буугдсан тухай нотлох баримтуудыг авч Дампуурсныг нотлох баримт болон Сангийн яамнаас өгсөн зөвлөмжийн дагуу даргын зөвлөлийн 2016 оны 10 дугаар хурлын шийдвэр, ИНЕГ-ын даргын 2016.05.13-ны А/342 тоот тушаалыг үндэслэн 1,260.9 мянган ам.долларын авлагыг данснаас хассан байна.

2.1.2 Дотоодын авиа компаний авлага: Дотоодын агаарын тээвэрлэгч компаниуд нь ИНЕГ-т навигацийн үйлчилгээний хураамж, цахилгаан, дулаан, холбоо, нисэх буудлын үйлчилгээ, орон нутгийн нисэх буудлуудад зорчигчийн үйлчилгээний хураамж, буулт хөөрөлт, бүртгэх цэгийн төлбөр, байрны түрээс, карго ачаа, тоног төхөөрөмжийн түрээс, шатахуун, тээврийн зардал зэрэг төлбөртэй үйлчилгээний хуримтлагдсан өр, төлбөрөөс үүссэн авлага байна. Дотоодын авиа компаниудын авлагыг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/						
	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017.9.30	хувь
Аэромонголиа ХХК	961.0	268.5	1,252.5	1,624.5	1,600.9	1,764.0	11.6
МИАТ ТӨХК	9,276.1	9,282.9	13,935.1	14,708.5	12,477.4	9,763.7	64.2
Хүннү Эйр ХХК	472.7	1,811.8	3,121.5	3,317.7	3,360.7	3,575.8	23.5
Изинес	383.2	251.4	-	0.7			
Бусад авиа компани	108.6	55.59	79.4	161.7	67.6	96.5	0.7
<b>ДҮН</b>	<b>11,201.5</b>	<b>11,670.1</b>	<b>18,388.6</b>	<b>19,813.2</b>	<b>17,506.5</b>	<b>15,200.1</b>	<b>100</b>

Дээрхи хүснэгтээс харахад дотоодын авиа компаниас авах авлага 2012-2015 онуудад 4.0-57.6 хувиар өссөн бол 2016 он, 2017 онуудад 11.6-13.2 хувиар буурсан байна. Дотоодын авиа компаниас авах авлагын 64.2 хувийг МИАТ ТӨХК-иас авах авлага эзлэж байх ба авлага нь 2015 оныг 2012 онтой харьцуулахад 58.6 хувиар өссөн бол 2016 онд 17.9 хувиар, 2017 онд өмнөх оноос 21.7 хувиар буурсан нь олон жилийн насжилттай хуримтлагдсан авлагыг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн ажлын үр дүн гэж үзэж байна. Харин Аэромонголиа, Хүннү Эйр ХХК-иас авах авлага нь өмнөх оноосоо бууралгүй байнга өссөн байна.

ИНЕГ-ын зүгээс дотоод авиа компаниас авах авлагыг бууруулах ажлын хүрээнд Нисэх буудлын болон агаарын навигацийн тоног төхөөрөмжийн шалгалтын нислэгийг агаарын тээврийн байгууллагуудаар гүйцэтгүүлж, өр төлбөрөөс нь тооцох /шалгалтын нислэгт жил бүр 800.0-850.0 сая төгрөгийг төсөвлөн зарцуулдаг/, ажилчдын гадаад дотоод томилолт болон сургалтад хамрагдах үед дотоодын агаарын тээвэрлэгчдээр үйлчлүүлж, тухайн нислэгийн тийзийн зардлыг суутгах, агаарын хөлгийн удирдлагын бүхээгт 10 болон 5-аас доошгүй цаг танилцах дадлага хийх ажлыг агаарын тээврийн компаниудын орон нутгийн нислэгийн үед зохион байгуулж, хоорондын өр авлагыг багасгах боломжийг бүрдүүлэх зэрэг ажлуудын хийсэн боловч хуримтлагдсан өр төлбөрийн хэмжээ дорвитой буурсан үр дүн харагдахгүй байна.

Дотоодын агаарын тээврийн компаниас авах авлагад "Транс-Өлгий" ХХК-ийн 2005 онд үүссэн өнгөрөлтийн болон буултын 27.24 сая төгрөг, "AIR FUTURE MONGOLIA" ХХК-ийн 2006 онд үүсэж тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 3.97 сая төгрөгийн авлага нь төлөгдөх найдваргүй болсон байна.

2.1.3 Гадны байгууллагын авлага: Энэ авлага 2017 оны 3 дугаар улиралд 8,735.3 сая төгрөг байгаа нь нийт авлагын 14.8 хувийг эзлэж байна. Үүнд:

Татварын илүү төлөлтийн 354.9 сая төгрөг,

Бараа бүтээгдэхүүн нийлүүлэлттэй холбогдон гарсан авлага 964.1 сая төгрөг

Гадаадад сурсан оюутантай холбоотой үүссэн 202.2 сая төгрөгийн авлага

Хувь хүмүүсээс авах авлага 244.9 сая төгрөг

Цахим шууданг хакердаж өөр данс руу шилжсэн 28.4 сая төгрөг,

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын урьдчилгаанд олгосон 5,142.5 сая төгрөг. Үүнээс 2012 онд үүссэн 3 аймгийн гэрээт ажилд 2,891.1 сая төгрөг /Говь-Алтай НБ, Завхан аймгийн Доной НБ, Хөвсгөл НБ/ зурвасны гэрэл суултын систем нийлүүлж, суурилуулах ажил. Энэ ажлын тоног төхөөрөмж нийлүүлэгдэж гэрээ дүгнэсэн боловч зурвасны ажил дуусаагүй тул тоног төхөөрөмжийг суурилуулаагүй. /гүйцэтгэгч ESDR Ele Pty Armenia/

2016 онд улсын төсвийн санхүүжилтээр хийгдэх гэрээт ажлын урьдчилгаанд 11 компанид 2,251.5 сая төгрөг, өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжих хөрөнгө оруулалтаар гэрээний дагуу 26 компанид олгосон урьдчилгаа төлбөр 1,251.5 сая төгрөгийг тус тус авлагаар бүртгэсэн. Дээрх авлагаас Хангарьд авиакомпаниас авахаар 1997 онд үүссэн 3,826.1 мянган төгрөг, Санкт Петербург хотод сурч байгаад хөөгдсөн гэх 3.Нарантуяагаас 2005 онд үүссэн 13,721.7 мянган төгрөг, Я.Гансүхэд 2007 онд олгосон цалингийн урьдчилгаа 600.0 мянган төгрөг, шатахууны дутагдуулсан Б.Мөнгөнчимэг, Б.Отгон нартай холбоотой 2008 онд үүссэн 2,542.0 мянган төгрөг, 2009 онд П.Эрдэнэ-Очирт эмчилгээний зардалд олгосон 2,148.9 мянган төгрөг нийт 22.8 сая төгрөг нь 1997-2009 онд бүртгэгдсэн насжилт өндөртэй найдваргүй авлага болох эрсдэл үүссэн байна.

Мөн ИНЕГ үйлдвэрлэлийн ажилчдаас авах авлагад 110.1 сая төгрөг бүртгэлтэй байгаа нь Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн нягтлан бодогчоор ажиллаж байсан Э.Ундрах нь 2013.07.05-ны өдөр Uls airlines cargo компанийн хуваарьт бус буултын төлбөр **5,777.9** ам.доллар буюу 10,292.06 мянган төгрөгийг бэлнээр авч касст тушаагаагүй ба энэ хүн ажлаас халагдсан тул төлбөр барагдуулах гэрээ байгуулсан боловч одоог хүртэл төлбөр барагдаагүй байна.

2.1.4 Гадаад оюутны зардалтай холбоотой авлага: Эдгээр авлагад 2012 онд 3 байгууллага иргэнтэй холбоотой 324.5 сая төгрөг, 2013 онд 4 иргэнтэй холбоотой 56.1 сая төгрөг, 2014 онд 479.8 сая төгрөг, 2015 онд 2 иргэнтэй холбоотой 137.1 сая төгрөгийн, 2016 онд 5 оюутантай холбоотой 218.8 сая төгрөг, 2017 оны 3 дугаар улиралд 202.2 сая төгрөгийн авлага бүртгэгдсэн байна. Үүнд: Цэдэндамба овогтой Бат нь ИНЕГ-ын даргын 2015.11.30-ны өдрийн А/795 тоот тушаалаар Австрали Улсын Бондын их сургуульд Агаарын тээврийн хуулийн мэргэжлээр докторын зэрэг хамгаалах сургалтанд хамрагдаж сургалтанд явах үедээ амьжиргааны зардлаа 2 жилээр нь буюу нийт 79,766.2 мянган төгрөгийг авч явсан ба 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 61.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй.

Энх-Амгалан овогтой Ганхүү 2014.07.16-ны өдөр Канад улсын Calgary Flying Club сургалтын байгууллага руу сургалтын төлбөр болох 53,100.0 ам.доллар буюу 103,714.4 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. Уг сургалтын төлбөрийг төлүүлэх тухай Зам, тээврийн сайдын тушаал гарсан боловч одоог хүртэл шийдвэрлэгдээгүй.

Батмөнх овогтой Түвшинжаргалын сургалтын гэрээг ИНЕГ-ын даргын 2013.04.05-ний өдрийн А/138 дугаар тушаалаар цуцалж, 17,067.0 ам долларын авлага үүсгэн эцэг Б.Батмөнхтэй 2013.08.08-нд төлбөр барагдуулах хэлцэлийг хийсэн боловч төлбөрийг өнөөдрийг хүртэл барагдуулаагүй байна.

2.2. Өглөг, өр төлбөр: Бусад байгууллага, иргэнд төлөх богино болон урт хугацаат өр төлбөр 2012 онд 16,478.0 сая төгрөгийн өр төлбөр бүртгэгдснээс 11.9 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр, 2013 онд 13,083.6 сая төгрөг, 2014 онд 9,171.6 сая төгрөг, 2015 онд 6,497.1 сая төгрөг 2016 онд 10,704.5 сая төгрөгийн, 2017 оны 3 дугаар улиралд 16,247.5 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. 2012-2015 онд өр төлбөр байнга буурах хандлагатай байсан боловч 2016 онд өмнөх оноос 64.7 хувиар, 2017 оны 3 дугаар улиралд 51.8 хувиар өссөн байна. Харин урт хугацаат зээлийн төлбөрийг 2014 онд бүрэн барагдууж ажилласан байна. *Хүснэгтээр харуулбал:*

/сая төгрөг/

Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017.09.30
Дансны өглөг	331.0	519.2	556.7	753.07	1,343.9	1,661.3
Цалингийн өглөг	31.6		-	9.0	2.0	-
Татварын өр	57.8	76.6	6.7	239.7	4,212.3	9,956.3
НДШ-ийн өглөг	4.14	16.0	4.1	101.3	2.1	3.54
Урьдчилж орсон орлого	14.43	15.0	20.5	55.9	155.0	97.0
Бусад	3,441.2	3,566.5	3,422.9	2,906.9	2,596.6	2,136.8
Банкны урт хугацаат зээл	11,928.1	7,193.1	2,729.5			

Хойшлогдсон татварын өр	669.7	1,697.4	2,431.3	2,431.3	2,392.6	2,392.6
Өр төлбөрийн дүн	16,478.0	13,083.7	9,171.6	6,497.1	10,704.5	16,247.6

Дээрхи өр төлбөрөөс татварын өглөг 61.3 хувийг эзлэж байна. Өглөгийн дансанд хөрөнгө оруулалтын барьцааны 5 хувь болох 1,543.8 сая төгрөг нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хийгдсэн гэрээт ажлуудын барьцаа төлбөр байна.

Гэвч эдгээр хөрөнгө оруулалтын барьцаанаас 2010 онд 14 компаний байршуулсан 116.4 сая төгрөг, 2011 онд 25 компаний байршуулсан 172.8 сая төгрөг, 2012 онд 22 компаний байршуулсан 98.7 сая төгрөг, 2013 онд 20 компаний байршуулсан 360.7 сая төгрөг, 2014 онд 21 компаний байршуулсан 157.3 сая төгрөг, 2015 онд 11 компаний байршуулсан 20.2 сая төгрөг, 2016 онд байршуулсан 45 компаний байршуулсан 341.6 сая төгрөг нийт 1,267.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын барьцаа хугацаа хэтэрсэн байна.

Хойшлогдсон татварын өр дансны үлдэгдэл 2,192.6 сая төгрөг бүртгэгдэж жил бүр өссөн байна. Дээрхи хөрөнгө оруулалтын ажил үйлчилгээг актаар хүлээн авснаас хойш баталгаат хугацаа дуусаж 10-д жил өнгөрсөн байхад барьцааны хөрөнгийг чөлөөлөх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна. Мөн гадаадын гэрээт авиа компаниудын барьцаанд байршуулсан 1,582.5 сая төгрөгийн барьцаа өглөгөөр бүртгэгдсэн байна.

#### **Долоо. БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛААР ГАДААДЫН ИХ ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖИД СУРАЛЦСАН ОЮУТНУУДАД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ.**

Иргэний нисэхийн салбарыг олон улсын агаарын тээврийн өнөөгийн хүрсэн амжилтад ойртуулах, олон улсын түвшинд шударгаар өрсөлдөх, өөрийн улсын үндэсний агаарын тээврийн эрх ашиг, зах зээлийг хамгаалан хөгжүүлж, аюулгүй, найдвартай үйлчилгээг бий болгоход мэргэжлийн чадварлаг, боловсролтой хүний нөөцөөр байнга хангаж ажиллах шаардлагатай байдаг.

Иймд Дэлхийн агаарын тээврийн хөгжлийн өнөөгийн чиг хандлагад нийцсэн, зах зээлийн орчинд өрсөлдөх чадвартай нисэхийн нарийн мэргэжлийн боловсон хүчнээр иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харъяа алба салбарыг хангах, хүний нөөцийн хэрэгцээг төлөвлөх, сургаж бэлтгэх, ажилтнуудыг давтан сургах асуудалд ИНЕГ-аас ихээхэн анхаарч ирсэн байна.

Энэхүү шаардлагын хүрээнд Сангийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдаар батлуулдаг ИНЕГ-ын урсгал зардлын төсөвт "Гадаадын өндөр хөгжилтэй орнуудад боловсон хүчин бэлтгэх" зориулалтаар 2.6-3.0 тэрбум төгрөгийг жил бүр төсөвлөж гүйцэтгэлийг санхүүжүүлсэн ба гадаадад суралцагч оюутнуудтай иргэн төлөгдөх нөхцөлтэй биш сургалтын болон барьцааны гэрээ байгуулснаар сургалтын төлбөрийг гэрээний үндсэн дээр төлж төлбөрийг шууд зардалд тооцож ирсэн байна.

Барьцааны эд зүйлс нь эд хөрөнгийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн үл хөдлөх хөрөнгө байх бөгөөд байгууллагад хохирол учирсан тохиолдолд үл маргах журмаар хохирлыг барагдуулах, хэрэв төгсөж ирээд таван жилийн хугацаанд Иргэний нисэхийн

салбарт тогтвортой ажилласан тохиолдолд барьцаа хөрөнгийг чөлөөлж байхаар гэрээнд тусгасан байна.

ИНЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журмын 1.7.2-т “Иргэний нисэхийн тусгай мэргэжлийн боловсон хүчнийг ИНЕГ-ын захиалгаар бэлтгэнэ. Үүнд:

- Нислэгийн хөдөлгөөний удирдлага
- Нисэхийн мэдээлэл хангалт
- Агаарын хөлгийн ашиглалт, засвар үйлчилгээ
- Аэродром, нисэх буудлын барилга байгууламж
- Агаарын тээврийн зохион байгуулалт
- Газрын холбоо, навигацын тоног төхөөрөмжийн ашиглалт
- Агаарын хөлгийн үйлчилгээний тусгай тоноглолтой автомашины засвар, үйлчилгээ
- Нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хангалт
- Нисгэгч /ИНД-61.31-д арилжааны нисгэгчийн үнэмлэх авах шаардлагыг хангасан/

Агаарын тээврийн удирдлага, менежмент, маркетинг төлөвлөлт, эдийн засаг, эрх зүй гэж заасан байна. ИНЕГ-ын даргын 2010 оны “Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай” А/191 тоот, ИНЕГ-ын даргын 2015 оны “Иргэний нисэхийн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг батлах тухай” А/833 тоот тушаалуудаар “Олон улсын иргэний нисэхийн байгууллага ИКАО-ийн стандарт шаардлагад нийцсэн Иргэний нисэхийн салбарын мэргэжилтэй ажилтанг шинээр бэлтгэх, боловсролын түвшинг дээшлүүлэх, давтан сургах, дадлагажуулах, мэргэшүүлэх, зорилтыг хэрэгжүүлсэнээр нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангасан иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлэх салбарын хүний нөөцийг хөгжүүлэх зорилгоор 2011 оны сүүлээр Иргэний нисэхийн ерөнхий газраас гадаадын их дээд сургуульд суралцах сонгон шалгаруулалт явагдсан байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргаар ажиллаж байсан С.Батмөнх, Хойд Америкийн боловсролын нийгэмлэг SABO институтын ерөнхийлөгч ноён Ж.Гордан/President of SABO institute association of north American education Mr.Gordan/ нар 2011 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн №104/11 дугаартай “Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Иргэний нисэхийн ерөнхий газар, Хойд Америкийн боловсролын нийгэмлэг SABO институтын хооронд оюутан сургах талаар” гэрээг баталж байгуулсан байна. Харин ИНЕГ-ыг төлөөлж ИНЕГ-ын дарга С.Батмөнх, Санхүүгийн ерөнхий менежер Г.Наранцэцэг, Захиргаа хүний нөөцийн ерөнхий менежер Т.Батжаргал, хуулийн зөвлөх З.Туяа, SABO институтыг төлөөлж, Төв Азийг хариуцсан менежер Б.Батжаргал нар гарын үсэг зурсан байна. Гэрээнд ИНЕГ нь SABO-тай хамтран ажиллаж, SABO нь ИНЕГ-ыг төлөөлөх онцгой эрх хүлээж, сонгон шалгаруулсан Монгол оюутнуудыг АНУ болон Канад улсуудад дараахь мэргэжлээр сургахаар болжээ.

Тус гэрээнд Иргэний байгууламжийн технологийн бакалаврын зэрэгт 4.5 жил суралцах/Аэродромын байгууламжийн мэргэжлээр /4 оюутан Канадын Торонто хотод,

иргэний байгууламжийн технологийн дипломын зэрэг 3.5 жил суралцах/Аэродромын байгууламжийн мэргэжлээр/ 5 оюутан Канадын Торонто хотод, Геоматикийн байгууламжийн бакалаврийн зэрэгт 4.5 жил суралцах /Агаарын зураглалын мэргэжлээр/ 2 оюутан Канадын Калгари хотод, агаарын хөлгийн хөдөлгүүр ашиглалтын засвар үйлчилгээний дипломын зэрэг- инженерээр 2.0 жил суралцах 9 оюутан Канадын Ричмонд хотод, Онгоцны цахилгаан засвар үйлчилгээний дипломын зэрэг-инженерээр 2.5 жил суралцах /авионик/-ээр 4 оюутан Канадын Ричмонд хотод, Нисдэг тэрэгний нисгэгчээр /Helicopter pilot private/ 1.5 жил суралцах 12 оюутан АНУ-ын Өмнөд Калифорнийн Карлсбад хотод нийт 39 оюутанг 3,286,289 ам доллараар суралцуулахаар заасан бөгөөд гэрээнд оюутан нэг бүрийг судлах хичээлийн хөтөлбөр, төлбөрийн хуваарь болон талуудын эрх үүргийг нарийвчлан заасан байна. Гэрээний 15-д “Энэхүү гэрээг зурагдсанаар нийт төлбөрийн 10 хувь 328,628.89 ам доллар, 2012 оны 3 дугаар сарын 31-ний дотор нийт төлбөрийн 20 хувь 657,257.89 ам доллар, 2012 оны 12 дугаар сард нийт төлбөрийн 30 хувь 985,886.66 ам доллар, 2013 оны 12 дугаар сард нийт төлбөрийн 20 хувь 657,257.78 ам доллар, 2014 оны 12 сард нийт төлбөрийн 20 хувь 657,257.78 ам долларыг” тус тус төлнө.

Оюутан сургах 104/11 тоот гэрээнд доорхи нэмэлт өөрчлөлтүүдийг хийж гэрээний дүн 5,052,725.29 ам доллар болсон байна. Үүнд:

- 2012 оны 1 дүгээр сарын 25-нд байгуулсан **01** тоот нэмэлт гэрээгээр агаарын хөлгийн засвар үйлчилгээний инженер/-ээр 2, нисдэг тэрэгний нисгэгч/-ээр 1 оюутанг нэмж сурган гэрээний дүн 218,850.06 ам доллараар өсч нийт дүн нь **3,505,138.94** ам доллар болжээ.
- 2012 оны 4 дүгээр сарын 11-нд байгуулсан **02** тоот нэмэлт гэрээгээр нисэх буудлын үйл ажиллагааны хөтөлбөр/Airport operation program/-мэргэжлээр 2 оюутанг нэмж сурган гэрээний дүн 124,830.0 ам доллараар өсч нийт дүн нь **3,629,968.94** ам доллар болжээ.
- 2012 оны 6 дугаар сарын 17-нд байгуулсан **03** тоот нэмэлт гэрээгээр Б.Амартүвшиний /Агаарын хөлгийн хөдөлгүүр ашиглалтын засвар үйлчилгээний инженер/ төлбөр 65,023.17 ам долларыг буцаан гэрээний нийт дүн 3,564,945.77 ам доллар болсон байна.
- 2012 оны 6 дугаар сарын 17-нд байгуулсан **04** тоот нэмэлт гэрээгээр А.Мөнхнастыг /Иргэний инженерийн технологийн дипломын зэрэг буюу civil engineering technology/ төлбөр 100,873.13 ам долларыг нэмж гэрээний нийт дүн 3,665,818.89 ам доллар болсон байна.
- 2012 оны 7 дугаар сарын 10-нд байгуулсан **05** тоот нэмэлт гэрээгээр С.Лхагвадорж, Х.Энхжин, О.Насанжаргал, Л.Номин нарын нийт 4 оюутны /Нисэхийн технологи ба арилжааны туршилтын хосолсон хөтөлбөр буюу Aviation technology and commercial pilot combined program/ төлбөр 325,551.60 ам долларыг нэмж гэрээний нийт дүн 4,968,025.29 ам доллар болсон байна.

- 2012 оны 8 дугаар сарын 10-нд байгуулсан 06 тоот нэмэлт гэрээгээр АНУ-д нисдэг тэрэгний хувийн болон арилжааны лицензийн хөтөлбөрт 6 сурагчийг бэлтгэх бөгөөд сургалтын бүх зардлыг өөрчлөгдөхгүй, 7 оюутны сургалтын төлбөрийг 53500 ам доллараас 65600 ам доллар болгож нэмэгдүүлсэнээр гэрээний нийт дүн 5,052,725.29 ам доллар болсон байна.

2013 онд ИНЕГазраас батлагдсан төсвөөс хэтэрсэн гэсэн маргааны улмаас Сабо институтэд төлдөг төлбөрийг зогсоосон байна. 2013 оны 9 сараас зарим нэг оюутнуудын төлбөрийг шилжүүлж эхэлсэн бөгөөд зарим байрны төлбөрийг бууруулан оюутнуудын хувийн дансанд төсөвлөн шилжүүлсэн байна. ИНЕГ-нь 2011 онд 328.6 мянган ам доллар, 2012 онд 1,302.6 мянган ам доллар, 2013-2014 онд 724.1 мянган ам долларыг Сабо руу, 793.9 мянган ам долларыг оюутнуудын данс руу шилжүүлжээ.

Мөн АНУ-ын Калифорны мужийн Фералта Кампанити коллежийн салбар Алимедиа коллежед суралцуулахаар Д.Цэрэндорж эрхлэгчтэй тус улсад амьдардаг Монголчуудын “Зимдаан” сэтгүүлийн газартай тус салбарын боловсон хүчнийг бэлтгэх зорилгоор оюутнуудыг явуулсан байна. Тус сургууль руу 2012 онд 57.6 мянган ам доллар, 2013 онд 9.6 мянган ам долларыг тус тус шилжүүлсэн байна.

Дээрхи сургалтуудын талаар Хан-Уул дүүргийн Цагдаагийн 2 дугаар хэлтэс, Авлигатай тэмцэх газар, дүүрэг, болон Нийслэлийн прокурорын газар хянаад Монгол Улсын эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан аж ахуй нэгж, байгууллага, иргэний өмчийг итгэмжлэн хариуцсан этгээд завшсан буюу үрэгдүүлсний улмаас бусдад онц их хэмжээний хохирол учирсан гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдохгүй байна гэж үзээд Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.1, 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтын үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон байна.

Мөн 2015 онд байгууллагын хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагад тулгуурлан Хөшигтийн хөндийд баригдаж буй Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын Цамхагийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын ажлын байранд шаардлагатай “Нислэгийн удирдагч” мэргэжлээр суралцах оюутнуудын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж Тайландын Вант улсын Иргэний нисэхийн удирдлагын төвд Нислэгийн удирдагч мэргэжлээр суралцах оюутнуудыг сонгон шалгаруулсан байна.

ОХУ-ын Москва хотын Автозамын техникийн их сургууль МАДИ, Москва хотын улсын техникийн их сургууль МГТУ, Санкт-петербург хотын техникийн их сургуулиудтай гэрээ байгуулан оюутнуудыг сургаж байсан байна.

2012 оноос тус байгууллагын зардлаар ОХУ, АНУ, Канад, Авсрали, Англи, Герман, БНСУ, Украин, Тайланд, Тайван, Япон, Франц, Шинэ Зелланд, Хятад, Турк зэрэг 15 оронд 2017 оны 10 дугаар сарын 01-ний байдлаар нийт 68 оюутан суралцаж, 26 оюутан төгссөн байна. Үүнээс мэргэжлийн сургалтад 4, бакалаврын сургалтанд 44, магистрийн сургалтанд 14, доктрантурт 6 хүн суралцаж байна.

*ИНЕГ-ын зардлаар 2013-2016 онууд, 2017 оны 10 дугаар сарын байдлаар  
суралцсан оюутнууд:*

Огноо	Суралцаж байсан оюутан	Шинээр элссэн	Оюутны зардалд шилжүүлсэн /мян.төгрөг/	Төгссөн оюутан	Гэрээ цуцлагдсан оюутан	Суралцаж байгаа
2010-2011	55	57	745,129.9	35	0	77
2012 он	77	48	835,913.8	20	0	105
2013 он	105	6	2,284,465.9	17	0	94
2014 он	94	29	2,816,454.3	11	0	112
2015 он	112	37	3,472,628.5	27	3	119
2016 он	119	19	2,621,298.4	50	4	84
2017.10.01	84	10	1,431,482.2	26	0	68
<b>Нийт</b>	<b>55</b>	<b>206</b>	<b>14,207,373.0</b>	<b>186</b>	<b>7</b>	<b>68</b>

Дээрхи оюутнуудад 2010-2011 онд 534.7 мянган доллар, 2012 онд 857.3 мянган доллар, 2013 онд 1,393.4 мянган доллар, 2014 онд 1,532.4 мянган доллар, 2015 онд 1,750.8 мянган доллар, 2016 онд 1,204.8 мянган доллар 2017 онд 573.9 мянган доллар зарцуулсан ба Т.Анрид шүүхийн 2015.05.12-ны өдрийн 278 дугаар шийдвэрээр 16,460 ам.доллар буюу 32,788.0 мянган төгрөг, Б.Номондалайд Анхан шатны шүүхийн 2016.09.07-ны өдрийн 183 дугаар шийдвэрээр 38,949.0 доллар буюу 86,670.7 мянган төгрөг олгосон байна. ИНЕГ-аас 2013-2016 онд сургалтын төлбөрт нийтдээ 7,878.6 мянган доллар буюу 14,207.4 сая төгрөг зарцуулсан байна.

**Гадаад сургалттай холбоотой шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар:**

1.Хөдөлмөрийн дотоод журмын 1.7.2-д заасныг болон дээрхи 9 тусгай мэргэжлийн шаардлагад нийцээгүй мэргэжлээр 17 оюутантай гэрээ байгуулан сургалтын зардлыг байгууллагаас санхүүжүүлж үргүй зардал гаргасан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

№	Овог нэрс	Сургууль	Мэргэжил	Тушаал	Суралцаж эхэлсэн Төгсөх	Гэрээний дүн /\$/	Гүйцэтгэлээр төлсөн /\$/
1	Д.Лхагважав	АНУ-ын Глобал их сургууль	Бизнесийн удирдлагын магистр	2015.11.19-ний А/777	2014.08.15 2018.8.15	69,676.0	69,072.65
2	Баярсайханы Бямбасүрэн	АНУ-ын Pacific statec university сургууль	Олон улсын бизнесийн удирдлагын магистр	2011.10.07-ны өдрийн Б/239	2012.01.02 2014.10.01	63,735.0	53,765.0
3	Нямжавын Ганжигүүр	АНУ-ын DEPAUL дээд сургууль	Бизнесийн удирдлагын магистр	2010.11.08-ны өдрийн А/427	2010 2012	28,545.0	42,225.25
4	Жамбалдагва Өлзийхишиг	Pacific state university АНУ	Бизнесийн удирдлагын мастер	2012.11.28 Б/384 2013.12.12А/716	2013.01.02 2015.01.01 2016.04.1	57,730.0	61,130.00
5	Лхагвасүрэн Хонгорзул	АНУ-ын Санфранциско хотын коллеж	Олон улсын бизнес худалдаа, харилцаа	2014.06.11А/275	2014.07.15 2017.01.15	41,000.0	41,000.00
		Пеннсилван мужийн их	ШУМэдээллийн технологи,аю	2015.11.04А/712	2016.09.01 2019.01.01	64,200.0	51,211.84



		сургууль АНУ	улгүй байдал, эрсдлийн шинжилгээ				
6	Батжаргал Номондалай	АНУ-ын Лос Анжелос хотын University of California	Улс төр, гадаад харилцаа	2015.09.10-ны өдрийн А/543	2015.09.01-2018.04.01	58,000.0	59,116.54
7	Буянбаатар Ундрал	Southern Cross их сургууль Австрали	Олон улсын санхүү, нягтлан бодох бүртгэлийн магистр	2015.11.17 А/760	2016.01.04-2018.01.04	47,045.01	37,111.25
8	Чилхаасүрэн Сэржмаа	CQ University Австрали	Бизнесийн удирдлагын мастер	2014.08.26-ны өдрийн А/428	2014.09.01-2017.04.01	61,800.0	55,844.89
9	Баасанжав Билгүүнмаа	Griffith их сургууль Австрали	Олон улсын гадаад харилцаа, эдийн засаг	2014.08.26-ны өдрийн А/428	2014.03.03-2017.09.03	63,000.0	64,193.44
10	Энхболд Энхмөнх	Griffith их сургууль Австрали	Бизнесийн удирдлагын магистр	2015.11.20-ны өдрийн А/779	2016.01.01-2018.06.04	75,884.03	38,477.44
11	Нэргүйн Хангал	CQ University Австрали	Бизнесийн удирдлагын мастер	2014.08.26-ны өдрийн А/428	2014.06.01-2015.12.31	54,420.0	54,752.20
12	Ганболдын Солонго	Griffith их сургууль Австрали	Хэлний бэлтгэл	2016.07.07-ны өдрийн А/484	2016.09.01-2017.02.01	10,837.0	10,837.00
13	Баярсайханы Тамираа	АНУ-ын Лос-Анжелос Embry-Riddle Aeronautical	Бизнесийн удирдлагын мастер	2014.11.06-ны өдрийн А/606	2015.01.10-2017.01.10	43,856.0	42,775.0
14	Бавуужав Жаргалмаа	АНУ-ын Дельта хот Pacific state university	Бизнесийн удирдлагын мастер	2014.03.03-ны өдрийн А/86	2014.01.04-2016.04.01	36,410.0	8,967.25
15	Дамдинжав Эрдэнэ-Очир	Griffith их сургууль Австрали	Бизнесийн удирдлагын мастер	2013.07.25-ны өдрийн А/398	2013.09.01-2015.09.01	56,950.0	54,768.0
16	Гомбодорж Урамбаяр	АНУ-ын Калифорнийн Олон улсын их сургууль	Олон улсын бизнесийн удирдлага		2011.10.22	32,631.0	32,631.0
17	Галхүү Сэржмядаг	ОХУ Москва Морис Торезийн нэрэмжит Гадаад хэл орчуулгын сургууль	Орос, Англи, Франц хэлний орчуулагч	2012.08.01-ний өдрийн А/426	2012.09.01-2016.06.01	39,000.0	28,538.04
Нийт дүн:						904,719.04	806,416.59

Дотоод журмын 1.7.2-д заасан нисэхийн тусгай мэргэжлийн бус мэргэжлээр 2012-2017 онуудад нийт 17 оюутантай сургалтын болон амьжиргааны зардлыг 100 хувь

байгууллагаас хариуцан 904.7 мянган ам.доллар төлөх, төгссөний дараа ажлын байраар хангах үүрэг хүлээсэн 18 гэрээг байгуулж 2017 оны 10 дугаар сарын байдлаар 806.4 мянган ам.долларыг зарцуулсан байна.

**2.Хөдөлмөрийн дотоод журмын 1.7.13-д заасныг зөрчин доорхи 5 ажилтантай 2-4 жилийн хугацаанд суралцах хугацааны докторын төлбөрт 235.7 мянган ам.долларыг төлж үргүй зардал гаргасан байна.**

Боловсролоо дээшлүүлэх чиглэлээр суралцаж байгаа дараах оюутнуудын сургалтын төлбөрийг 100 хувь хариуцахаар гэрээ байгуулан төлж байгаа нь Хөдөлмөрийн дотоод журмын 1.7.13-д “Аспирантур, эрдмийн зэрэг, цол хамгаалах сургалтын зардлыг ажилтан өөрөө хариуцах, хүсвэл /3.2.2.б/ ... “ИНЕГ, түүний харьяа байгууллагад 5-с доошгүй жил ажилласан ажилтан байгууллагад хэрэгцээ шаардлагатай мэргэжлээр боловсролоо дээшлүүлэхээр ажлын бус цагаар, үндсэн ажлаас чөлөөлөгдөхгүйгээр суралцахад нь хүсэлт, тодорхойлтыг үндэслэн **1 жилийн сургалтын төлбөрийн 70%-тай тэнцэх 1 удаагийн тэтгэмж олгох**” гэсэнтэй нийцэхгүй байна.

№	Овог нэрс	Сургууль	Мэргэжил	Тушаал	Суралцаж эхэлсэн төгсөх	Гэрээний дүн	Гүйцэтгэлээр олгосон
	Ойдов Намбат	ОХУ-ын Москва хотын Иргэний нисэхийн техникийн их сургууль	Техникийн шинжлэх унааны доктор /эчнээ/	2014.09.22 Б/481	2014.09.01 2017.09.01	40,000.0	38,073.51
2	Сэдбазар Манлай	Pacific state university АНУ	Бизнесийн удирдлагын доктор	2013.06.27А/336 2015.12.16 А/845	2013.07.012 017.01.01	118,957.0	110,407.79
3	Цэдэвдамба Бат	Австрали улс Бондын их сургууль	Хууль, эрх зүйн докторын зэрэг олгох сургалт	2015.11.30-ны өдрийн А795	2016.09.012 018.09.01	98,339.73	\$83,510.00 /AUD108,792.5/
4	Г.Мөнхболд	ОХУ-ын Санкт Петербург	Докторын зэрэг олгох сургалт	2016.04.13 А/247	2016.09.01 2020.09.01	9,000.0	1,878.46
5	А.Баасандагва	ОХУ-ын Санкт Петербург	Докторын зэрэг олгох сургалт	2016.04.13 А/247	2016.09.01 2020.09.01	9,000.0	1,878.46
<b>Нийт дүн</b>						<b>275,296.73</b>	<b>235,748.22</b>

**3. Дараах оюутнууд суралцаж байх хугацаандаа мэргэжлийн чиглэлээ өөрчилснөөс болж илүү зардал гаргасан байна.**

№	Овог нэр	Суралцаж буй сургууль	Мэргэжил	Тушаал шийдвэр	Суралцаж эхэлсэн төгсөх	Гэрээний дүн	Нийт төлөгдсөн
1	Лхамсүрэнгийн Номин	Канад Торонто хотын Seneco коллеж	Агаарын тээврийн технологи	2012.08.01-ний өдрийн А/268	2012.09.01 2017.03.01	Гэрээнд тусгаагүй	276,105.46
			Нисэхийн аюулгүй байдал	2016.06.23-ны өдрийн А/445	2016.09.01 2019.09.01		60,571.0
2	Ганболдын Энхдөлгөөн /АНУ/	Канад Торонто хотын Seneco коллеж	Агаарын хөлгийн инженер	2015.08.25-ны өдрийн А/502	2015.09.01 2018.03.01	39,900.0	18,489.00
			Агаарын хөлгийн нисгэгч	2016.06.23-ны өдрийн А/444	2016.08.01 2018.02.01	65,630.0	59,372.00

3	Лхагвасүрэн Хонгорзул /АНУ/	Сан-франциско хотын коллеж АНУ	Олон улсын бизнес худалдаа, харилцаа	2014.06.11-ний өдрийн А/275	2014.07.15 2017.01.15	41,000.0	92,211.84
		Пеннсилван мужийн их сургууль АНУ	ШУМэдээллийн технологи, аюулгүй байдал, эрсдлийн шинжилгээ	2016	2016.09.01 2019.01.01	64,200.0	
Нийт дүн:							450,378.30

- Лхамсүрэн овогтой Номинг ИНЕГ-ын даргын 2012.08.01-ний өдрийн А/268 дугаар тушаалаар Канад улсын Торонто хотын Сенесаколлежид “Агаарын тээврийн технологи” мэргэжлээр 2012.09.01-нээс 4.6 жил суралцуулах гэрээ байгуулсан ба гэрээнд байгууллагаас хариуцан төлөх төлбөрийг тусгаагүй. Л.Номингийн “Агаарын тээврийн технологи” мэргэжлээр 2012-2016 онд суралцсан сургалтын төлбөр нийт 474,630.0 мянган төгрөг буюу 276.1 мянган доллар төлсөн байна. Л.Номин нь ИНЕГ-т “Агаарын тээврийн технологи” мэргэжлээр “Нисэхийн аюулгүй байдал” мэргэжлээр өөрчлөх хүсэлт гаргасныг ИНЕГ-ын даргын зөвлөлийн 2016.06.17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж Канад улсын Торонто хотын Сенека коллежид “Нисэхийн технологи” мэргэжлийн 3-р курст сурч байгаа Л.Номингийн гаргасан мэргэжлээ өөрчлөх хүсэлтийг үндэслэн “Нисэхийн аюулгүй байдал” /Aviation safety/ программ-д шилжүүлэн сургалтын гэрээнд өөрчлөлт оруулах шийдвэр гаргасан байна. ИНЕГ-ын 2016 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/445 дугаар тушаалаар хүний нөөцийн зайлшгүй хэрэгцээ шаардлагын хүрээнд 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2 жилийн хугацаатай шилжүүлэн суралцуулж нийт зардлын төсвийг 60,751.0 ам.доллараар тооцон, Л.Номинтой байгуулсан 3 талт гэрээнд нэмэлт өөрчлөлтийг тусган шинэчлэн байгуулахыг Захиргаа, удирдлагын газар /З.Туяа/-т үүрэг болгосон байна. Шинэчилсэн гэрээгээр Л.Номингийн сургалтын зардалд 2016 онд 2,100.0 ам доллар, 2017 онд 2,100.0 ам доллар нийт 10,005.0 мянган төгрөг буюу 4,200.0 ам доллар төлсөн байна.

-Ганболдын Энхдөлгөөн нь “Агаарын хөлгийн инженер” мэргэжлээр 2015.09.01-нээс 2018.03.01 хүртэл суралцах сургалтын төлбөрт 39,930 ам.долларыг ИНЕГ хариуцахаар гэрээ байгуулан 1 жил суралцан 18,489 ам.доллар төлсөн байна. Тухайн коллежид нисэгч бэлтгэх анги шинээр нээгдэж нисэгч мэргэжлээр шилжин суралцах тухай хүсэлт гаргасан үндэслэлээр мэргэжил, сургалтын төлбөр зэрэгт өөрчлөлт орж нэмэлт гэрээ байгуулсан байна.

**4.ИНЕГ-ын зардлаар гадаадад суралцан төгссөн боловч дахин гэрээ байгуулан үргэлжлүүлэн өөр мэргэжлээр 2 оюутан суралцсан байна.**

Гадаадын их дээд сургууль, коллежид суралцагч оюутнуудтай байгуулсан сургалтын гурван талт гэрээнд “Сургууль төгсөөд тухайн эзэмшсэн мэргэжлээрээ томилогдсон ажлын байранд тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй, 5-аас доошгүй жил тасралтгүй ажиллана. Энэ заалтыг биелүүлээгүй нөхцөлд суралцсан хугацааны нийт зардлыг ИНЕГ-т буцаан төлж, байгууллагыг хохиролгүй болгоно” гэсэн заалтыг зөрчин төгссөн мэргэжлээрээ ажиллалгүй доорхи оюутнууд дахин зардлаа төлүүлэн үргэлжлүүлэн сурсан байна.

№	Овог Нэр	Мэргэжил	Гэрээний нийт дүн ам.доллар	Тушаал шийдвэр	Суралцаж эхэлсэн ба төгсөх	Төгсөх хугацаа	Нийт төлөгдсөн /ам.доллар/
1	Батжаргалын Номондалай	АНУ-ын Сан-Франциско хотын АЛАМЕДА Коллеж	Агаарын хөлгийн засвар үйлчилгээний технологи	2012.08.01-ны өдрийн А/268	2013.01.01 2015.07.01	Гэрээнд тусгаагүй	41,417.49
		АНУ-ын Лос-Анжелос хотын University of California	Улс төр гадаад харилцаа	2015.09.10-ны өдрийн А/543	2015.09.01 2018.04.01	58,000.0	59,116.54
2	Хүрэлчулууны Энжин	Канад Торонто хотын Seneco коллеж	Агаарын тээврийн технологи	2012.08.01-ний өдрийн А/268	2012.09.01 2016.09.01	Гэрээнд тусгаагүй	48,199.16
		Тээвэр зохион байгуулалт /Канад Seneca	Тээвэр зохион байгуулалт	2015.11.20-ны өдрийн А/786	2016.01.01 2019.09.01	194,700.0	108,392.0
<b>Нийт дүн:</b>							<b>257.125.19</b>

**Б.Номондалай** нь ИНЕГ-ын даргын 2012 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн А/268 дугаар тушаалаар ОХУ-ын Воронеж хотын Их сургуульд олон улсын харилцааны чиглэлээр суралцах болсон Батжаргалын Номондалайг нь суралцах хугацаанд нь байгууллагын тэтгэлэгт/тээврийн зардал, оюутны тэтгэлэг/ хамруулж төгсч ирсний дараа ажлын байраар хангасугай гэсэн тушаал гарсан болоч ОХУ-руу сургалтанд яваагүй байна. ИНЕГ-ын даргын 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн Б/325 дугаар тушаалаар АНУ-ын Peralta Community College District-д "Агаарын хөлгийн засвар үйлчилгээний технологи" мэргэжлээр Б.Номондалайг байгууллагын зардлаар суралцуулсугай" гэсний дагуу "ИНЕГ-ын тэтгэлэгээр гадаадад суралцагчтай байгуулах" гэрээг байгуулсан байна. Гэрээнд "Агаарын хөлгийн засвар үйлчилгээний технологи" мэргэжлээр 2.5 жил, англи хэлний бэлтгэл курст 6 сар байгууллагын зардлаар суралцуулахаар хийжээ. 2012 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 56,000 ам долларын төлбөртэй сургуульд 158,000.0 мянган төгрөгийг үл хөдлөх хөрөнгө барьцаалсан барьцааны гэрээг байгуулсан байна. 2012-2015 онд нийт 41,417.49 ам долларын сургалтын төлбөрийн зардал гарсан байна. 2015 оны 7 дугаар сарын 23-нд төгсөж ирээд, ИНЕГ-ын даргын 2015 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/543 дүгээр тушаалаар "АНУ-ын Калифорни мужийн University of California Los Angeles их сургуульд Б.Номондалайг 2015 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2.5 жилийн хугацаатайгаар байгууллагын зардлаар үргэлжлүүлэн суралцуулахаар болсон байна. Суралцах хугацааны зардлын төсвийг 58000 ам доллартай тэнцэхүйц санхүүжилтийг Монгол төгрөгөөр тооцон олгохоор тушаалд дурдсан байна. Б.Номондалайг өмнө байгуулсан сургалтын гэрээний 2.4-т "Байгууллагын удирдлага солигдох нь энэхүү гэрээг цуцлах үндэслэл болохгүй ба гэрээний бүх заалтууд хүчин төгөлдөр байна. Суралцагч амжилттай сайн суралцсан тохиолдолд дараагийн шатны сургалтанд үргэлжлүүлэн суралцуулах асуудлыг тухайн үед нь шийдвэрлэж болно" гэсэн заалтыг хангасан гэж үзэн үргэлжлүүлэн АНУ-ын Калифорни мужийн "University of California Los Angeles" их сургуульд "Улс төр, гадаад харилцаа" мэргэжлээр 2.5 жил суралцах хугацааны сургалтын зардал, болон тээврийн зардлыг нэг

удаа Монголын үндэсний агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөг зорчиж байгаа агаарын шугамд хоорондын тооцоогоор тооцохоор зардлыг хариуцан төлж сар дутам 200 ам долларыг тэтгэлэгтэй нийтдээ эхний жилийн сургалтын төлбөрийг 58000 ам долларын зардалтайгаар суралцуулахаар ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбилэгийн баталсан “ИНЕГ-ын зардлаар гадаадад суралцагчтай байгуулах сургалтын” №114/15 тоот, барьцааны 115/15 тоот гэрээнүүдийг байгуулсан байна. Сургалтын гэрээний 2.2-т “Сургалтын гэрээнд заасан хугацаанд оролцогчийн үзүүлсэн сурлагын амжилт, түүний талаарх сургуулийн тодорхойлолт болон төлбөрийн дэлгэрэнгүй нэхэмжлэлийг үндэслэн дараах жилийн сургалтын төлбөрийг шилжүүлнэ” гэж заасан байна. Суралцах хугацааны эхний жилийн төлбөр болох 58000 ам доллароос 3 дугаар дамжааны намрын улирлын сургалтын төлбөр 13,650 ам доллар, байрны нэг жилийн төлбөр 6,000 ам долларыг шилжүүлсэн байна. Үлдэгдэл 38,350 ам долларыг шилжүүлээгүй байна. 2017 оны 6 дугаар сарын 16-нд сургуулиа төгссөн бөгөөд нэхэмжлэгч Б.Номондалай нь 38,349 ам доллартай тэнцэх хэмжээний 86,670.7 мянган төгрөгийг ИНЕГ-аас нэхэмжилсэн тул Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн Анхан шатны шүүхийн 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн №183/ШШ2016/00608 шийдвэрээр ИНЕГаараас 86,670.7 мянган төгрөг гаргуулж нэхэмжлэгч Б.Номондалайд олгохоор шийдвэрлэсний дагуу 2016 оны 9 дүгээр сарын 21-нд 86,670.7 мянган төгрөгийг өгсөн байна. Одоо ИНЕГ ажлын байраар хангаагүй байгаа бөгөөд шүүхийн шийдвэрт Иргэний нисэхийн салбарын бус мэргэжлээр суралцуулахаар гэрээ байгуулсны улмаас хохирол учирсан гэж үзвэл холбогдох этгээдээс зохих журмын дагуу жич нэхэмжлэх эрхтэй болно гэжээ

Х.Энхжин нь Канад улсын Торонто хотын Seneco коллежийн Агаарын тээврийн технологи мэргэжлээр 4 жил сурч төгсөөд дахин Тээвэр зохион байгуулагч мэргэжлээр 3.5 жил сурах сургалтын гэрээ байгуулан суралцсан байна.

#### **5. Гэрээний дүнгээс хэтрүүлэн сургалтын төлбөрийг төлсөн байна.**

№	Овог Нэр	Сургууль	Мэргэжил	Тушаал шийдвэр	Суралцаж эхэлсэн батөгсөх хугацаа	Гэрээний нийт дүн ам.доллар	Нийт төлөгдсөн зардал ам.доллар	Гэрээний дүнгээс илүү төлсөн
1	Бадамбазар Урантөгс	ОХУ-ын Санкт-Петербург хотын Иргэний нисэхийн улсын их сургууль	Нислэгийн хөдөлгөөний удирдлага		2011.10.01 2014.10.01	28,000.0	28,788.96	788.96
2	Галбаатар Мөнх-Учрал	ОХУ-ын Москва хотын Иргэний нисэхийн техникийн улсын их сургууль	Тээвэр зохион байгуулалт	2014.08.25-ны өдрийн А/426	2014.09.01 2016.09.01	10,500.0	12,737.14	2,237.14
3	Сэлэнгэ Чогдон	Украин Улсын Харьков хотын Нисэхийн их сургууль	Агаарын хөлгийн хөдөлгөөр ашиглалтын инженер	2014.08.25-ны өдрийн А/421	2014.09.01 2016.09.01	14,200.0	16,949.01	2,749.01
4	Сэр-Од Одбаяр	САН-ФРАНЦИСКО ХОТ: АЛАМЕДА коллеж	Агаарын хөлгийн хөдөлгөөр ашиглалтын техникч	2011.10.06 Б/349	2011.12.10 2016.02.10	56,500.0	57,144.22	644.22
5	Энхбатын Түвшинбат	САН-ФРАНЦИСКО ХОТ: АЛАМЕДА коллеж	Агаарын хөлгийн хөдөлгөөр ашиглалт	2011.10.06 Б/349	2011.12.10 2016.02.10	56,500.0	57,134.31	634.31

6	Батжаргал Номондалай	АНУ-ын Лос-Анжелос хотын University of California	Улс төр, гадаад харилцаа	2015.09.10-ны өдрийн А/543	2015.09.01 2018.04.01	58,000.0	59,116.54	1,116.54
7	Даваажав Бүрэнхишиг	АНУ-ын Сан-Франциско хотын Перралто коммунити коллеж	Агаарын хөлгийн засвар үйлчилгээ	2012.08.01-ний А/268	2012.10.23 2015 он	45,000.0	48,195.49	3,195.49
8	Дорж Мөнхтулга	АНУ-ын Сан-Франциско хотын Перралто коммунити коллеж	Агаарын хөлгийн засвар үйлчилгээ	2012.10.22-ны Б/325	2013.01.01 2016.01.01	45,000.0	49,440.11	4,440.11
9	Ганбат Мэргэн	АНУ-ын ШУТИС-ын	Агаарын зайн инженер	2012.8.20 Б/239 2015.11.05 Б/721	2012.08.29 2014.12.30	43,611.0	88,370.72	44,759.72
10	Нямжав Ганжигүүр	АНУ-ын DEPAUL дээд сургууль	Бизнесийн удирдлагын магистр	2010.11.08-ны өдрийн А/427	2010 2012	28,545.0	42,225.25	13,680.25
11	Жамбалдава а Өлзийхишиг	АНУ-ын Канзасын их сургууль Pacific state university	Бизнесийн удирдлагын магистр	2014.06.11-ний өдрийн А/275	2014.01.03 2016.04.01	57,730.0	61,130.0	3,400.0
12	Жаргалсайхан н Болорчимэг	АНУ-ын Канзасын их сургууль Wichita state university	Нисэхийн электроникч инженер		2011.01.15 2014.01.15	90,000.0	93,301.0	3,301.0
13	Ганболдын Энхдурсгал	АНУ-ын Канзасын их сургууль Pacific state university	Нисэгч		2012.09.11 2014.06.30	81,440.0	84,683.0	3,243.0
14	Баасанжав Билгүүнмаа	Griffith их сургууль Австрали	гадаад харилцаа, эдийн засаг		2014.03.03 2017.09.03	63,000.0	64,193.44	1,193.44
15	Мэндсайхан Хишигбат	Вестминистер их сургууль	Агаарын тээврийн төлөвлөлт менежмент		2014.09.15 2015.09.15	50,510.0	52,682.27	2,172.27
16	Уламбаяр Ариунаа	Франц ENAC	Агаарын тээврийн менежмент		2014.10.01 2015.10.01	20,900.0	25,585.83	4,685.83
	Нийт дүн					749,436.0	841,677.29	92,241.29

Дээрх 16 оюутаны сургалтын гэрээний дүнгээс 92,241.29 ам.долларыг хэтрүүлэн илүү төлсөн тул буцаан байгууллагад төлүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоов.

**6. ИНЕГ-ын зардлаар гадаадад суралцан төгссөн боловч ажлын байраар одоо хүртэл хангагдаагүй байна.** ИНЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журам/2015.12.22-гоос хүчингүй болсон/-ын 1.7.3-т "Иргэний нисэхийн тусгай мэргэжлийн хэрэгцээ, шаардлагыг дараах тооцоо судалгаа, үндэслэлүүдийг харгалзан тодорхойлно. Үүнд: Эрхэм зорилго, хэтийн зорилт, стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах мэргэжлийн боловсон хүчний 5-10 жилийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон судалгаа, ИНЕГ, түүний харьяа байгууллагуудад ажиллагчдын нөхөн хангалтыг бүртгэл, судалгааг..." харгалзан элсүүлэх гэжээ. Гэтэл хүний нөөцийн бодлого, төлөвлөлтгүйгээс их хэмжээний зардал гарган сургасан оюутнуудыг төгсөж ирэхэд 100 хувь ажлын байраар хангаж чаддаггүй байна. Үүнд: 2012-2017 онд төгссөн нийт 186 оюутнаас 31 оюутан ажлын байраар хангагдаж ажиллаагүй байна. Хүснэгтээр харуулбал:

№	Овог	Нэр	Сургууль	Мэргэжил	Боловсролын зэрэг	Зарцуулагдсан нийт зардал /ам доллар/	Ажил эрхлэлтийн байдал
<b>2012-2013 онд төгсөгч оюутан</b>							
1	Баярсайхан	Бямбасүрэн	Ану-ын лос анжелос хотын state	Бизнесийн удирдлага	Магистр	53,765.00	ИНЕГ-ын хүний нөөцийн бүртгэлд орсон.

			pacific university-д				
2	Нямжав	Ганжигүүр	Ану-ын иллионис мужийн Чикаго хотын default их сургууль	Бизнесийн удирдлага	Магистр	42,225.25	Хувийн зардлаар магистрт суралцаж байна.
<b>2015 ОНД ТӨГСӨГЧ ОЮУТНУУД</b>							
1	Болд	Цэнгэл	Канад улсын Бурнаби хот: british columbia institute of technology	Airport operation	Мэргэжлийн дипломын сургалт	41,305.6	Авиа компаниудруу холбогдох бичгийг хүргүүлж, ажлын байраар ханган хамтран ажиллахыг хүссэн хүсэлтийг хүргүүлсэн.
2	Баярсайхан	Мөнх-Оргил		Агаарын хөдөлгүүрийн ашиглалтын инженер	Мэргэжлийн дипломын сургалт	51,772.07	Боловсролын зэргээ дээшлүүлэх зорилгоор Канад улсад хувийн зардлаар сурч байгаа
3	Батболд	Анхболд		Агаарын хөдөлгүүрийн ашиглалтын инженер	Мэргэжлийн дипломын сургалт	50,360.27	Авиа компаниудруу холбогдох бичгийг хүргүүлж, ажлын байраар ханган хамтран ажиллахыг хүссэн хүсэлтийг хүргүүлсэн.
4	Баясгалан	Амарбаяр		Airport operation	Мэргэжлийн дипломын сургалт	40,030.38	Хувиараа үргэлжлүүлэн суралцаж байна
5	Мундаг	Дашдаваа		Агаарын хөлгийн авионикын инженер	Мэргэжлийн дипломын сургалт	66,150.36	ИНЕГ-ын хүний нөөцийн бүртгэлд бүртгэгдсэн.
6	Отгонболд	Насанжаргал		Aviation operation	Бакалавр	41,802.83	
<b>2016 ОНД ТӨГСӨГЧ ОЮУТНУУД</b>							
1	Төмөр	Ашидмөнх	АЛАМЕДА нисэхийн коллеж	Агаарын хөлгийн хөдөлгүүр ашиглалтын техникч	Мэргэжлийн дипломын сургалт	56,685.92	Хувийн компанид туршилтын хугацаагаар ажиллаж байна.
2	Энхбат	Түвшинбат	АЛАМЕДА нисэхийн коллеж		Мэргэжлийн дипломын сургалт	57,134.31	ИНЕГ-ын хүний нөөцийн бүртгэлд бүртгэгдсэн.
3	Дорж	Мөнхтулга	Peralta Community college district сургууль	Агаарын хөлгийн засвар үйлчилгээний технологи	Мэргэжлийн дипломын сургалт	49,440.11	ИНЕГ-ын хүний нөөцийн бүртгэлд бүртгэгдсэн.
4	Галхүү	Сэржмядаг	Морис Торезийн нэрэмжит Гадаад хэл, орчуулгын их сургууль	Орос-Англи-Франц хэлний орчуулагч	Бакалавр	10,461.96	Хувийн компанид туршилтын хугацаагаар ажиллаж байна.
5	Баасанжав	Билгүүнмаа	Криффид их сургууль	Олон улсын гадаад харилцаа, эдийн засагч	Бакалавр	64,193.44	ИНЕГ-ын хүний нөөцийн бүртгэлд бүртгэгдсэн.

6	Нэргүй	Хангал	Queensland University of technology	Бизнесийн удирдлага	Магистр	54,752.20	Монгол ардын намын удирдах зөвлөлийн ажлын албанд улс төрийн ажилтан
7	Ганзориг	Хаш-Эрдэнэ	" Pacific Professional Flight Centre" сургууль /PPFC Ltd/	Агаарын хөлгийн нисгэгч	Мэргэжлийн дипломын сургалт	81,516.00	ИНЕГ-ын хүний нөөцийн бүртгэлд бүртгэсэн.
8	Батжаргал	Номондалай	Peraita Community college district сургууль	Агаарын хөлгийн засвар үйлчилгээний технологи	Бакалавр	41,417.49	Үргэлжүүлэн өөр мэргэжлээр суралцаж байгаа.
9	Чинбаатар	Алдарбаяр	Калгарийн их сургууль	Aircraft maintenance engineering	Бакалавр	46,742.73	Үргэлжүүлэн хувийн зардлаараа суралцаж байна.
10	Баярсайхан	Анар	Иргэний нисэхийн их сургууль /ENAC/	Агаарын зайн менежмент болон нислэгийн менежмент	Магистр	25,749.08	Герман улсад төслийн менежерээр ажиллаж байгаа.
11	Сүхбаатар	Баясгалан	British Columbia Технологийн институт	Агаарын хөлгийн хөдөлгүүр ашиглалтын инженер	Бакалавр	53,167.01	ИНЕГ-ын хүний нөөцийн бүртгэлд бүртгэсэн.
12	Мажигсүрэн	Батбаяр	Жорж Брауны коллеж	Аэродром ашиглалт	Бакалавр	67,028.00	ИНЕГ-ын хүний нөөцийн бүртгэлд бүртгэсэн.
<b>2017 ОНД ТӨГСӨГЧ ОЮУТНУУД</b>							
1	Энхбаяр	Анхбаяр	Иргэний нисэхийн техникийн улсын их сургууль /МГУТА/	Агаарын хөлгийн хөдөлгүүр ашиглалтын инженер	Бакалавр	29,913.32	ИНЕГ-ын хүний нөөцийн бүртгэлд бүртгэсэн.
2	Сүхбат	Шийрэв		Агаарын хөлгийн хөдөлгүүр инженер	Бакалавр	28,836.46	ИНЕГ-ын хүний нөөцийн бүртгэлд бүртгэсэн.
3	Даваасамбуу	Дэлгэрмөрөн		Агаарын хөлгийн хөдөлгүүр инженер	Бакалавр	28,097.35	ИНЕГ-ын хүний нөөцийн бүртгэлд бүртгэсэн.
4	Баярсайхан	Тамираа	Embry-Riddle Aeronautical university	Бизнесийн удирдлага	Магистр	42,775.00	ИНЕГ-ын хүний нөөцийн бүртгэлд бүртгэсэн.



5	Тэгшжаргал	Амарзаяа	Griffith их сургууль	Нисэхийн удирдлага	Магистр	31,232.22	ИНЕГ-ын хүний нөөцийн бүртгэлд бүртгэсэн.
6	Сүхбаатар	Лхагвадорж	Сенека коллеж	Нисэхийн үйл ажиллагаа	Бакалавр	58,216.77	ИНЕГ-ын хүний нөөцийн бүртгэлд бүртгэсэн.
7	Жамбалдагва	Өлзийхишиг	Pacific state university	Олон улсын бизнесийн мастер	Магистр	61,130.00	ИНЕГ-ын хүний нөөцийн бүртгэлд бүртгэсэн.
8	Батжаргал	Номондалай	University of California, Los Angeles	Улс төр гадаад харилцаа	Бакалавр	59,116.54	ИНЕГ-ын хүний нөөцийн бүртгэлд бүртгэсэн.
9	Даваажав	Бүрэнхишиг	Peralta Community college district сургууль	Агаарын хөлгийн засвар үйлчилгээний технологи	Мэргэжлийн сургалт	48,195.49	ИНЕГ-ын хүний нөөцийн бүртгэлд бүртгэсэн.
10	Сүх	Хэрлэн	Иргэний нисэхийн үндэсний их сургуулийн салбар Нисэхийн академи	Нисгэгч	Бакалавр	44,441.08	ИНЕГ-ын хүний нөөцийн бүртгэлд бүртгэсэн.
11	Цогтсайхан	Бэлгүдэй	British Columbia Технологийн институт	Агаарын хөлгийн авионик инженер	Бакалавр	72,031.56	ИНЕГ-ын хүний нөөцийн бүртгэлд бүртгэсэн.
Дүн						1,499,682.80	

#### **8.Барьцааны гэрээг хугацаанаас өмнө чөлөөлсөн байна.**

ИНЕГ нь суралцагсадтай сургалтын болон барьцааны гэрээ байгуулдаг ба барьцааны хөрөнгө нь эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлсэн үл хөдлөх хөрөнгө байх ба байгууллагад хохирол учруулсан тохиолдолд үл маргах журмаар хохиролыг барагдуулах, хэрэв төгсөж ирээд 5 жилийн хугацаанд иргэний нисэхийн салбарт тогтвортой ажилласан тохиолдолд барьцаа хөрөнгийг чөлөөлөх нөхцөлтэй байна. Гэтэл дээрхи шаардлагыг зөрчин 2012-2017 онд суралцсан 19 оюутны барьцааны гэрээг хугацаанаас нь өмнө чөлөөлсөн байна.

#### **Найм. ИНЕГ-ЫН ЗАРДЛААР ДОТООДЫН ИХ ДЭЭД СУРГУУЛЬД СУРАЛЦУУЛСАН АЖИЛЛАГСАДЫН ТАЛААР:**

ИНЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журмын 4.2.2.2-т "ИНЕГ-т 5-аас доошгүй жил ажилласан ажилтан байгууллагад хэрэгцээ, шаардлагатай мэргэжлийн чиглэлээр, боловсролоо дээшлүүлэхээр ажлын бус цагаар, үндсэн ажлаас чөлөөлөгдөлгүйгээр суралцах тохиолдолд сургалтын төлбөрийг төлөхөд тусламж, дэмжлэг үзүүлэхийг хүсвэл үндсэн байгууллага, нэгжийн тодорхойлолт, сургалтын байгууллагын нэхэмжлэлийг үндэслэн нэг жилийн сургалтын төлбөрийн 70 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэгийг нэг удаа олгох" гэж заасан байдаг. Үүний дагуу 2012 оноос хойш одоог хүртэл доорхи

ажилчдын сургалтын төлбөрт 56,965.4 мянган төгрөгийг байгууллагаас төлж суралцуулжээ.

Хүснэгтээр харуулбал:

д/д	ИНЕГ-ын даргын шийдвэр	Нэр	Албан тушаал	Сургуулийн нэр	Мөнгөн дүн /мян төг/
1	2012.01.25 №Б/24	Э.Алтайхүү	"Буянт-Ухаа" рестораны зөөгч	Хөдөлмөрийн дээд сургуулийн ХНМ-ийн эчнээ 3 курс 1 жилийн төлбөр	1,120.0
2	2012.02.14 Б/38	Б.Ганхуяг	Газрын тусгай үйлчилгээний инженер	Удирдлагын академийн ТУ-ын магистр	1,050.0
3		П.Эрдэнэбат	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны нислэгийн удирдагч	Цэцээ гүн ДС-ийн ТЗУ мэргэжлээр 4 курс	805.0
4	2012.06.11 А/216	П.Нарантуяа	Мэдээлэл технологийн ахлах инженер	ШУТИС-н магистрын 70 хувь	1,088.0
5	2012.09.03 Б/250	Р.Хангай	Оператор	ШУТИС-н инженерийн 70 хувь	718.7
6	2012.10.08 Б/316	Н.Батзориг	НБҮГ-ын мэргэжилтэн	Роял ОУ-н академи БУМагистр	4,830.0
7	2011.06.27 Б/205	С.Буяннэмэх	Оюутан	ШУТИС-д шилжүүлэн сургасан /ОХУ-н Санкт-Петербургээс/	1,500.0
8	2012.10.08 №Б/315	Б.Жаргал-Эрдэнэ	Онгоцны техникч Г.Батбаярын хүү	ШУТИС МИС-н 50 хувь	600.0
9	2012.12.27 №Б/435	Л.Ганбат	Техникч	ШУТИС-ийн Политехник коллежийн	726.0
10	2012.01.05 №Б/02	М.Шагдар	Цогцолборын ажилтан	ХААИС-н Экологи технологи хөгжил 3 курс /1 жилийн төлбөр/	1,325.5
11	2012.01.05 №Б/02	А.Даваажаргал	Цогцолборын ажилтан	МУИС-н ЭЗС-н 3 курсийн төлбөр /1 жилийн төлбөр/	1,387.5
12	2012.01.05 №Б/02	Б.Энхмагнай	Цогцолборын ажилтан	ШУТИС-н УУИнженер 4 курсын төлбөр /1 жилийн төлбөр/	1,056.0
13	2012.01.05 №Б/02	Ц.Ангар	Цогцолборын ажилтан	МУИС-н ГЗГС-ийн 2 курсийн төлбөр /1 жилийн төлбөр/	1,125.0
14	2012.01.05 №Б/02	Э.Дэлэг	Цогцолборын ажилтан	МУИС-н ЭЗС-н 2 курсийн төлбөр /1 жилийн төлбөр/	1,125.0
15	2012.01.23 №Б/18	Х.Энхбаатар	Дорнод аймгийн НБДарга	"Улаанбаатар-Эрдэм-Оюу" ДС-н БУМ-н 70 хувь	700.0
16	2012.12.27 №Б/435	Д.Өнөржаргал	ГТҮ мэргэжилтэн	МУИС ХЗС эчнээ анги	574.0
17	2013.02.04 №А/52	Ц.Отгонсүрэн	ГТҮА токарчин	ХААИС Инженер механик 3 курс-70 %	952.0
18	2013.02.04 №А/52	С.Болоржаргал	ТХМ баримт бүрдүүлэгч	ШУТИС-н МИС-н магистрантур	973.0
19	2014.12.25 А/710	Б.Эрдэнэжаргал	Техникч	ШУТИС-н ЭХС-н магистр	1,127.2
20	2014.12.10 А/675	Н.Чинбаатар	Техникч	ҮГДСургууль цахилгаан инженер	819.0
21	2014.12.19 А/697	А.Алтангэрэл	Хэлтсийн дарга	ШУТИС МИС-н магистрийн 1 жил	2,091.5
22	2014.09.19 А/477	С.Энхтуяа	НТМХ-ийн мэргэжилтэн	Удирдлагын академийн магистр	945.0
23	2014.12.31 Г/736	Н.Бямбасүрэн	Техникч	ҮГДСургууль цахилгааны инженер 1 жилийн төлбөр	976.5
24	2015.10.09 А/643	Н.Мөнгөнбөгж	Инженер	МХТДС-н магистр	1,134.0
25	2015.10.09 А/642	Б.Ернар	Инженер	ШУТИС-н МИС-н магистрантур	1,699.4
26	2015.10.09 А/644	Д.Атарсайхан	Инженер	МУИС-н магистр	1,663.2
27	2015.12.18 А/858	Р.Ариунжав	Ахлах техникч	ҮТИС-д Цахилгаан инженер орой	1,071.0
28	2015.01.13 А/15	Ч.Орхон	Техникч	ТТДС-н цахилгааны техникч	645.1
29	2015.05.01 А/203	Ш.Тулга	Техникч	ҮГДС-н цахилгааны инженер	1,071.0
30	2015.04.06 А/143	Ч.Баттүвшин	Инженер	ШУТИС-н ЭХС-н бакалавр 1 жил 70 хувь	1,511.9
31	2015.04.06 А/141	Д.Батжаргал	Инженер	ШУТИС-н ЭХС-д 1 жилийн 70 хувь	1,479.5
32	2016.01.20 А/48	Б.Золбоо	Өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн	Удирдлагын академийн Удирдахуйн ухааны сургуульд Төрийн захиргааны менежмент мэргэжлээр магистрын сургалтын 1 жилийн сургалтын төлбөрт	7,000.0
33	2016.01.26 А/57	Х.Энхбаатар	НХҮА-ны дэд дарга	Улаанбаатар Эрдэм их сургуульд БУМ доктор сургалтанд	3,477.6
34	2016.05.31 А/390	З.Ундрах	Ахлах инженер	ШУТИС-н ЭХС-н бакалавр 1 жил	1,256.8
35	2016.07.18 А/498	А.Ууганбаяр	Мэргэжилтэн	БХИС -н нийтийн захиргаа удирдлагын мэргэжлээр 1 жилийн 70 хувь	1,512.0
36	2016.05.11 А/329	Д.Галт	Ахлах инженер	ҮГДС-н цахилгааны инженер магистр 1 жилийн 70 хувь	1,795.5
37		Б.Одхүү	Инженер	ТТДС-н автозамын инженер 1 жил 70 хувь	1,666.8
38	2017.04.21 А/254	Ё.Эрдэнэбат	Хэлтсийн дарга	МУЭИС-д эрх зүйч магистрийн 1 жилийн 70 хувь	2,366.7
ДҮН					56,965.4

Гэтэл дээрхи журмыг зөрчин онгоцны техникч Г.Батбаярын хүү Б.Жаргал-Эрдэнэд ШУТИС-ын МИС-ийн төлбөрийн 50 хувь болох 600.0 мянган төгрөг, өргөдөл, гомдол

хариуцсан мэргэжилтэн Б.Золбоод Удирдлагын академийн Удирдахуйн ухааны сургуульд Төрийн захиргааны менежмент мэргэжлээр магистрын сургалтын 1 жилийн төлбөрт 7,000.0 мянган төгрөг, Буянт-Ухаа рестораны зөөгч Э.Алтайхүүд Хөдөлмөрийн дээд сургуулийн 1 жилийн төлбөр 1,120.0 мянган төгрөг, СЗСЦогцолборын ажилтан А.Даваажаргалын МУИС-ийн ЭЗС-ийн 1 жилийн төлбөр 1,387.5 мянган төгрөг, Ц.Ангарт МУИС-ийн ГЗГС-ийн 1 жилийн төлбөрт 1,125.0 мянган төгрөг, Э.Дэлэгт МУИС-ийн ОУХС-ийн 1 жилийн төлбөрт 1,125.0 мянган төгрөг, М.Шагдарт ХААИС-ийн 1 жилийн төлбөрт 1,325.5 мянган төгрөг, Б.Энхмагнайд ШУТИС-ийн 1 жилийн төлбөрт 1,056.0 мянган төгрөгийг нийт 14,739.0 мянган төгрөгийг тус тус төлсөн байна.

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны дэд дарга Х.Энхбаатар нь Дорнод аймгийн нисэх буудлын даргаар ажиллаж байхдаа 2012 онд "Улаанбаатар Эрдэм-Оюу" дээд сургуулийн магистрийн төлбөрийн 1 жилийн 70 хувь болох 700.0 мянган төгрөг, мөн сургуулийн докторт суралцахад 3,477.6 мянган төгрөгийг 2016 онд байгууллагаас давхардуулан төлж нэмэгдэл зардал гаргажээ.

### **Ес. АЖИЛЧДАД ОЛГОСОН ОРОН СУУЦНЫ ХӨНГӨЛӨЛТИЙН ТАЛААР**

Тус байгууллага нь ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тогтвор суурьшилтай ажиллах боломж, нөхцлийг бүрдүүлэх, ажлын бүтээмжийг дээшлүүлэх, идэвх санаачлагыг өрнүүлэх зорилгоор орон сууцны хангамжийн асуудлыг шийдвэрлэж жил бүрийн төсөвт тодорхой хэмжээний төсөв батлуулан хэрэгжүүлж ирсэн байна. Дэмжлэг үзүүлэх мөнгөн тусламжийн хэмжээ нь тухайн нутаг дэвсгэрт шинээр баригдаж буй 1 өрөө орон сууцны 70 хувьтай тэнцэх байдлаар тогтоох ба үнийг ОСК болон бусад төрийн байгууллагын судалгааг үндэслэн тогтооно гэж журамдаа заасан байна. *Орон сууц олгосон судалгааг хүснэгтээр харуулбал:*

№	Он	хамрагдсан ажилтны тоо	Төлөвлөсөн мөнгөн дүн /мянган.төгрөг/	Гүйцэтгэлээр олгосон /мянган төгрөг/	Зөрүү	Тайлбар
1	2006-2011 он		11,890,000.0	12,031,084.8	(141,0084.8)	2007 онд хэтрүүлсэн
2.	2012 он	149	3,800,000.0	3,678,000.0	122,000.0	
3.	2013 он	85	1,800,000.0	1,798,000.0	2,000.0	
4.	2014 он	96	2,500,000.0	2,367,450.0	132,550.0	
5.	2015 он	83	1,800,000.0	1,824,000.0	(24,000.0)	
6.	2016 он	69	1,400,000.0	1,414,000.0	(14,000.0)	
7.	2017.10.01	1	22,000.0	22,000.0	-	
	Нийт дүн	483 хүн	23,190,000.0	23,134,534.8	55,466.0	

Орон сууцны хөнгөлөлтөнд хамрагдсан байдлыг харахад ИНЕГ-ын агентлаг, харьяа салбар нэгж, байгууллагууд, аймгуудын нисэх буудлын ажилтнууд, өндөр настан, Зам, тээврийн яамны ажилтнуудыг орон сууцны хөнгөлөлтөнд хамруулсан байна. 2006-2017 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 483 ажилтанд 23,134.5 сая төгрөгийн орон сууцны хөнгөлөлтийг олгосон байна.

**Ажилчдад олгосон орон сууцны хөнгөлөлтийн холбоотой шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар**

1.Доорхи 14 ажилтанд ИНЕГ-ын даргын 2013 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн А/678 тоот тушаалаар баталсан “Орон сууцны үнийн хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 2.2.1-д “Урьд өмнө улсаас буюу байгууллагаас орон сууц авсан, хөнгөлөлт эдэлсэн бол орон сууцны хөнгөлөлт олгохгүй” гэсэн заалтыг зөрчиж давхардуулан орон сууцны хөнгөлөлт олгожээ.

№	Овог нэр	Албан тушаал	Ажилласан жил		Өмнө нь орон сууц улсаас болон байгууллагаас авч байсан эсэх	
			Улсад	ИНЕГ-т	Шийдвэр	Хөнгөлөлт олгосон байдал
1	Содномцэрэн Энх-Амгалан /Агентлаг/	Тэргүүн дэд даргаар ажиллаж байсан	33	30	1992 онд	Буянт-Ухаа 7-р байранд 2 өрөө байр авсан.
					1996 онд	СБД-ийн 6-р хороо, 8-р байранд 2 өрөө байр
					2002 онд	БГД-ийн ТБД андуудын 60-р байр 3-н өрөө байр
					2013.12.26-ны №А/754	30.000.000 төгрөг
2	Чимэддорж Нямсайхан /Агентлаг/	Дэд даргаар ажиллаж байсан /Одоо МИАТ ХК-д ажиллаж байгаа/	22	23	2006 онд	МИАТ ХК-с 23.040 \$ олгосон.
					2014.05.28-ны №А/242	30.000.000 төгрөг
3	Хорлоо Батсайхан /НААХЗГ/	Одоо НХҮА-нд ажиллаж байгаа	31	31	1996 онд	Буянт-Ухаа дахь 58 айлын 2-р байранд 3 өрөө байр
					2014.05.20-ны №А/227	30.000.000 төгрөг
4	Ганболд Ганхуяг /НААХЗГ/	Ахлах байцаагч	16	16	2007 онд	Орон сууцны дэмжлэг 16.000\$ авсан.
					2014.05.20-ны №А/227	30.000.000 төгрөг
5	Жамсран Баярсайхан /ШНЗА/	Даргаар ажиллаж байсан /Өндөр настан/	35	35	1996 онд	МИАТ ХК-аас 13-р хороололд 3 өрөө байр
					2014.06.11-ний №А/278	30.000.000 төгрөг
6	Сэнгээ Буяндалай /Агентлаг/	ИНЕГ-ын даргаар ажиллаж байсан /Одоо НХҮА-нд ажиллаж байгаа/	20	20	1992 онд	Буянт-Ухаа 7-р байранд 2 өрөө
					1998 онд	Гангар Инвест-ийн I хороолол дахь 55-р байр 2 өрөө байр
					2009.12.29-ний №583	10.000.000 төгрөг
					2014.01.30-ны №А/41	55.000.000 төгрөг
7	Тогтохбаяр Лхагвасүрэн /Агентлаг/	ИНЕГ-ын даргаар ажиллаж байсан	14	14	2009.12.29-ний №583	24.000.000 төгрөг
					2014.01.30-ны №А/40	28.000.000 төгрөг
					2014.01.30-ны №А/40	28.000.000 төгрөг
8	Цэрэнчимэд Эрдэнэбилэг /Агентлаг/	ИНЕГ-ын даргаар ажиллаж байсан /Одоо МИАТ ХК-д ажиллаж байгаа/	24	24	2009.12.29-ний №583	24.000.000 төгрөг
					2014.06.11-ний №А/278	30.000.000 төгрөг
9	Хүрлээ Болор-Эрдэнэ /Агентлаг/	Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны эдийн засагч	17	6	2012.12.07-ны №А/420	30.000.000 төгрөг
					2014.07.09-ний №А/334	20.000.000 төгрөг
10	Баатаржав Хүдэрчулуун НААХЗГ	Нислэгт тэнцэх чадварын хэлтсийн дарга	16	16	2009.12.29-ний №583	24.000.000 төгрөг
					2014.07.09-ний №А/333	30.000.000 төгрөг
11	Дашдэндэв Сувдаа /Агентлаг/	Хууль, эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн	12	6	2012.7.23-ны №А/257	30.000.000 төгрөг
					2014.07.09-ний №А/334	20.000.000 төгрөг
12	Дамдинсүрэн Содцэцэг /Агентлаг/	Архивын арга зүйч мэргэжилтэн	14	14	2009.12.29-ний №583	24.000.000 төгрөг
					2014.12.25-ны №А/714	10.000.000 төгрөг
13	Чоймаа Дарьсүрэн /НААХЗГ/	Нислэгийн стандарт, үйл ажиллагааны хяналтын хэлтсийн ахлах байцаагч	21	21	2001 онд	С.Хүрэлбаатарын БГД-ийн 3 хороололд байрлах 3 өрөө хуучин байрыг өгсөн.
					2015.11.04-ний №А/714	22.000.000 төгрөг
14	Даваа	Онгоцны техникч	28	26	2007.04.12-ны №А/248	5,000,000 сая төгрөг

Болдбаатар /Чойбалсан НБ/	/дарга Энхбаатар/			2013.12.26-ны №А/754	33.375.000 төгрөг
------------------------------	-------------------	--	--	----------------------	-------------------

Журмын 2.2.1-д зааснаар “Урьд өмнө улсаас буюу байгууллагаас орон сууц авсан, хөнгөлөлт эдэлсэн бол олгохгүй” гэсэн заалтыг зөрчин 2012-2017 онд нийт 14 ажилтанд **398.4** сая төгрөгийн орон сууцны хөнгөлөлтийг давхардуулан олгосноос Тэргүүн дэд даргаар ажиллаж байсан С.Энх-Амгалан 2 өрөө байр 2, 3 өрөө байр 1, нийт 3 орон сууц авсан боловч 2013 онд 30.0 сая төгрөг авч нийт 4 удаа хамрагдсан бол ИНЕГ-ын даргаар ажиллаж байсан С.Буяндалай мөн л 4 удаа хамрагдсанаас 1992 онд 2 өрөө, 1998 онд мөн 2 өрөө нийт 2 орон сууц авсан боловч, 2 удаа орон сууцны хөнгөлөлт /2009 онд 10.0 сая, 2014 онд 55.0 сая/-д нийт 65.0 сая төгрөгийг албаны эрх мэдлээ урвуулан ашиглаж авсан байна. Тэргүүн дэд дарга С.Энх-Амгалангийн 2014 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар С.Буяндалайд 55.0 сая төгрөгийн орон сууцны үнийн хөнгөлөлтийг олгожээ. Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглосноос гадна авлигын дараах зөрчлийг хориглоно”, 7.1.6-д “албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх”, 7.1.7-д “албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх” гэснийг зөрчсөн тул орон сууцны хөнгөлөлтөд олгосон 85.0 сая төгрөгийг С.Буяндалай, С.Энх-Амгалан нараар төлүүлэхээр, үлдэх 313.4 сая төгрөгийн орон сууцны хөнгөлөлтийн асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэн хянуулахаар **улсын байцаагчийн акт тогтоов.** Мөн Дорнод аймгийн Нисэх буудлын онгоцны техникч Д.Болдбаатарт өмнө нь 2007 онд хөнгөлөлт эдэлсэн байхад 2013 оны 2013.12.26-ны өдрийн А/754 дүгээр тушаалаар 33,375.0 мянган төгрөг буюу 3 хүнд олгох хөнгөлөлтийг 1 хүнд олгосон зөрчил илэрч байна. Энэ зөрчлийг 2013 он, 2014 онд ИНЕГ-ын даргаар С.Буяндалай даргыг ажиллаж байх үед дээрхи тушаалууд гарсан ба СЭЗГ-ын даргаар Л.Нэргүй ажиллаж байсан байна.

**2.ИНЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журмын 3.3.3.б/2013 оны 11 дүгээр 26-ны өдрөөс өмнөх/ “Орон сууцны үнийн хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 2.1.1-д “ИНЕГ түүний харьяа байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан үндсэн ажилтан байх” гэсэн заалтыг зөрчиж орон сууцны хөнгөлөлт олгожээ. Үүнд:**

№	Овог нэр	Албан тушаал	ИНЕГ-т ажилласан жил	Олгосон хөнгөлөлт	Тайлбар
<b>2012 онд</b>					
1	С.Мандухайцэцэн	Шалгалтын нислэг зураглалын албаны цаг уурын мэргэжилтэн	4.6 жил	30,000,000	2012.03.29-ны өдрийн А/118
2	Ч.Сарантуяа	“Чингис хаан” ОУНБ-ын Үйлдвэрлэл зохицуулалт, хяналтын хэлтэст мэргэжилтэн	1.6 жил	30,000,000	2012.07.10-ны өдрийн А/250
3	Д.Туяацэцэг	Нисэхийн аюулгүй байдал хяналт зохицуулалтын албаны ажилтан	4.3 жил	30,000,000	2012.07.10-ны өдрийн А/250
4	Ц.Ган-Эрдэнэ	Захиргаа, аж ахуйн тасгийн Контор,	2	30,000,000	2012.07.23-ны өдрийн А/257

		барилга байгууламжийн аж ахуйн эрхлэгч			
5	Ө.Дашхорол	ХОХ-ийн инженер	3	30,000,000	2012.07.23-ны өдрийн А/257
6	М.Дашпунцаг	Говь-Алтай аймгийн Нисэх буудлын дарга	3	30,000,000	2012.07.23-ны өдрийн А/257
7	Ч.Батхуяг	ГТҮА-ны дарга	4	30,000,000	2012.07.23-ны өдрийн А/257
8	Б.Лхагва	ГТҮА-ны жолооч	2	30,000,000	2012.07.23-ны өдрийн А/257
9	А.Энхбаяр	ГТҮА-ны жолооч	4	30,000,000	2012.07.23-ны өдрийн А/257
10	Ц.Төрмөнх	ГТҮА-ны дотоод хяналтын инженер	3	30,000,000	2012.07.23-ны өдрийн А/257
11	Б.Оюунгэрэл	НЭСЗСЦ-ын дарга	2	30,000,000	2012.07.23-ны өдрийн А/257
12	М.Дэмбэрэл	"Чингис хаан" ОУБ-ын үйлчилгээний дэд дарга	2.2	30,000,000	2012.07.23-ны өдрийн А/257
13	С.Цэрэн-Ойдов	Нисэхийн музейн жижүүр	2	30,000,000	2012.10.04-ны өдрийн А/332
14	Д.Дашдорж	ГТҮА-ны Захиргааны хэлтсийн дарга	3	30,000,000	2012.12.04-ний өдрийн А/417
15	Х.Болор-Эрдэнэ	ЭЗБЗХэлтсийн дарга	3	30,000,000	2012.12.07-ний өдрийн А/420
16	С.Дэжид	Захиргаа, аж ахуйн тасгийн музейн жижүүр	2	30,000,000	2012.12.07-ний өдрийн А/420
17	В.Төгсжаргал	Захиргаа, аж ахуйн тасгийн мужаан	2	30,000,000	2012.12.07-ний өдрийн А/420
<b>ДҮН</b>				<b>510,000,000</b>	

**2013 онд**

1	Б.Батхуяг	Хөвсгөл нисэх буудлын сантехникийн механик	3	22,250,000	Мөн орон нутгийн 2 хүний хөнгөлөлтөнд олгохыг 1 хүнд
<b>Дүн</b>				<b>22,250,000</b>	

**2014 онд**

1	Л.Нэргүй	СЭЗГ-ын дарга	1	30,000,000	Эрхэлсэн ажилдаа онцгой амжилт гаргасан үндэслэлээр
2	М.Энхмаа	Ерөнхий нягтлан бодогч	1	30,000,000	Эрхэлсэн ажилдаа онцгой амжилт гаргасан үндэслэлээр
3	С.Содном	ЧХОУБ-ын албаны дарга	1	14,450,000	Гэр нь гал түймэрт өртсөн шалтгаанаар олгосон.
4	Ч.Сараа	АХХ-ийн орчуулагч	1	10,000,000	ЗТЯ-нд ажиллахаар шилжсэн гэсэн үндэслэлээр олгосон.
5	С.Энхзул	ШНЗА-ны бичиг хэргийн эрхлэгч	4	30,000,000	ШНЗА-ны дарааллын дагуу орсон.
6	Б.Жавзмаа	Музейн жижүүр	3	15,000,000	Гэр нь гал түймэрт өртсөн гэсэн шалтгаанаар олгосон.
7	Т.Отгонжаргал	СЗСЦ-ын сувилагч	2	30,000,000	Эмнэлэгийн байгууллагад олон жил үр бүтээлтэй хөдөлмөрлөж удаа дараагийн нисэх онгоцны ослоор хүнд бэртэж гэмтсэн нисэх багийн гишүүдийг эмчлэн сувилж хөл дээр нь босгоход гавьяа зүтгэл гаргасан төдийгүй Сэргээн засал, сувиллын цогцолборын залуу мэргэжилтнүүдийг сурган дадлагажуулах ажилд мэргэжлийн өндөр нэмэр оруулж буй гэсэн үндэслэлээр
<b>Дүн</b>				<b>159,450,000</b>	

**2015 онд**

1	Э. Удвал	ХЭЗДБГ-ын ахлах мэргэжилтэн байсан.	1	30,000,000	Эрхэлсэн ажилдаа онцгой амжилт гаргасан үндэслэлээр
2	Б.Батнасан	Жолоочоор ажиллаж байсан	3	22,000,000	2015.10.06-нд чөлөөлөгдсөн. 2015.11.04-ний өдрийн А/714
3	Ж.Бяхаржалбуу	Завхан аймгийн нисэх буудлын дарга	4	11,000,000	
4	Б.Ган-Очир	ЗУГ-ын даргаар ажиллаж байсан	1,9	25,000,000	
<b>Дүн</b>				<b>88,000,000</b>	

• **2016 онд**

1	Б.Молор-Эрдэнэ	ХЭЗДБГ-ын ахлах мэргэжилтэн байсан.	4.7	22,000,000	
	Дүн			22,000,000	

ИНЕГ, болон харьяа байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан байх гэсэн шаардлагыг зөрчин нийт 30 ажилтанд **801.7** сая төгрөгийн хөнгөлөлт олгосноос 2014 онд санхүүгийн аудитын дүгнэлтээр “Хязгаарлалттай санал дүгнэлт” авч үндсэн ажилдаа хариуцлагагүй хандсан 2014 онд 1 жил ажилласан СЭЗГ-ын дарга Л.Нэргүй, Ерөнхий нягтлан бодогч М.Энхмаа нарт “Онцгой амжилт гаргасан” үндэслэлээр байрны хөнгөлөлт олгосон тул **60.0 сая төгрөгийг буцаан төлүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоов.**

Мөн жолооч Б.Батнасан Газрын тусгай үйлчилгээний албанаас ирүүлсэн саналд нэр нь тусгагдаагүй, ИНЕГ-т 3 жил ажилласан, 2015.10.06-нд хөдөлмөрийн гэрээ цуцалж ажлаас халагдан чөлөөгдсөн байх боловч ИНЕГ-ын даргын 2015.11.04-ний өдрийн А/714 дүгээр тушаалаар ИНЕГ-ын Орон сууцны хөнгөлөлт үзүүлэх журам зөрчиж 22.0 сая төгрөг олгосон байна. Хөвсгөл аймгийн Нисэх буудлын сантехнекийн механик Б.Батхуяг ажилласан жилийн шаардлага хүрээгүй боловч 2 хүнд олгох мөнгө /орон нутгийн нэг хүнд 11,125.0 төгрөг/ 22,250.0 мянган төгрөгийг олгосон байна.

**3.2012-2017 онд орон сууцны үнийн хөнгөлөлтөд хамрагдсан ажилтнуудаас ажлаас чөлөөлөгдсөн байдлын талаар:**

Ажилтанд орон сууцны үнийн хөнгөлөлт олгох гэрээний 3.1.5-д “Орон сууц худалдан авахад нь дэмжлэг үзүүлснээс хойш 5 жилийн хугацаанд Ажилтны санаачлагаар буюу түүнээс хамаарч хөдөлмөрийн гэрээ цуцлагдах тохиолдолд орон сууц худалдан авахад болон орон сууцны зээлийн урьдчилгаа төлбөрийн тодорхой хэсгийг төлөхөд нь дэмжлэг үзүүлж олгосон хөрөнгийг ажилтнаас нэхэмжилж буцаан авна.” гэж заасныг зөрчин орон сууцны хөнгөлөлт аваад ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудаас олгосон хөрөнгийг ажилтнаас нэхэмжилж аваагүй зөрчил илэрлээ.

№	Овог, нэр	Албан тушаал	Орон сууцны асуудлаа шийдвэрлүүлсэн байдал	Ажлаас чөлөөлөгдсөн шалтгаан, огноо
1	Сономцэрэн Энх-Амгалан	ИНЕГ-ын Тэргүүн дэд дарга	2013.12.26 А/754 30.000.000 төгрөгний орон сууцны хөнгөлөлт эдэлсэн.	Албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласан. /ЗТС-ын 2014.10.13 №233 дугаар тушаалаар чөлөөгдсөн/
2	Чимэддорж Нямсайхан	ИНЕГ-ын Дэд дарга	2014.05.28 А/242 30.000.000 төгрөгний орон сууцны хөнгөлөлт	Өөрийн хүсэлтээр /ЗТС-ын 2015.01.15 №02 дугаар тушаал/
3	Чогсом Сараа	Агаарын харилцааны хэлтэс орчуулагч	2014.07.09 А/334 10.000.000 төгрөгний орон сууцны хөнгөлөлт эдэлсэн.	ЗТЯ-нд шилжин ажилласан. /ИНЕГ-ын даргын 2014.7.23 №6/111 дүгээр тушаал/ ЗТЯ-наас 2016 онд чөлөөлөгдсөн.
4	Цэрэнчимэд Эрдэнэбилэг	Эдийн засгийн зохицуулалтын хэлтсийн дарга	2009 онд орон сууцны дэмжлэг 24 сая төгрөг, 2014.06.11 А/278 30.000.000 төгрөгний хөнгөлөлт	Өөрийн хүсэлтээр /ИНЕГ-ын даргын 2014.6.24 №6/96 дугаар тушаал/
5	Мөөсөө Энхмаа	Ерөнхий хянагч бөгөөд ерөнхий нягтлан бодогч	2014.12.25 А/713 тушаалаар 30.000.000 төгрөгний орон сууцны хөнгөлөлт эдэлсэн.	Өөрийн хүсэлтээр /ИНЕГ-ын даргын 2015.04.16 №6/65 дугаар тушаал/
6	Лувсан Нэргүй	СЭЗГ-ын дарга	2014.12.25 А/713 30.000.000 төгрөгний орон сууцны хөнгөлөлт	Өөрийн хүсэлтээр /ИНЕГ-ын даргын 2015.01.07 №6/01 дүгээр тушаал/

7	Эрдэнэтостын Удвал	ХЭЗГ-ын ахлах мэргэжилтэн	2015.04.02 А/134 30.000.000 төгрөгний орон сууцны хөнгөлөлт	Орон тоо хасагдсан./ИНЕГ-ын даргын 2015.07.03 №6/141 дүгээр тушаал/
<b>Сэргээн засал, сувиллын цогцолбор</b>				
8	ГанбэхАмгалан зул	Сэргээн засал сувиллын цогцолборын зохион байгуулагч	2014.11.03 А/593 30.000.000 төгрөгний орон сууцны хөнгөлөлт эдэлсэн.	Өөрийн хүсэлтээр /СЗСЦ-ын даргын 2016.09.15-ны өдрийн Б/36 дугаар тушаал/
<b>Газрын тусгай үйлчилгээний алба</b>				
9	БанзрагчТамир	Жолооч	ГҮА-ны даргын зөвлөлийн хурлын шийдвэрээр- 2013.12.19, 10.000.000 төгрөгний орон сууцны хөнгөлөлт	Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн./ГҮА-ны даргын 2015.10.28 Б/109-р тушаал/
10	БатжаргалБатн асан	Жолооч	2015.11.04 А/714 22.000.000 төгрөгний орон сууцны хөнгөлөлт	Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн. /ГҮА-ны даргын 2015.10.07 Б/99-р тушаал/
11	Жаргалын Ариунтунгалаг	Нягтлан бодогч	2015.11.04 А/714 22.000.000 төгрөгний орон сууцны хөнгөлөлт	Өөрийн хүсэлтээр 2016 онд ажлаас чөлөөлөгдсөн. /ГҮА-ны даргын 2016- 05-02. Б/79-р тушаал/
12	Цоолойгийн Энхээ	Жолооч	ГҮА-ны даргын зөвлөлийн хурлын шийдвэрээр- 2013.12.19, 15.000.000 төгрөгний орон сууцны хөнгөлөлт	Хөдөлмөрийн чадвар алдаж группэд орсон. /ГҮА-ны даргын 2014.07.01 Б/84-р тушаал/
<b>"Чингис хаан" Олон улсын нисэх буудал</b>				
13	Сундуйн Содном	Зорчигч үйлчилгээний албаны дарга	2014 онд 25.0 сая төгрөгний орон сууцны хөнгөлөлт эдэлсэн.	Бүтцийн өөрчлөлтөөр 2015.02.23- наас ажлаас чөлөөлөгдсөн.
<b>Орон нутгийн нисэх буудал</b>				
14	Дондовын Учралт	Баянхонгор нисэх буудлын сумлагчийн жолооч	2013 оны 12 сард 13.500.000 төгрөгний орон сууцны хөнгөлөлт эдэлсэн.	Ажлын байранд удаа дараа архи ууж сахилгын зөрчил гаргасан. /2014.08.13 Нисэх буудлын даргын А/31 тоот тушаалаар/
15	Базаргарьдын Баттөгс	Баянхонгор нисэх буудлын шатахууны лаборант -нярав	2013 оны 12 сард 13.500.000 төгрөгний орон сууцны хөнгөлөлт эдэлсэн.	НБ-ын даргын 2015.12.07-ны А/51 тоот тушаалаар шатахуун дутааж, өмч хөрөнгө шамшигдуулж ажлаас халсан. боловч шүүхээр 4-5 удаа явж эвлэр-лийн гэрээгээр уурын зууханд ажиллах хүсэлт гаргаж одоо уурын зууханд түр ажиллаж байна.
16	Цэцгээгийн Шинэбаяр	Баянхонгор нисэх буудлын Аэродромын сахиул	2013 оны 12 сард 13.500.000 төгрөгний орон сууцны хөнгөлөлт эдэлсэн.	Орон тооны цомхотголоор /2016.03.14 Нисэх буудлын даргын Б/06 тоот тушаалаар/
<b>Нийт дүн:</b>			<b>348,500,000 төгрөг</b>	

Нийт **348.5** сая төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн 16 ажилтан албан хаагчид ажлаас чөлөөлөгдсөн нь тогтвор суурьшилтай 5 жил ажиллах заалтыг зөрчиж байна.

4.Орон сууцны үнийн хөнгөлөлт авсан ажилтнуудаас Иргэний нисэхийн үндсэн ажилтан байх заалтыг зөрчин ЗТБХБЯамны 11 ажилтанд 150.0 сая төгрөг, Сангийн яамны 3 ажилтанд 90.0 сая төгрөг, "Изинис айрвейз" ХХК-ийн дэд дарга С.Хүрэлбаатарт -10.0 сая төгрөг, 2014-2015 онд ЗТЯ-ны 5 ажилтанд 80,0 сая төгрөг, нийт 330.0 сая төгрөг олгосон байна.



5.ИНЕГ-ын даргын баталсан “Орон сууцны үнийн хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 3.6-д “Амьдралын хүнд нөхцөлд амьдарч байгаа ахмад настанд хүсэлтийг харгалзан 5 хүртэл сая төгрөгийн дэмжлэг үзүүлж болох ба зохих зардлыг ахмадын сангаас зарцуулна” гэсэн заалт байгаа боловч орон сууцны хөнгөлөлт олгох талаар заагүй байна. Гэтэл 2 ахмад настанд /Б.Хоролжав-25,0, Д.Даваад-20,0/ 45.0 сая төгрөгийн орон сууцны хөнгөлөлт олгосон.

**6.Орон сууцны хөнгөлөлтийгнэг гэр бүлийн 2 хүнд давхардуулан олгосон зөрчил:**

№	Овог нэр	Албан тушаал	Орон сууцны асуудлаа шийдвэрлүүлсэн байдал	Гэр бүлийн хүний овог нэр	Хаана ажиллаж байсан Албан тушаал	Орон сууцны асуудлаа шийдвэр-лүүлсэн байдал
1	Дашжамцын Мөнхбагана	Шалгалтын нислэгийн шалгагч нисэгч	2014.05.28-ны А/242 тушаалаар 27,000,0000 төгрөг	Эхнэр Ганбэхийн Амгаланзул	Сэргээн засах сувилалын зохион байгуулагч байсан	2014.11.03-ны А/593-р тушаалаар 30,000,000 төгрөг
2	Нойсүрэнгийн Гантуяа	“Чингис хаан” ОУНБ-ын Аюулгүй байдлын шалгагч	2014.07.09-ний А/333 дугаар тушаалаар 30,000,000 төгрөг	Нөхөр Баастын Баянмөнх	ГТҮА-ны жолооч	2011.12.21-ны Б/181 дүгээр тушаалаар 30,000,000 төгрөг
3	Мөөсөөгийн Энхмаа	ИНЕГ-ын ерөнхий нягтлан бодогч байсан	2014.12.25-ны А/713 дугаар тушаалаар 30,000,000 төгрөг	Нөхөр Чимэд-Очирын Эрдэнэбат	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албанд нислэг удирдагч	2011.12.21-ны Б/181 дүгээр тушаалаар 30,000,000 төгрөг
Дүн			87,000,000		Дүн	90,000,000

Дээрхи байдлаар 3 гэр бүлийн 6 хүнд давхардуулан олгосон байна.

**7.Нийслэлийн Татварын газрын улсын байцаагчийн тавьсан актыг төсвийн мөнгөнөөс төлсөн зөрчил илэрлээ.**

Нийслэлийн Татварын газраас тус газрын 2008-2012 оны татварын ногдуулалт төлөлтийн байдалд шалгалт хийж 21,409.2 сая төгрөгийн зөрчилд 2,105.8 сая төгрөгийн нөхөн татвар, 631.7 сая төгрөгийн торгууль, 683.3 сая төгрөгийн алданги нийт 3,420.9 сая төгрөгийн төлбөр ногдуулсныг тус газраас Татварын маргаан таслах комисст хандан 2,384.4 сая төгрөгийг ИНЕГ-т хариуцуулсан ба дээрхи төлбөрийг эс зөвшөөрч шүүхэд хандсан байна.Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүхийн 2015 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн тогтоолоор ИНЕГ-аас 2008-2012 онд орон сууцны хөнгөлөлтөнд олгосон 14,034.5 сая төгрөгийн 10 хувь болох 1,403.5 сая төгрөгийг 2016 онд байгууллагын зүгээс төлж үргүй зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-д заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараахь байдлаар хэрэгжүүлнэ.”, 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэснийг зөрчсөн тул 1,403.5 сая төгрөгийг хувь хүмүүсээр төлүүлж байгууллагыг хохиролгүй болгохоор улсын байцаагчийн албан шаардлага өглөө.

**Арав. ЦАЛИН ХӨЛСНИЙ ТАЛААР:**

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 43 дугаар тогтоолоор Иргэний нисэхийн ерөнхий газар /агентлаг-ын/ орон тоог 125 баталсан ба

Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /НТОЗШША/-ны 10 орон тоог хасаад ИНЕГ-ын орон тоо өмнө нь байсан буюу ЗТБХБ-ын сайдын 2010 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 156 дугаар тушаалаар батлагдсан орон тоо болох 115 хэвээр мөрдөгдөж ирсэн байна.

Зам, тээврийн сайдын 2012 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 16 дугаар тушаалаар НТОЗШША-ны зохион байгуулалтын бүтцийг батлаж, орон тооны дээд хязгаарыг 10-аар тогтоосон байна.

Зам, тээврийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 68 дугаар тушаалаар ИНЕГ-ын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан ба ИНЕГ-ын даргын 2013 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр А/144 дүгээр тушаалаар агентлагын орон тоог 113 орон тоогоор баталсан байна.

Мөн Засгийн газраас 2014.12.15-ны өдөр "Засгийн газрын агентлагын талаар авах зарим арга хэмжээний тухай" 387 дугаар тогтоолоор ИНЕГ-ын орон тоог 106, 2015.12.21-ний өдрийн "Засгийн газрын агентлаг, төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 501 дүгээр тогтоолболон Засгийн газрын 2016.07.27-ны өдрийн "Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 4 дүгээр тогтоолоор ИНЕГ-ын орон тоог 106-гаар хэвээр баталсан байна.

ИНЕГ-ын дарга нь ИНЕГ болон түүний харьяа байгууллагуудын бүтэц орон тооны асуудлаар 2012 онд 46 тушаал, 2013 онд 55 тушаал, 2014 онд 29 тушаал, 2015 онд 83 тушаал, 2016 онд 84 тушаал, 2017 онд 19 тушаал шийдвэр гаргасан байна.

**Арван нэг. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР БОЛОН БАЙГУУЛЛАГЫН ЦЭВЭР АШИГ,  
УРСГАЛ ЗАРДЛААР САНХҮҮЖҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ,  
ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮНГИЙН ТАЛААР**

Иргэний нисэхийн ерөнхий газар нь улсын төсвийн хөрөнгөөр болон байгууллагын цэвэр ашиг, урсгал зардлын эх үүсвэрээр хийгдсэн хөрөнгө оруулалт, худалдан авалтын үйл ажиллагааг ихэвчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж хэрэгжүүлжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар **2012 онд** нийт 66 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээс 21 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, 18.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн байна. Тайлант онд 2011 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас 11 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээс 16 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж 1.1 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгджээ.

**2013 онд** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 43 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээс 26 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 7 төсөл, арга хэмжээ он дамжин гүйцэтгэгдэж, 10 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг Худалдан авах ажиллагааны газраас шалгаруулж ирүүлээгүй тул хийгдээгүй байна. Дээрхи хөрөнгө оруулалтын ажилд гүйцэтгэлээр 11.8 төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. Энэ онд ИНЕГ-ын 2012 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас нийт 45 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, бүрэн

хэрэгжүүлж дууссан бөгөөд 4.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт хийгджээ.

**2014 онд** улсын төсвийн хөрөнгөөр 36 төсөл арга хэмжээнд 158,947.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээс тухайн онд санхүүжих 44,201.2 сая төгрөгийг санхүүжүүлэхээс 30,685.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Тайлант онд 17 төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, 2 төсөл арга хэмжээ гэрээний дагуу үргэлжлэн хийгдэж, байна. Монгол улсын Засгийн газрын 2014 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 291 дүгээр тогтоолын:

1.1-д Улсын төсвийн орлогын бүрдүүлэлттэй уялдуулан мөнгөн хөрөнгийн зохицуулалтын хүрээнд санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийг бууруулан зохицуулж байх;

1.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний сахүүжилтийг банкны урьдчилгаа төлбөрийн баталгаагаар олгохыг зогсоох;

2.2. Улс, орон нутгийн төсвийн урсгал болон хөрөнгийн зардлаар 9 дүгээр сарын 19-нөөс хойш хийгдсэн, худалдан авахаар төлөвлөсөн бараа, ажил, үйлчилгээний тендер зарлах, дүгнэх, гэрээ байгуулах ажлын санхүүжилтийг энэ оны төсвөөс санхүүжүүлэхгүй байх, ирэх оны төсвийн төсөлд тусган хэрэгжүүлэх бэлтгэлийг хангаж ажиллах гэсэн заалтуудын дагуу хэрэгжих боломжгүй болсон 9 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй болж хойшлогдож, нийт 31.1 тэрбум төгрөгийн төсөл хэрэгжихээс, 25.3 тэрбум төгрөгийн буюу 81.4 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.

Хэрэгжүүлсэн томоохон ажлуудаас дурдвал: зай хэмжих төхөөрөмж /DME/ сайтад 10 комыг худалдан авч суурилуулуулан хүлээн авчээ. Ажиглалтын радиолокаторын тоног төхөөрөмж 2 иж бүрдлийг нийлүүлж, суурилуулах, түүний барилга байгууламж, дэд бүтэцтэй холбоотой томоохонтөсөл арга хэмжээг нээлттэй тендер зарлан гүйцэтгэгчийг сонгон гүйцэтгүүлжээ. Нисэх буудлуудын цаг уурын автомат системийг 11 нисэх буудалд шинэчлэн суурилуулж хүлээн авч, туршсан байна. Алсын удирдлага бүхий хэт богино долгионы 2 сувгийн радио станцын /RCAG/ шинэчлэл, суурилуулалт, 6 иж бүрдэлийг 6 сайтад нийлүүлж суурилуулсан. Ажиглалтын ADS/B-ES /dual channel/ систем, түүний зангилаа төв систем, программ хангамжийг суурилуулах ажлыг 5 сайтад нийлүүлж суурилуулжээ. Агаарын навигацын тоног төхөөрөмжүүдийн цахилгаан тэжээлийн хангалтын иж бүрэн системчлэгдсэн тоног төхөөрөмжүүдийг нийлүүлж суурилуулсан байна.

Ойртолтын болон супервайзер ажлын байруудыг шинээр худалдан авч суурилуулсан, мөн ATN router нийлүүлэх суурилуулах /үндсэн/ нөөцийг худалдан авч суурилуулж бэлэн болгожээ.

Баянхонгор аймгийн хөөрч буух хатуу хучилттай зурвасны гадаргууд хэсэгчилсэн засварын ажлыг, Өмнөговь аймгийн “Говь гурван сайхан” НБ-ын хөөрч, буух хатуу хучилттай зурвасын эвдрэл гэмтэлд халуун асфальтбетоноор нүхэн засвар зэрэг ажлуудыг бүрэн хийж гүйцэтгүүлэн хүлээн авсан зэрэг ажлууд хийгджээ.

ИНЕГ-ын 2013 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас санхүүжүүлэхээр 40 төсөл, арга хэмжээг төлөвлөж ажилласнаас бүрэн хэрэгжүүлсэн 15, гэрээний дагуу хэрэгжиж байгаа 6, сонгон шалгаруулалт нь хийгдэж гэрээ байгуулсан 2 төсөл мөн Засгийн газрын 2014 оны 291 дүгээр тогтоол гарснаар хэрэгжих боломжгүй болсон 17 төсөл арга хэмжээ байна. Цэвэр ашгаас нийт 7.9 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээс 4.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллажээ.

Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр болон өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн нийт 75 төсөл арга хэмжээний сонгон шалгаруулалтыг нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулж, захиалагчийн хяналтыг тодорхой түвшинд тавьж хэрэгжүүлэн ажиллажээ.

2015 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6 төсөл, арга хэмжээг 2,292.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр хэрэгжүүлэхээр батлагдсан байна. Эдгээр арга хэмжээнүүдээс "MASCOM-VSAT сансрын холбооны төв станц болон 11 алсын станцын хамт IDU төхөөрөмжүүдийг нийлүүлэх, суурилуулах /11 ком/ Баян-Өлгий, Ховд, Ховдын Булган, Завханы Доной, Хөвсгөлийн Хатгал, Баянхонгор, Хархорин, Мандалговь, Даланзадгад, Баруунтуруун", "Зай хэмжих төхөөрөмж /DME/ нийлүүлж суурилуулах /10 ком/ ажлуудыг бүрэн хэрэгжүүлж 2015 оны улсын төсөвт тусгагдсан 683.4 сая төгрөгөөр санхүүжүүлж дуусгажээ. Говь-Алтай, Завхан аймгуудын нисэх буудлын хөөрч буух хатуу хучилттай зурвасыг үерийн далангийн хамт хийх ажлууд нь 2008 оноос хийгдэж байгаа бөгөөд 2015 оны улсын төсөвт нийт 837.0 сая төгрөг суусан боловч гэрээг дүгнэж, гэрээний хугацааг 2015 оны 8 дугаар сард гэрээг сунгасан тул, 2015 онд ажлыг гүйцэтгэх боломжгүй болжээ. Нэмэлт гэрээний хугацаа нь 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдөр дуусчээ.

Тухайн онд Бүсийн нислэг хөдөлгөөний удирдлагын төвийн барилга, тус барилгын гадна дэд өртөө, гадна цахилгаан, гадна холбооны ажлуудад улсын төсөвт нийт 772.2 сая төгрөгийг суулгасан боловч ажил хийгдэлгүй, төсвийн жил дууссан байна.

Зам, тээврийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 127 дугаар тушаалаар батлагдсан ИНЕГ-ын 2013 оны цэвэр ашгийн үлдэгдлээс санхүүжих төсөл, арга хэмжээний жагсаалтаар 4,746.3 сая төгрөгийн 21 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 15 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж дууссан ба 2 төсөл, арга хэмжээ үргэлжлэн хийгдэж, тухайн төсвийн жилд 3,318.8 сая төгрөгийн санхүүжилт хийгджээ. Энэ онд хоёрдох удаагаа тендер зарлан нээгээд үнэлж байгаа 1, шууд гэрээ байгуулсан 1 төсөл арга хэмжээ үргэлжилж байна.

Зам, тээврийн сайдын 2015 оны 263 дугаар тушаалаар 2014 оны цэвэр ашгаас санхүүжүүлэх 18,970.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 26 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж батлуулжээ. Гүйцэтгэлийг авч үзэхэд 5 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж дууссан ба гэрээ байгуулагдан ажил үргэлжилж байгаа 5, гэрээ байгуулах шатандаа байгаа 7, тендерийн үнэлгээ хийж байгаа 5, нээхээр бэлтгэж байгаа 1, ТББ-ыг боловсруулж байгаа 2, өмнөх нийлүүлэгчтэй хэлэлцээ хийж байгаа 1 төсөл арга

хэмжээнүүд байна. Бүрэн хэрэгжүүлсэн, эхэлж байгаа болон хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний санхүүжилтэнд нийт 10,121.7 сая төгрөгийг олгосон байна.

ИНЕГ-ын үйлдвэрлэлийн албадын 2015 оны батлагдсан урсгал зардлын санхүүжилтийн эх үүсвэрээр 2,488.8 сая төгрөгийн 25 төсөл арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулан 72 төсөл, арга хэмжээг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж ажиллажээ.

2016 онд Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн бүтэцэд өмнөх онд Хөрөнгө оруулалтын тасаг нэртэйгээр ахлах эдийн засагч 1, инженер 4, мэргэжилтэн 4, нийт 9 хүний орон тоотойгоор ажиллаж байсан бол Зам тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 70 дугаар тушаалын хавсралтаар баталсан ИНЕГ-ын бүтэц, зохион байгуулалтыг шинээр батлахдаа Худалдан авах ажиллагааны хэлтэс болгон менежер 1, мэргэжилтэн 3 нийт 4 хүний орон тоотойгоор худалдан авалт хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавих чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

Тус хэлтэс нь тайлант онд Улсын төсвийн хөрөнгөөр болон Хөгжлийн банкны /эргэн төлөгдөх нөхцөлтэй/ эх үүсвэрээр, мөн 2015 оны цэвэр ашиг, урсгал зардлаар санхүүжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон түүнийг хэрэгжүүлэхээр гарсан холбогдох журам, аргачлалын дагуу зохион байгуулж ажилласан байна.

#### ИНЕГ-т 2016 онд хөрөнгө оруулалтын эх үүсвэр

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Төсөл арга хэмжээний тоо	Батлагдсан төсөв /тэрбум төгрөгөөр/
1	Улсын төсвийн хөрөнгөөр	87	13,5
2	Хөгжлийн банкны эх үүсвэрээр	6	2,2
3	2015 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас	26	4,9
4	Урсгал зардлаар	22	2,5
<b>Дүн</b>		<b>141</b>	<b>23,1</b>

Иргэний нисэхийн ерөнхий газарт 2016 онд 23.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн нь нийт эх үүсвэрээр 58.0 хувь буюу 13.5 тэрбум төгрөг, цэвэр ашгаас 21.0 хувь буюу 4.9 тэрбум төгрөг, урсгал зардлаар 11.0 хувь буюу 2.5 тэрбум төгрөг, Хөгжлийн банкнаас 10.0 хувь буюу 2.2 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ.

Тайлант онд ЗТХСайдын 2016 оны 156 тоот тушаалаар баталсан ИНЕГ-ын 2015 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний талаар: Нийт 4.9 тэрбум төгрөгийн 26 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 23 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 4.7 тэрбум төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээг байгуулж бүрэн хэрэгжүүлсэн байна.

Улирлын байдлаас шалтгаалдаг 3 төсөл арга хэмжээг түр зогсоож дараагийн онд хийхээр шийдвэр гаргажээ. Урсгал зардлаар хийх төсөл арга хэмжээний хувьд нийтдээ 2.5 тэрбум төгрөгийн 22 төсөл арга хэмжээг хуулийн дагуу хэрэгжүүлж, гэрээг дүгнэн хүлээн авсан байна.

Зам тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 44 дүгээр тушаалаар батлагдсан ОУ-ын шинэ нисэх буудал барихтай холбогдуулж Хөгжлийн банкны эх үүсвэрээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 2016 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт дараах байдалтай байна. /Хүснэгтээр харуулбал/:

№	Тухайн жилд худалдан авсан бараа ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөвт өртөг /сая.төг/	Гэрээний дүн /сая. төг/	Тайлбар, тодруулга
1	Тавилга, эд хогшил	459.4	387.2	Бүрэн хэрэгжсэн
2	Компьютер, техник хэрэгсэл	199.0	199.0	Бүрэн хэрэгжсэн
3	Багаж, тоног төхөөрөмж	333.4		2 удаа НТ зарласан боловч амжилтгүй болсон тул шууд гэрээ байгуулах ҮХ-ны зөвлөмж гарсан боловч 2016 ондоо хэрэгжих боломжгүй болсон.
4	Дунд оврын автобус 1 ширхэг	130.0		2 удаа нээлттэй тендерээр зарласа амжилтгүй болсон тул шууд байгуулах ҮХ-ны зөвлөмж гарсан боловч 2016 ондоо хэрэгжих боломжгүй болсон.
5	Бага оврын автобус 1 ширхэг	60.0		Бүрэн хэрэгжсэн.
6	Олон улсын шинэ нисэх буудлын навигацын тоног төхөөрөмж болон шинээр зохиогдох нислэгийн журмыг шалгалтын нислэгээр шалган баталгаажуулалт, гэрчилгээжүүлэлт хийх ажил.	1,000.0	489.6	Багц 1: дүн- 489 634 717 төг Тоног, төхөөрөмжүүдийг шалгалтын нислэгээр шалган баталгаажуулалт, гэрчилгээжүүлэлтийг хийхээр шалгарсан "Геосан" ХХК-тай гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлж байна. Багц 2: Нислэгийн журмыг шалгалтын нислэгээр шалган баталгаажуулалтыг гүйцэтгэх гүйцэтгэгчид шаардлага хангасан нэг ч тендер ирүүлээгүй тул "МИАТ" ТӨХК-тай ШГБ-аар ажиллаж байна.
Нийт дүн		2,181.8	1,075.8 /1,075,834,717 Төгрөг/	

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 99, /хуучнаар 170/ тоот тушаалаар батлагдсан "АСЕМ"-ийн 11 дүгээр чуулга уулзалтын аюулгүй байдлыг хангах зориулалттай ИНЕГ-ын тоног төхөөрөмж"-ийн худалдан авалтын гүйцэтгэлийн талаар Үүнд:

Нийт 87 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээс 5,125.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27 төсөл, арга хэмжээг гэрээний дагуу 4,940.0 сая төгрөгөөр бүрэн хэрэгжүүлсэн байна. Мөн ажлын гүйцэтгэлийг шалгаж, гэрээг дүгнэн хүлээн авч байгаа 1,474.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл арга хэмжээг 1,372.3 сая төгрөгөөр гүйцэтгүүлжээ.

Тайлант онд ажил дуусаагүй, гүйцэтгүүлж байгаа 786.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл арга хэмжээг 754.6 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр сонгон шалгаруулалт

хийж гэрээ байгуулсан ажилласан байна. Мөн 728.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээг 634.8 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулжээ.

Тайлант онд хэрэгжих боломжгүй болсон 3,725.7 сая төгрөгийн төсөв өртөг бүхий 17 төсөл, арга хэмжээг ондоо багтаан хэрэгжүүлэх боломжгүй болжээ. ЗТХСайдын 2016 оны 99 тоот тушаалаар нэмэгдсэн 25 төсөл, арга хэмжээний 1,660.0 сая төгрөгийн эх үүсвэрийг хэрэгжүүлээгүй үлдсэн байлаа. Нийтдээ гэрээ байгуулж, хэрэгжүүлсэн 45 төсөл, арга хэмжээнээс 410.1 сая төгрөгийг улсын төсвийн эх үүсвэрээс хэмнэж, гүйцэтгэгч нартай байгуулсан гэрээний хэрэгжилтийн үр дүнгээр /7 гүйцэтгэгчээс/ 29.7 сая төгрөгийн алданги тооцсон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 13.5 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээс гүйцэтгэлээр 5.2 тэрбум төгрөг, цэвэр ашгаар 4.9 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээс гүйцэтгэлээр 4.7 тэрбум төгрөгийг зарцуулсан, Хөгжлийн банкны эх үүсвэрээр 2.2 тэрбум төгрөгийн худалдан авалт хийхээс гүйцэтгэлээр 1.2 тэрбум төгрөгийг, урсгал зардлаар 2.5 тэрбум төгрөг зарцуулахаас 100.0 хувь хэрэгжүүлж 2.5 тэрбум төгрөгийг тус тус зарцуулжээ.

**2017 оны 3 улирлын байдлаар:** Улсын төсвийн санхүүжилтээр хийгдэж буй төсөл арга хэмжээ Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын 13.2.1.3.1 дэх заалт, Зам тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 85 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу 2.9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 19 төсөл, арга хэмжээ, 13.2.1.1.3 дах заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 191 тоот тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу 2.9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 10 төсөл, арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журмын хүрээнд зохион байгуулж, хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

2017 онд улсын төсвийн хөрөнгөөр нийт 31 төсөл, арга хэмжээнд 6,532.2 сая төгрөгийн эх үүсвэр төлөвлөгдсөнөөс 2017 оны 11 дүгээр сарын 01-ны байдлаар 15 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 2,683.6 сая төгрөгийн санхүүжилт олгогджээ. Энэ нь нийт санхүүжилтийн 41.0 хувийн гүйцэтгэлтэй байгааг хүснэгтээр харуулбал:

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл

№	Төсөл, арга хэмжээний нэр	/сая.төг/					
		Төлөвлөсөн		Гүйцэтгэл		Биелэлтийн хувь	
		Төслийн Тоо	өртөг	Төслийн тоо	Санхүүжилт	Төслийн тоо	Санхүүжилтийн хувь
1	Нисэх буудлын онгоц хөөрч, буух Хатуу хучилттай зурвас, үерийн далан /Говь-Алтай аймаг/	1	492.1	1	483.3	100	98.2
2	Нисэх буудлын онгоц хөөрч буух хатуу хучилттай зурвас, үерийн далан /Завхан	1	344.9	-	-	-	-
3	ОУ-ын шинэ нисэх буудал барихтай холбогдуулан Монголын талын гүйцэтгэх төсөл, арга хэмжээ	10	2,895.4	-	-	-	-

4	АСЕМ-ын чуулга уулзалтын аюулгүй Байдлыг хангах зориулалттай тоног төхөөрөмжийн жагсаалт	19	2,801.3	14	2,200.3	74.0	79.0
Нийт дүн		31	6,532.2	15	2,683.6	48.0	41.0

Говь-Алтай аймгийн нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвасын ажил олон жил дамжин хийгдэж, 2016 онд бүрэн дууссан байна. Харин Завхан аймгийн нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвасын /2008-2013 онд дуусах/ ажил - Үлдэгдэл ажлын тоо хэмжээг баталгаажуулан нэмэлт гэрээг байгуулахаар Зам тээвэр хагжлийн яаманд хандсан. Уг ажлын үндсэн гэрээг Зам, тээврийн яам /тухайн үеийн/ баталсан байдаг тул нэмэлт гэрээг ИНЕГ-т байгуулах эрх зүйн үндэслэлгүй шалтгааны улмаас гэрээний хэрэгжилт зогсчээ.

Зам тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 191 дүгээр тушаалаар батлагдсан “Олон улсын шинэ нисэх буудал барихтай холбогдуулан Монголын талын гүйцэтгэх төсөл, арга хэмжээ” төсөл. Уг тушаалыг ЗТХЯ-ны бодлого, төлөвлөлтийн газрын даргын 2017 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 04/4227 тоот албан бичгээр 2017 оны 10 дугаар сарын 02-ны өдөр ИНЕГ-т ирүүлсэн байна. Нийт хэрэгжүүлэх 10 төсөл, арга хэмжээнд зарцуулах 2,895.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээний гүйцэтгэл дараах байдалтай байна.

№	Үзүүлэлт	Ажлын тоо	Төсөвт өртөг /сая.төг/	Санхүүжилт
1	Гэрээ байгуулан ажиллаж байгаа	1	1,000.0	-
2	Тендер зарлагдсан	5	1,325.2	-
3	Үнэлгээний хороо байгуулагдан техникийн тодорхойлолт бэлтгэж байгаа	4	570.2	-
Нийт дүн		10	2,895.4	-

Олон улсын шинэ нисэх буудлын навигацын тоног төхөөрөмж болон шинээр зохиогдох нислэгийн журмыг шалгалтын шалгалтын нислэгээр шалган баталгаажуулах ажил. Уг ажлын навигацын тоног төхөөрөмжийг шалган баталгаажуулах хэсгийг 489.6 сая төгрөгөөр “Геосан” ХХК-иар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. Шинээр зохиогдох нислэгийн журмыг шалгалтын нислэгээр шалган баталгаажуулах ажлыг МИАТ компаниар үйлдүүлэхээр Үнэлгээний хорооны зөвлөмж гарсан боловч тоног төхөөрөмжийг шалган баталгаажуулсаны дараа нислэгийн журмын дагуу шалгалтын нислэг үйлдэхээр хойшлуулжээ.

Олон улсын шинэ нисэх буудлаас дулааны станц хүртэлх 2,9 км хатуу хучилттай авто зам, хяналтын зөвлөх үйлчилгээ, замын зураг төсөл боловсруулах 3 ажлыг багцлан ИНЕГ-ын 2017 оны 10 сарын 11-ний өдрийн 644 тоот тушаалаар томилогдсон ҮХ нээлттэй тендер зарлан 12- дугаар сарын 04-ний өдөр нээхээр ажиллаж байлаа. “Багаж, төхөөрөмж ” ажлыг ИНЕГ-ын даргын 2017 оны 10 дүгээр сарын 11-ний өдрийн 648 тоот тушаалаар томилогдсон үнэлгээний хороо НТ-ийг зарлан, 11 сарын 30-ны өдөр нээхээр, “Дунд оврын автобус 1 ширхэг” ажлыг ИНЕГ-ын 2017 оны 10 сарын 11-ны өдрийн 647 тоот тушаалаар томилогдсон Үнэлгээний хороо нээлттэй тендер зарлан 11 сарын 27-ны өдөр нээхээр тус тус ажиллаж байна. Үнэлгээний хороо байгуулагдан техникийн тодорхойлолт бэлтгэж буй ажил нь “Ландшафт / барилга, байгууламжийн гадна зүлэгжүүлэлт, тохижилт/ ажил” ИНЕГ-



ын 2017 оны 10 сарын 17-ны өдрийн 664 тоот тушаалаар томилогдсон Үнэлгээний хороонд тендерийн бичиг баримт боловсруулах ажил хийгдэж байна.

АСЕМ-ийн чуулга уулзалтын аюулгүй байдлыг хангах, зориулалттай тоног төхөөрөмжийн жагсаалтад 19 ажил, үйлчилгээг 2,801.3 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 14 ажил нь бүрэн хийгдэж, 2,200.3 сая төгрөгийн санхүүжилт олгогджээ.

№	Үзүүлэлт	Тоо	Төсөвт өртөг	Гүйцэтгэл
1	Бүрэн дууссан	14	2,200.3	2,200.3
2	Ажлыг хүлээн авч	2	316.8	
3	Шүүхийн шийдвэрээр	1	47.9	
4	Гэрээ цуцлагдаж, дахин тендер зарлагдсан	2	165.8	
5	Барьцаа төлбөр		70.5	
<b>Нийт дүн</b>			<b>2,801.3</b>	<b>2,200.3</b>

Шүүхийн шийдвэрээр “Агаарын хөлгийн дугуйн ивүүр 300 ширхэг” нийлүүлэх ажлыг хүлээн авах комисс нь уг ивүүрүүдийг шаардлага хангахгүй гэж хүлээн аваагүй боловч шүүхийн шийдвэрээр ивүүрүүдийг хүлээн авч, төлбөрийг төлүүлэх шийдвэр гарч хэрэгжүүлсэн байна. Гэрээ цуцлагдсан 2 ажил нь валютын ханшийн өсөлтөөс шалтгаалан гэрээ хийсэн компани нийлүүлэх болж, тендерийг дахин нээлттэй зарлажээ.

Цэвэр ашгаас санхүүжүүлж хийсэн ажлуудын талаар.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 137, мөн оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 207 тоот тушаалуудаар тус тус батлагдсан “Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт” төлөвлөгөөний дагуу 29 төсөл, арга хэмжээг 9,331.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Байгууллагын цэвэр ашгаас 2017 онд хийгдсэн төсөл,  
арга хэмжээний гүйцэтгэл

№	Төсөл, арга хэмжээний нэр	төлөвлөсөн		гүйцэтгэл		/сая.төг/ Биелэлтийн хувь	
		Төслийн тоо	өртөг	Төслийн тоо	Санхүүжилт	Төслийн тоо	Санхүүжилтийн хувь
1	Бүрэн дууссан	5	279.7	5	270.9	100.0	97.0
2	Гэрээ байгуулсан, ажил нь хийгдэж Байгаа	1	125.0				
3	Тендерийн үнэлгээ хийж байгаа	3	1,498.0				
4	Үнэлгээний хороо байгуулагдсан	12	882.3				
5	Ажил нь зогссон байгаа	2	6,399.9				
<b>Нийт дүн</b>		<b>29</b>	<b>9,331.0</b>	<b>5</b>	<b>270.9</b>	<b>17.0</b>	<b>3.0</b>

ЗТХСайдын тушаалаар тайлант онд байгууллагын хуримтлагдсан ашгаас санхүүжүүлж хийх, төсөл арга хэмжээний төлөвлөгөөг хоёр дахин өөрчлөгдөж баталсан байх тул, тендер зарлах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлууд оны төгсгөл рүү шахагдсан цаг хугацаанд нь хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болсон байна. 2017 оны 11 дүгээр сарын 01-ны байдлаар бүрэн хийгдсэн 5 ажлыг 279.7 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна. Тендер зарласан болон үнэлж байгаа 1,644.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ажил хийгдэж байна. Цэвэр ашгаас хийж байгаа нийт 29 төсөл, арга хэмжээний 12-ыг нь НТШ-аар, 14-ийг нь харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан бөгөөд 2 ажил он дамжсан ажлын нэмэлт ажлаар, 2016 оны 1 төсөл арга хэмжээг үргэлжлэн хийгдэж санхүүжилт олгогджээ.

## Урсгал зардлын санхүүжилтээр 2017 онд хийгдсэн ажлууд

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2017 оны 6 дугаар сарын 02-ны өдөр баталсан харъяа байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны урсгал зардлаар худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөө"-г баримтлан худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу хэрэгжүүлсэн байна. Тайлант онд нийт 12,644.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 67 ажил төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

### 2017 онд урсгал зардлаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ

№	Үзүүлэлт	Тоо	/сая.төг/			
			Төсөвт өртөг	Гүйцэтгэл	Хэмнэлт	Хувь
1	Бүрэн дууссан	40	8,351.9	6,685.5	1,666.4	66.1
2	Гэрээ байгуулан ажиллаж байгаа	5	1,254.7	211.3	-	10.0
3	Шууд гэрээ	3	16.0	16.0	-	0.1
4	Тендер зарласан болон үнэлж байгаа	13	2,388.2	-	-	18.9
5	Хийгдээгүй	2	526.5	-	-	4.2
6	Хасагдсан	4	107.4	-	-	0.7
<b>Нийт дүн</b>		<b>67</b>	<b>12,644.7</b>	<b>6,912.8</b>	<b>1,666.4</b>	<b>100.0</b>

Нийт төлөвлөсөн ажлын 66.1 хувь нь буюу 8,351.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 40 ажил бүрэн хийгдэж дууссан, 10.0 хувь нь буюу 1,254.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ажлыг хүлээн авч байна. Эдгээр хүлээн авч байгаа ажлуудыг оруулан тооцвол төлөвлөгдсөн төсөл, арга хэмжээний 76.1 хувийн гүйцэтгэлтэй харагдаж байна. Тайлант онд авч хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлийг, төсөв өртөгтэй харьцуулан авч үзэхэд 1,666.4 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллаж байна.

Тус байгууллага нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээс гадна өөрийн хөрөнгийн эх үүсвэр /урсгал орлого/ хуримтлагдсан ашгаасаа хөрөнгө оруулалт хийж үндсэн хөрөнгө, техник, тоног төхөөрөмж худалдан авах, их болон урсгал засвар хийх бусад арга хэмжээнүүдийг санхүүжүүлж байна.

### Иргэний нисэхийн ерөнхий газрын 2012-2017 онуудад даатгалын зөвлөх үйлчилгээг худалдан авсан талаар

Иргэний нисэхийн ерөнхий газар нь 2012-2017 онуудад 4,669.3 сая төгрөгийн даатгалын зөвлөх үйлчилгээг худалдан авч хэрэгжүүлсэн байна. Иргэний нисэхийн ерөнхий газар нь 2012 онд 6 төрлийн 1,356.1 сая төгрөгийн даатгалын зөвлөх үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нээлттэй тендер зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахгүйгээр шууд гэрээ байгуулж хэрэгжүүлсэн байна. Харин 2012 онд байгуулсан даатгалын гэрээний хугацаа дуусахаас өмнө **2013-2014 оныг дамжин хэрэгжих даатгалын зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг 2013 оны 4 дүгээр улиралд нээлттэй тендер зарлан зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан хэрэгжүүлсэн байна.**

**2013 онд:** Даатгалын үйлчилгээний урьд онд байгуулсан шууд гэрээний дагуу даатгагдсан үйлчилгээний хугацаа дуусах болсон тул, дуусах хугацаанаас эхлэн

хэрэгжүүлэх өнгөрөлтийн даатгалын үйлчилгээг үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг нээхэд Бодь даатгал, Монгол даатгал, Миг даатгал, Тэнгэр даатгал, Соёмбо даатгал, Ард даатгал, Мандал женерал даатгал зэрэг 7 компани оролцох хүсэлтээ илэрхийлж материалаа ирүүлжээ. 2013 оны 10 дугаар сарын 24-ны өдөр Үнэлгээний хорооны зөвлөмж гарчээ. Захиалагчийн зүгээс 10 дугаар сарын 24-ний өдөр хүргүүлсэн мэдэгдлийн дагуу МИГ даатгал ХХК-ийг шалгаруулж, бусад оролцогчдод шалгараагүй тухай мэдэгдлийг мөн хүргүүлсэн байна. Гэтэл Соёмбо даатгал ХХК-иас Захиалагчид болон Сангийн яаманд гомдол гаргаснаар маргаан үргэлжилж, холбогдох газрууд хянаж хариу хүргүүлсэн, дахин хандсан Сангийн яамнаас тендерийг түдгэлзүүлсэн, тендер хүчинтэй байх байх хугацааг сунгасан, захиалагч дахин үнэлгээг 11 дүгээр сарын 27-нд хийж, өмнө гаргасан шийдвэрийг хэвээр үлдээсэн, үүний дараа 12 дугаар сарын 04-ний өдөр МИГ даатгал ХХК-тай гэрээ байгуулж эрхийн харьцаа үүсгэжээ.

2014 оноо эхлэн улсын төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Худалдан авах ажиллагааны газраар гүйцэтгүүлсэн байна. Мөн гэрээний үүрэг хариуцлагыг өндөржүүлж, гүйцэтгүүлсэн бараа, ажил, үйлчилгээний үр дүнг талуудын хооронд байгуулсан гэрээг заасан хугацааг баримтлан Ажлын хэсэг томилж дүгнэн акт үйлдэж, төлбөр тооцоог хийж гэрээний үүргийн гүйцэтгэл хангагдаагүй, хугацаа хоцроосон хоног тутамд алданги, торгууль ногдуулах зэргээр гэрээний хөшүүргийг ашиглан ач холбогдол, үүрэг хариуцлагыг өндөржүүлэхэд анхаарч ажилласан байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2015-2016 оны “Олон улсын өнгөрөлтийн нислэгт үзүүлэх навигацын үйлчилгээний явцад гуравдагч этгээдийн хариуцлагын даатгал”-ын үйлчилгээ үзүүлэх ИНЕГ-УЗ/ХББ/Ү/15 тоот тендер шалгаруулалтад оролцогчдын гомдлоор Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газраас хянан үзэхэд хамгийн сайн гэж үнэлж, гэрээ байгуулах эрх олгосон “Монгол даатгал” ХХК нь сүүлийн 3 жилийн санхүүгийн аудитлагдсан санхүүгийн тайлан баланс ирүүлээгүй, зөвхөн аудитын дүгнэлтийн хураангуйг ирүүлсэн нь ТББ-ийн ТОО33-ны 4.2/е/ заалтыг, 2014 онд алдагдалтай ажилласан байгаа нь 4.2 /е/-ын 2 дахь заалтыг тус тус хангахгүй, тендер шалгаруулалтыг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргыг сонгож зохион байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.2 дахь заалтын дагуу тендерийн урилгыг худалдан авах ажиллагааны цахим хуудсанд нийтлээгүй нь хуулийн 21.4, 32.2 дахь заалтыг тус тус зөрчсөн байгааг дурдаж, тендерийг хүчингүй болгож, дахин зохион байгуулахыг 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдөр албан тоотоор мэдэгдсэн байхад тэр өдөр нь “Монгол даатгал” ХХК-тай гэрээ байгуулж, 12 дугаар сарын 30-ны өдөр 420.0 сая төгрөгийн хураамжийг шилжүүлж хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Даатгалын зөвлөх үйлчилгээг худалдан авсан байдал

## /2012-2016 он, 2017 оны эхний 9 сар/

д/д	Даатгалын төрөл	Хураамжийн хэмжээ	Даатгагчийн нэр	Даатгасан хугацаа /эхлэх, дуусах/	/төгрөгөөр/ тайлбар
<b>2012 оны даатгал</b>					
1	Олон улсын өнгөрөлтийн нислэгт үзүүлэх навигацын үйлчилгээний явцад гуравдагч этгээдийн эд хөрөнгө, эрүүл мэнд, амь насанд учирч болзошгүй тохиолдлын даатгал	571,695,880	"Бодь даатгал" ХХК	2012.02.02 2013.02.01	Нээлттэй тендер зарлалгүйгээр шууд гэрээ байгуулсан.
2	Эд хөрөнгийн даатгал	70,317,927 276,093,850	"Практикал" даатгал ХХК	2012	2012.05.29-нд Голомт банкнаас 346,411,777 төгрөг шилжсэн.
3	ИНЕГ-ын салбарын эрсдэлийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээ	100,000,000	"Практикал" даатгал ХХК	2012.12.28	Урьдчилгааг 2012.01.05-нд 30,000,000 төг, 2012.04.06-нд 70,000,000 төг шилжүүлсэн.
4	Гэнэтийн ослын болон ажиллагсадын хариуцлагын даатгал	26,400,000 36,960,000	"Ард даатгал" ХХК		2012.06.14-нд 63,360,000 төгрөг шилжүүлсэн
5	Ханрим зочид буудлын барилгын ажлын даатгал	61,984,500	"Ард даатгал" ХХК	2012	2012.08.03-нд 61,984,500 төг шилжүүлсэн.
6	2 аймгийн хөөрч буух хатуу хучилттай зурвас	212,658,237	"Практикал" даатгал ХХК	2012 Эхлэх, дуусах хугацаагүй	2012.08.03-нд ХХБ-наас шилжүүлсэн.
<b>2012 оны дүн</b>		<b>1,356,110,394</b>			
<b>2013 оны даатгал</b>					
1	ИНЕГ-ын харъяа хөөрч, буух зурвасын талбайд гуравдагч этгээдийн эд хөрөнгө, амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй тохиолдлын хохирлын хариуцлагын даатгал.	430,000,000	"МИГ" даатгал ХХК	2013.12.04 2014.12.04	2013.12.17-нд Төрийн банк харилцахаас 430,000,000 төгрөгийг шилжүүлсэн.
2	Олон улсын өнгөрөлтийн нислэгт үзүүлэх навигацын үйлчилгээний явцад гуравдагч этгээдийн эд хөрөнгө, эрүүл мэнд, амь насанд учирч болзошгүй тохиолдлын даатгал	440,000,000	"МИГ" даатгал ХХК	2013.12.04 2014.12.04	2013.12.17-нд 440,000,000 төгрөг шилжүүлжээ.
3	ИНЕГ-ын газрын үйлчилгээний албаны аюултай ачааны даатгалын үйлчилгээ.	30,000,000	"Соёмбо даатгал" ХХК	2013.08.09 2014.08.08	2013.08.16-нд Голомт банкнаас 30,000,000 төг
4	ИНЕГ-ын барилга байгууламжийн үндсэн хөрөнгийн даатгалын үйлчилгээ	66,695,785	"Ард даатгал" ХХК	2013.09.14 2014.09.14	2014.09.15-нд 66,695,785 төг шилжсэн.
5	ИНЕГ-ын газрын тусгай үйлчилгээний албаны тээврийн хэрэгслийн даатгалын үйлчилгээ үзүүлэх зөвлөх үйлчилгээ	34,704,560	"Ард даатгал" ХХК	2014.08.09 2013.04.05 гэж ойлгомжгүй огноо бичжээ.	2013.08.15-нд Голомт банкнаас Хураамжийг 100 хувь шилжүүлжээ.
6	Байгууламжийн хөрөнгийн даатгалын үйлчилгээ.	88,288,908	"Монре даатгал"	2013.12.24 2014.12.23	2013.12.31 Голомт банкнаас 88,288,908 төгрөг Шилжүүлсэн.

<b>2013 оны дүн</b>		<b>1,089,689,253</b>			
<b>2014 оны даатгал</b>					
1	Аюултай ачааны даатгал /ТС тээвэрлэх/	21,375,000	"Соёмбо даатгал" ХХК	2014.08.20 2015.08.20	2014.09.04-нд Голомт банкнаас 21,375,000 төг шилжүүлсэн.
2	Тээврийн хэрэгслийн даатгал /ИНЕГ-ын үйлчилгээний албаны/	34,704,560	"Ард даатгал"	2014.08.20 2015.08.19	2014.09.04-нд 34,704,560 төг шилжүүлсэн.
<b>2014 оны дүн</b>		<b>56,079,560</b>			
<b>2015 оны даатгал</b>					
1	2015-2016 оны Нисэх буудлуудын талбайд гуравдагч этгээдийн хариуцлагын даатгалын үйлчилгээ үзүүлэх гэрээ	420,000,000	"Монгол даатгал" ХХК	2015.12.28 2016.12.28	2015.12.20-нд Голомт банкнаас 420,000,000 төгрөг шилжүүлсэн.
2	Олон улсын өнгөрөлтийн нислэгт үзүүлэх навигацын үйлчилгээний явцад гуравдагч этгээдийн эд хөрөнгө, эрүүл мэнд, амь насанд учирч болзошгүй тохиолдлын даатгал	420,000,000	"Монгол даатгал" ХХК	2015.12.28 2016.12.28	2015.12.30-нд 420,000,000 төгрөг шилжүүлсэн.
3	Барилга, байгууламжийн даатгалын үйлчилгээ	168,216,230	"Ард даатгал"	2015.12.28 2016.12.27	2015.12.30-нд 168,216,230 төгрөг шилжсэн.
4	Тоног, төхөөрөмжийн даатгалын үйлчилгээ үзүүлэх. /2015-2016 он/	85,221,885	"Ард даатгал"	2015.12.28	2015.12.28-нд ХХБ-наас 85,221,885 төг шилжсэн.
5	Ажиллагсадын хариуцлага, гэнэтийн ослын даатгал /2015-2016/	33,180,000	"МИГ" даатгал ХХК	2015.12.24 2016.12.23	2015.12.31 Голомт банк 33,180,000 төгрөг шилжүүлсэн.
6	ИНЕГ-ын үйлчилгээний албаны тээврийн хэрэгслийн даатгалын үйлчилгээ.	40,946,346	"Ард даатгал"	Гэрээнд эхлэх дуусах хугацаа заагаагүй	2015.10.09-нд 40,946,346 төгрөг Шилжүүлсэн.
<b>2015 оны дүн</b>		<b>1,167,564,461</b>			
<b>2016 оны даатгалын үйлчилгээ.</b>					
1	Тээврийн хэрэгслийн даатгалын үйлчилгээ	48,456,325	"Ард даатгал"	2016.10.20 2017.10.19	2016.11.01-нд
2	Ачаа тээврийн даатгалын үйлчилгээ	28,500,000	"МИГ" даатгал ХХК	2016.09.10 2017.09.09	2016.10.06-нд ГБ-наас 28,500,000 төгрөг шилжүүлсэн.
3	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	20,799,505	"Соёмбо даатгал" ХХК		2016.06.22-нд ГБ 20,799,505 төгрөг шилжүүлэв.
<b>2016 оны дүн</b>		<b>97,755,830</b>			
<b>2017 оны даатгал</b>					
1	ИНЕГ-ын барилга, байгууламжийн даатгалын үйлчилгээ	140,529,841	"Практикал" даатгал ХХК	2017.04.06 2018.04.06	2017.04.14-нд Богд банкнаас 140,529,841 төгрөг шилжсэн.
2	Олон улсын ШНБ-ын барилга байгууламжийн даатгалын үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ	77,714,867	"Бодь даатгал" ХХК	2017.08.01 2018.07.31	2017.08.25-нд ХААН банкнаас 77,714,867 төгрөг шилжүүлсэн.
3	Олон улсын өнгөрөлтийн нислэгт үзүүлэх навигацын үйлчилгээний явцад гуравдагч этгээдийн эд хөрөнгө, эрүүл мэнд, амь насанд учирч болзошгүй тохиолдлын даатгал	314,000,000	"Мандал даатгал" ХХК	2017.08.11 2018.08.10	Богд банкнаас 2017.08.25-нд 314,000,000 төгрөг шилжүүлэв.
4	ИНЕГ-ын Нисэх буудлуудын талбайд гуравдагч	314,000,000	"Мандал даатгал" ХХК	2017.08.11 2018.08.10	Богд банкнаас 2017.08.25-нд

	этгээдийн хариуцлагын даатгалын үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ.				314,000,000 төгрөг шилжүүлэв.
5	Нэр бүхий 9 хүнийг 30 хоног РА 2099 G агаарын хөлгийн зорчигчийн амь нас гэнэтийн ослын даатгал /шууд гэрээ/	8,470,000	"Ард даатгал" ХХК	30 хоног	2017.06.06-нд УБ банкнаас 100 хувь шилжүүлсэн.
6	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	20,711,505	"Практикал" даатгал ХХК	2017.06.26 2018.06.26	Капитрон банкнаас 2017.06.21-нд 20,711,505 төгрөгийг шилжүүлсэн.
7	Ажиллагсадын хариуцлага, гэнэтийн ослын даатгал	26,700,700	"Ард даатгал" ХХК	2017.06.13 2018.06.12	Капитрон банкнаас 2017.06.21-нд 26,700,700 төгрөг Шилжүүлэв.
<b>2017 оны дүн</b>		<b>902,126,913</b>			
<b>2012-2017 онуудын дүн</b>		<b>4,669,326,411</b>			

"Практикал даатгал" ХХК-д 2012.08.03 нд ТД-2084 ИНЕГ-ын ХХБ-ны 499133504 тоот данснаас 212,658,236.94 төгрөгийг шилжүүлжээ. Гэрээний дугаар- ЭХ30С1200425 Гэрээнд он сар, өдөр огноогүй байна. /2 аймгийн хөөрч буух хатуу хучилттай зурвас/ шууд гэрээ байгуулж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.1, 21.4, 32.2 дах заалуудыг зөрчжээ.

Мөн "МИГ даатгал" ХХК-тай байгуулсан ИНЕГ-ТББ/У-12/13 дугаартай гэрээ нь /2013.1204-2014.12.04 нд дуусах/ Олон улсын өнгөрөлтийн нислэгт үзүүлэх навигацын үйлчилгээний явцад гуравдагч этгээдийн эд хөрөнгө, амь нас, эрүүл мэндэд учруулж болзошгүй хохирлын хариуцлагын даатгалын үйлчилгээ үзүүлэх /2013 оны урсгал орлогоос/ даатгалын хураамжид 440,000,000.00 төгрөгийн нэхэмжлэлийн дагуу төлбөрийг ИНЕГ-ын Төрийн банк дах 1067 0014 717 тоот харилцахаас 2013.12.17-нд 440,000,000 сая төгрөгийг шилжүүлжээ. /Даатгуулагч олон улсын нислэгийн өнгөрөлтийн нислэгт нислэгийн үйлчилгээний явцад гуравдагч этгээдийн эд хөрөнгө, эрүүл мэнд, амь насанд учирч болзошгүй тохиолдлын даатгал/ Гэрээний дугаар-BD/LIA 03121204011828/ Гэрээ ёсоор 2012.02.02-ны 00 цагаас 2013 оны 2 дугаар сарын 01-ний 24 цаг хүртэлх хугацаанд хүчинтэй/ Энд тендерийн маргаан үүссэн Захиалагчийн 2013.10.24-ний өдрийн 01/2626 болон 01/2633 тоот мэдэгдлийн дагуу гэрээ байгуулж байсан боловч түр хүлээсэн зарим оролцогч гомдол гаргасны дагуу эрх бүхий байгууллагаас түр түдгэлзүүлсэн, 2013.12.04-нд гэрээ байгуулна уу гэсний дагуу тухайн өдөр нь гэрээ байгуулжээ. 2013.12.20-ны өдөр Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тендерийг хүчингүй болгосон тул мөнгийг буцаан шилжүүлнэ үү гэсэн ИНЕГ-ын даргын 01/3270 дугаартай албан тоотыг хүргүүлж байсан боловч, асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэхгүй байсаар зөрчилтэйгээр үргэлжилсээр даатгалын гэрээний хугацаа дууссан байна.

Ард даатгал ХХК. 2017.06.06-нд ТД№1706-008-0021 тоотоор УБ хотын банкнаас 8 470,000,00 төгрөгийг 2017.06.02-ны №10/141/0602 тоот даатгалын гэрчилгээний дагуу нэр

бүхий 9 хүнийг /30 хоног/ RA2099G агаарын хөлгийн зорчигчийн ам нас, гэнэтийн ослын даатгалд хамруулж хураамж төлж төлөвлөгөөнд тусгаагүй шууд гэрээ байгуулжээ.

**ИНЕГ-ын захиалгаар улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа олон жил болсон зарим зам, барилгын ажлын талаар:**

ИНЕГ-ын захиалгаар хийгдэж байгаа олон он дамжсан, гэрээний үүргээ биелүүлээгүй 4 ажил байгаа бөгөөд “Үүрэг трейд”, “Хурдны зам” зэрэг компаниуд ажил гүйцэтгэх явцад захиалагчтай маргаан үүсгэж, ажлаа гүйцэтгэлгүй өнөөг хүрчээ.

Гүйцэтгэсэн ажлынхаа хэмжээгээр авсан санхүүжилтээс гадна, үнийн тохируулга хийгээгүй гэж шүүхийн шийдвэрээр захиалагчаас их хэмжээний мөнгийг гаргуулан авсан боловч ажлаа үргэлжлүүлэн хийлгүй өнөөг хүрч байгаа нь өмнө хийсэн ажлын чанар байдал алдагдаж, эвдрэл гэмтэл гарсаар өртөг зардал нэмэгдэж байгааг онцгой анхаарч, тодорхой шийдвэр гарган, шуурхай арга хэмжээ авах шаардлагатай болжээ.

Дээрхи барилгын болон онгоц хөөрч буух аэродромын зурвасын ажил, үр ашиггүй худалдан авалтуудын талаар дор дурдаж байна. Үүнд:

д/д	Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, төрөл, тоо хэмжээ, хаана хэрэгжсэн	Гүйцэтгэгчийн нэр	Төсөвт өртөг	Төсвийн гүйцэтгэл	Тайлбар, тодруулга
1	Нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан барих. /Завхан аймаг, Донойн хөндий/	“Хурдны зам” ХХК	8,651.5	88.4 хувийн санхүүжилт 7,649.4 сая төгрөг, Шүүхийн шийдвэрээр 2,645.6 тус тус авчээ	2008-2013 онд баригдаж дуусах атал одоо хүртэл дуусаагүй маргаантай байгаа, ажлын гүйцэтгэл 88.4 хувьтай эвдэрсэн. 2013 онд шүүхийн шийдвэрээр 2,645,633,684 төгрөг авсан, мөн 88.4 хувийн гүйцэтгэл, санхүүжилт 7,649,415,772 төгрөг
2	Бүсийн нислэг хөдөлгөөний удирдлагын төвийн барилга /УБ хот, Буянт-Ухаад/	“Үүрэг трейд” ХХК	6,759.5	6,100.0 Шүүхийн шийдвэрээр 3,800.0 сая төгрөг авсан	2011-2013 онд барьж дуусах байсан б маргаан үүсч өнөөг хүрсэн, гүйцэтгэл 80.0 % 11,165,360,360 төгрөг.
3	БНХУТөвийн барилгын дэд өртөө, гадна цахилгаан, гаднах холбооны ажил /УБ Буян-Ухаа/	“Үүрэг трейд” ХХК	1,005.5	1,301.5 гаднах дулаан бохирын ажилд 542.2 сая төгрөг, инж/шугам сүлжээнд 759.3 сая.төг	/2012-2013 онд дуусах/ НТ зарласан боловч, дээрх барилгын ажилтай нягт холбоотой гэж үзээд “Үүрэг трейд” ХХК-тай шууд гэрээ байгуулсан. Гүйцэтгэл 40.0 хувь, 2012 онд 375.0 сая.төг олгосон.
4	Баруун 4 аймгийн хөөрч буух хатуу хучилттай зурвасын гэрэл суултын систем суурилуулах /Увс, Говь-Алтай Завхан, Хөвсгөлд/ хийгдэх	“ESDR Electronics PTY” LTD	4,000.0	3,800.0	Увс аймаг дууссан, Говь-Алтай 80 %-тай байна. Суурилуулах бүх Тонотөхөөрөмжөө авсан тул үлдэгдэл 289.0 сая төгрөгөө багтаан Завхан, Хөвсгөл аймгуудын зурвасын ажил дуусахааражлаа хийж дуусгана гэсэн тайлбартай өнөөг хүрчээ. Нийт гүй/гэл 95%
Нийт дүн			20,416.5	26,561.9	

**1.Завхан аймгийн “Доной” нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвасын аэродромын барилга угсралтын ажлын талаар.**

Захиалагч: Зам, тээвэр, аялал жуулчлалын яам

/хуучин нэрээр/

Ашиглагч:	ИНЕГазар
Гүйцэтгэгч:	“Хурдны зам” ХХКомпани
Гэрээний дугаар:	ИНЕГ.ТББ/БУ-56-07
Гэрээг хэрэгжүүлэх хугацаа:	2008-1-31 / 2013-11-30
Гэрээний үнийн дүн:	8,651,499,690 төгрөг
Санхүүгийн эх үүсвэр:	Улсын төсвийн хөрөнгөөр
Гэрээт ажлын гүйцэтгэл:	70.0 хувь буюу 6,450,451,751 ₮
Санхүүжүүлсэн хэмжээ:	88.4 хувь буюу 7,649,415,772 ₮
Шүүхийн шийдвэрээр:	2,645,633,684 ₮ / 2013 онд /
Барилга байгууламжийн хийц:	Асфальтобетон хийцтэй

ИНЕГ.ТББ/БУ-56-07 тоот гэрээг анх Нэг талаас: Зам, тээвэр, аялал жуулчлалын яам /хуучин нэрээр/, нөгөө талаас “Хурдны зам”ХХК-иуд 2008 оны 01 дүгээр сарын 31-ны өдөр байгуулжээ. Анх гэрээний 3 дугаар заалтаар гэрээний дүн: 8,651,499,690 төгрөг, Үүнээс: 2008 онд 1,0 тэрбум, 2009 онд 7,651,499,690 төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр тусгажээ. Гэрээний тусгай нөхцөл /ГЕН-17,26\-өөр ажил дуусах хугацаа: 2009 оны 12 дугаар сарын 20-ны өдөр болно. Уг гэрээт ажил нь олон он дамжиж, бараг 10 жил болох гэж байна. Энэ хугацаанд талууд: 2009 оны 8 дугаар сарын 06-ний өдөр, 2010 оны 5 дугаар сарын 18-ны өдөр, 2011 оны 5 дугаар сарын 19-ны өдөр, 2012 оны 4-р сарын 13-ны өдөр, 2013 оны 02-р сарын 20-ны өдөр тус тус нэмэлт хийж баталгаажуулжээ.

Гэрээний тусгай нөхцөл: “Гэрээний ерөнхий нөхцлийн 44 дүгээр зүйлийн дагуу гэрээнд үнийн тохируулга хийж “болно” /ГЕН-44/-н дагуу үнийн тохируулга хийнэ гэж тусгажээ. Мөн Улсын Их Хурлын 2009 оны 3 дугаар сарын 13-ний өдрийн “Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн 3 дугаар хавсралтын дагуу гүйцэтгэгч “Хурдны зам” ХХК-ийн 2008 оны батлагдсан гүйцэтгэлийн зөрүүг 348,800,000 төгрөгөөр тооцож 2009 оны 8 дугаар сарын 06-ны өдөр хийсэн гэрээний нэмэлтийн дагуу олгожээ.

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн ХХ.1.2.2.48, Монгол Улсын их хурлын Төсвийн байнгын хорооны 2012-11-09-ны өдрийн 9/3117 тоотыг үндэслэн үнийн зөрүү 2,645,633,684 төгрөгийг “Хурдны зам” ХХК-д олгосон байна.

Гэрээт ажлыг анх Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдөр томилогдсон, “Иргэний нисэхийн салбарт улсын төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсгүүд томилогдож, барилгын ажилтай танилцан ажлыг зогсоосон хэдий ч гэрээт ажилтай холбогдуулан ЗТЯ-наас дахин томлогдсон Ажлын хэсэг 2015 оны 03-р сарын 26 өдөр хуралдаж гэрээт ажлыг үргэлжлүүлэн хийлгэхээр тохирч, акт үйлдсэн боловч хэрэгжүүлээгүй байна. Гэвч гүйцэтгэгч байгууллага болох “Хурдны зам” ХХК-ны зүгээс нэмэлт зардлын асуудлыг шийдвэрлэсний дараа, ажлаа гүйцэтгэх талаар албан ёсоор хүсэлт ирүүлсэнийг авч үзээд холбогдох мэргэжлийн байгууллага болох “Зам



тээврийн хөгжлийн төв"-өөр хянуулж, үнэлгээ хийлгэж, дүгнэлт гаруулжээ. Мөн Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 233 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг Завхан аймаг дахь Нисэх буудлын хөөрч буух зурвас, явгалах зам, перрон, үерийн далан ба аэродромын бусад элементүүдийн барилгын гэрээт ажлын явц, гүйцэтгэлийн байдалтай танилцаж ажлын хэсгээс дараах дүгнэлтийг гаргажээ. Ажлын хэсгийн дүгнэлтэд: Завхан аймгийн нисэх буудлын онгоц хөөрч буух хатуу хучилттай зурвас, үерийн далан барих ажлын гэрээний хэрэгжилт сунжирсан шалтгаан нь :

-Захиалагч тал гэрээний санхүүжилтийг он дамжуулж хувааж тусгасан;

-2012 онд захиалагч тал гэрээнд тамга дараагүйгээс гүйцэтгэгч компани ажлын талбайд гараагүй;

-2013 онд битумны маргаантай асуудал үүсч ажил зогссон;

-Мөн гэрээнд заасан үнийн тохируулга хийнэ гэсэн заалтаа захиалагч биелүүлээгүй буюу өсөлтийн зөрүүг тухай бүрт нь тооцож олгоогүй зэрэгтэй холбоотой байна.

Дээрхи нөхцөл байдлаас шалтгаалан гүйцэтгэгч тал Иргэний хуулийн 355 дугаар зүйлд зааснаар гэрээг цуцалж учирсан хохирлоо шаардах эрх үүсэж болно. Захиалагч тал гэрээний 3 дахь хэсэг буюу "Энэхүү гэрээний нэмэлтийн хавсралт болох аэродромын барилга угсралтын ажлыг холбогдох норм, дүрэм, стандартын дагуу гүйцэтгэх хуваарийг хатуу мөрдөн ажиллах" гэсэн үүргийг гүйцэтгэгч тал биелүүлээгүй хугацаа алдсан гэх үндэслэлийг нотолж чадвал гэрээний 227 дугаар зүйлийн 227.3 дахь заалтыг үндэслэн "Үүрэг гүйцэтгүүлэгчээс гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэн бол үүрэг гүйцэтгэгчид зайлшгүй орох байсан орлогыг хохиролд тооцон нэхэмжлэх" эрх үүснэ. Мөн захиалагч хийсэн ажлын гүйцэтгэлээс илүү олгосон санхүүжилтээ буцаан шаардах эрхтэй боловч эдгээр шаардлагууд хангагдах эсэх нь тодорхойгүй байна.

1. Гүйцэтгэгч талын хувьд иргэний хуулийн 355 дугаар зүйлийн 355.5 дахь хэсэгт заасны дагуу "Өөрөө гэм буруугүй, эсхүл хүндэтгэн үзэх онцгой нөхцөл байдал бий болсон бол ажил гүйцэтгэгч гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй" гэсэн заалтыг хэрэглэх боломжтой. Энэ тохиолдолд захиалагчид учруулсан хохирлыг ажил гүйцэтгэгч нөхөн төлөх үүрэг хүлээхгүй, харин гэрээ цуцлахаас өмнө ажил гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын үр дүнд захиалагч ямар нэгэн ашиг сонирхолтой байвал ажил гүйцэтгэгчгүйцэтгэсэн ажлын хөлсөө шаардах эрх үүснэ.

2. Гүйцэтгэгч талд ажлаа үргэлжлүүлэн гүйцэтгэхэд битум, эрдэс нунтгийн дахин тээврийн зардал, буталсан чулуун суурийг сэргээх зэрэг нэмэлт ажлууд хийхшаардлагатай. Захиалагч болон зургийн зохиогч нар нэмэлт ажлын хэмжээг хүлээн зөвшөөрснөөр, "Зам тээврийн хөгжлийн төв" 2016 оны 05 дугаар сарын 02-ны 064/2016 тоот дүгнэлтээр төсвийг 1.152 тэрбум төгрөгөөр хянаж баталгаажуулсан ба Захиалагчийн зүгээс нэмэлт ажлыг санхүүжүүлэх, мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын үлдэгдэл 344.9 саятөгрөгөөр дуусгах боломжтой.

3.Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цуцалж өөр хуулийн этгээдтэй гэрээ байгууланүлдэгдэлажлыг хийж дуусгахаднийт 6.216 тэрбум төгрөг шаардлагатай.

4.Тиймээс Завхан аймгийн "Доной" нисэх буудлын онгоц хөөрч буух хатуу хучилттай зурвас, үерийн далан барих ажлыггүйцэтгэгч болох "Хурдны зам" ХХК-аар үргэлжлүүлэн дуусгах нь зүйтэй гэж үзэв.

Гэвч нэмэлт санхүүжилтийг олгохоор Зам тээврийн сайдын 2016 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 134 тоот тушаалын 1.2-т 1,142.4 сая төгрөг туссан байсан боловч, Зам тээврийн сайдын 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 156 дугаар тушаалаар нэмэлт санхүүжилтийг хассан байна.

ЗТЯ-аас 2017 онд ИНЕГ-т Завхан аймгийн хөөрч буух хучилттай зурвасын ажлыг үргэлжлүүлэх нь зүйтэй, мөн нэмэлт санхүүжилтийг тус газраас шийдвэрлэх талаар албан хүсэлт ирсэний дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/54 дугаар тушаалаар Завхан аймгийн Доной нисэх буудлын онгоц хөөрч буух хатуу хучилттай зурвас үерийн далангийн хамт гүйцэтгэх ИНЕГ/ТББ/БУ-56-07 дугаар бүхий гэрээт ажлын гүйцэтгэлийг тодорхойлох, дүгнэлт гаргах ажлын хэсэг томилогдон ажиллажээ.

2016 оны төсөвт тээврийн зардал болон нэмэлт ажлын зардал тусгагдсан байсан бөгөөд харин 2017 онд ажил гүйцэтгэхэд шаардагдах битум худалдан авах үнэ өссөнтэй холбогдон зардал өссөн байна. Иймд ажлын хэсгээс дараах дүгнэлтийг хийжээ. Үүнд:

1.Гэрээт ажлыг "Хурдны зам" ХХК-аар үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх.

2.Гэрээт ажлыг 2017 онд гүйцэтгэгчээс ирүүлсэн төсвийг хянасан дүн болох 1,7 тэрбум төгрөг /Шууд зардлын дүн-1,495.5 сая төгрөг, НӨАТ-10 хувь-149.5 сая төгрөг, нүүлгэн шилжүүлэлтийн зардал 49,3 сая төгрөг/, 2016 онд батлагдсан байсан төсвийн нэмэлт ажлын зардал болох 199.0 сая төгрөг, 2017 онд Улсын төсөвт тусгагдсан 344.9 сая төгрөг, мөн ИНЕГ-аас илүү суутган авсан 81.0 сая төгрөгийг гүйцэтгэгчид олгож гэрээт ажлыг дуусгах боломжтой гэсэн байна.

3.Гэрээт ажлын үндсэн гэрээний сунгалт болон нэмэлт зардал шийдвэрлэх гэрээнүүдийг байгуулах.

4.Гэрээт ажлыг 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдөр ашиглалтад өгөхөөр тохиролцов гэсэн боловч, ажил хийгдэлгүй төсвийн жил дууссан, шүүхэд маргаан үргэлжилж байна.

## **2.Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн**

### **барилгын талаар/"Үүрэг трейд" ХХК/:**

Энэхүү барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2011 онд Зам, тээвэр, барилга хот байгуулалтын яам /хуучин нэрээр/-наас зохион байгуулсан байна. ЗТБХБЯ болон ИНЕГ, "Үүрэг трейд" ХХК-тай 2011 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн ИНЕГ/ТББ/БУ-47/10/93 дугаартай БНХУТ-ийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ, 2012 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн ИНЕГ/ШТ/А-01/12/56 дугаартай 6/0.4.0 2x1000 кВт-

ын Дэд өртөөний барилга, гадна цахилгаан, гадна холбооны ажил гүйцэтгэх гэрээ, 2011 оны 09 дүгээр 06-ны өдрийн ИНЕГ/ШТ/А-02/11/132 дугаартай Гадна дулаан, инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтийн байдал, олгосон санхүүжилт, гэрээний ерөнхий нөхцөлийн 44, тусгай нөхцөлийн 44 дүгээр зүйлүүдэд зааснаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40.4.2 дах заалтын дагуу хийлгэсэн үнийн тохируулга зэрэгт тус газрын Дотоод аудитын албанаас мэргэжлийн хүмүүсийн бүрэлдэхүүнтэй хийсэн аудитийн зарим материалыг ашиглан, санхүүгийн үндсэн баримтад тулгуурлан дахин нягталж, тулган баталгаажуулах замаар шалгалтыг хийлээ.

Энэхүү барилгын ажил нь 2011 онд эхэлсэн боловч өнөөг хүртэл дуусаагүй, ажил зогссон энэ хугацаанд үнийн тохируулга хийгээгүй гэж шүүхэд нэхэмжлэл гарган Сүхбаатар дүүргийн шүүхийн 2013 оны 07 дугаар сарын 1463 тоот шийдвэрээр “Үүрэг трейд” ХХК-ийн нэхэмжилсэн 5,063,872,944 төгрөгийн нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж, үнийн тохируулгад 3,664,462,152 төгрөг, гэрээний тоо хэмжээнд тусгагдаагүй 145,124,031 төгрөг, нийт 3,809,586,183 төгрөгөөр тогтоож, улсын тэмдэгтийн хураамж 19,205,880 төгрөгийг Иргэний нисэхийн ерөнхий газар болон Зам тээврийн яамнаас гаргуулж “Үүрэг трейд” ХХК-д олгохоор шийдвэрлэжээ.

ИНЕГ-ын Голомт банк дахь харилцах данснаас үл маргах журмаар гүйцэтгэл хийлгэхээр Нийслэлийн ШГА-ны 2013 оын 11 дүгээр сарын 25-ны өдрийн 2/16323 тоот мэдэгдлээр дээр дурдсан мөнгөн дүн дээр, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардалд 300,000 төгрөг нэмж, 3,829,092,063 төгрөгийн төлбөрийг Төрийн банкны тус албаны 10330001600 дансанд шилжүүлж, дээрхи дансны зарлагын гүйлгээг нээхийг мэдэгдэж шийдвэрлэсэн байна. Гэвч барилгын бүх ажлууд зогссон бөгөөд анхны төсөвт өртгөөс давсан санхүүжилт авсан боловч цаашид ажлыг гүйцэтгүүлэхэд нэмэлт төсөв гаргаж, санхүүгийн эх үүсвэрээ шийдвэрлэх шаардлагатай болсон байна.

Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн 6,759,536,000.0 /зургаан тэрбум долоон зуун тавин есөн сая, таван зуун гучин зургаан мянга/ төгрөгийн төсөвт өртөг бүхий барилгын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгүүлэхээр “Үүрэг трейд” ХХК-ийн ерөнхий захирал О.Баяр, захиалагч: Зам, тээвэр, барилга хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэ нар 2011 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн ИНЕГ/ТББ/БУ-47/10/93 дугаартай гэрээг баталж, 2011 оны 06 дугаар сарын 28-ны өдөр эхэлж, 2012 оны 12 дугаар сарын 30-ны өдөр ашиглалтанд оруулахаар гэрээ байгуулжээ.

Гэрээний хугацааг 2013 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр болгон өөрчилсөн. /2013 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн гэрээний нэмэлтээр /үнийн тохируулга хийх талаар: гэрээний тусгай нөхцөлийн 6 дугаар зүйлд. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40.4-т заасныг баримталж ажиллахаар тусгажээ.

Худалдан авах бараа, ажил үйлчилгээний тоног төхөөрөмж үндсэн материал, түүхий эд, хөдөлмөрийн хөлсний үнэд захиалагч дараах тохиолдолд тохируулга хийхээр гэрээнд тусгаж болно. 40.4.1 Хоёр жилээс дээш хугацаанд хэрэгжих гэрээний явцад хэрэглээний үнийн индекс өөрчлөгдсөн. 40.4.2. Суурь үнэ огцом өөрчлөгдсөн.

Гэтэл уг ажлын гүйцэтгэлийн явцад төсвийн хуваарийг ажлыг эхлэх, дуусах гэрээний хугацаатай уялдуулалгүй төсвийг хэсэгчлэн хувааж он, он дамжуулсан, нийслэлийн шинэ удирдлагууд 2012 онд барилгын ажлыг зогсоосон, ЗТБХБСайдын тушаалаар зам, барилгын ажлын норм, үнэлгээг шинэчлэн, мөрдүүлсэн зэргээс шалтгаалан маргаан үүсч, ажил зогссоноос өнөөг хүртэл ашиглалтад ороогүй байна.

Төлөвлөгдсөн хөрөнгө:	2011 онд	2,000.0 сая төгрөг	/Улсын төсвөөс/
	2012 онд	4,116.5 сая төгрөг	/Улсын төсвөөс/
	2013 онд	643.5 сая төгрөг	/Улсын төсвөөс/
	2015 онд	321.0 сая төгрөг	/Улсын төсвөөс/
	2017 онд	4,400.0 сая төгрөг	/ЗТХС-ын 137 дугаар

тушаал 2017.07.04/

Батлагдсан гүйцэтгэл: Нийт 5,511,571,915 төгрөг

Санхүүжилтийн байдал: Нийт 6,034,774,117 төгрөг

Шүүхийн шийдвэрээр: 3,800,000,000 төгрөг

ИНЕГ-аас “Үүрэг трейд ХХК-д БНХУТ-ийн барилгын санхүүжилтэд 6,034,774,117 төгрөгийн, харин дэд өртөөний барилга, гадна цахилгаан, гаднах холбооны ажлын санхүүжилтэнд 542,207,280 төгрөгийн, гадна дулаан гадна бохир, инженерийн шугам сүлжээний санхүүжилтэд 759,286,900 төгрөгийн, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийн 44 дүгээр зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40.4.2 заалтыг үндэслэн үнийн тохируулгад шүүхийн шийдвэрээр 3,829,092,063 төгрөгийг тус тус олгож нийт дүнгээрээ 11,165,360,360 төгрөгийн санхүүжилт хийгджээ. Хавсралт № 51 /Шүүхийн шийдвэрээр үнийн тохируулгад олгосон дээрхи мөнгийг барилга угсралтын ажлын гүйцэтгэлд оруулан тооцвол барилга угсралтын ажлын нийт гүйцэтгэл 6,602,232,613 төгрөг болжээ. “Үүрэг трейд” ХХК-иас ИНЕГ-ын БНХУТөвийн барилгын гүйцэтгэлд үнэлгээний төсвөөс 1,557,556,495 төгрөгийн ажлын үнэлгээг үнийн тохируулга хийхийн өмнө захиалагчийн хяналт хангалтгүй, гүйцэтгэгчээс ирүүлсэн материалыг /цаасаар/ хянаж санхүүжилт олгохыг зөвшөөрч гарын үсэг зурж баталгаажуулсан байгаагаас үзэхэд тухайн мэргэжилтэний мэдлэг, чадвар, ажилдаа хаиуцлагагүй хандаж байсныг далимдуулан гүйцэтгэлийг өсгөсөн, давхардуулсан, тарифыг нэмэгдүүлсэн, хийгээгүй ажлыг гүйцэтгэлд оруулж, илүү бичиж авсан зэрэг зөрчил илэрч байгаа бөгөөд энэ нь шүүхийн шийдвэрээр олгогдсон 3,829,092,063 төгрөгийн санхүүжилттэй давхардсан байна. /тооцоог хавсралтаар тусд нь гаргасан байгаа/ Тухайлбал: БНХУТ-ийн үндсэн барилгад хийгдээгүй ажлын гүйцэтгэл болох 2,081,902, 848 төгрөг, үнэлгээний төсвөөс илүү бичсэн 1,557,556,495 төгрөг, Голомт банкны баталгаагаар

2013.01.23-нд 500,000,000 төгрөгийг олгосон, 05 дугаар ажлын гүйцэтгэлд ажлын гүйцэтгэлээс 23,202,202 төгрөг илүү олгосон, төв барилгын гадна дулаан солих, бохирын инженерийн шугам сүлжээг зөөх, гадна дулааны Ф-150 шугамыг Ф-200 болгон солих, барилгын талбайн замын хавтанг буулгах ажлаас 429,286,922 төгрөгийн ажлыг гэрээт ажлын гүйцэтгэлээр гаргасан ба мөн Голомт банкны баталгаагаар 329,999,978 төгрөгийн санхүүжилт олгосон барилгын цахилгааны дэд өртөө, гаднах цахилгаан, холбооны ажлын дэд өртөөний цахилгааны тоног төхөөрөмжийг давхардуулан гүйцэтгэлд оруулсан 70,466,224 төгрөгийн санхүүжилтийг тус тус илүү олгосон нийт 4,563.1 сая төгрөгийн тооцоог захиалагчтай хийж тооцоо нийлж, баталгаажуулах шаардлагатай байна гэж үзлээ. ИНЕГ нь захиалагчийн зүгээс тавих хяналт хангалтгүй, хариуцаж буй алба нэгжийн удирдлагын ажлын хариуцлага суларсан, гүйцэтгэгчээс ирүүлсэн ажлын гүйцэтгэлийн баримт материалыг үнэлгээ төсөв, гүйцэтгэл тоо мэдээтэй, бодит хийсэн ажлын гүйцэтгэлтэй тулган баталгаажуулах, үйл ажиллагааг мөрдөх журам заавар, барилгын ажлын үнэлгээ нормыг нарийвчлан хянаж баталгаажуулаагүй, хариуцан ажиллаж байгаа мэргэжилтэний ажлын мэдлэг, чадвар, дадлага туршлага, хариуцлага сахилга хангалтгүй байсантай холбоотойгоор илүү санхүүжилт олгогдсон болох нь баримтаар тогтоогдож байгаа бөгөөд банкны баталгаагаар гүйцэтгээгүй ажлын гүйцэтгэлд их хэмжээний санхүүжилт илүү авсан байна. Иймд энэхүү илүү олгосон санхүүжилтийг “Үүрэг трейд” ХХК-иас нэхэмжлэн авах, эсвэл ажлыг гүйцэтгүүлэн, гаргаж ирүүлсэн гүйцэтгэлээс суутган тооцох, эс тохиролцвол шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Мөн Захиалагчийн хяналтын ажлыг хариуцаж байсан, гүйцэтгэлийг хянаж баталгаажуулан хяналт тавьж байсан албан тушаалтнуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох.

Гүйцэтгэгчээс шүүхэд нэхэмжлэл гаргасан үед захиалагчийн зүгээс анхааралтай хандаж, бодитой тайлбар, нотолгоог гаргаж өгч ажиллаагүй байна. “Үүрэг трейд” ХХК

нь Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ: ИНЕГ/ТББ/БУ-47/10/93 дугаар гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийн 44 дүгээр заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40.4, 40.4.2 дах заалтын дагуу Зам, тээвэр, барилга хот байгуулалтын яамны сайдын 2012 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 18 дугаар тушаалаар “Барилгын машин ашиглалтын жишиг үнэ” /БД 81-112-11/, “Барилгын технологийн тээврийн автомашины цагийн болон тн/км-ийн жишиг үнэ” /БД81-113-11/ болон “Барилгын материал, бүтээц, эдлэлийн жишиг үнийн 2012 оны үнийн лавлах” БД81-109-11/-г баталж мөрдүүлснээр барилгын материалын суурь үнэ огцом өөрчлөгдөж, нэхэмжлэгч нь барилгын гол нэрийн материалын үнийн өсөлтийн талаарх мэдээллийг Үндэсний статистикийн хорооноос гаргуулж хавтас хэрэгт авагдсаныг ШУТИС-ийн Барилгын инженер архитектурын сургуулийн шинжээчид үндэслэл болгон Монгол Улсын зөвлөх эдийн засагч

Д.Очирбат, Барилгын инженер Ж.Дуламжав, Ш.Бадамцэцэг нар шинжээчийн дүгнэлт гаргаж, дээрхи дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд ирүүлжээ.

Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд дээр дурьдсан үндэслэлүүдийг иш үндэс болгон 2013 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 1463 тоот шийдвэрээр шинжээчдийн гаргасан дүгнэлтээр гарсан үнийн тохируулга болон тэмдэгтийн хураамж, бусад зардалд 3,892,092,063 төгрөгийг Зам тээврийн яам, ИНЕГ-аас гаргуулан “Үүрэг трейд” ХХК-д олгохоор шийдвэрлэжээ. Гэтэл ИНЕГ-аас 2016 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 01/393 тоот албан бичгээр Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2012 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн “Барилгын дүрмүүд батлах тухай” 18 дугаар тушаал нь Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журмын 2.4, 2.5-д заасны дагуу Хууль зүйн яаманд бүртгүүлж нийтээр дагаж мөрдөх эрхийн актын жагсаалтад орсон эсэхийг тодруулахад Хууль зүйн яамны Хууль зүйн нэгдсэн бодлогын газрын дарга Т.Ганбаатарын гарын үсэгтэй 2016 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 5/701 дугаар бүхий албан бичигт энэхүү тушаал нь захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн нэгдсэн бүртгэлийн санд бүртгэгдээгүй болохыг мэдэгдсэн байна. Захиргааны хэм хэмжээ тогтоосон, гадгаш чиглэсэн шийдвэр нь Хууль зүйн мэдээлэл сэтгүүлд нийтлэгдсэнээр хүчин төгөлдөр болно гэжээ. Энэхүү албан тоотод уг тушаалыг ирүүлж бүртгүүлээгүй тул хуулиар эрх олгосон, хэм хэмжээ тогтоосон эсэхийг мэдэх боломжгүй гэжээ. Иймд Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2012 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн “Барилгын дүрмүүд батлах тухай” 18 дугаар тушаал нь Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журмын 2.4., 2.5-д заасны дагуу хүчин төгөлдөр мөрдөх эсэх, Хууль зүйн яаманд бүртгүүлж нийтээр дагаж мөрдөх эрхийн актын жагсаалтад орж, “Хууль зүйн мэдээлэл сэтгүүлд нийтэлсэнээр хүчин төгөлдөр болно гэж заасны дагуу хүчин төгөлдөр нийтээр дагаж мөрдөх, хэм хэмжээ болгосон эрхийн акт эсэх нь тодорхойгүй байхад, “Үүрэг трейд” ХХК нь захиалагчаас 5,4 тэрбум төгрөг нэхэмжилж 3,829.0 сая төгрөгийг гаргуулах нэхэмжлэл гаргуулах шүүхийн шийдвэр гарч, шийдвэр гүйцэтгэлийн журмаар хэрэгжүүлсэн байна.

Энэ байдлаас үзэхэд улсад болон байгууллагад ихээхэн хэмжээний хохирол учирч байхад энэ хугацаанд Захиалагч болох ЗТЯ-ны болон ИНЕГ-ын тухайн үеийн удирдлагууд, тэдгээрийн хуулийн газар холбогдох, эрх бүхий албан тушаалтнууд нотлох баримтыг гарган, хуульд нийцсэн бодит үндэслэлтэй тайлбарыг гарган өгч, шударгаар мэтгэлцэх замаар өөрсдийн эрх ашгийг хамгаалах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна гэж үзэж байна.

Байгууллагад хохиролтой гэрээ байгуулж үргүй зардал гаргасан

“ARINC” компанийн Монгол дахь албан ёсны төлөөлөгч

“Электрон системс” ХХК-ийн талаар

“Чингис хаан” Олон улсын буудалд зорчигч бүртгэлийн системийн операторын ажлыг гүйцэтгүүлэх тухай ИНЕГ/У/ХХБ-04/12 дугаартай гэрээг 2012 оны 02 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан байна.

Иргэний нисэхийн ерөнхий газар нь “Чингис хаан” Олон улсын буудалд зорчигчдын бүртгэлийн электрон системийг нэвтрүүлж, түүний операторын үүргийг гүйцэтгүүлэхээр “ARINC” компанийн албан ёсны төлөөлөгч гэх “ЭЛЕКТРОН СИСТЕМС” ХХК-тай 2012 оны 02 дугаар сарын 27-ны өдөр гэрээ байгуулсан байна. Гэтэл уг зорчигч бүртгэлийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт “Азиатал” ХХК шалгарч техник, тоног төхөөрөмж, зорчигч бүртгэлийн программ хангамжийн иж бүрдэл COTS software “vMUSE” License лицензийн хамт 299.3 сая төгрөгөөр 2012 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр нийлүүлсэн байна. Үүний дараа тендер шалгаруулалтаар зорчигч бүртгэлийн дундын системд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх ИНЕГ/У/Х/ХББ/Б-34/12 тоот гэрээг “Электрон системс” ХХК-тай байгуулж 29.6 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг нэмж авчээ. “Азиатал” ХХК нь тендерт оролцох үедээ “ARINC” LLC компанитай хамтран ажилладаг түншлэгч болохоо нотолсон баримтын хуулбарыг ирүүлсэн байгаагаас ойлгогдож байна.

“Азиатал” ХХК нь зорчигч бүртгэлийн дундын систем болох “vMUSE” License системийг суурилуулж, нутагшуулах, боловсон хүчнийг нь сургаж, бэлтгэн өгөх тухай үүрэг хүлээсэн байсныг харгалзахгүйгээр гэнэт “ARINC” LLC компанийн Монгол дахь албан ёсны төлөөлөгч гэх “Электрон системс” ХХК-тай гэрээ байгуулж, энэ ажлыг гүйцэтгүүлэх болсон нь ойлгомжгүй асуудал болсон төдийгүй, үргүй зардал гарч, ажлын тодорхой үр дүнд гараагүй бөгөөд хууль хяналтын байгууллагаар удаа дараа шалгагдсан зэрэг шалтгааны улмаас 2014 оноос энэ систем нэвтрүүлэх ажил зогссон байна.

“Электрон системс” ХХК нь “ARINC” LLC компанийн албан ёсны төлөөлөгч биш болохыг хожим нь тогтоож нотлох баримттай болсон бөгөөд тус компани нь зөвхөн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг худалдан авч борлуулсан болох нь тодорхой болжээ.

Мөн энэ үед олон улсын агаарын тээврийн холбооны IT SITA компани “Чингис хаан” ОУБуудалд зорчигч бүртгэлийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж, программ хангамж, лицензийн хамт нэг удаагийн худалдан авалтаар 264,9 мянган ам доллар, хэрэв 5 жилийн хугацаатай лизенгээр худалдан авах бол 307,9 мянган ам доллараар нийлүүлэхээр санал болгож, энэ хөрөнгө оруулалтыг нөхөх хугацаа, боломжийн талаар санал тавьж байсныг ч тухайн үед харгалзан үзэлгүй шийдвэрлэж байжээ. ИНЕГ-ын бодлого, зохицуулалтын ерөнхий менежерээс, санхүү төлөвлөлтийн ерөнхий менежерт 2011 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 65 тоот албан бичгээр “Чингис хаан” ОУБуудалд мөрдөж буй зорчигч үйлчилгээний хураамжийг нэмэгдүүлэх санал, хүсэлт шаардлагыг үндэслэн санхүү, төлөвлөлтийн ерөнхий менежер Г.Наранцэцэгийн 11 дүгээр сарын 18-ны өдрийн 03/3117 тоот албан бичигт одоо мөрдөж байгаа үйлчилгээний үнэлгээг холбогдох тооцоо, үндэслэлийг сайтар судалж өөрчлөн тогтоож, баталгаажуулж ажиллах

талаар “Чингис хаан” ОУБуудлын захирал Л.Нацагнямд мэдэгджээ. Үүний дагуу тус буудлын захирал 2011.11.18-ны өдөр А/96 тоот тушаал гаргаж “Чингис хаан” ОУБуудлын үйлчилгээний үнэ тарифт өөрчлөлт оруулжээ. Үнэлгээнд өөрчлөлт оруулсан уг тушаалын 7.2 заалтад олон улсын зорчигч үйлчилгээний хураамжийг 22,000 төгрөг болгон өөрчлөн тогтоосон байна.

Ийнхүү үнэ тарифыг өөрчлөн тогтоож буй шийдвэр нь Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан журмын 1.3-т заасан захиргааны хэмжээ тогтоосон шийдвэр гаргах этгээд мөн эсэх, нийтээр дагаж мөрдөх шийдвэр гаргах, хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээд мөн эсэх, гаргасан шийдвэрээ энэ журмын 4.2-д заасны дагуу Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлж журмын 4.3. болон 2.5.1-2.5.3-д заасны дагуу шийдвэрлүүлсэн эсэх нь тодорхойгүй байна. /тухайн үед мөрдөж байсан Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоол Ер нь Иргэний нисэхийн салбарын хэмжээнд нийтээр дагаж мөрдөх журмыг тогтоохдоо хуульд нийцүүлэх үүднээс Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар эрх үндсийг бүрдүүлж, баталгаажуулж, журамлан тодорхой болгох шаардлагатай байна.

Иймд Иргэний нисэхийн салбарт захиргааны хэм хэмжээ тогтоосон, нийтээр дагаж мөрдөхөөр гаргаж буй шийдвэрийг хуулиар тусгайлан эрх олгогдоогүй субъект гаргаснаас шалтгаалан ихээхэн сөрөг үр дагавар гарч, эрсдэл үүсч болзошгүй байдалтай байгааг анхаарч хууль журмын хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.

“Чингис хаан” Олон улсын буудал нь 2012 оны 10 дугаар сарын 01-нээс эхлэн “МИАТ” ХК болон “Монголиан Эйрлайнс” групптэй зорчигч бүртгэлийн “vMUSE” License системийг ашиглах талаар хамтран ажиллах гэрээ байгуулсан байна. Үүний дараагаар уг системийн алдаа дутагдлын талаар “МИАТ” ХК-иас 2013 оны 03 дугаар сарын 01-нд 03/852 тоотор, 2012 оны 12 дугаар сарын 08-наас 2013 оны 02 дугаар сарын 08-ныг хүртэлх хугацааны системд гарсан зөрчил, дутагдал, гологдлын жагсаалтыг ирүүлсэн байна. Энэ байдлаас үзэхэд энэ систем нь хэвийн ажиллагаанд жигдрээгүй, дутагдал доголдол гарсаар байсныг тодорхойлж, гүйцэтгэгч компанид энэ систем дээр ажиллах өндөр мэдлэг чадвар, туршлагатай ажилтан байхгүй болох нь тодорхой бөгөөд системийг хэрэглэгч агаарын тээврийн компаниуд нэгдэн ороход энэ систем найдвартай ажиллана гэдэгт итгэл үнэмшил төрөхгүй байсан бололтой байна. Үүнийг Air China-гийн төлөөлөгчийн газар болон “МИАТ” ХК-иудаас ирүүлсэн албан бичгээс тодорхой харагдаж байлаа.

**Дутагдалтай тал нь:** Гэрээндээ уг системийг суурилуулан хүлээлгэн өгөх хугацааг тодорхой заагаагүй, мөн гүйцэтгэгч энэ системийг нутагшуулах, ажиллах мэргэжилтнүүдийг сургаж, бэлтгэн өгөх хугацаа, тодорхой хөтөлбөр, төлөвлөгөө байхгүй. Уг системийг суурилуулж, турших хугацааг захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд тодорхой зааж тохиролцоогүй. Зорчигчийн бүртгэл явуулах “vMUSE” системийг суурилуулж нэвтрүүлснээр бусад хэрэглэгч болох агаарын тээврийн компаниудтай харилцан тохирч



/урьдчилсан төсөл боловсруулж, үр ашгийн тооцоо хийсэн байх/ төлбөр хураамж авах талаар ярилцаагүй байсан нь шууд төлбөр авах эрх зүйн үндэс бүрдээгүй бололтой. Тухайлбал: "Чингис хаан" ОУБуудлын захирлын 2011 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/96 тоот тушаалаар "Чингис хаан" ОУБуудлын үйлчилгээний үнэлгээнд өөрчлөлт оруулахдаа 7.2 заалтад олон улсын зорчигч үйлчилгээний хураамжийг 22,000 төгрөг болгон өөрчилөн тогтоосон нь дээрхи гэрээний ерөнхий нөхцөлийн "С"-д заасан зорчигч бүртгэлийн үйлчилгээний орлогоос төлбөрийн эх үүсвэр болгон ашиглах үндэслэл байхгүй байна гэж үзэж байна.

"ЭЛЕКТРОН СИСТЕМС" ХХК нь "Чингис хаан" ОУБуудалд дундын хэрэглээний зорчигч бүртгэлийн систем суурилуулан, нутагшуулах, техникийн шаардлагад тусгагдсан гүйцэтгэгч нь Иргэний агаарын тээврийн мэдээллийн технологийн чиглэлээр хамгийн багадаа 10 жил ажиллаж, олон улсын зах зээл дээр бараа, бүтээгдэхүүн нь танигдсан, амжилтад хүрсэн гадаадын мэдээллийн технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч байгууллагын системийг /программ хангамж, тоног төхөөрөмж/-ийг нийлүүлж, нутагшуулах гэсэн ТББ-д заасан шаардлагыг хангаж байсан нь эсэхийг тогтоох боломжгүй /баримт байхгүй/ байна.

"МИАТ" ХК нь Монгол улсад олон улсын агаарын тээврийн зорчигч үйлчилгээ эрхэлж буй гадаадын агаарын тээврийн компаниудтай олон жилийн турш газрын багц үйлчилгээ үзүүлэх гэрээтэй ажилладаг бөгөөд энэхүү гэрээнд зорчигч бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ мөн хамрагдах ёстой байна. Иймд энэ үйлчилгээг "Чингис хаан" олон улсын нисэх буудалд шилжүүлэн авч ажиллуулан орлого үйлчилгээгээ нэмэгдүүлэх нь зөв зүйтэй ажил боловч, энэ үйлчилгээг шууд эрхлэн явуулах боловсон хүчний нөөцгүй, сургаж дадлагажуулсан хүнгүй, ямарч бэлтгэл ажил хангагдаагүй, агаарын тээврийн компаниудтайгаа урьдчилан ярьж тохиролцоогүй байсан нь энэ ажил үр дүнгүй болж зогсоход хүрчээ. "Чингис хаан" Олон улсын буудал нь 2012 оны 10 дугаар сарын 01-нээс эхлэн зорчигч бүртгэлийн "vMUSE" License системийг нэвтрүүлж ажилласнаар "Чингис хаан" ОУБуудлын захирлын 2011 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/96 тоот тушаалаар "Чингис хаан" ОУБуудлын үйлчилгээний үнэлгээнд өөрчлөлт оруулахдаа 7.2 заалтад олон улсын зорчигч үйлчилгээний хураамжийг 22,000 төгрөг болгон өөрчилж тогтоосон нь орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлсэн биш, зорчигч тутамд 4,000 төгрөгөөр бууруулсан гэрээ болсон байна. Мөн "Электрон системс" ХХК-тай операторын үйл ажиллагааг гүйцэтгүүлэх гэрээний ерөнхий нөхцөлийн "b" заалтад дурдсан үйлчилгээ үзүүлэгчид төлөх үйлчилгээний төлбөр нь бүртгүүлсэн нэг зорчигчид "1,000" төгрөг, "4,000" төгрөг гэсэн хоёр өөр үнэлгээтэй 2 өөр гэрээний аль нэг нь хуурамч гэрээ байна гэж үзэж байна.

ИНЕГазар нь "Чингис хаан" Олон улсын буудалд "ARINC" компанийн албан ёсны төлөөлөгч "ЭЛЕКТРОН СИСТЕМС" ХХК-иар зорчигчийн бүртгэлийн системийн операторын үйл ажиллагааг гүйцэтгүүлэх гэрээг 2012 оны 02 дугаар сарын 27-ны өдөр байгуулж, гэрээний дагуу 2012 оны 02 дугаар сарын 28-нд 300,000,000 төгрөг, 02 дугаар сарын 29-нд

236,331,200 төгрөг, 10 дугаар сарын 09-ний өдөр 300,000,000 төгрөг, 12 дугаар сарын 28-нд 226,628,000 төгрөг, нийт 1,062,959,200 төгрөг шилжүүлсэн бөгөөд, мөнгийг нягтлан бодох бүртгэлийн бичилтээр "ЭЛЕКТРОН СИСТЕМС" ХХК-ийн нэр дээр 1200-1716-04 тоот урьдчилж төлсөн тооцоо данс нээж бүртгэсэн ба "Чингис хаан" ОУБуудлаас тооцогдож ирсэн зорчигч бүртгэлийн хураамж болох 329,382,225.50 төгрөгөөр дээрхи урьдчилж төлсөн тооцооны дансанд нэмэгдүүлэн бүртгэж, тус компанид төлсөн нийт 1,392,341,425.50 төгрөгийг "Чингис хаан" ОУБуудлаас авах авлагаар шилжүүлэн хаасан бичилт хийжээ.

"Чингис хаан" ОУ-ын буудал нь авиа компаниудаас авах зорчигч үйлчилгээний хураамж болох 22,000 төгрөгөөс 4,000 төгрөгийг ИНЕГ-т өгөх өглөгөөр бичиж, үлдэх 18,000 төгрөгийг зорчигч үйлчилгээний орлогоор бүртгэж, мөн 1,392,341,425 төгрөгийг ИНЕГ-т өгөх өглөг, "Электрон системс" ХХК-иас авах авлагаар хааж бичсэнээр дээрхи компаниас авах авлага, өгөх өглөггүйгээр бүртгэлийн бичилтийг хийжээ. Иргэний нисэхийн ерөнхий газар нь "Чингис хаан" Олон улсын буудалд зорчигчдын бүртгэлийн электрон системийг нэвтрүүлж, түүний операторын үүргийг гүйцэтгүүлэхээр "ARINC" компанийн албан ёсны төлөөлөгч гэх "ЭЛЕКТРОН СИСТЕМС" ХХК-тай 2012 онд гэрээ байгуулж ажилласан нь ИНЕГазарт хохиролтой, тавьсан зорилго нь хангагдаагүй тул, үр ашиггүй хөрөнгө оруулалт болсон байна. "Чингис хаан" ОУБуудлын зорчигч үйлчилгээний орлогыг нэмэгдүүлэх биш бууруулж, хэрэглэгч авиа компаниудаас уг системийг ашигласны төлбөр хураамж авах нөхцөл бүрдээгүй, урьдчилан ярилцаж тохиролцоогүй, систем ашигласны үйлчилгээний төлбөр авах эрх зүйн зохицуулалтгүй байна. Суурилагдсан тоног төхөөрөмжийг бүрэн ашиглаж, зорчигч бүртгэлийн үйл ажиллагааг хэвийн горимд оруулж чадаагүй, программ хангамжийг ашиглах чадвартай мэргэжлийн боловсон хүчин байхгүй, сургаж бэлтгэн өгч дадлагажуулаагүй. Зорчигч бүртгэлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, уг системээр нэвтэрсэн зорчигчийн бүртгэлд үндэслэн бичсэн төлбөрийн нэхэмжлэл ирүүлдэггүй, 2 өөр үнэтэй, 2 гэрээ байх тул алийг нь мөрдөж ажиллах нь ойлгомжгүй байгууллагад хохиролтой байна. Операторын хөлсөнд төлсөн 1,062.9 сая төгрөгийг "Электрон системс" ХХК-иас буцаан нэхэмжлэх, зорчигч бүртгэлийн хөлсөнд өглөгөөр тусгасан 329.4 сая төгрөгийн өглөгийг хүчингүй болгох зэрэг арга хэмжээ авч ажиллах.

**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмыг зөрчиж хэрэгжүүлсэн худалдан авалтын талаар:**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-дэх заалтын дагуу, босго үнийн хязгаарыг баримтлалгүйгээр, төсөвт өртгийг хэсэгчлэн хувааж, нээлттэй тендер зарлахаас татгалзаж худалдан авах ажиллагааны аргыг буруу хэрэглэсэн, хөдөлмөр хамгааллын болон ажлын хувцас, дүрэмт хувцсыг алба нэгжээр нь салган төлөвлөж тус бүрээр нь салгаж, худалдан авалтыг зохион байгуулж хууль зөрчсөн байна.

Тус газар нь 2017 оны 08 дугаар сарын 01-ний өдөр 2017 оны урсгал зардлын төлөвлөгөөнд тусган "Гүрэн" дээд сургуультай 640.0 сая төгрөгийн зөвлөх үйлчилгээний

гэрээ байгуулж ИНЕГ-ын харъяа алба салбарын ажилтнуудад салбарын менежмент, нисэх буудал газрын үйлчилгээ, ачаа тээвэр, аюулгүй байдлын чиглэлийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сертификат бүхий сургалтуудыг англи, монгол хэл дээр зохион байгуулж, сургагч багш нарыг бэлтгэх, мэргэжлийн англи хэлний мэдлэгийг дээшлүүлэхээр тохиролцсон байна.

Гэрээнд заасны дагуу 2017 оны 8 дугаар сарын 3-нд урьдчилгаанд 240.0 сая төгрөг, 11 дүгээр сарын 21-нд 16.0 сая төгрөг, 12 дугаар сарын 28-нд 256.0 сая төгрөг нийт 512.0 сая төгрөгийг тус сургуульд шилжүүлж үлдэгдэл 128.0 сая төгрөг байна. Шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг хүснэгтээр харуулбал:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланд тусгагдаагүй худалдан авалтын ажлууд /урсгал орлогоос/

д/д	Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, төрөл, тоо хэмжээ, хаана хэрэгжсэн	Гүйцэтгэгчийн нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Гүйцэтгэл өртөг /сая.төг/	Тайлбар
1	Орон нутгийн нисэх буудлуудад агаарын хөлгийн гал унтраах зориулалтын хөөс нийлүүлэх	"Энх заяат Фамили" ХХК	29.5	29.5	ТББ-д заагаагүй 40.0 Хувийн урьдчилгаа өгсөн зөрчилтэй. Хэсэгчлэн хувааж НТШ-ыг зарлахаас зайлсхийсэн.
2	Орон нутгийн нисэх буудлуудад 2 тн галын хөөс нийлүүлэх	"Энх заяат Фамили" ХХК	25.9	25.9	Хэсэгчлэн хувааж НТШ-ыг зарлахаас зайлсхийсэн.
3	Орон нутгийн НОБ-уудад хорлон сүйтгэх ажиллагаа, хууль бус наймааны халдлагад дам ачаагаар дамжин өртөхөөс агаарын тээврийн зорчигчдыг сэргийлэх сэрэмжлүүлэг нийлүүлэх.	"Баянгол Фүүд" ХХК	29.9	29.9	Нэг төрлийн барааг нэгтгэж багцлалгүй, салган хувааж, нээлттэй тендер зарлахаас зайлсхийсэн.
4	Агаарын хөлөгт хориглосон эд зүйлс,	"Баянгол Фүүд" ХХК	29.9	29.9	Багцлалгүй, НТШ-аас зайлсхийсэн.
5	Орон нутгийн НОБ-уудад Аюулгүй байдлын үзлэгийн наалт 850 000 ш нийлүүлэх.	"Энхзаяат фамили" ХХК	29.9	29.9	1 төрлийн бараанаас салган нээлттэй Тендерээс зайлсхийсэн. 2012 онд
6	ИНЕГ-ын харъяа Ус, дулаан дамжуулах төв №3-ын гадна гадна цахилгааны кабель нийлүүлэх	"Бодь суварга" ХХК	17.2	17.2	2012 онд Төлөвлөгөөнд тусгалгүй худалдан авч, гүйцэтгэлийг тайланд тусгаагүй орхисон.
7	"Иргэний нисэхийн салбарын эрсдлийн үнэлгээ хийх" ИНЕГ ТББ/ЗҮ/03-11	"Практикал даатгал" ХХК	100.0	100.0	2011.11.28-нд гүйцэтгэчийг шалгаруулах НТШ-гүйгээр шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТ Хуулийн холбогдох заалтыг зөрчсөн. АХКомисс 2012.03.22 А/107
8	Өмнөговь аймгийн хөөрч,буух асфальтон зурвасыг даатгах	"Жонон даатгал" ХХК	86.5	86.5	Сонгон шалгаруулалт явуулалгүй Шууд гэрээг 2011.10.02-нд байгуулж, даатгалын хураамжийн урьдчилгаанд 30.0 сая төгрөгийг 2012.01.06 ТД№1586-гаар 86,549,168.30 төгрөг шилжүүлжээ.
9	Тээврийн дээд сургуулийн механик инженерийн ангийн лекцийн танхим болон лаборато засварын ажлыг хийж гүйцэтгүүлэх.	"Ресистант Констракшн" ХХК	6.5	6.5	Шууд гэрээ байгуулж бусад Байгууллагын урсгал засвар, тохижилтыг байгууллагын зардлаар хийж, ивээн тэтгэсэн.
10	2012 оны даатгалын зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулалтгүйгээр шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн	"Ард", Бодь" "Практикал" даатгал компаниуд	-	1.2	"Бодь даатгал" ХХК-д 571.7 сая төгрөг, "Практикал" даатгалд 559.1 сая төгрөг, "Ард" даатгалд 125.3 сая төгрөг
11	Бодит ажиглалтын систем 2 ширхэг /баруун, зүүн бүсэд/	Бодь-Интернейшнль ХХК	10.0	9.5	Захиалагч Бодь-Интернейшнль ХХК-ийг шалгаруулсан боловч, оролцогч АУМ ХХК-ийн гомдлоор маргаан үүсч Сангийн яамнаас

					тенд-ийн үнэлгээг дахин хийлгэсэн боловч, өмнөх үнэлгээ хэвээр гарсан. ШӨХТГ-аас 2011.07.22-ны 1/664 тоотор захиалагчийн шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгож дахин тендер зарлахыг мэдэгдсэн боловч, уг компаниар ажлыг хийлгэж дуусгасан.
12	Увс аймгийн шинэ нисэх Буудалд 50 м3 багтаамж бүхий Шатахууны агуулах барих /Улсын төсвийн хөрөнгөөр/ Гэрээний дугаар ИНЕГ-ТББ/А-55/11	"Арвижих Увс" ХХК	149.5	105.5	2011-2012 онд хийгдсэн. НТШ-ыг зарласан боловч тусгай зөвшөөрөлгүй компанийг шалгаруулсан. Гомдол гарч эрх бүхий байгууллагаас тендерийг түдгэлзүүлсэн боловч захиалагч өмнө нь энэ төлийн ажлыг хийж байсан гэдгээр шууд гэрээ байгуулж сонгон шалгаруулалтын маргаан дуусаагүй байхад гүйцэтгүүлж дуусгасан.
13	Зам, тээврийн яамны гадна фасат, дээврийн засварын ажил гүйцэтгүүлсэн	"Баядах өргөө" ХХК	136.8	136.8	2012.08.24 А/287 №ИНЕГ/У/ХББ/А-46/12 136.8 сая төгрөгөөр засвар хийж, гүйцэтгэлийг ИНЕГ--ын зардлын гүйцэтгэлд тооцож тайлагнасан. Хуулийн 34.1.5 заалтыг баримтлан шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн.
14	Thales RSM-970S моноимпульсийн хоёрдогч Радиолокаторын S горимын хүлээн авагчийн блок 1 ширхэг	"Thales" ХХК	151.0	151.0	2013 онд НТШ амжилтгүй болж, үйлдвэрлэгчтэй шууд гэрээ байгуулан 70843 евро буюу тухайн үеийн ханшаар 150.0 сая төгрөгийг 100 хувь төлж, 4 сарын дотор бүрэн нийлүүлэхээр тохирсон боловч хуулийн 34.3-д заасны дагуу дуусгавар болгоогүй байна.
15	"Чингис хаан" ОУНБ-ын Зорчигчдын ирэх, явах чиглэлд аюулгүй үзлэгийн тоног төхөөрөмж 2 ширхэгийг худалдан авах /X-RAY/	"Ач СВС"	200.0	199.7 Цэвэр ашгаас санхүүж-сэн	2013.10.10-нд НТШ зарлаад, 2013.11.11 нээсэн, "БИТ ТНН" ХХК-иас "ШӨХТГ-т гомдол гарснаар ТББ-д өөрчлөлт оруулж, хугацааг сунгуулж дахин зарлаад нээж үнэлэхэд мөн "Ач СВС" шалгарч гэрээ байгууулсан үүний дараа 2013.12.26-нд СЯ-наас гэрээ байгуулах эрх олгосон нь үндэслэлгүй байна гэсэн бичиг ирсэн боловч, 2013.12.24-нд байгуулсан гэрээ маргаан дуусаагүй байхад хэрэгжсэн байна.
16	Хөдөлмөр хамгааллын хувцасны дүн		212.2	212.2	2012-2013 онд худалдан авсан
-	ХНБАҮА-ны ИТА-нуудын өвөл зуны ажлын гутал	"Вюрт Монголия" ХХК		20.8	2012 он, Хэсэгчлэн хувааж худалдан авалт хийсэн. Харьцуулалтын хэрэглэж сонголт хийж гэрээ байгуулсан 20 769 000 төгрөг
-	ХНБАҮА-ны ИТА нарын өвлийн хувцас	"Дархан нэхий" ХХК		9.3	2012.12.20-нд хэсэгчлэн авсан. /ХА/ 9 388 750 төгрөг
-	ТХҮА-ны ИТА-нуудын өвлийн хүрэм /56 хос/	"Дархан нэхий" ХХК		10.4	Харьцуулалт 10 360 000 төгрөг
-	Өвлийн гутал 47 хос, зуны гутал 43 хос хөд/хам/-ын хувцас	"Их угсаа" ХХК		12.7	Харьцуулалтын аргаар 12,691,250 төгрөгөөр
-	Зуны хүрэм 98 хос, зуны мөрвчтэ Хүрэм 33 ширхэг	"Баялаг хатгамал"		8.9	Харьцуулалтын аргаар 8,908,000 төгрөгөөр
-	Хөдөлмөр хамгааллын хувцас	"Соджель ном" ХХК		29.9	2012 онд 29,904,000 төгрөгөөр худалдан авсан.
-	Хөдөлмөр хамгааллын хувцас	"Наран шигтгээ" ХХК		18.4	18,410,139 төгрөг

-	178 хос гутал худалдан авсан	"Агудам" ХХК		29.8	Харьцуулалтын аргаар 29,760,000 төгрөг
-	Хөдөлмөр хамгааллын хувцас	"Стандарт оюу" ХХК		29.3	Харьцуулалтын арга 29,326,000 төгрөг
-	Хөдөлмөр хамгааллын хувцас	"Энхзаяат Фамиле" ХХК		24.7	ХА 24,680,000 төгрөг
-	Ажлын гутал 150 ширхэг нийлүүлэх	"Корнфловей" ХХК		18.0	2012.10.31-нд хүлээн авч гэрээг дүгнэсэн.
17	Зам тээврийн яамны 3 өрөөнд засвар хийсэн	"Алтайн мөнх билэгт"		4.6	Төлөвлөгөөнд тусгаж батлаагүй, тайланд орхиж тайлагнаагүй. 2015 онд ИНЕГ-ын дарга Т.Лхагвасүрэн баталж шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. 4,587,360 төгрөг
18	УБ хотоос Хөшигийн хөндийн шинэ буудал хүртэлх 45 км шилэн кабелийн трассын дагуу 10 м өргөнтэй хамгаалалтын зурвасын байр зүйн дэвсгэр зургийн хээрийн судалгаа хэмжилтийн ажил.	"Геоботаник" ХХК		8.1	Төлөвлөгөөнд тусгаж батлаагүй, тайланд орхиж тайлагнаагүй.
19	DME-435 зай хэмжих төхөөрөмж, нийлүүлж суурилуулах /10ком/	"Тридум э-Секьюрити" ХХК	2,000.0	1,998.9	2013-2015 он 2015.11.27-ны өдөр үйлдвэрлэгч Итали улсын "Thales" компанийн эрх олгосон дистербютер-тэй гэрээ байгуулсан боловч хуулийн 34.3-д заасны заасны дагуу СЯ-д мэдэгдэж дуусгавар болгоогүй. 1,998,950,000 төгрөг
20	Сургалт зохион байгуулах зардалд	Тридум Э-секьюрити ХХК		42.7	2014.07.01-ний №60/14 Сургалтын гэрээний дагуу Голомт банкны Харилцахаас ТД-509-өөр 2014.07.04-ны 42,670,000 төгрөгийг шилжүүлсэн гүйцэтгэлийн тайлан, холбогдох баримтыг хавсаргаагүй.
21	Хөрш зэргэлдээ орнуудын нислэг хөдөлгөөн удирдах төвүүдтэй өгөгдөл дамжуулах тоног төхөөрөмж, программ хангажийн өргөтгөл	Үйлдвэрлэгч Испани улсын "Индра" компани	713.0	713.0	Урьд нь гүйцэтгэсэн адил төстэй гэрээний үнийн дүнгийн 20%-д багтаж байгаа үйлдвэрлэгчтэй шууд гэрээ байгуулсан. 327,004.22 евро хуулийн 34.3-д заасны заасны дагуу СЯ-нд мэдээллээ хүргүүлээгүй.
22	Нислэгийн хөдөлгөөний удирдлагын автоматжуулалтын системийн программ хангамжийн өргөтгөл.		370.0	370.0	2015.10.16-нд "Индра" компанитай 169.7 мянган евро буюу 370.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан ТБОНӨХБАУХАТ-ийн 34.3-д заасны заасны дагуу СЯ-нд шууд гэрээ байгуулсан үндэслэл, гэрээний хувийг хүргүүлээгүй.
23	ИНЕГ-ын ажлын хэрэгцээнд 7 ширхэг суурин компьютер худалдан авч бэлтгэсэн	"Эм эс Эй" ХХК		10.0	Төлөвлөгөө, тайланд тусгагдаагүй шууд худалдан авсан
24	Чиглүүлэх станцуудын эд анги модулиуд	"Глобал телеком" ХХК	80.0	78.2	2015.10.16-нд өмнө байгуулж байсан гэрээний 16.5 хувь байгаа тул шууд гэрээ байгуулсан.ТБОНӨХБАУХАТ Хуулийн 34.3-д заасны заасны дагуу СЯ-нд шууд гэрээ байгуулсан үндэслэл, гэрээний хувийг хүргүүлээгүй 78,210.0 мянган төгрөг байна.
25	Перрон онгоц зогсоолын талбайн гэрэлтүүлэг	"РЭС" ХХК	240.0	227.8	2015.10.16-нд ШГБ-лсан боловч, үндэслэл гэрээний хувийг хүргүүлээгүй.
26	Канон, принтерийн төрөл бүрийн хорнууд	"ЦЦАМ" ХХК	32.1	32.1	2013.11.29-ний ТД-983-аар 32,135,000 төгрөгийг шууд шилжүүлэн худалдан авч, ХАА-ны тайланд тусгаж тайлагнаагүй.
27	Радио аэронавигацын үйлчилгээний DVOR/DME-ийн сэлбэг нийлүүлэх А2523 тоот гэрээгээр	INDRA AUSTRALA / Pty Ltd /		21,102 Авсрали доллар	Үйлдвэрлэгчтэй шууд гэрээ байгуулан худалдан авсан ТБОНӨХБАУХАТ Хуулийн 34.3-д заасны заасны дагуу СЯ-нд шууд гэрээ байгуулсан үндэслэл, гэрээний хувийг хүргүүлээгүй
28	Зурвасын хөрсний нягтрал	"Элим	100.0	93.5	2012 онд 2 удаа НТШ-г явуулсан

	хэмжих 2 ком багаж худалдан авах	Техномарт" ХХК			боловч тендер амжилтгүй болсон тул 3 компаниас үнийн санал авч ШГБ-аргыг сонгосон. ТБОНӨХБАҮХАТ Хуулийн 34.3-д заасны заасны дагуу СЯ-нд шууд гэрээ байгуулсан үндэслэл, гэрээний хувийг хүргүүлээгүй.
29	GAREX-220 MIDI – VCCS тоног төхөөрөмжийн сэлбэг нийлүүлэх /2012 он/	"INDRA NAVIA" Испани улсын компани Норвеги дах салбараас		45,970,83 долл	Үйлдвэрлэгчтэй шууд гэрээ байгуулсан. Шууд гэрээ байгуулсан үндэслэл, гэрээний хувийг хүргүүлээгүй дуусгасан.
30	MSSR MODES радиолакотар болон ATM AIRCON-2100 системийн сэлбэг нийлүүлэх	"INDRA SYSTEMS" Испани улс		55,745 евро	Үйлдвэрлэгчтэй шууд гэрээ байгуулсан. Шууд гэрээ байгуулсан үндэслэл, гэрээний хувийг хүргүүлээгүй дуусгасан. Тайлагнаагүй.
31	Зам, тээврийн яамны гаднах дулаан, цэвэр усны шугам угсрах, дулааны үзелийн шугамыг өөрчлөх, засварын ажилд шаардлагатай материал худалдан авах.	"Тамгат тулга" ХХК		22.4	3 компанийн үнийн санал авч харьцуулалт хийж бага үнийн саналаар шалгаруулсан. ИНЕГ-ын хөрөнгөөр хийлгэсэн.
32	ИНЕГ-ын хэрэгцээнд Бичгийн шкаф-35 ширхэг Хувцасны 2 хаалгатай шкаф 20 ширхэг Хувцасны 4 хаалгатай шкаф 30 ширхэг	"Ингэт түшиг"		28.7	Төлөвлөгөөнд тусгалгүй 2012 онд урсгал орлогоос худалдан авсан.
33	Холбоо навигаци бодит ажиглалтын албаны байранд хийх урсгал засвар.	"Болор өргөө" ХХК		8.8	Урсгал засварын ажлыг шууд гэрээгээр 8,830,000 төгрөгөөр гүйцэтгүүлсэн боловч худалдан авалтын тайлан маягт 3-д тайланд тусгаагүй.
34	Зам тээврийн яамны сайдын өрөөний засвар, тохижилт	"Би И Эс Си ӨҮ" ХХК BESCO LLC		68.9	2012 оны 9-р сард ИНЕГ-ын урсгал орлогоос ажлыг гүйцэтгүүлсэн. ИНЕГ. ТББ/А-39/12 Чой жэ су
35	Шинэ нисэх буудлын нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байранд дэд станц нийлүүлж, суурилуулах	"Нью Телеком" ХХК	190.0	150.0	2016 онд Улсын төсөв, төсөвт өртөг 190.0 сая төг, 2 удаа НТШ зарлаад амжилтгүй болсон тул ШГБайгуулж, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34.3-д заасны заасны дагуу СЯ-нд шууд гэрээ байгуулсан үндэслэл, гэрээний хувийг хүргүүлээгүй.
36	Нар дизель хосолсон холимог тэжээлийн сиситемийн инвертер нийлүүлэх, 4 ширхэг /DC24V/AC220V-4kW/ /АСЕМ-ийн зардал./	"Гранд Океанос" ХХК	80.0	78.0	2016 оны улсын төсөв, 2 удаа НТШ-т явуулсан амжилтгүй болсон тул шууд гэрээ байгуулсан СЯ-нд мэдэгдээгүй.
37	Технологийн зориулалтын туулах чадвар бүхий автомашин 2 ширхэг /АСЕМ-ийн зардал/	"Моннис Моторс" ХХК	160.0	137.8	2016 оны улсын төсөвт, 2 удаа НТШ Явуулсан амжилтгүй болсон тул шууд гэрээ байгуулсан СЯ-нд мэдэгдээгүй.
38	Аэродромын ашиглалт болон засвар үйлчилгээнд ашиглах олон үйлдэлтэй бага оврын механизм/ ковш, цас шидэгч зам цэвэрлэгч, доргиурт алх өрөм, суваг шуудуу ухагч, доргиурт индүү, грейдер/ /АСЕМ-ийн зардал/	"Голомт Эрвэн" ХХК	290.0	290.0	2016 оны улсын төсөв, 2 удаа НТШ-т Явуулсан амжилтгүй болсон тул, сүүлдээ 1 компаниас үнийн сан аваад л шууд гэрээ байгуулсан СЯ-нд мэдэгдээгүй.БНХАУ-д үйлдвэрлэсэн техник авсан.
39	ИНЕГ азрын болон шинэ нисэх буудлын ажилтнуудад зориулж сургалт авах	"Гүрэн" дээд сургууль	640.0	512.0	Өөрсдийн сургалтын төвийг түшиглэн сургалтыг зохион байгуулаагүй, нисэхийн салбарын талаар тусгайлан мэргэшээгүй, байгууллагаас өндөр, үнэтэй сургалт авсан.
Нийт дүн				5,725.7сая төгрөг ба 21.2 мянган AUS \$, 46.0 мянган \$, 55.7 мянган евро	

Монгол Улсын Зам тээврийн сайдын 2014-05-01-ний 108 тоот тушаалын дагуу технологийн автомашин болох туулах чадвар сайтай Ланд круйзер 200 автомашиныг 129.6 сая төгрөгөөр авахаар төсөвлөсөн боловч 174.4 сая төгрөгөөр худалдан авсан нь,

батлагдсан төсвийг 44.8 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Төсөвт өртгийг хэтрүүлсэн шалтгааныг судлан үзвэл: СЯ, ЗТЯ-ны сайдын хамтарсан тушаалаар баталсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт багтсан авто машины техникийн тодорхойлолтыг гаргаагүй, хэт өндөр хүчин чадалтай машины техникийн тодорхойлолт гаргаснаас уг авто машиныг худалдан авах боломжгүй болж үнэлгээний хороо 3 байгууллагаас үнийн санал авах урилга илгээснээр ажлаа хязгаарлан төсөвт өртөгтөө багтаан асуудлыг шийдвэрлээгүй, шууд худалдан авалтын аргаар худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн байна.

Нэг талаас захиалагч: Монгол Улсын ИНЕГ газар 2014 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Испани улсын Индра Системас С.А компанитай Эйркон сургалтын нөхцлийн 60,000 евро буюу /тухайн үеийн ханшаар 141 102 798.89 төгрөгийг урьдчилан 100.0 хувь шилжүүлэх гэрээг ИНЕГ-ыг төлөөлж Агаарын навигацын үйлчилгээний газрын дарга П.Ганболд, Санхүү эдийн засгийн газрын дарга Л.Нэргүй, Хуулийн хэлтсийн дарга Р.Ариунболд, Индра Системас С.А.-г төлөөлж АТМ Олон улсын Индра Системас С.А.-ийн Харилцагчийн үйлчилгээний менежер J.Juan Fernandez Munoz нар байгуулж, гэрээг ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Лхагвасүрэн баталсан байна. Сургалтын гэрээний дагуу 141 102 798.89 төгрөгийг 2014 оны 12 дугаар сарын ны 24 өдөр харилцагчийн дансанд шилжүүлсэн боловч хаана хэдэн хүнд хэдэн удаа ямар сургалт явуулсан тайлан байхгүй холбогдох гүйцэтгэлийн баримт хавсаргаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн байдлаас үзэхэд: Тендер шалгаруулалтаар худалдан авч буй бараа, ажил, үйлчилгээ хуулийн дагуу явагдахгүй, тендерт шалгарсан зарим гүйцэтгэгчид элдэв бэрхшээл, шалтаг, шалтгаан тоочиж, нийлүүлэх хугацаагаа сунгуулах асуудал тавьдаг байна. Үүнээс шалтгаалан гэрээний ач холбогдлыг бууруулж, торгууль алданги хүлээлгэх гэрээнд заасан хөшүүргийг хэрэглэхгүй болдог, мөн улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж буй төсөвт өртөг өндөртэй, томоохон төсөл арга хэмжээний ажлын санхүүжилтийг санхүүгийн эх үүсвэрээс шалтгаалан төсвийн жилд нь багтаан олгох боломж хязгаарлагдмал болж, хэд хэдэн он дамжиж санхүүжихээр төсөвт тусгаж байгааг далимдуулан, санхүүжилтээ өгөөгүй гэдгээр гэрээнд заасан хугацаандаа ажлаа дуусгадаггүй, өөрийн хөрөнгөөрөө 80.0-90.0 хувийн гүйцэтгэлтэй болгосон гээд суучихдаг, үнийн тохируулгаар нэмэлт санхүүжилт авна, санхүүжилт өгөхгүй ажил зогсоосон, түр суурилагдсан болон тээвэрлэж хүргэсэн машин, механизмуудыг удаан хугацаагаар он дамжуулан ажилгүй зогсоосноос олон сая төгрөгийн орлого олох боломж алдсан гэх мэт олон зүйлийг ярьж шүүхэд нэхэмжлэл гаргаад шүүхийн шийдвэр гаргуулан ихээхэн хэмжээний мөнгө авчихаад, хугацаагаа сунгуулж, удаашируулж, царцаадаг нийтлэг хандлага буй болжээ.

Худалдан авах ажиллагаанд тодорхой нөхцөлд шууд гэрээ байгуулах аргыг сонгосон байдаг бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3, 33.4, 34 дүгээр зүйлийн 34.1.2, 34.1.3, 34.1.4, 34.1.5, дах заалтуудын дагуу шууд гэрээ байгуулах аргыг сонгож хэрэглэсэн байгаа боловч, хуулийн 34.3-д заасан энэ хуулийн 34.1-д заасны дагуу шууд гэрээ байгуулсан тохиолдолд "захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалтыг мөрдөж ажиллахгүй гэрээ байгуулаад л дуусгавар болгодог зөрчил давтан гарсаар байна.

**Нисэхийн мэдээлийн үйлчилгээний албаны захиалгаар нисэхийн аюулгүй байдлыг хангахын тулд улсын төсвийн хөрөнгөөр сүүлийн жилүүдэд хийгдсэн байр, зүйн цаасан зургийг тоон хэлбэрт хөрвүүлэх, газрын гадарга, саад болон аэродромын зураглалын өгөгдлийн сан бүрдүүлсэн ажлын талаар**

Нислэгийн мэдээллийн үйлчилгээний албаны захиалгаар 2005-2016 оны хооронд 1:200 000 масштабтай газрын зургийг тоон хэлбэрт хөрвүүлэх, 1:50 000, 1:25 000 масштабтай сансрын зургаас газрын гадарга болон саадын өгөгдлийн санг бүс 1, бүс 2-оор, аэродромын зураглалын өгөгдлийн сан /АМ/-г /бүс 3/-аар хийлгэсэн ажлуудын талаар гарсан зөрчил, дутагдлууд нь дараах зүйлүүдээс шалтгаалжээ гэж үзэж байна.

**Нэгдүгээр ажил:** Өвөрхангай, Өмнөговь, Хэнтий, Дорнод, Дундговь, Говь-Алтай, Завхан, Баянхонгор аймгуудын нисэх буудлуудад оролтын нислэгийн саадын зураг хийлгэх ажил.

ИНЕГ болон "Монмет эйр сервис" ХХК-ийн хооронд 2000 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр гэрээ байгуулж 8 нисэх буудал, тэдгээрийн орчмын саадын зураг хийлгэх болжээ.

Энэхүү гэрээгээр 189.0 сая төгрөгийн ажлыг 2000 онд багтаан хийлгэхээр 148.7 сая төгрөгийг шилжүүлсэн, гэтэл уг ажлын чанар байдлаас шалтгаалан гүйцэтгэгчээс 2003 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр гэрээг дүгнэж 21 СД-нд багтаасан аэродромын газрын зургийг хүлээн авсан байна. Гэвч энэ зургийг ашиглаж байгаа гэх нотолгоо олдохгүй байна.

Мөн 2005 онд Өвөрхангай, Өмнөговь, Хэнтий, Дорнод, Дундговь, Говь-Алтай, Завхан, Баянхонгор аймгуудын нисэх буудлуудад хийсэн оролтын нислэгийн саадын зураг нь ИКАО-гийн хавсралт 15-ын 10.1.4.-10.1.6.-д зааснаар биш шаардлагагүй аэродромуудад хийлгэсэн байна. Уг ажлыг гүйцэтгүүлсэн өртөг нь 140.0 сая төгрөг, энэ 2 ажлыг нэгтгэвэл 288.7 сая төгрөгийн ажил үр ашиггүй болжээ гэж үзэхээр байна.

Эдгээр хийлгэсэн зурагт Улсын мэргэжлийн хяналтын газрын 2005 оны 03/44/2416 дугаар бүхий дүгнэлт, 03/44/789 дугаартай улсын байцаагчийн албан шаардлагаар 3 төрлийн алдаа, зөрчилтэй байгааг гаргаснаар энэ зургийг ашиглах боломжгүй болжээ.

**Хоёрдугаар ажил:** Монгол улсын нийт нутгийг хамарсан 1:50 000 масштабтай газрын гадаргын болон саадын өгөгдлийн сан бүрдүүлэх (сансрын зургаас) ажил. /Техникийн тодорхойлолтоор / Бүс 2-оор Энэ ажлыг гүйцэтгүүлэхдээ ТБОНӨХБАУХАТХуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 болон 17 дугаар зүйлийн 17.1.1., 17.1.2. заалтын дагуу НТШ-ыг зарлах атал,



31 дүгээр зүйл. Тендер шалгаруулалтын онцгой журам, 31.1.1., 32 дугаар зүйл Хязгаарлагдмал тендер шалгаруулалтын заалтыг баримталж хууль зөрчжээ.

Ийм хэмжээний ажлыг хийж гүйцэтгэхэд гэрээнд заасан хугацаа нь техникийн хувьд боломжгүй байсны улмаас "Монмап", "Геосан" ХХК-иудад ТООЗ-ийн 1.2-т заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүй гэдэг үндэслэлээр 2010 оны 08 дугаар сарын 24-нд татгалзсан хариу ирүүлснээр "Имидж солишн" ХХК өрсөлдөгчгүй үлдсэн байна.

ТШӨХ-ийн ТООЗ 5.2./б/ сүүлийн 3 жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, ТООЗ 5.2./г/ Хийж гүйцэтгэсэн ажлын нийт мөнгөн дүнг жил, жилээр харуулсан жагсаалт: сүүлийн 3 жил, ТООЗ 5.2. /д/ Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн ажлын туршлагын талаарх мэдээлэл: Сүүлийн 3 жил, ТООЗ 5.2./з/ тендерт оролцогч туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох хувь хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 15.0 хувь хүртэл, Үүнээс дээш хувийг 3 дагч этгээдээр гүйцэтгүүлэх бол түншлэлийн гэрээ байгуулж, тендерийн хамт ирүүлэх ба ТООЗ-нд дурдсан бусад шалгууруудыг хангасан байх шаардлагатай, ТООЗ 5.3. /а/ Ажлын нийт мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлтийг тооцох жилийн тоо: Сүүлийн 2 жил, жилийн дундаж нь 50.0 сая төгрөгөөс багагүй байх зэрэг шаардлагуудыг хангаагүй төдийгүй, үүсгэн байгуулж улсын бүртгэлд бүртгүүлээд дөнгөж 7 сар гаруй болж байсан, шалгуур үзүүлэлтүүдийг хангаагүй компанийг гүйцэтгэгчээр сонгож хууль зөрчжээ. Мөн ТООЗ 5.2. /з/-д захиалагчаас тавигдсан шаардлагын дагуу орж байгаа бол туслан гүйцэтгэгч буюу албан ёсны түншлэлийн гэрээ байгуулах ёстой атал "БЭЙС ПОИНТ" ХХК-тай ямар ажил гүйцэтгэх, юу хийх гэж байгаа нь ойлгомжгүй, зорилго нь тодорхой бус "Хамтран ажиллах, харилцан туслах гэрээ"-г 2010.08.10-ны өдөр байгуулж, тус компанийн хийж гүйцэтгэсэн ажлуудын гэрээний хувь, 2009-2010 оны эхний хагас жилийн аудитаар баталгаажгаагүй санхүүгийн тайлан тэнцлийн хуулбарыг тендерийн баримт бичигт оруулсан байгаа нь түншлэлийн гэрээгээр хамтран ажиллана гэж харуулах гэсэн оролдлого гэж үзэхээр байна. ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 27 дугаар зүйл. Тендерийг хянан үзэх, 28 дугаар зүйл. Тендерийг үнэлэх зэрэг үйл ажиллагаа явагдсан тухай материал байхгүй байгаа нь хуулийн дагуу явагдсан эсэх нь тодорхойгүй байна.

"ИМИДЖ СОЛЮШН" ХХК-ийн Улсын бүртгэлийн гэрчилгээний нэмэлт өөрчлөлтийн хэсэгт 749900 кодтой Зайнаас тандан судлал, газар зүйн мэдээллийн системийн үйлчилгээ, зөвөлгөө эрхлэх туслах үйл ажиллагааг 2010.06.21-ний өдөр УБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн газар 7/06 дугаар бүхий улсын бүртгэгч Ч.Батцэцэг шинээр бүртгэжээ. Харин тусгай зөвшөөрлийн гэрчилгээ байхгүй байгаа нь энэ нэмэлт өөрчлөлтийн бичилт эргэлзээтэй байна.

Тус компани нь ажлын туршлагаа харуулахаар Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр болон "Геомон" ХХК-ийн хооронд хийсэн Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэрийн лицензийн талбайд 2004-2005 онд гүйцэтгэсэн 1:50 000 масштабтай сансрын зургийн боловсруулалт, тайлалтын үр дүн гэсэн тайлангийн нүүр, тайлангийн товъёог, "Геомон" ХХК, захиалагч

ИНЕГ-ын Нисэхийн мэдээлэл хангалтын албатай 2006 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр байгуулсан 05/01 тоот гэрээний гүйцэтгэлийн тайлан материал хавсаргажээ.

“ИМИДЖ СОЛЮШН” ХХК нь тендерийн баримт бичигт дээрхи материалуудын хамтаар СБД-ийн Татварын албанд ААНОАТ-ын тайлангаар 2010 оны 1, 2 дугаар улиралд үйл ажиллагаа явуулаагүй гэсэн чагтан тайлан өгсөн баримт хавсаргажээ. 1:50 000 масштабтай газрын гадаргын болон саадын өгөгдлийн сан бүрдүүлэх, ИНЕГ/ТББ/А-28/10 дугаартай гэрээт ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны сонгон шалгаруулалтын эцсийн хурал хэзээ, хаана, ямар бүрэлдэхүүнтэй хийж, ямар шийдвэр гаргасан талаар энэхүү тендерийн материалд байхгүй байлаа.

2010 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тухай гэсэн Үнэлгээний хорооны зөвлөмжид тус газраас зарлагдсан 1:50 000 масштабтай газрын гадаргын болон саадын өгөгдлийн сан бүрдүүлэх ИНЕГ/ТББ/А-28/10 дугаартай гэрээт ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан тухай Үнэлгээний хорооны 2010.09.08-ны өдрийн хурлын дүгнэлтээр хуулийн 29 дүгээр зүйлийг үндэслэн “ИМИДЖ СОЛЮШН” ХХК-д гэрээ байгуулах эрх олгох, гэрээ байгуулах үнэ 448,000,000 төгрөг /Дөрвөн зуун, дөчин найман сая/ гэж Нислэгийн мэдээллийн үйлчилгээний албаны дарга бөгөөд Үнэлгээний хорооны дарга П.Ариунгэрэл гарын үсэг зурсан байна.

Энэхүү Үнэлгээний хорооны энэхүү зөвлөмжийг үндэслэн, Захиалагч 2010.10.19-нд 03/2538 тоот албан бичгээр “ИМИДЖ СОЛЮШН” ХХК-д гэрээ байгуулах тухай эрх олгосноо мэдэгдэж, гэрээ байгуулж ажил хийгдсэн байна. Дээрхи ажлыг 2010.12.03-ны өдөр хүлээн авч акт үйлдсэн бөгөөд актанд техникийн тодорхойлолт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн гэж дүгнэжээ. Ажлыг техникийн даалгаврын дагуу шалгасан байдал гэсэн хүснэгтээр газрын гадаргын болон саадын өгөгдлүүдийг техникийн тодорхойлолтод тусгасны дагуу шаардлагад нийцэж буй эсэхийг НМҮА-ны НТМХ-ийн дарга Д.Эрдэнэбаатар, НМҮА-ны Нисэхийн зураг зүйч С.Амарсанаа нар 2010.12.06-ны өдөр шалгасан гэж гарын үсэг зуржээ.

Гэвч тус ажлыг гүйцэтгэсэн “ИМИДЖ СОЛЮШН” ХХК хийсэн ажлын тайландаа зөвхөн Гадаргын тоон загварын боловсруулалт хийсэн тухай харин саадын өгөгдлийн сангийн боловсруулалт хийгдсэн тухай тусгаагүй байхад тус ажлын хэсэг хүлээн авсан бөгөөд шалгасан НМҮА-ны ажилтнууд техникийн тодорхойлолт шаардлагын дагуу хийгджээ гэж дүгнэснээр хийгээгүй ажлын хөлсөнд илүү төлбөр төлөх нөхцлийг бүрдүүлсэн байна. Үүний улмаас тус компанид хийгээгүй саадын өгөгдлийн санд Бүс 1-ээр хийлгэсэн ажлын өртөгөөр тооцвол 179 246 100 төгрөгийг илүү төлж, энэ хийгдсэн ажлын ашиглагдахгүй байгаа 268 753 900 төгрөгийн ажил хэрэгцээгүй болж, нийт дүнгээрээ 448.0 сая төгрөгийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагджээ гэсэн дүгнэлт хийгдэж байна.

Монгол улсын нийт газар нутгийг хамарсан 1:50 000 масштабтай газрын гадаргын болон саадын өгөгдлийн сан бүрдүүлэх /сансрын зургаас/ ажил нь ИКАО (ICAO)- гийн Хавсралт 15-ын 10.6.1.1. /2004.11.25/-д зааснаар Бүс 1-ээр DOC 9368 Instrument Flight Procedures Construction Manual 2.4 maps-ийн 2.4.1.-ээр бол ашиглах боломжтой болох

байсан боловч Бүс 2-оор техникийн шаардлагыг өгч хийлгэсэн бөгөөд уг ажил нь Газрын харилцаа, геодези, зураг зүйн газраар хянуулан баталгаажуулж “Геодези, байр зүйн зургийн мэдээллийн сан”-д одоо хүртэл хүлээлгэж өгөөгүй байгаа нь шаардлага хангасан ажил болсон эсэх нь маш эргэлзээтэй болжээ. Хэрэв 1:50 000 масштабтай газрын гадаргын болон саадын өгөгдлийн сан бүрдүүлэх /сансрын зургаас/ ажил нь Бүс 1-ээр хийгдсэн бол дараагийн ажлууд давхцахгүй байсан ба харин Бүс 2-оор хийгдсэн учраас үйлдвэрлэлийн үйл ажиллагааны шаардлага хангахгүй бөгөөд дараагийн хийгдсэн ажлууд давхардсан ажлууд болжээ гэж үзэхээр байна.

#### **Гуравдугаар ажил:**

Монгол орны газар нутгийн 1:200 000 масштабтай байр зүйн зургийн 212 планшейтэд дүрслэгдсэн байр зүйн бүх элементүүдийг тоон хэлбэрт хөрвүүлэх ажил.

ИКАО (ICAO)- гийн DOC 9368 Instrument Flight Procedures Construction Manual 2.4 MARS хэсэгт зөвлөмж болгосон: Олон улсын Иргэний нисэхийн байгууллага /ИКАО/-ын Хавсралт 15-ын 10.1.3. ИКАО-гийн гишүүн улс бүр өөрийн улсын нийт нутаг дэвсгэрийг хамарсан электрон газрын гадарга болон саадын өгөгдлийн сантай байх зөвлөмж байгааг байх ёстой гэсэн шаардлага болгон хувиргаж, нислэгийн хөөрөлт болон буултын схем боловсруулахад ашиглах зорилгоор 1:200 000 масштабтай байр зүйн зургийг тоон хэлбэрт шилжүүлэх.

Монгол орны газар нутгийн 1:200 000 масштабтай байр зүйн зургийн 212 планшейтэд дүрслэгдсэн байр зүйн бүх элементүүдийг тоон хэлбэрт хөрвүүлэх ажил нь ямар байгууллагын захиалгаар, ямар зориулалтаар, яах гэж хийлгэсэн нь тодорхойгүй байхын зэрэгцээ техникийн тодорхойлолт, шаардлага нь буруу байсан байна. Үүний зэрэгцээ уг гүйцэтгэсэн ажлыг ГХГЗЗГ-ын 2014 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 1/1315 тоот бичгээр ИНЕГ-ын захиалгаар гүйцэтгэсэн Монгол Улсын 1:200 000 масштабтай 101 хуудас байр зүйн тоон зургийг шалгасан тухай дүгнэлтэд 19 төрлийн алдаа байгааг илэрүүлэн засварыг хийж, мэдээллийн төвд хүлээлгэн өгөхийг мэдэгджээ. Үүнээс үзэхэд энэ ажил нь шаардлагагүй ажил байсны зэрэгцээ мөн л ашиглалтгүй хэрэгцээгүй ажил болсон төдийгүй энэ ажлын зардалд 49,422,450 төгрөг болжээ.

#### **Дөрөвдүгээр ажил: 1:25 000 масштабтай газрын гадарга болон саадын өгөгдлийн сан бүрдүүлэх ажил. / 7 аэродромд /**

ИКАО-гийн Аппех 15-ын 10.1.4.- 10.1.6.-аар Олон улсын агаарын тээврийн нислэгт тогтмол ашиглагддаг аэродромд газрын гадарга болон саадын өгөгдлийн мэдээллийг Бүс 2-оор бүрдүүлж сан үүсгэх, НМҮА-наас гаргасан техникийн тодорхойлолтоор: ИКАО-гийн Аппех 15-ын 10.1.-д 2015.11.12-ноос ИКАО-гийн гишүүн улс бүр өөрийн улсад байгаа олон улсын иргэний нислэгт тогтмол ашиглагддаг аэродромуудын ойртолтын удирдлагын бүсийн электрон газрын гадарга болон саадын өгөгдлийн санг ашиглаж эхлэх ёстой гэсэн шаардлагыг хангах, “Чингис хаан” ойртолтын удирдлагын бүс “Аэродромын хяналтын цэгээс 80 км-ийн радиуст хамрах, бусад орон нутгийн аэродромд 45 км-ийн радиуст хамрах

мэдээллийн өгөгдлийг Бүс 2-оор өгнө гэжээ. Гэвч ИКАО-гийн энэ шаардлага нь “Зөвлөмж” хэлбэрээр өгөгдсөн ба заавал гэсэн шаардлага биш юм.

Хэрвээ ИКАО-гийн хавсралтад заасан материал: Үүнд заагдсан Конвенцийн заалтуудын дагуу Зөвлөлөөс баталсан стандарт, зөвлөмж, шаардлагууд дараах байдлаар тодорхойлогдоно: Стандарт-физик шинж чанар, тохиргоо, материал, гүйцэтгэл, боловсон хүчин эсвэл журам, аюулгүй байдал, эсхүл байнгын ажиллагаанд шаардлагатай гэж хүлээн зөвшөөрөгдсөн ижил төстэй хэрэглээ Олон улсын агаарын навигаци ба хэлэлцэн тохирогч улсууд энэхүү конвенцийн дагуу зохицуулна гэжээ. Үүнд: Дагаж мөрдөх боломжгүй бол Зөвлөлийн мэдэгдэлд 38 дугаар зүйлд заасны дагуу заавал мэдэгдэнэ гэжээ. Харин НМҮА нь үүнийг заавал биелүүлэх шаардлага гэж хийлгэж байгаа бүх ажлын техникийн тодорхойлолт, шаардлагад оруулсан байна.

Олон улсын иргэний нислэгт тогтмол ашиглагддаг аэродромуудын ойртолтын удирдлагын бүсийн электрон газрын гадарга болон саадын өгөгдлийн санг ашиглах нь зөвхөн “Чингис хаан” ОУНБ-д хамаарахаас бусад орон нутгийн бусад орон нутгийн 6 нисэх буудлын аэродромд заавал хийх шаардлагагүй ажил байна. Энэ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТХуулийн дагуу явуулсан байна.

Энэ ажлыг гүйцэтгээд Газрын харилцаа, геодези зураг зүйн газраар хянуулан баталгаажуулж “Геодези, байр зүйн зургийн мэдээллийн сан”-д хүлээлгэж өгөөгүй байгаагаас харахад энэ ажил нь шаардлага хангасан ажил болсон эсэх нь тодорхойгүй байна. Энэ ажлын нийт өртөгт 478.0 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд “Чингис хаан” ОУНБ-д  $478.0/7*1=68,285,700$  төгрөгийг зарцуулсан гэвэл бусад орон нутгийн шаардлагагүй 6 аэродромд зарцуулсан 409.7 сая төгрөгийн үргүй зардал болж, Геодези, зураг зүйн тухай хуулийн 9.2.-т зааснаар ГХГЗЗГ-аар хянуулан “Геодези, байр зүйн зургийн мэдээллийн сан”-д хүлээлгэж өгөөгүй нь байгаа нь үйлдвэрлэлд ашиглах бололцоогүй болсон байна.

**Тавдугаар ажил:** 1:25 000 масштабтай газрын гадарга болон саадын өгөгдлийн санг үлдсэн орон нутгийн 12 аэродромд бүрдүүлэх ажил. Энэ ажил мөн л 4 дүгээр ажлын нэгэн адил болсон бөгөөд ганцхан “Чингис хаан” ОУНБуудлын аэродромоор л ялгаатай байна. 1:25 000 масштабтай газрын гадарга болон саадын өгөгдлийн сан бүрдүүлэх /үлдсэн 12 аэродромд/ Хатгал, Тосонцэнгэл, Хархорин, Булган сум, Өндөрхаан, Арвайхээр, Алтай, Баянхонгор, Баруун-Урт, Дадал, Доной, Мандалговь зэрэг аэродромуудад /ажил нь Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ИКАО/-гийн хавсралт 15-ын 10.1.4.-10.1.6.-д олон улсын иргэний нисэхэд тогтмол ашиглагддаг аэродромд газрын гадаргын болон саадын өгөгдлийн сантай байх тухай туссан боловч, заавал гэсэн шаардлага байхгүй байна. Энэ ажлыг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газраар хянан баталгаажуулж, “Геодези, байр зүйн зургийн мэдээллийн сан”-д хүлээлгэн өгөөгүй байгаагаас үзэхэд энэ ажлын үр дүн хэрхэн гарсаныг дүгнэх аргагүй байна. Энэ ажлын нийт төсөвт өртөг 489,000,000 төгрөг бөгөөд шаардлагагүй аэродромуудад хийлгэснээр, шаардлагагүй хөрөнгө оруулалт гэж үзэхээр байна.

**Зургаадугаар ажил:** Монгол улсын Бүс 1-ийн саадын өгөгдлийн сан бүрдүүлэх ажил.  
/Улсын хэмжээгээр/

Монгол улсын Бүс 1-ийн саадын өгөгдлийн сан бүрдүүлэх ажил /улсын хэмжээгээр/ нь "ИМИДЖ СОЛЮШН" ХХК-ийн өмнө нь гүйцэтгэсэн гэх Монгол улсын нутаг дэвсгэрийг хамарсан 1:50 000 масштабтай газрын гадарга болон саадын өгөгдлийн сан бүрдүүлэх /сансрын зургаас/ гэсэн ИНЕГ/ТББ/А-28/10 дугаартай гэрээт ажлаар Бүс 2-оор техникийн шаардлагыг өгсөн ч хийгдээгүй орхигдсон саадын өгөгдлийн сангийн ажлыг "Геокад" ХХК-иар Монгол улсын Бүс 1-ээр /улсын хэмжээнд/ саадын өгөгдлийн сан бүрдүүлэх № 57 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээт ажлаар 179,246,100 төгрөгийн өртөгтэйгээр хийлгэсэн.

Хэрвээ 1:50 000 масштабтай газрын гадарга болон саадын өгөгдлийн сан бүрдүүлэх /сансрын зургаас/ гэсэн ИНЕГ/ТББ/А-28/10 дугаартай гэрээт ажлыг ICAO-гийн Annex 15-ын 10.6-д /2004.11.25/ Бүс 1-ээр саадын өгөгдлийн өндөр нь 100 метрээс дээш байна гэснээр хийлгэсэн бол энэ ажлыг дахин хийлгэх шаардлагагүй байсныг мэргэжлийн хүмүүсээс тодруулахад хэлж байлаа.

"ИМИДЖ СОЛЮШН" ХХК-ийн гүйцэтгэсэн гэх Монгол улсын нутаг дэвсгэрийг хамарсан 1:50 000 масштабтай газрын гадарга болон саадын өгөгдлийн сан бүрдүүлэх /сансрын зургаас/ гэсэн ИНЕГ/ТББ/А-28/10 дугаартай гэрээт ажлаар Бүс 2-оор техникийн шаардлагыг өгсөн ч хийгдээгүй орхигдсон саадын өгөгдлийн сангийн ажлыг хүлээн авсан комисс, НМҮА-ны ажлыг шалгасан ажилтнууд саадын өгөгдлийн санг хийгдээгүй орхигдсоныг тогтоож хариуцлагатай ажилласан бол энэ ажилд дахин хөрөнгө гаргах шаардлагагүй байсан юм. /Энэ ажлыг гүйцэтгээгүй байсан талаар мөн урьд дурьдсан байгаа. / Гэвч энэхүү ажлыг Бүс 1-ээр хийгдсэн хэмжээгээр ашиглаж болох ба "ИМИДЖ СОЛЮШН" ХХК-ийн хийгээгүй үлдээсэн ажилд ногдох хэмжээний зардлыг /төсөвт өртөгийг/ акт гарган тооцож нэхэмжлэх шаардлагатай гэж үзэж байна.

**Долоодугаар ажил:** Аэродромын зураглалын өгөгдлийн сан байгуулах ажлууд. (AMDB) Ховд, Мөрөн, Даланзадгад, /Гурван сайхан/, Чойбалсан, Ханбумбатгэсэн аэродромуудад ICAO Хавсралт 15-ын 10.1.8.-д Олон улсын иргэний нисэхэд тогтмол ашиглагддаг аэродромд электрон газар нутаг, саад тотгорын өгөгдлийг Бүс 3-аар болон 11.1-д аэродромын зураглал мэдээллээр хангах шаардлага.

Энэ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг ХААГ-т зохион байгуулжээ. Дээрхи 5 нисэх буудлын аэродромууд нь өнөөдрийн байдлаар олон улсын иргэний нислэгт тогтмол ашиглагддаггүй аэродромууд байхын зэрэгцээ ICAO-гийн Хавсралт 15-ын 10.1.8 болон 11.1-д зааснаар заавал биелүүлэхийг шаардаагүй байхад эдгээр аэродромуудад AMDB-г хийлгэж улсын төсвөөс 648,213,499 төгрөгийн хөрөнгө зарцуулжээ.

Эдгээр аэродромуудад AMDB-г хийлгэхэд хувийн эзэмшлийн Ханбумбат аэродромд хийсэн зураглалын өгөгдлийн сангийн ажил орсон бөгөөд энд улсын төсвөөс 129,672,700 төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байна.

Эдгээр ажлуудад давхардал байхгүй гэж үзэж байгаа боловч, заавал хийх шаардлагагүй байсан төдийгүй, хувийн эзэмшлийн аэродромд улсын төсвөөс хөрөнгө гаргаж AMDB-г хийлгэсэн тухайн аэродромыг эзэмшигчтэй /урьдчилан тохироогүй/ тус компанид хийсэн ажлаа хүлээлгэн өгөөд гарсан зардлаа нэхэмжилж аваагүй байна.

**Наймдугаар ажил:** “Чингис хаан” ОУНБ-ын Аэродромын зураглалын өгөгдлийн сан (AMDB) 1 иж бүрдэл. ICAO Хавсралт 15-ын 10.1.8 болон 11.1-д заасан Олон улсын иргэний нисэхэд тогтмол ашиглагддаг аэродромд Бүс 3-аар шаардлага тавигддаг байна. ИНЕГ-ын 2013 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/3098 тоот албан бичгээр гэрээ байгуулах эрх олгосон байна. Үүний дагуу гүйцэтгэгчтэй “Аэродромын зураглалын өгөгдлийн сан бүрдүүлэх (AMDB) 1 иж бүрдэл боловсруулах, ИНЕГ/ТББ/ЗҮ-03/13 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг ИНЕГ болон “Мон Мэн” ХХК-тай 2013.12.12-ны өдөр 188,700,000 төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулсан нь төсөвт тусгагдсан дүнгээс 20.0 сая төгрөгөөр илүү байсан боловч, гүйцэтгэл нь 167 244 855 төгрөг болсон байна. “Чингис хаан” ОУНБ-ын Аэродромын зураглалын өгөгдлийн сан (AMDB) 1 иж бүрдэл ажлыг ICAO-гийн Хавсралт 15-ын 10.1.8 болон 11.1-д зааснаар “Чингис хаан” ОУНБ-ын аэродром нь энэ заалтад хамаарч болох тул бусад ажлуудтай давхардсан гэж үзэхээргүй байна.

**Есдүгээр ажил:**

Дүгнэлт: Бүс 2 саадын өгөгдлийн сан бүрдүүлэх /Булган, Ханбумбат, Овоот, Налайх, Тавантолгой Нисэх буудлуудын ажил/

Булган, Ханбумбат, Овоот, Налайх, Таван толгой зэрэг нисэх буудлуудын Бүс 2-ын саадын өгөгдлийг бүрдүүлэх № 99 дугаар бүхий зөвлөх үйлчилгээний гэрээт ажлын санхүүжилтийн эх үүсвэрийг 2014 оны улсын төсөвт тусгаж батлагдсанаар 250,000,000 төгрөг тусгагджээ. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг ХААГ-т зохион байгуулжээ.

Дээрхи нисэх буудлуудын Бүс 2-ын саадын өгөгдлийг бүрдүүлэх зөвлөх үйлчилгээний № 99 дугаар бүхий гэрээт ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг ХААГ-аас зохион байгуулан хийж, ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батзаяа болон “Эм Эс Пи Эм” ХХК-ийн хооронд 2014.06.13-ны өдөр 249,475,000 төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулжээ.

ICAО-гийн Хавсралт 15-ын 10.1.4.-10.1.6.-д зааснаар эдгээр 5 нисэх буудлын аэродромууд нь олон улсын иргэний нислэгт тогтмол ашигладаггүй, аэродром байхын зэрэгцээ хувийн эзэмшлийн 4 нисэх буудлын аэродромд улсын төсвөөс 199,580,000 төгрөгийн хөрөнгө зарцуулж, саадын өгөгдлийн сан бүрдүүлэх ажил хийж өгчээ.

Эдгээр нисэх буудлуудын аэродромд хийгдсэн ажил нь ICAO-гийн Хавсралт 15-ын 10.1.4.-10.1.6.-д зааснаар бол шаардлагагүй, аэродромуудад хийгдсэн байна. Булган нисэх буудлын аэродром нь олон улсын нислэг байтугай, орон нутгийн нислэггүй төрийн эзэмшлийн Нисэх буудлын аэродром бөгөөд 49,895,000 төгрөгөөр шаардлагагүй ажил хийгдсэн байна. Дээр дурдсан хувийн эзэмшлийн 4 аэродромд улсын төсвөөс 199,580,000

төгрөгөөр, шаардлагагүй аэродромд 45,895,000 төгрөг, нийт 249,475,000 төгрөгийг улсын төсвөөс зарцуулсан нь үр өгөөж багатай ажил болжээ.

/ ICAO /-гийн Хавсралт 15-ын 10.1-д 2015 оны 11 дүгээр сарын 12-ноос гишүүн улс бүр өөрийн улсын иргэний нислэгт тогтмол ашиглагддаг аэродромуудын ойртолтын удирдлагын бүс (ТМА)-ийн газрын гадарга, саадын өгөгдлийн санг ашиглаж эхлэх ёстой гэсэн заалт нь заавал гэсэн шаардлага биш бөгөөд Хавсралт 15-ын Хавсралтын бүрэлдэхүүн хэсгийн байдлын 1а-д дурдсанаар "Дагаж мөрдөх боломжгүй бол Зөвлөлийн мэдэгдэл 38 дугаар зүйлд заасны дагуу заавал мэдэгдэнэ" гэсэн байхад заавал хийх ёстой гэж тайлбарлан, ойлгуулж улсын төсвөөс ихээхэн хэмжээний хөрөнгө гаргаж, ач холбогдол, үр өгөөж багатай давхардсан, ажлуудыг удаа дараа хийж, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газраар хянан баталгаажуулж, "Геодези, байр зүйн зургийн мэдээллийн сан"-д хүлээлгэн өгөөгүй байдалтай байна.

**Аравдугаар ажил:** Хөшигийн хөндийн ОУНБ-ын газрын гадаргын болон саадын өгөгдлийн сан бүрдүүлэх ИНЕГ/УТ/ТББ/ЗҮ-36/16 дугаартай гэрээгээр гүйцэтгэсэн ажил.

ICAO Annex 15. Chapter 10-ын 10.1.5.,- 10.1.6., Олон улсын иргэний нисэхэд тогтмол ашиглагддаг аэродромд газрын гадаргын болон электрон саадын өгөгдлийн санг/Бүс 2а, b/Хөөрөлт, буулт үйлдэх нислэгийн замын бүс, с/Аэродромын саадын хязгаарлалт нь бүсийн гадаргуугийн хажуугийн хил хязгаар гэсэн заалттай. НМҮА-наас ИКАО- (ICAO)-гийн Хавсралт 15-ын 10.1.3-д болон Нисэхийн мэдээллийн үйлчилгээ (AIS)-нээс Нисэхийн мэдээллийн менежмент (AIM)-д шилжих ерөнхий төлөвлөгөөний дагуу нисэхийн мэдээллийн үйлчилгээний бүрэн автомат системийг хэрэгжүүлэхэд олон улсын Иргэний нисэхэд тогтмол ашиглагддаг буудлуудад Бүс 2-ын Газрын гадарга болон саадын өгөгдлийн санг 2015 оны 11 дүгээр сарын 12-ноос эхлэнэ гэсэн шаардлага тавигджээ. "Геосан" ХХК-ийн гүйцэтгэсэн ажлын техникийн тодорхойлолтоор өгөгдсөн Бүс 2-ын өгөгдлийн хүрээ нь "Мон Мэп" ХХК-ийн 2011 оны 06 дугаар сарын 20-ноос 09 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэсэн 1:25 000 масштабтай газрын гадаргын болон саадын өгөгдлийн сан /сансрын зургаас/ бүрдүүлэх ИНЕГ/ХББ/ЗҮ-12/11 дугаартай гэрээт ажлын "Чингис хаан" ОУНБ-ын Аэродромын ойртолтын удирдлагын бүс /Аэродромын хяналтын цэгээс 80 км-ийн радиустай тойрогт хамрах газар/-ын хамрах хүрээнд орж байгаа тул давхардсан ажил болсон ба, энэ ажлын төсөвт өртөг нь 265,197,000 төгрөг болсон байна. Харин үүнийг шинэ буудал ашиглалтад орсны дараа нэмэлт ажил хийж ашиглах боломжтой байна гэж үзэж байна.

Дүгнэлт хийж үзэхэд:

1. ICAO-гийн зарим баримт бичиг, санал, зөвлөмж, шаардлагыг хэрхэн зөв ойлгож, буруу ашиглаж, хэрэглэж байгаад ИНЕГ-ын мэргэжлийн хэлтэс, ажилтнуудын зүгээс хяналт тавьж, дүгнэлт хийж, саналаа гаргаж, тэдний саналыг авч, сонсож ажиллаагүй байна.
2. Улсын төсөвт зураглалын ажлын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг тусгахдаа зориулалт, өмнө улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн ажлын гүйцэтгэл ашиглалт /санд

бүртгэгдсэн байдал/ түүний үр өгөөж, одоо хийгдэх хөрөнгө оруулалтын үр ашгийн тооцоо үндэслэл, давхцал зэргийг ИНЕГ-ын мэргэжлийн болон, санхүү эдийн засгийн хэлтсүүд, дотоод аудитын албаны холбогдох ажилтнуудын зүгээс хяналт тавьдаггүй, төлөвлөлт хийх үед саналыг авч харгалзан үздэггүйтэй холбоотой байна.

3. Хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, хийсэн ажлын чанар хүртээмж, үр ашгийг тооцож байх тус байгууллагын хувьд улсын төсвийн эх үүсвэрээс гадна байгууллагын өөрийн урсгал орлого болон хуримтлагдсан ашгаас хөрөнгө оруулалт хийдэг хэд хэдэн эх үүсвэртэй тул төлөвлөлтийг байгууллагын түвшинд алба нэгжийн саналыг авч, ил тод нээлттэй хэлэлцүүлж, ИНЕГ-ын мэргэжлийн хэлтсүүдээр давхар ярилцаж дотоод аудитын албаар дүгнэлт гаргуулж төлөвлөгөөг хянаж нэгтгэн дээд байгууллагад уламжилдаг шинэ журамд шилжих шаардлагатай байна.
4. Улс орон нутгийн төсвийн болон төрийн байгууллагын хэрэгжүүлж буй төслийн хөрөнгөөр гүйцэтгүүлсэн ажлынхаа тайлан, эх материал, солбицлын жагсаалт /католог/ бүдүүвч зураг, бичлэг, нисэх буудлуудын оролтын нислэгийн саадын зураг, Монгол орны нийт нутгийг хамарсан хэд хэдэн масштабтай газрын гадаргын болон саадын өгөгдлийн сан бүрдүүлэх зураглалын ажил, аэродромын зураглалын ажлын өгөгдлийн сан, газрын гадаргын болон саадын өгөгдлийн сан болон бусад тоон мэдээллийг нэгдсэн санд үнэ төлбөргүй шилжүүлнэ гэсэн хуулийн заалтын дагуу геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлээгүй, шилжүүлсэн зарим нэг ажлын зөрчлийг арилгаад ирүүл гэсэн үүргийг ч хэрэгжүүлээгүй байна.
5. ICAO Doc. FPC manual 2.4, 2.4.1. Maps-д /ICAO/-гийн DOC 8697,9368,9674 Хавсралт 4-ийн шаардлагууд, Хавсралт 15-ын 10.1.3. Газар зүйн мэдээллийн талбайн өгөгдлийг

Бүс 1-ээр саадын өндөр 100 метрээс дээш байна. Геодези зураг зүйн тухай хуулийн 5.7.2. улсын захиалга, даалгавраар болон салбарынхаа хүрээнд хийх геодези, зураг зүйн ажлын дараа жилийн захиалгыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухайн жилийн 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж өгөхөөр зохицуулалттай байна. Гэтэл хууль, журмаа мөрдөхгүй мэдээллийн санд хийж гүйцэтгүүлсэн зураглалын ажлаа оруулахгүй байгааг анхааруулья.

Зураглалын ажил, саадын өгөгдлийн санг хийлгэх хэрэгцээ, шаардлагагүй байсан 1,467.2 сая төгрөгийн ажил, хийлгэсэн боловч ашиглалтгүй байгаа 606.9 сая төгрөгийн ажил, давхардаж хийгдсэн ажлын өртөг 265.2 сая төгрөг, нийт 2,339.3 сая төгрөгийн ажлыг 10 жилийн хугацаанд гүйцэтгүүлсэн боловч, аэродромуудад байнгын ашиглалт байхгүй, үхмэл хөрөнгө болсон байгааг ИНЕГ-ын өнөөгийн удирдлагууд нэгтгэн авч үзэж, дүгнэлт хийхийн зэрэгцээ хэдийд, хаана, хэний шийдвэрээр хийгдсэн, тухайн ажлыг бүрэн гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх, чанар, үр өгөөж нь ямар болсон, “Геодези, байр зүйн зургийн мэдээллийн сан”-д бүртгүүлсэн эсэх, хэрэв бүртгүүлээгүй байгаа бол шалтгааныг тогтоож, буруутай албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх хүртэл арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэж байна.



Зураглалын ажлыг хийлгэхдээ БХБСайдын /тухайн үеийн нэрээр/ 2006 оны 116, 2013 оны 45 дугаар тушаалуудаар баталсан Геодези, зураг зүйн ажлын жишиг үнийг баримтлах бөгөөд цаашид үүнийг мөрдөж ажиллахыг зөвлөж байна.

#### Шалгалтын явцад тодруулга хийсэн тухай.

Дээр дурдсан “Байр зүйн цаасан зургийг тоон хэлбэрт хөрвүүлэх, газрын гадарга, саадын болон аэродромын зураглалын өгөгдлийн сан бүрдүүлэх” 10 ажлын талаар Иргэний нисэхийн ерөнхий газрын “Нислэгийн мэдээллийн үйлчилгээний алба”-ны дарга П.Ариунгэрэл болон тус албаны Нислэгийн зураглалын хэсгийн дарга Н.Хаш-Эрдэнэ нартай уулзаж сүүлийн 15 жилд улсын төсвийн хөрөнгөөр хийж, гүйцэтгүүлсэн байр зүйн цаасан зургийг тоон хэлбэрт хөрвүүлэх, газрын гадарга, саад болон аэродромын зураглалын өгөгдлийн сан бүрдүүлсэн ажлын гүйцэтгэлийг баталгаажуулсан баримтуудыг цаасаар болон файлаар, /цахим карт/ зэргээс үзэж тодуулахын зэрэгцээ, ажлыг гардан хариуцаж байгаа мэргэжлийн хүмүүсийн тайлбар тодорхойлолтуудыг авч танилцан дүгнэж үзлээ.

#### Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын талаар.

Монгол Улс 1989 онд олон улсын агаарын тээврийн тухай Чикагогийн конвенцид нэгдэн орсноор Олон улсын иргэний нисэхийн байгууллагын өмнө нислэгийн аюулгүй ажиллагааг хангах тухай заалт болох “гишүүн улс нь өөрийн нутаг дэвсгэрт нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх” гэсэн үүргийг хүлээж байдаг байна.

Чикагогийн конвенцын хавсралт 15-ын дагуу 2002 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба байгуулагдан нисэхийн аюулгүй ажиллагаа, тогтмолжилт, үр ашигт шаардлагатай нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллийн урсгалаар хэрэглэгчийг хангах үйлчилгээг “Иргэний нисэхийн дүрэм”-ийн 175-д заасны дагуу үзүүлж байна.

НМҮБ нь нисэхийн мэдээллийн дараах үйлчилгээг эрхлэн явуулдаг байна. Үүнд:

- “NOTAM” мэдээний үйлчилгээ.

NOTAM мэдээний үйлчилгээний хүрээнд богино хугацааны түр шинж чанартай нислэгийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой мэдээллүүдийг 2D график, 3D график текст хэлбэрээр боловсруулан хэрэглэгчдэд нэгдсэн цахилгаан холбооны сүлжээ, /AFTN/, цахим шуудан болон өөрийн албаны вэб сайтаар дамжуулан хүргэдэг байна.

- Нисэхийн мэдээлийн эмхтгэлийн үйлчилгээ

Монгол улсын агаарын зайд үйлдэгдэж буй нислэгүүд болон агаарын навигацид чухал шаардлагатай урт хугацааны, тогтмол шинж чанартай нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллийг цуглуулж, Чикагогийн конвенцын Хавсралт 15-ын шаардлагад нийцүүлэн монгол, англи хэл дээр боловсруулж, Монгол улсын нисэхийн мэдээллийн эмхтгэлийн өөрчлөлтүүдээр хэрэглэгчдэд тарааж хүргэдэг байна.

Нисэхийн мэдээллийн эмхтгэл нь агаарын навигацийн бүх төрлийн текстэн мэдээлэл болон маршрутын зураг, аэродромын зураг, саадын зураг, агаарын хөлгийн зогсоолын зураг, хэрэглэлээр ойртолт үйлдэх зураг, хэрэглэлээр нисэн гарах зураг, шувуудын

бөөгнөрлийн зураг гэх мэт нислэгийн аюулгүй үйл ажиллагаанд шаардлагатай бүхий л тогмол шинж чанартай мэдээллүүдийг агуулсан 419 орчим хуудас бүхий мэдээллийн товхимол байна.

#### Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээний талаар

Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээний хүрээнд “Чингис хаан” ОУНБуудлаас эхлэх ОХУ, БНХАУ, БНСУ, Япон, ХБНГУ, Казахстан, Польш, Хонг Конг, Тайланд болон орон нутгийн бүх нислэгүүдийн нисгэх баг болон түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчид, тухайн нислэгтэй холбоотой аэронавигацын мэдээнүүдийг хүргэдэг байна.

#### Аэродромын нислэгийн хөдөлгөөний мэдээ зохицуулалтын үйлчилгээ

Нислэгийн мэдээлэл зохицуулалтын үйлчилгээний хүрээнд “Чингис хаан” аэродромын нислэгийн хөдөлгөөнтэй холбогдолтой нислэгийн төлөвлөгөө, түүний өөрчлөлт, саатал, хөөрөлт, буултын мэдээллийг холбогдох байгууллагад дамжуулж байдгаас гадна, тус НМҮА нь олон улын иргэний нисэхийн байгууллагын стандарт, зөвлөмжүүдийг баримтлан ажиллаж, Ази-Номхон далайн бүсийн 41 орны ижил төстэй байгууллагуудын хэмжээнд тэргүүлж байгаа бөгөөд өөрийн үйл ажиллагаандаа дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар хэрэглэгчийн шаардлагад нийцсэн, тэдгээрийн эрэлт хэрэгцээг мэдэрч, нисэхийн үнэн зөв, бодит мэдээллээр хангах зорилтыг тавьж хэрэгжүүлсэн байна.

ИНЕГ-ынхаа хэмжээнд Чанарын удирдлагын тогтоолцоо хэрэгжүүлсэн 2 дахь байгууллага болж, ажилтнуудынхаа ур чадвар, мэдлэг боловсролыг байнга дээшлүүлж, Монгол улсын Иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх талаарх бодлогыг хэрэгжүүлэхэд тэргүүн эгнээнд явж гадаад, дотоодын үйлчлүүлэгч байгууллагуудын итгэлийг хүлээж ажиллахыг эрхэмлэж иржээ.

Энэхүү алба нь 2013 онд нисэхийн мэдээллийн үйлчилгээнээс нисэхийн мэдээллийн менежментэд шилжих олон улсын 8 дугаар хурлыг эх орондоо анх удаа, амжилттай зохион байгуулсан ба олон улсын “AIS-AIM implementation task force” /нисэхийн мэдээллийн үйлчилгээнээс Нисэхийн мэдээллийн менежментэд шилжих/ хурлын даргалагчаар НМҮА-ны дарга П.Ариунгэрэл мөн IFAIMA /Олон улсын нисэхийн менежментийн холбооны Ази-Номхон далайн бүсийн захирлаар тус албаны Аюулгүй ажиллагаа, чанар хангалтын хэсгийн дарга Д.Эрдэнэбаатар тус тус томилогдон ажиллаж байна.

2012 онд БНЭУ-д зохион байгуулагдсан Ази-Номхон далайн бүсийн Иргэний нисэхийн захирлуудын уулзалт 49 дүгээр хуралдаанд НМҮА-ны ажилтан Н.Хаш-Эрдэнэ оролцож “Газрын гадарга болон саадын өгөгдлийн сан бүрдүүлэх асуудал” сэдвээр илтгэл тавьж, асуулга, хэлэлцүүлэг амжилттай зохион байгуулан олон улсын иргэний нисэхийн байгууллага болон бусад олон улсуудаас талархал хүлээж авсан бөгөөд манайхаас гаргасан санал, зөвлөмжийн дагуу олон улсын иргэний нисэхийн байгууллагаас стандарт, зөвлөмжүүддээ холбогдох өөрчлөлтүүдийг оруулах ажил хийгдэж байгааг танилцууллаа.

Тус албанаас туршлага судлахаар БНСУ, БНАСУ, Малайз, Тайвань, Хонг Конг, Макао зэрэг улсуудын мэргэжилтүүд ирж байсан бөгөөд, тус албаны мэргэжилтнүүд Малайз улсын

нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагад аудит, шалгалт хийж, зөвлөгөө өгч ажиллажээ. Мөн тус албанаас 2017 онд олон улсын иргэний нисэхийн байгууллагад хүлээн зөвшөөрөгдсөн “Нисэхийн мэдээллийн менежментийн мэргэжилтэн бэлтгэх” олон улсын сургалтыг эх орондоо анх удаа зохион байгуулж Австрали, Бангладеш, Непал улсын нисэхийн мэргэжилтнүүдэд “Нисэхийн мэдээллийн мэргэжилтэн”-ий сертификат олгосон нь олон улсын түвшинд багшлах чадвар бүхий, мэргэжлийн боловсон хүчинтэй болжээ.

**Нисэхийн аюулгүй ажиллагааг хангах, Нисэхийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах байр зүйн зураг, газрын гадарга, саад болон аэродромын зураглалын өгөгдлийн сан бүрдүүлсэн талаар.**

Дээр дурдсан нисэхийн мэдээллийн үйлчилгээг үзүүлэхэд ашиглагдах байр зүйн зураг, газрын гадарга, саад болон аэродромын зураглалын өгөгдлийн сан бүрдүүлэх ажлуудыг “Олон улсын иргэний нисэхийн байгууллага”-д тавигддаг шаардлагын дагуу техникийн тодорхойлолтыг НМҮА-аас боловсруулж, ИНЕГ-ын даргаар батлуулан Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгчийн сонгон шалгаруулж /тусгай зөвшөөрөлтэй/ компаниар гүйцэтгүүлж Ажлын хэсэг томилж хүлээн авч, удирдах шатны байгууллагадаа хүргүүлж, санхүүжилтийг олгуулдаг гэж тайлбартаа тусгажээ.

ИНЕГ-аас зохих шийдвэрийг гарган, тухайн ажлын үнэлгээг гарган Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4-д заасны дагуу өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар зарим ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах “Үнэлгээний хороо” томилсон байна. Үнэлгээний хорооноос гаргасан зөвлөмжид үндэслэн ИНЕГ-ын дарга нь Монгол улсын геодези, зураг зүйн үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, хамгийн сайн үнэлэгдсэн тендерт оролцогчтой гэрээ байгуулан ажилласан байна.

Мөн зарим ажлуудыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулсан байна.

Олон улсын Иргэний нисэхийн байгууллагын стандарт, зөвлөмжийн дагуу бүрдүүлсэн газар зүйн мэдээлэл агуулсан өгөгдлийн санг ямар байгууллага шалгаж, баталгаажуулах талаар заасан журам, заавар Монгол улсад одоогоор байхгүй тул НМҮА-наас гэрээт ажлын дагуу хүлээн авсан газрын гадарга, саад болон аэродромын зураглалын өгөгдлийн сан бүрдүүлсэн ажлын гүйцэтгэлийг мэргэжлийн байгууллагын хувьд олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, зөвлөмжийн чанарын шаардлагатай тулган шалгаж, дүгнэлт гарган ИНЕГ-т хүргүүлдэг байна.

Иргэний нисэхийн ерөнхий газарт ЗТЯ-наас хүргүүлсэн 2014 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 3/4864 тоот албан бичгийн дагуу 2014 оноос эхлэн газрын гадарга, саад болон аэродромын зураглалын өгөгдлийн сан бүрдүүлсэн ажлуудыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох /ГХГЗЗГ/-аар шалгуулж, дүгнэлт гаргуулахаар болсон бөгөөд 2016 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 2016/40 дугаартай

ИНЕГ болон ГХГЗЗГ-уудын хооронд хамтын ажиллагааны санамж бичгийг 3 жилийн хугацаатай байгуулан ажилласан байна.

Энэхүү санамж бичгийн 4.1-д Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар /ГХГЗЗГ/ нь ИНЕГ-ын захиалгаар хийгдсэн байр зүйн зураг, газрын гадарга саад болон аэродромын зураглалын өгөгдлийн санг шалгаж, баталгаажуулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх /талууд/ гэж харилцан ойлголцлын санамж бичигт тусгажээ.

ИНЕГ нь улсын төсвийн хөрөнгөөр хийлгэсэн /бүрдүүлсэн/ газрын гадарга, саад болон аэродромын зураглалын өгөгдлийн санг шалгуулж, баталгаажуулах, нэгдсэн санд оруулах талаар ГХБГЗЗГ-т 2016 оны 02 дугаар сарын 22-ны 08/в-46, 2016 оны 10 дугаар сарын 25-ны 08/в-267 болон 2018 оны 12 дугаар сарын 21-ний 08/в-411 тоот албан бичгүүдээр тус тус хүргүүлсэн боловч Газрын харилцаа, геодези, зураг зүйн газраас ИНЕГ-ын захиалгаар 2010-2013 онуудад хийгдсэн газрын гадарга, саад болон аэродромын зураглалын өгөгдлийн сангийн эцсийн тайланд магадлал хийх боломжгүй гэсэн хариуг 2018 оны 01 дүгээр сарын 10-ны 2/78 тоот албан бичгээр ИНЕГ-т ирүүлсэн байна.

Иймд Нисэхийн аюулгүй ажиллагаа хяналт зохицуулалтын алба /НААХЗА/-ны байцаагчийн 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 161/16 дугаартай дүгнэлт болон НААХЗА-ны Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтсийн 2017 оны 11 дүгээр сарын 10-ны 04/17 дугаар тайлан, дүгнэлтэд "Газрын гадарга, саад болон аэродромын зураглалын өгөгдлийн санг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газраар баталгаажуулж, ашиглах" гэсэн шаардлага хэрэгжих боломжгүй болсон байна.

Олон улсын Иргэний нисэхийн байгууллагаас Бүс 1-ийн газрын гадарга болон саадын өгөгдлийн санг 2008 оны 11 дүгээр сарын 20 гэхэд, Бүс 2-ын газрын гадарга болон саадын өгөгдлийн санг 2015 он 11 дүгээр сарын 12 гэхэд олон улсын агаарын навигацид ашиглаж эхлэхийг шаардсаны дагуу Монгол улсын ИНЕГ нь улсын төсвийн хөрөнгөөр 2005-2017 онуудад дээр дурдсан олон улсын шаардлагыг бүрэн хангасан өгөгдлийн санг бүрдүүлсэн боловч, НААХЗА-наас тавьсан шаардлагаар дээрхи өгөгдлийн санг нисэхийн үйл ажиллагаанд ашиглах боломжгүй, аэродромын саадын мэдээлэлд шинэчлэлт хийх үйл ажиллагаа явагдахгүй байгаа, хэрэглэгчдийг шаардлагатай мэдээллээр хангаж чадахгүй байгаа бөгөөд энэ асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг НМҮА-наас удирдах дээд шатны байгууллагадаа удаа дараа тавьсан боловч, өнөөг болтол тодорхой шийдвэр гаргахгүй байгаа талаар тус албаны дарга П.Ариунгэрэл, нислэгийн зургийн хэсгийн дарга Н.Хаш-Эрдэнэ нарын тайлбарт болон явуулсан албан бичгүүдээс тодорхой харагдаж байна.

Иймд Чикагогийн конвенцын Хавсралт 15-ын бүлэг 10 болон бүлэг 11-д заасан шаардлагад нийцүүлэн бүрдүүлсэн газрын гадарга, саад болон аэродромын зураглалын өгөгдлийн сан (AMDB)-г нисэхийн үйл ажиллагаанд ашиглаж болох эсэхэд олон улсын мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн аудит /эксперт/ хийлгэн дүгнэлт гаргуулах шаардлагатай гэж үзэж байна.

Мөн дотоод аудитын хийсэн шалгалт дүгнэлтэд дурдсан техникийн тодорхойлолтод заасан газрын гадарга, саад болон аэродромын зураглалын өгөгдлийн сан бүрдүүлэх ажлыг бүрэн хийгээгүй, орхигдуулсан, ажлыг бүрэн хийгээгүй байхад санхүүжилт илүү олгосон, давхардуулан хийж үргүй /нэмэгдэл/ зардал гаргасан, хувийн эзэмшлийн аэродромуудад хийсэн хөрөнгө оруулалтын зардлыг нэхэмжилж авах зэрэг асуудлуудыг олон улсын аудит хийлгэж дүгнэлт гарсаны дараа шийдвэрлэх нь зүйтэй.

Нисэхийн аюулгүй ажиллагааг хангах, нисэхийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах байр зүйн зураг, газрын гадарга, саад болон аэродромын зураглалын өгөгдлийн сан бүрдүүлэх, шалгуулах, гарсан асуудлыг шийдвэрлүүлэх шийдвэрлүүлэх талаар авсан арга хэмжээтэй холбогдох баримтуудыг тайлбарын хамт авсан болно.

### **Арван хоёр. САЛБАРЫН ЯАМНЫ БОЛОН БАЙГУУЛАГА, ИРГЭДИЙГ ИВЭЭН ТЭТГЭСЭН, ХАНДИВЛАСАН ЗЭРЭГ ЗӨРЧИЛҮҮД ИЛЭРЛЭЭ.**

Тус газар гадны байгууллага хүмүүст хандив өгдөг, ивээн тэтгэж 98.7 сая төгрөгийг үргүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-д заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараахь байдлаар хэрэгжүүлнэ.”, 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Үүнд

-Гадны байгууллага хүмүүст олгосон хандивын жагсаалт

д/д	Огноо	Шийдвэрийн огноо	Гүйлгээний утга	Мөнгөн дүн
1	2012.01.27	ИНЕГ-н даргын 2012.01.27 №Б/27	Буянт-Ухаа цогцолбор, 114 дүгээр сургууль, 134 дүгээр цэцэрлэг, 49 дүгээр цэцэрлэгийн багш нарыг шагнасан	1,260.0
2	2012.03.14	ИНЕГ-н даргын 2012.03.19 №Б/68	Голомт банкны нисэх тооцооны төвийн 15-н жилийн ойд бэлэг дурсгал	288.0
3	2012.03.14		Нисэх- Голомт банкны төвийн захирал Д.Дүүриймааг шагнав	270.0
4	2012.05.23	ИНЕГ-н даргын 2012.05.22 №Б/139	Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтсийн дарга, хурандаа Д.Сүхбаатар, Монголын үндэсний бөхийн холбооны тэргүүн Р.Нямдорж	900.0
5			ГИХАЭГазрын тасвийн дарга Ж.Саранчимэг, ГХЯамны консулын газрын захирал Д.Ганхуяг, Үндэсний бөхийн холбооны нарийн бичгийн дарга, бөх тайлбарлагч Б.Цогтбаатар, Буянт-Ухаа цогцолбор сургуулийн захирал Ө.Болормаа, 4 багш нарын тус бүр 70000 төгрөгөөр шагнах	504.0

6	2012.06.21	ИНЕГ-н даргын 2012.06.21 №Б/182	"Монконкорд" ХЗХ-ны нягтлан бодогч, нярав нарыг шагнах	126.0
7	2012.10.03	ИНЕГ-н даргын 2012.10.04 №А/334	Итали улсад зохиогдох үсчин, гоо засалчдын Дэлхийн аваргын тэмцээнд оролцох Н.Алтаншагайгийн онгоцны билет, тэмцээний хураамжинд	2,400.0
8	2015.10.19	ИНЕГ-н даргын 2015.10.14 №А/654	Хөгжлийн дэмжих Хан-Уул санд Хан-Уул дүүргийн 50-н жилийн ойн арга хэмжээнд санхүүгийн дэмжлэг	6,000.0
9	2012.05.09	ИНЕГ-ын даргын 2012.07.06 №А/247	Баянзүрх дүүргийн Алчилсан Холбоонд дэмжлэг үзүүлэх тухай	1,000.0
10	2012.07.06		Төв аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтанд дэмжлэг үзүүлэх тухай	15,000.0
11	2012.07.09	Монголын нисэх загварын спорт нийгэмлэг	Монголын нисэх загварын спорт нийгэмлэгийн тэмцээний санхүүжилт	5,000.0
12	2012.07.17	ЗТБХБЯ-ны 2012.06.29-ны 2/3236 албан бичиг,	Олимп хөгжил санд Лондон-2012 олимпын хандив	20,000.0
13	2012.09.17	ИНЕГ-ын даргын 2012.09.03 А/298	Тохижилтонд дэмжлэг үзүүлэх	1,000.0
14	2012.10.08	ИНЕГ-ын даргын 2012.09.27 А/324	49 цэцэрлэгт хөгжмийн үнэ	1,000.0
15	2015.04.02	Гэрээ 20/15	Тээврийн дээд сургуулийн Механик инженерийн ангийн лекцийн танхим, лабораторийн ангийн засварын ажил	6,512.7
16	2015.07.09	ЗТЯ-ны 2015.06.30-ны өдрийн 02/2890 тоот албан бичиг	Автотээврийн 90-н жилийн ойн хандив	9,000.0
17	2016.03.18	Олимп хөгжлийг дэмжих сан	Рио-2016 оны зуны олимпын наадмын тэмцээнд оролцох дэмжлэг	15,000.0
18	2016.05.04			8,989.2
19	2016.04.15	Монголын Авто замчдын холбоо	Авто тээврийн бүтээн байгуулалтын зар сурталчилгааны хандив	4,500.0
Дүн				98,749.9

Зам тээвэр хөгжлийн яаманд өгсөн бэлэг дурсгал, шатахуун, сэлбэг хэрэгсэл бусад арга хэмжээний зардал:

д/д	Огноо	Гүйлгээний утга	Мөнгөн дүн /мян.төг/
1	2012.01.31	Шинээр томилогдсон ЗТБХБСайдад дурсгах бэлэг	464.5
2	2012.04.11	ЗТБХБЯамны удирдлагуудтай оройн зоог барих	400.0
3	2012.06.29	ЗТБХБСайд Ц.Дашдоржид гарын бэлэг	214.0
4	2012.08.17	ЗТБХБЯ-ны мэргэжилтэн Г.Батад /эмчилгээний 5.0 сая төгрөг, цалингийн урьдчилгаа 5.0 сая төгрөг/	10,000.0
5	2012.09.13	Зам тээврийн газрын дотор гэрэлтүүлэг, хяналтын камер	347.1
6	2012.10.25	ЗТЯ-ны дэд сайд Х.Ержанд бэлэг	29.0
7	2012.11.20	ЗТЯ-ны сайдын өрөөний хаалга	1,206.5
8	2014.01.16	ЗТЯ сэтгүүлийн үнэ	3,500.0
9	2015.04.02	ЗТЯ-ны Агаарын тээврийн бодлогыг хэрэгжүүлэх хэлтсийн 3	4,126.8

		өрөөний засвар	
10	2015.06.23	"Их түмэн санаачлага" тээврийн хорооны 5-р хурлын орчуулгын төлбөр /9 цаг/	2,754.0
11	2012-2017	Шатахууны зардал	17,647.0
12	2012-2017	Сэлбэгийн зардал	6,259.4
13	2012-2017	Засвар, тохижилтонд	168,000.0
<b>Нийт дүн</b>			<b>214,948.3</b>

Зам, тээврийн яаманд өгсөн бэлэг дурсгал, эмчилгээ, шатахуун, сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ болон бусад арга хэмжээний зардалд 214.9 сая төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасан "тухайн шатны төсвөөс санхүүжилтээр хэрэгжүүлэх", 6.6.6-д "тухайн шатны төсвөөс хэрэгжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн тул зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлага өглөө.

#### **Арван гурав.ГАДААД ТОМИЛОЛТООР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН ТАЛААР:**

ИНЕГазар нь гадаад томилолтын тооцоог хийхдээ Монгол улсын Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 188 дугаар тушаалын хавсралт "Төсөвт байгууллагын гадаад арга хэмжээний зардлыг төлөвлөх, гадаад албан томилолтын зардлын төсвийг зохиох, хянах санхүүжүүлэх, тайлагнах журам"-ыг зөрчин хот доторхи унааны зардлын хэмжээг тухайн хотод байх хугацааг хоногт 10 ам доллароос илүү тооцсон, хүлээн авалт, холбоо, орчуулагч, уулзалт, вип заалны төлбөрийг төлсөн зөрчил илэрлээ.

№	Огноо	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	Нийт дүн
2	Хот дотор /ам доллар/	4,720.0	1,250.0		790.0		6,759.95
3	Хүлээн авалт /ам доллар/	9,000.0	4,100.0	14,350.0	20,913.0	7,200.0	55,563.00
4	Холбооны зардал/ам доллар/	250.0	560.0	170.0	600.0		1,580.00
5	Бусад зардал /ам доллар/	2,065.0	425.0	132.5	4,800.0	900.0	8,322.50
<b>ДҮН</b>		<b>16,035.0</b>	<b>6,335.0</b>	<b>14,652.5</b>	<b>27,103.0</b>	<b>8,100.0</b>	<b>72,225.45</b>

Төсвийн тухай хуулийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-д заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараахь байдлаар хэрэгжүүлнэ.", 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 188 дугаар тушаалыг зөрчин гадаад томилолтын зардлыг зориулалт бусаар зарцуулсан 72,225.45 ам долларыг улсын төсөвт төлүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоов.

**Арван дөрөв. ХӨРӨНГӨ МӨНГИЙГ ЗОРИУЛАЛТ БУС, ҮР АШИГГҮЙ. БАРИМТГҮЙ  
ЗАРЦУУЛСАН ЗӨРЧИЛ ИЛЭРЛЭЭ.**

1.ИНЕГазар 2012 оноос хойш хэвлэл мэдээлэл, зар сурталчилгаанд 145.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Зарцуулсан мөнгийг хүснэгтээр харуулбал:

д/д	Огноо	Мөнгө шилжүүлсэн газар	Гүйлгээний утга	Мөнгөн дүн
1	2012.01.06	Ардчилал сонин	Зар сурталчилгааны чиглэлээр	6,000.0
2	2012.02.14	"Үнэн ньюс" ХХК	Реклам сурталчилгаа, мэдээллийн төлбөрт	5,000.0
3	2012.02.29	Өдрийн шуудан сонин	Гэрээний дагуу төлбөр	10,000.0
4	2012.12.28	Ардчилал сонин	Шинэчлэлийн Засгийн газрын 100 хоногийн хүрээнд ЗТЯ-аас зохион байгуулах арга хэмжээний зардал	700.0
5	2013.06.20	Макс колор ХХК	веб сайтны төлбөр	6,200.0
6	2013.07.18	Ардчилал сонин	Реклам сурталчилгаа, мэдээллийн төлбөрт	3,000.0
7	2013.11.18	Ньюс Аженси ХХК	Мэдээний төлбөр	8,000.0
8	2013.12.05	Эрдэнэ Минерал ХХК	Сурталчилгааны зардал	5,000.0
9	2013.12.05	Батаар медиа ХХК	Мэдээллийн төлбөр	5,000.0
10	2014.01.15	Үндэсний шуудан сонин	Мэдээний төлбөр	10,000.0
11	2014.02.07	Ийгл бродкастинг ХХК	Гэрээний дагуу төлбөр	10,000.0
12	2014.04.18	Ийгл бродкастинг ХХК	Гэрээний дагуу төлбөр	10,000.0
13	2014.04.22	Маш нууц медиа ХХК	Хамтран ажиллах гэрээ	6,000.0
14	2014.08.21	ТСУБүтээлчдийн холбоо	Сурталчилгааны зардал	1,500.0
15	2014.11.17	ТВ сэтгүүлч уран бүтээлч холбоо	Гэрээний дагуу төлбөр	10,000.0
16	2014.01.21	Онлайн хүрээ ХХК	Хамтран ажиллах гэрээний дүн	10,000.0
17	2014.09.10	Залуу сэтгүүлчдийн холбоо	Сурталчилгааны зардал	1,800.0
18	2014.09.12	Чухал ньюс ХХК	Гэрээний дагуу төлбөр	4,000.0
19	2014.10.20	Монголчууд сэтгүүл	Зар сурталчилгаа	3,000.0
20	2014.11.17	Мэдээллийн сайтуудын ассоциаци	Гэрээний дагуу төлбөр	6,000.0
21	2015.04.21	Наран Энх Блэк Энд Вайт фото	Сурталчилгааны зардал	1,650.0
22	2015.08.12	Өглөөний сонин	Төлбөр	225.0
23	2015.08.12	Өдрийн мэдээ ХХК	2 нүүр төлбөр	1,760.0
24	2015.08.12	Монголын Мэдээ сонин	Төлбөр	500.0
25	2015.08.12	Нээлттэй хаалга сонин	Төлбөр	200.0



26	2015.10.15	Монгол ньус ХХК	Төлбөр	1,860.0
27	2015.09.17	Хэвлэл мэдээллийн хөгжлийг дэмжих төв	Сурталчилгааны зардал	1,000.0
28	2016.05.04		Гэрээний дагуу төлбөр	14,700.0
29	2015.09.17	Эдимүүн ХХК	Сурталчилгааны зардал	1,000.0
30	2015.09.18	Чухал ньус ХХК	Сурталчилгааны зардал	1,000.0
Дүн				145,095.0

Дээрхи зар сурталчилгаанд зарцуулсан мөнгөнөөс байгууллага иргэний хоорондын маргаан, хувийн ашиг сонирхолд байгууллагыг ашиглаж мөнгө зарцуулсан зөрчил илэрлээ. Тухайлбал: Т.Батжаргалын нэхэмжлэлтэй Сүхбаатар дүүргийн 2013 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 2244 дүгээр тогтоол, Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 2375 дугаар шийдвэрүүдээр Өдрийн сонин, Өглөөний сонинтой холбоотой нэр төр сэргээлгэж эдийн бус гэм хорын хохиролын мөнгийг гаргуулах тухай хэрэгт хариуцагч Өдрийн сонин, Өглөөний сонин нь Т.Батжаргалын талаар нэр төр гутаагдсаныг уг сонингуудад нийтлэгдсэн хэлбэр хэмжээгээр няцаалт хийхийг үүрэг болгосон байна. Мөн дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 1837 дугаар шийдвэр, Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн 2014 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 548 дугаар тогтоолоор Т.Батжаргалын нэхэмжлэлтэй “Ийгл” телевизид холбогдох хэргийг хэлэлцээд нэвтрүүлгээр цацагдсан мэдээлэл бодит байдалд нийцсэн мэдээлэл болж чадаагүй байх тул Т.Батжаргалын нэр төрийг гутаагдсан гэж үзэн өөрийн мэдээлдээ няцаалт хийхийг үүрэг болгосон байна. Гэтэл “Ийгл бродкастинг” ХХК-руу 20.0 сая төгрөг, “үндэсний шуудан” руу 10.0 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Тус газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн Б.Пүрэвсүрэн өгсөн тайлбардаа “... 2013, 2014, 2015 онуудад хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ хийгдсэн асуудал хэвлэл мэдээллийн асуудал хариусан мэргэжилтэнд хамааралгүй явж ирсэн...” гэсэн тайлбарыг өгсөн.

2.ИНЕГазар доорхи тоглолтын төлбөр, тоглолтын билет, программ хангамж зэрэг 397.9 сая төгрөгийн мөнгө хөрөнгийг зарцуулсан байна.

д/д	Огноо	Мөнгө шилжүүлсэн газар	Гүйлгээний утга	Мөнгөн дүн/мян.төг/
1	2012.03.27	Жуулчин уорлд турс ХХК	2012 оны Олимпын тоглолт үзэх	15,458.4
2	2012.05.11	МҮБөхийн холбоо	Барилдааны зардал	13,200.0
3	2012.05.29	Монгол костюмс ХХК	Загвар үзүүлбэр төлбөр	1,200.0
4	2012.06.11	Гамма агентлаг	Зураг угаалгах	1,600.00

5	2012.07.17	Мөнх баян бараат ХХК	2011 оны жилийн ажлын үр дүнгээр Куба улсад аялах эрхийн бичиг	104,400.0
	2012.09.10	Монголын жүдо бөхийн холбоо	200 ширхэг билетний үнэ	4,000.0
6	2013.05.17	МҮБөхийн холбоо	Барилдааны зардал	13,200.0
7	2013.08.30	Битүби ХХК	Орчуулгын төлбөр	3,996.0
8	2013.11.21			3,996.0
9	2013.09.18	Consultants Joint Venture	Олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих тухай зөвлөх талын үйлчилгээ үзүүлэх барилгын төслийн гэрээ	9,030.1
10	2013.10.16	Үндэсний ХНСҮТөв	Сургалт зөвлөлгөө	5,880.0
11	2014.05.06	Жудо бөхийн холбоо	Билетний үнэ	4,000.0
12	2014.10.10	Хөгжмийн зохиолчдын холбоо	Тоглолтын билет	2,000.0
13	2014.10.16	Нислэгийн удирдагчдын холбоо	Арга хэмжээнд	16,250.0
14	2014.11.04	Монголын чанарын холбоо	Урьдчилгаа төлбөр	9,306.0
15	2015.11.19		Үлдэгдэл төлбөр	6,204.0
16	2014.11.21	Хөгжлийн зам төв ТББ	Судалгааны гэрээт ажлын хөлс	9,800.0
17	2014.12.01	Д.Батбаатар	Судалгааны ажлын 30 хувь	1,050.0
19	2015.11.18	Лонг байнери сити ХХК	Программ хангамж	5,999.4
20	2014.12.26	Олон улсын таеквондогийн холбоо	120 хүний сургалтын төлбөр	1,000.0
21	2015.04.27	Лихт дизайн ХХК	Олон улсын зорчигчдын танхимыг өргөтгөх зураг төслийн ажил	3,000.0
22	2015.05.06		Зураг төслийн ажил гүйцэтгэх	2,100.0
23	2015.04.29	"Төгөлдөр урлаг" ТББ	90-н жилийн ойн дуу клипний зардал	15,000.0
24	2015.05.15	"Өнөбаз" ХХК	ИНЕГ-ын даргын өрөө, амралтын өрөө, нарийн бичгийн өрөөний засварын ажил	9,980.3
25	2015.06.11			8,091.3
26	2015.12.14	Амури Оргил ХХК	Шинэ жилийн арга хэмжээний урьдчилгаа	35,200.0
27	2015.12.24		Төлбөрийн гүйцэтгэл	17,255.5
28	2015.12.18	Арт саунд продакшн ХХК	2015.12.21 ба 2012.12.22-нд "Гранд хилл" зочид буудалд зохион байгуулагдах "Мөнгөн үдэш" тоглолтыг зохион байгуулах	25,200.0
29	2015.12.24			8,400.0
30	2015.12.16	Сэтгэц оношлогоо сэтгэлзүй төв	Судалгааны аргачлал	1,200.0
31	2016.08.16	Н.Уянга	Арга хэмжээний урлагийн тоглолт	5,400.0
32	2016.08.16	"Чингис хааны" хүрээ ХХК	Хүлээн авалтын төлбөр	8,800.0
33	2016.11.29	Ингрид ХХК	Бүртгэлийн ажилтны зөвлөлгөөний арга хэмжээнд	14,500.0

34	2016.07.05	Цэвэгмид Батзориг сан	Гэрэл зургийн цомог	12,300.0
<b>Дүн</b>				<b>397,997.0</b>

Дээрхи 397.9 сая төгрөгийг загвар үзүүлбэр, сургалт зөвлөлгөө, судалгааны ажил, программ хангамж, зураг төслийн ажил зэрэг ажлууд нь ажлын тайлан, хүлээн авсан акт байхгүй, баримт дутуу зарцуулсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." гэсэн заалтыг зөрчсөн тул **397.7 сая төгрөгийг зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлага өглөө.**

**Арван тав. БАРАА МАТЕРИАЛ, ШАТАХУУН, СЭЛБЭГ ХЭРЭГСЭЛ, ЦАЛИН ХӨЛС, ӨГЛӨГ АВЛАГАТАЙ ХОЛБООТОЙГООР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН ТАЛААР**

1.Үйлдвэрлэлийн 2012 оны бараа материалын тайланд орлогын 2,785.6 мянган төгрөг, зарлагын 5,575.0 мянган төгрөг, 2013 онд зарлагын 4,793.2 мянган төгрөг нийт 13,153.9 мянган төгрөгийн өртөг бүхий бараа материалыг орлого, зарлагын баримтыг хавсаргаагүй, байгууллагын тамга тэмдэг, гарын үсэг байхгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.Үндэсний аудитын газраас тус агентлагийн 2014 оны санхүүгийн тайланд аудит хийж газар хэлтсийн 12 дарга шатахуун, сэлбэгийн зардалд 89.6 сая төгрөгийн зардал гаргасан нь Засгийн газрын 2007 оны "Суудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай" 349 дүгээр тогтоолын 5 дахь заалт, Засгийн газрын "Суудлын автомашины талаар авах арга хэмжээний тухай" 2014 оны 147 дугаар тогтоолд Засгийн газрын 2007 оны 349 дүгээр тогтоолоор тогтоосон албан тушаалын болон албан ажлын автомашины хэрэглээний зардлыг 20 хувиар хэмнэх гэж заасантай нийцэхгүй байна гэсэн үндэслэлээр акт тогтоосон байна. Актын 89.6 сая төгрөгийг байгууллагаас төлж барагдуулсан боловч зардалд бичиж давхар зардал гаргасан ба энэ зардлыг цаашид гаргахгүй байх талаар ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй байна. Засгийн газрын 2007 оны 349 дүгээр тогтоолд заагдаагүй нэр бүхий албан тушаалтны суудлын авто машинд гарсан зардлаас гадна грашийн төлбөр, сэлбэг, жолоочийн цалин, нийгмийн даатгал, тослох материалын зардал давхар гарч үргүй зардал гарсан.

3.Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын “Технологийн зориулалтаар ашиглах автомашины гүйлтийн лимит шинэчлэн батлах тухай” 2013 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/295, 2015 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн А/425, 2017 оны 02 дугаар сарын 06–ны өдрийн А/70 тоот тушаалаар ИНЕГ-ын дарга, тэргүүн дэд дарга, газрын дарга нарт Улаанбаатар хот ирж очих сул явалтад өдрийн 40-50 км-р баталсан бөгөөд 2012 оны 01 дүгээр сарын 01-с 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл нийт 43,386.3 мянган төгрөгийн сэлбэг, 258,404.3 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөг/

Он	Нэрс	Албан тушаал	Зарцуулсан сэлбэг	Зарцуулсан шатахуун
2012	С.Батмөнх	Дарга	2,666.2	24,820.1
2012	П.Мөнхжаргал	Тэргүүн дэд дарга	2,218.0	12,291.4
2012	Б.Алтанцом	Дэд дарга	3,363.3	10,580.9
2012	Ж.Цолмон	Нислэг техникийн осол зөрчлийн шинжлэн шалгах албаны дарга	1,625.1	9,449.3
2012	С.Янжинхорлоо	Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга	1,750.1	8,461.4
2012	Г.Батбаяр	АТБЗЭМ-ын дарга	2,888.5	8,834.8
2012	Т.Батжаргал	Захиргаа, удирдлагын газрын дарга		390.2
2013	С.Буяндалай	Дарга		21,199.8
2013	С.Энх-амгалан	Тэргүүн дэд дарга		11,200.8
2013	Б.Алтанцом	Дэд дарга	13,653.6	9,092.2
2013	С.Наранхүү	Нислэг техникийн осол зөрчлийн шинжлэн шалгах албаны дарга		9,252.4
2013	Г.Ганболд	Агаарын навигацийн үйлчилгээний газрын дарга	109.6	9,084.5
2013	М.Цогтгэрэл	Нисэх буудлын үйлчилгээний газрын дарга	1,147.4	15,784.8
2013	С.Янжинхорлоо	Санхүү, эдийн засгийн газрын дарга	365.4	7,207.8
2013	Д.Эрдэнэбат	Агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалтын газрын дарга	2,117.8	13,148.4
2013	Б.Ган-очир	Захиргаа, удирдлагын газрын дарга	9,090.5	6,072.2
2014	С.Буяндалай	Дарга		10,889.5
2014	С.Энх-амгалан	Тэргүүн дэд дарга	32.1	7,934.1
2014	Ч.Нямсайхан	Дэд дарга	236.0	1,538.9
2014	Ж.Цолмон	Нислэг техникийн осол зөрчлийн шинжлэн шалгах албаны дарга	93.0	18,894.9
2014	Г.Ганболд	Агаарын навигацийн үйлчилгээний газрын дарга		9,531.6
2014	М.Цогтгэрэл	Нисэх буудлын үйлчилгээний газрын дарга	1,142.5	9,001.1
2014	Л.Нэргүй	Санхүү, эдийн засгийн газрын дарга	212.7	6,825.4
2014	Л.Бямбасүрэн	Агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалтын газрын дарга	674.5	9,571.1
2014	Б.Ган-очир	Захиргаа, удирдлагын газрын дарга		7,346.7
<b>Нийт</b>			<b>43,386.3</b>	<b>258,404.3</b>

Зам Тээврийн Хөгжлийн Яам, ИНЕГ-ын дарга, тэргүүн дэд дарга, газрын дарга нарт 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл нийт 34,226.0 мянган төгрөгийн сэлбэг, 253,849.5 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна. Үүнээс Зам Тээврийн Хөгжлийн Яамны үйлчилгээнд 2015–2017 онуудад нийт 6,259.4 мянган төгрөгийн сэлбэг, 17,647.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь Засгийн газрын 2015 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн “суудлын автомашины

ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 184 дүгээр тогтоолыг зөрчсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөг/

Он	Нэрс	Албан тушаал	Зарцуулсан сэлбэг	Зарцуулсан шатахуун
2015	Т.Лхагвасүрэн	Дарга	42.3	5,331.7
2015	Ц.Эрдэнэбилэг	Дарга	296.3	10,278.1
2015	Г.Нямдаваа	Дарга	296.3	7,461.9
2015	Г.Ганхуяг	Тэргүүн дэд дарга		1,325.7
2015	Г.Мөнгөнхуяг	Дэд дарга Нисэхийн аюулгүй ажиллагаа, хяналт, зохицуулалтын газрын дарга	279.0	11,177.2
2015	А.Дагвадорж	Санхүү, эдийн засгийн газрын дарга	26.4	9,454.2
2015	Т.Батжаргал	Захиргаа, удирдлагын газрын дарга	1,300.4	6,155.3
2015	н.Пүрэвсүх	Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын газрын дарга	380.6	6,267.2
2015	М.Цогтгэрэл	Нисэх буудлуудын удирдах газрын дарга		10,334.3
2015	Г.Ганболд	Нийслэгийн хөдөлгөөн удирдах газрын дарга		457.9
2015	Б.Урантөгс	Нийслэгийн хөдөлгөөн удирдах газрын дарга		3,697.0
2015	Л.Бямбасүрэн	Агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалт, гадаад хамтын ажиллагааны газрын дарга	844.3	5,778.3
2015	Ч.Мөнхтуяа	Агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалт, гадаад хамтын ажиллагааны газрын дарга		1,102.7
2015	Ё.Энхтөр	Нислэг техникийн осол зөрчлийн шинжлэн шалгах албаны дарга	4,169.8	8,444.0
2016	Г.Нямдаваа	Дарга	4,997.5	24,053.3
2016	Л.Бямбасүрэн	Дарга		4,422.0
2016	Д.Батчулуун	Дэд дарга		13,334.9
2016	С.Манлай	Дэд дарга бөгөөд Нисэхийн аюулгүй ажиллагаа, хяналт, зохицуулалтын газрын дарга	1,436.9	1,945.0
2016	Т.Батжаргал	Захиргаа, удирдлагын газрын дарга		2,718.7
2016	А.Дагвадорж	Санхүү, эдийн засгийн газрын дарга	4,328.2	11,672.0
2016	Ч.Нямсүрэн	Санхүү, эдийн засгийн газрын дарга		164.0
2016	Д.Эрдэнэбаатар	Нийсэх буудлуудын бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга	1,479.1	10,539.6
2016	П.Ганболд	Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга	4,273.0	11,821.3
2016	З.Туяа	Хууль,эрх зүйн дүрмийн боловсруулалтын газрын дарга	453.2	4,468.4
2016	С.Цолмон	Нислэг техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах албаны дарга		13,804.2
2017	Л.Бямбасүрэн	Дарга	2,439.8	13,713.7
2017	Д.Эрдэнэбаатар	Нисэх буудлуудын бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга	176.0	5,656.6
2017	Ё.Эрдэнэбат	АНБЗХ-ын дарга	37.5	4,752.2
2017	Б.Алтанцом	Тэргүүн дэд дарга	250.8	5,723.6
2017	Шуурхай дуудлагаар	Нислэг техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах албаны шуурхай дуудлага	331.5	5,317.3
2017	Т.Батжаргал	Захиргаа, удирдлагын газрын дарга	116.9	3,239.0
2017	С.Манлай	Дэд дарга бөгөөд Нисэхийн аюулгүй ажиллагаа, хяналт, зохицуулалтын газрын дарга		8,809.8
2017	Ч.Нямсүрэн	Санхүү, эдийн засгийн газрын дарга	10.7	2,781.4
2015	ЗТХЯ явдаг		8.6	
2016	авто машин		4,509.3	9,667.2
2017			1,741.5	7,979.8
Нийт			34,226.0	253,849.5

4.ИНЕГ-ын даргын 2017 оны 01 дүгээр сарын 31–ний өдрийн 05/425 тоот “Автомашинны шатахууны тооцоог бодох тухай” тушаал, 2013 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/295, 2015 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн А/425, 2017 оны 02 дугаар сарын 06–ны өдрийн А/70 тоот “Технологийн зориулалтаар ашиглах автомашины гүйлтийн лимит шинэчлэн

батлах тухай” тушаалуудаар лимитээр автомашины спидометрийн тооцоог боддог нь бодит гүйлтээс зөрүүтэй, жолоочийн тооцоог цаг тухай бүрт хийж тооцоо бодоогүй, спидометрийн заалт хоорондоо зөрүүтэй лимитэнд тааруулж боддог, зарим тусгай зориулалтын автомашин, механизмын спидометрийн заалт ажиллахгүй байсныг залруулан зөрүүг арилгаж тооцоо бодсон нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” заалтыг зөрчсөн байна.

5.ИНЕГ болон харьяа алба нэгжийн удирдах ажилтнуудад суудлын автомашинаар үйлчлэх хоногийн гүйлтийн лимитэд ногдох шатахууны үнийг тухайн ажилтны цалингийн картанд шилжүүлж ирсэн байна. Үүнд: 2012 онд 67 ажилтанд 114.8 сая төгрөг, 2013 онд 75 ажилтанд 110.2 сая төгрөг, 2014 онд 72 ажилтанд 145.1 сая төгрөг, 2015 онд 70 ажилтанд 108.6 сая төгрөг, 2016 онд 86 ажилтанд 103.7 сая төгрөг, 2017 оны 11 сарын байдлаар 51 ажилтанд 76.2 сая төгрөг олгосон байна.

6.Иргэний нисэхийн ерөнхий газрын гадаад, дотоод авиа компаниуд болон, улсын төсөв, өөрийн хөрөнгийн эх үүсвэрийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа арга хэмжээний урьдчилгаа төлбөр, урсгал зардлаас санхүүжсэн бараа материал, сэлбэгийн нийлүүлэлт мөн гадаадад суралцаж буй оюутны сургалтын төлбөрийн урьдчилгаа төлбөрөөс 2012 онд 185 байгууллагын 13,866.9 сая төгрөгийн, 2013 онд авлагын үлдэгдэлээс 189 байгууллага, иргэний 11,089.3 сая төгрөгийн, 2014 онд 180 байгууллага, иргэнтэй холбоотой 10,316.4 сая төгрөгийн, 2015 онд 90 байгууллага, иргэний 18,890.9 сая төгрөгийн, 2016 онд 65 байгууллага, иргэнтэй холбоотой үүссэн 10,767.4 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг баталгаажуулаагүй зөрчил илэрсэн боловч баталгаажуулаагүй авлагын үлдэгдэл жил бүр тодорхой хувиар буурсан нь сайшаалтай байна. Үүнд: 2012 оны нийт авлагын 53.0 хувь, 2013 онд 39.6 хувь, 2014 онд 23.9 хувь, 2015 онд 36.4 хувийг, 2016 онд 19.1 хувийн авлагын үлдэгдлийг тус тус тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-д *"эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах"*, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д *"Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"* гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй тул **10,767.4 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг баталгаажуулахаар улсын байцаагчийн албан шаардлага өглөө.**

7.ИНЕГ-ын удирдлагуудын шийдвэрээр ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн ажилтнуудад шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны цалинг буцаан олгох, ажилд эргүүлэн авах асуудал цөөнгүй гарч байгаагаас үргүй зардал гарч хөрөнгө мөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Тухайлбал: 2012-2016 онд ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудын тэтгэмжинд 4.4 сая төгрөг, ажлаас үндэслэлгүй халагдсан үндэслэлээр шүүхийн шийдвэр гарсан 18 ажилтанд 374.8 сая төгрөгийн цалин, 29.2 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн олгож, эдгээр ажилтны оронд авч ажиллуулсан

ажилтны тухайн хугацаанд ногдох цалинд 357.4 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 39.8 сая төгрөг олгож цалингийн давхардал үүсгэн үргүй зардал гаргасан байна. Иймд Удирдлагын шийдвэрийг хууль эрх зүйд нийцүүлэн үндэслэлийг зөв тогтоон гаргаж үргүй зардал гаргах, эрсдэл үүсэх нөхцөл боломж гаргахгүй ажиллах шаардлагатай байна. Мөн ажлаас чөлөөгдсөн ажилтны нэхэмжлэлийн маргаанд өмгөөлөгч, хууль зүйн үйлчилгээ авснаар 2014 онд 3 хэрэгт 9.0 сая төгрөг, 2015 онд 12 хүнд 22.0 сая төгрөг нийт 31.0 сая төгрөг зарцуулсан байна.

8. Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн мэргэжлийн үнэмлэх эзэмшигч ажилтан 47 хүнд 2014 онд 196.2 сая төгрөг, 2015 онд 50 хүнд 220.8 сая төгрөг, 2016 онд 41 хүнд 110.2 сая төгрөг, 2017 оны эхний 9 сарын байдлаар 18 хүнд 88.4 сая төгрөг ур чадвар хадгалж ажилласаны хөлсөнд олгосон байна. Мэргэжлийн ур чадвараа хадгалж ажиллах шаардлагын эрх зүйн үндэс болон хадгалж ажилласан тохиолдолд олгох цалин хөлсний талаар Иргэний нисэхийн дүрмийн 65-ын "Ж" бүлэгт нислэгийн удирдагчийн зэрэглэл тогтоох тухай заасан байна. Зэрэглэл тогтоогдсон үнэмлэх эзэмшигчийн дадлага туршлагад тавигдах шаардлагыг ИНД 65.309.б-т заахдаа "Зэрэглэл тогтоогдсон үнэмлэх эзэмшигч нь энэ дүрмийн дагуу олгосон зэрэглэлийн дагуу тухайн ажлын байранд сард 10-аас доошгүй цаг ажилласан, эсхүл дадлагажуурт дадлага хийж ур чадвараа хадгалах ба сүүлийн 21 хоногт олгогдсон зэрэглэлийн дагуу үүрэг гүйцэтгээгүй бол бие дааж ажиллах чадвараа дахин шалгуулна." хэмээн заажээ. Улмаар ИНЕГ-ын даргын 2009 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 405 дугаар тушаалаар "Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн мэргэжлийн үнэмлэх эзэмшигч ИНЕГ-ын албан тушаалтан, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг хадгалах тухай журам"-ыг шинэчлэн баталсан байна.

Энэ журмын 5.2-т ИНЕГ-ын албан тушаалтан, мэргэжилтнүүд нь мэргэжлийн мэдлэг, дадлага туршлага, ур чадвараа хадгалах зорилгоор нислэгийн удирдагчийн ажлын байранд ажилласан тохиолдолд Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албанаас ирүүлсэн тодорхойлолтыг үндэслэн цамхаг болон бүсийн нислэгийн удирдагчийн ажлын байрны цалингийн сүлжээ, 3 дугаар түвшингийн жишгээр тооцож ажилласан цагийн хөлсийг олгоно." гэж заажээ. Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн мэргэжлийн үнэмлэх эзэмшигч ажилтнуудын мэргэжлийн ур чадвар хадгалах асуудлыг хангалтгүй түвшинд зохион байгуулж ирсэн ба 2015 онд мэргэжлийн ур чадвараа хадгалж ажилласан 50 ажилтанд ойртолтын болон бүсийн нислэгийн удирдагч нарын 3 дугаартүвшингийн хөдөлмөрийн хөлсний 1 хувийг ур чадвараа хадгалж ажилласан цагаар үржүүлэн олгож ирсэн байна. Тухайлбал 2015 онд англи хэлний ур чадварын шаардлага хангаагүй 34 ажилтан, эрүүл мэндийн шаардлага хангаагүй 10 ажилтан, мэргэжлийн үнэмлэхний хүчинтэй хугацаа нь дууссан 4 ажилтан мэргэжлийн ур чадвараа хадгалж ажилласанаар ИНД 65.27.а.1, ИНД 65.25.а, ИНД 65.5.а заалтуудыг зөрчин нэмэгдлийг олгосон байна.

9. ИНЕГ-ын даргын тушаалаар ямар эх үүсвэрээс олгож байгаа нь тодорхойгүй зардал гарган 2012-2014 онуудад ИНЕГ-аар түүний харьяа алба, нэгжийн ажилтан эхэд

үндсэн цалингийн 70 хувийн тэтгэмжийг хүүхэд нь 1 нас хүртэл сар бүр олгож ирсэн ба Үндэсний аудитын газрын дүгнэлтийг үндэслэн 2014 оны 10 дугаар сараас эхлэн хүүхдээ асарч байгаа эхэд үндсэн цалингийн 70 хувийг олгохоо зогсоож 2015 оноос 1.1 сая төгрөг, 2015 оноос 2.0 сая төгрөгийг хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаанд нь 1 удаа олгож ирсэн байна. Тухайлбал: 2012-2013 онд 115 эхэд 285.6 сая төгрөг, 2014 онд 80 эхэд 235,4 сая төгрөг, 2015 онд 87 эхэд 95.7 сая төгрөг, 2016 онд 51 эхэд 102.0 сая төгрөг нийт 718.3 сая төгрөг олгосон нь төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж, цалингийн давхардал үүсгэсэн байна.

10.ИНЕГ-ын даргын 2010-8-31-ний өдрийн А/355 тоот тушаалд Ахмадын сан байгуулах журам баталсан байна. Журмын 2.1.1-д “байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлтээс цалингийн нийт сангийн 3.0 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийн эх үүсвэртэй байхаар”, 3.1.1-д “Ахмад настанд сар бүр 30.0 мянган төгрөгийн нэмэгдэл тэтгэвэр тэтгэмж хэлбэрээр холбогдох банкны дансаар шилжүүлэн олгоно” гэжээ. Гэтэл ахмадын сангийн эх үүсвэр байхгүй, нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийн зардлаас 2012 онд 198.4 сая төгрөг, 2013 онд 231.4 сая төгрөг, 2014 онд 29.4 сая төгрөгийг олгосон байна.

#### **Арван зургаа. ДҮГНЭЛТ, САНАЛ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР:**

Иргэний нисэхийн салбарын аюулгүй байдлыг хангах, материаллаг баазыг бэхжүүлэх, үйлчилгээний чанар /стандарт/-ыг хангаж, дээшлүүлэх, боловсон хүчнээр бэхжүүлэх талаар төр, засгаас ихээхэн анхаарч, улсын төсөвт жил бүр тодорхой эх үүсвэрийг тусган баталж хөрөнгө оруулалтыг бодлого, үе шаттайгаар хийсний үр дүнд тус салбарын хөгжил тодорхой төвшинд хүрсэн байна.

Иргэний нисэхийн Ерөнхий газар, салбарын хамт олон “Иргэний нисэхийн тухай” Монгол улсын хууль, Төрөөс Иргэний нисэхийн талаар баримтлах үзэл баримтлал, Олон улсын Иргэний нисэхийн байгууллага (ИКАО)-ын зөвлөмж, Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенц /1989.09.07-нд нэгдэн орсон/, иргэний нисэхийн багц дүрэм зэрэг салбарын хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулснаар, өөрийн үндсэн чиг үүрэг, дэвшүүлсэн зорилтуудаа ханган биелүүлсэн, аюулгүй ажиллагааны бэлэн байдлыг хангахуйц техник, тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон, материаллаг баазаар хангагдсан, улс эх орондоо болон бүсийн нутгийн хэмжээнд танигдаж, тодорхой байр суурь эзэлсэн байгууллага хамт олон болжээ. Гэвч шалгалтаар:

1.ИНЕГазрын даргын албан тушаалд 2012 оноос хойш өнөөг хүртэл нийт 6 дарга солигдон ажилласнаас, даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр 3 хүн томилогдон ажиллаж, жинхэлж чадалгүйгээр солигдсон байна. Энэ хугацаанд бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийх, баг хамт олноо бүрдүүлэх нэрээр улс төрийн үзэл бодол, намын харъяалал, эсвэл хооронд нь муудалцуулж, хагалдаг /энэ байдал нь далд явагддаг/ шахаж хавчдаг, тэтгэвэрт шахаж гаргах, өөрөөр шаардаж өргөдөл, хүсэлт бичүүлдэг болон бусад шалтгаанаар 1000 гаруй хүнийг ажлаас чөлөөлж, 1200 гаруй хүнийг ажилд нөхөн томилсон



байна. Дээр дурдсан хүмүүсийг ихэвчлэн захиргааны санаачлагаар ажлаас чөлөөлж байгаа тул холбогдох хууль тогтоомжийн дагуу олон сая төгрөгийн буцалтгүй тусламж олгожээ. Мөн ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтнууд эрх ашгаа хамгаалуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргахад, байгууллагын удирдлагын шийдвэрийг хамгаалуулах нэрээр өмгөөлөгч хөлслөн өмгөөлөгчийн хөлсийг байгууллагаас төлжнэмэгдэл зардал гаргаж, үндэслэлгүй халагдсан /ажилтнуудын/ нэхэмжлэлийн шаардлагыг хангасан, шүүхийн шийдвэр ихэнхдээ гарч ажилгүй байсан хугацааны цалин хөлс, олговор, даатгал, шимтгэлийг мөн л байгууллагаас гаргаж байснаас олон сая төгрөгөөр байгууллагыг хохироосон байна.

2.ИНЕГазар нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг боловч эрхлэх үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан тус байгууллагын дарга, дэд даргаас бусад албан хаагчид нь төрийн албан хаагчийн ангилал, зэрэглэлд хамаардаггүй, улсын үйлдвэрийн газрын жишгээр цалинжуулж, үр дүнгийн шагнал олгодог, хөдөлмөрийн харилцааг хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулдаг бөгөөд ажилтан, албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг алдагдуулсан байна.

3.ИНЕГазар нь “Иргэний нисэхийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж эрх зүйн орчин бүрдүүлэх, иргэний нисэхийн болон аюулгүй байдлыг хангах” чиглэлтэй “Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар” гэж Улсын бүртгэлийн 2005 оны 10 дугаар сарын 21-ний 000125468 дугаар гэрчилгээнд бүртгэсэн бөгөөд Засгийн газрын 2012 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг”-аар тогтоожээ. Үүнээс үзэхэд тус газрын статус нь тодорхойгүй, хоёрдмол /холимог/, шинжтэй /байна.

4.ИНЕГ-ын үндсэн бүтцэд үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг, алба нэгжүүд байдаг боловч, тэдгээр нь бие даасан хуулийн этгээдийн эрх хэмжээ, хуулийн этгээдийн гэрчилгээ, бүртгэл байхгүй/ дотоод салбар нэгжийн зохион байгуулалттай байна. Шалгалтад хамрагдсан онуудын жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын байгууллагаас өгсөн дүгнэлтээр 2012 онд “Зөрчилгүй”, 2013 онд “Хязгаарлалттай”, 2014 онд “Зөрчилгүй”, 2015 онд “Зөрчилгүй, 2016 онд “Хязгаарлалттай” гэсэн санал дүгнэлт”-тэй ажиллажээ.

5.Зардлын гүйцэтгэл, үр ашгийн үзүүлэлтүүдэд санхүүгийн шинжилгээ судалгаа хийж, өртөг зардлыг бууруулах, үр ашгийг дээшлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна. ИНЕГазар нь санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 2012 онд 17,055.5 сая төгрөг, 2013 онд 31,512.8 сая төгрөг, 2014 онд 41,362.6 сая төгрөг, 2015 онд 22,239.5 сая төгрөг, 2016 онд 46,188.4 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлжээ. Шалгалтанд хамрагдсан онуудад төсөвт зардлыг нийт дүнгээр хэмнэсэн боловч зарим нэр төрлийн зардлыг хэтрүүлэн зарцуулсаны гадна, шүүхийн шийдвэрийн дагуу олгосон төлбөр хураамж, өмгөөллийн хөлс, хяналт шалгалтын байгууллагуудын удаа дараагийн актаар тогтоосон төлбөр, банкны үйлчилгээний хураамж, гадаад зочны зардал, зарим төрлийн

бараа ажил үйлчилгээ худалдан авсан зэрэг зэрэг төсөвт суугдаагүй зардлуудад хөрөнгө зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах заалтыг зөрчсөн байна. Тухайлбал: шатахуун тээврийн зардал 142.6 сая төгрөг, хөдөлмөр хамгааллын зардал 111.3 сая төгрөг, гадаад сургалтын зардал 202.4 сая төгрөг, хөдөлмөр хамгааллын зардал 251.3 сая төгрөг, шалгалтын нислэг 205.0 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн татвар 105.0 сая төгрөг, холбооны суваг ашигласны төлбөр 123.1 сая төгрөг, валютын ханшийн зөрүүний зардал 1,244.8 сая төгрөг, нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардал 73.7 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна. гадаад томилолт 66.6 сая төгрөг, сэлбэг хэрэгсэл 217.2 сая төгрөг, төлбөр хураамжийн бусад бусад зардал 2,660.2 сая төгрөг, гадаад сургалтын зардал 20.8 сая төгрөг, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардал 235.7 сая төгрөг, шагнал урамшуулал баяр ёслолын зардал 137.4 сая төгрөг, үндсэн ба нэмэгдэл цалин 1,433.3 сая төгрөг, холбооны суваг ашигласны төлбөр 147.4 сая төгрөг, дотоод сургалтын зардал 33.2 сая төгрөг, олон улсын хурал зохион байгуулах зардал 92.5 сая төгрөг, мэргэжлийн зөвлөлгөө авсаны зардал 14.9 сая төгрөг, хөрөнгийн даатгалын зардал 1,116.8 сая төгрөг, хог хаягдал устгах зардал 167.7 сая төгрөг, нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийн зардал 129.7 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн татвар 61.2 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр хураамжийн зардал 13.5 сая төгрөг, улсын мэдээллийн маягтыг хэвлэх бэлтгэх зардал 26.9 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна. Өмнөх онуудаас зардал 2013 онд 9.8 хувь буюу 7,330.0 сая төгрөгөөс өссөн, 2014 онд 1.2 хувь буюу 950.0 сая төгрөгөөр буурсан, 2015 онд 12.8 хувь буюу 10,451.2 сая төгрөгөөр өссөн, 2016 онд 10.3 хувь буюу 9,505.9 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Үндэсний аудитын газар нь, ИНЕГ-тай "Санхүүгийн аудит гүйцэтгэх гэрээ"-г байгуулан, аудитын үйлчилгээний төлбөрт 2012 онд 20.0 сая төгрөг, 2013 онд 17.0 сая төгрөг, 2014 онд 10 20.0 сая төгрөг, 2015 онд 25.0 сая төгрөг, 2016 онд 25.5 сая төгрөг нийт 107.5 сая төгрөгийн төлбөр авчээ. Үүнээс гадна аудитын үйлчилгээний төлбөр гэж 2012 онд "Бисофт" ХХК-нд 7.7 сая төгрөг, 2015 онд "Акпар аудит" ХХК-нд 5.5 сая төгрөг, 2016 онд "Энич аудит" ХХК-нд 8.7 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн байгаа нь давхардсан байдалтай буюу ялангуяа Төрийн аудитын байгууллага Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн статустай төсвөөс санхүүжилт авдаг байгууллагад их хэмжээний төлбөртэй үйлчилгээ үзүүлсэн байна.

6.Тус газар нь 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 57,676.0 сая төгрөгийн авлагатай, 16,247.5 сая төгрөгийн өр төлбөртэй байна. ИНЕГ-ын санхүүгийн нэгдсэн тайлангаас үзэхэд 2012 онд 26,184.2 сая төгрөгийн, 2013 онд 28,026.9 сая төгрөгийн авлагатай байсан бол 2014 онд 43,247.3 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 35.2 хувиар, 2015 онд 51,880.4 сая төгрөг болж 16,7 хувиар, 2016 онд 44,109.9 сая төгрөг болж урьд оноосоо 15.0 хувиар буурсан боловч, 2017 оны 3 дугаар улиралд 28.1 хувиар өссөн дүнтэй байна. 2012-2017 онуудад нийт авлагын 65.6-70.9 хувийг ИНЕГ-ын үйлдвэрлэлийн

салбарын авлага, 25.7-31.8 хувийг Чингис хаан ОУНБ-ын авлага, 2.1-4.0 хувийг Газрын тусгай үйлчилгээний албаны авлага, 0.4-0.8 хувийг аймгуудын нисэх буудлуудын авлага эзлэж байна.

Нийт авлагын дийлэнхи хувийг эзлэж байгаа ИНЕГ-ын үйлдвэрлэлийн албаны авлагын 43.7-78.0 хувийг гадаадын авиа компаниудын авлага, 13.3-18.0 хувийг дотоодын авиа компаниас авах авлагууд эзэлж байна. Харин төлөгдөх магадлал багатай найдваргүй эрсдэлтэй авлага нь нислэг үйлдэхээ больсон авиа компаниас авах авлага гадаад авиа компаниас авах нийт авлагын 2012 онд 21.1 хувийг, 2013 онд 22.3 хувийг, 2014 онд 20.8 хувийг, 2015 онд 27.8 хувийг, 2016 онд 16.5 хувийг 2017 онд 10.3 хувийг тус тус эзлэж байна.

7.ИНЕГазар нь тэтгэлэгээр гадаадын их дээд сургуулиудад оюутан суралцуулахдаа хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг шаардлагатай байгаа мэргэжлээр хэдэн онд хичнээн мэргэжилтэн шаардлагатай байсныг тооцож бодитоор төлөвлөдөггүй, сонгон шалгаруулалтыг нээлттэй ил тод зохион байгуулаагүй, шаардлагатай мэргэжлээр суралцуулдаггүй явж ирсэн байна

8. Тус газраас байгууллага, иргэдтэй байгуулж буй гэрээ нь гэрээний эрх зүйн шаардлага, талуудын хүлээх үүрэг хариуцлагыг тэгш эрхийн зарчимд тулгуурлан хийхгүйгээс ихэнх тохиолдолд байгуулагад хохиролтой гэрээ хийгдэж байгаа нь удаа дараагийн шүүхийн шийдвэрүүдээс тодорхой харагдаж байна.

9. Гэрээгээр үүрэг гүйцэтгэдэг нэр бүхий компаниуд тендерт шалгарч томоохон ажлуудыг гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажлаа эхлээд, гүйцэтгэлийн явцад ямар нэг байдлаар гомдол, маргаан гаргадаг, хохирол нэхэмжилдэг, шүүхийн шийдвэрээр захиалагч торгууль, алданги хүлээдэг/өмгөөллийн хөлс төлдөг/ зэргээр нэмэлт санхүүжилт гаргаснаас шалтгаалан, зардал нь төсөвт өртгөөс хэтэрч улс, байгуулагад хохирол учруулдаг тохиолдол нилээд гарсан байна.

Мөн ажлын гүйцэтгэлийн явцад захиалагчийн зүгээс хяналт хангалтгүй, хяналт тавьж буй ажилтны мэргэжлийн болон хууль эрх зүйн мэдлэг, чадвар, дадлага туршлага, шаардлагын түвшинг хангадаггүй, ажлын хариуцлага, сахилга сулаас шалтгаалан гүйцэтгүүлж байгаа ажлын чанар хангалтгүй, цаг хугацаандаа хийгддэггүй удааширдаг, үе шатны ажлын гүйцэтгэлийг бодитоор хянаж тооцож, нүдээр үзэж баталгаажуулдаггүй, гүйцэтгэгчийн бичиж ирүүлсэн, материалыг сайтар шалгалгүй баталгаажуулан, санхүүжилт олгосноос үнэлгээ нормыг нэмэгдүүлсэн, гүйцэтгэлийг өсгөж бичсэн, давхардуулсан, хийгээгүй ажлыг хийснээр бичсэн зэргээр илүү санхүүжилт олгосон зэрэг зөрчил илэрлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-дэх заалтыг зөрчиж, босго үнийн хязгаарыг баримтлалгүй, төсөвт өртгийг хэсэгчлэн хувааж, нээлттэй тендерээс татгалзан худалдан авах ажиллагааны аргыг буруу хэрэглэсэн, хөдөлмөр хамгааллын болон ажлын хувцас,

дүрэмт хувцсыг алба нэгжээр нь салган төлөвлөж тус бүрээр нь салгаж, худалдан авалтыг зохион байгуулж хууль зөрчсөн байна.

Худалдан авах ажиллагааг тодорхой нөхцөлд шууд гэрээ байгуулах аргыг сонгосон байдаг бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3, 33.4, 34 дүгээр зүйлийн 34.1.2, 34.1.3, 34.1.4, 34.1.5, дах заалтуудын дагуу шууд гэрээ байгуулах аргыг сонгож хэрэглэсэн байгаа боловч, хуулийн 34.3-д заасан энэ хуулийн 34.1-д заасны дагуу шууд гэрээ байгуулсан тохиолдолд "захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт, Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалтыг мөрдөж ажиллахгүй гэрээ байгуулаад л дуусгавар болгоод байгаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж өгч ажиллав.

10. Тус газарт эрх бүхий дээд байгууллагуудаас хийсэн удаа дараагийн шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалыг арилгах, давтан гаргахгүй байх талаар дүгнэлт хийж тодорхой арга хэмжээ авч ажиллаагүйгээс зөрчил дутагдал давтагдан гарах, төлбөр зөрчил буурахгүй байх хандлага байсаар байна. Мөн шалгалтаар тавигдсан төлбөрийг буруутай хүмүүсээс суутгадаггүй байгууллагаас давхардуулан төлсөн, эрх бүхий дээд байгууллага болон гадны байгууллага, хувь хүмүүсийн ивээн тэтгэдэг, орон сууцны хөнгөлөлтийн олгож журмыг зөрчин хөнгөлөлтийг давхардуулан, ажилласан жил хүрээгүй, гэр бүлийн хүмүүст олгодог, журамдаа үнийн дүнг буюу хязгаар тогтоогүйгээс дуртай нэг дураараа эсвэл шүүхийн шийдвэрээр хөнгөлөлт авдаг

11. "Чингис хаан" ОУНБуудлын мөрдөж буй үнэ тарифыг буудлын дарга тогтоож буй шийдвэр нь Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан журмын 1.3-т заасан захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах этгээд эсэхийг лавлах, нийтээр дагаж мөрдөх шийдвэр гаргах, хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээд мөн эсэх, гаргасан шийдвэрээ энэ журмын 4.2-д заасны дагуу Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлж журмын 4.3. болон 2.5.1-2.5.3-д заасны дагуу шийдвэрлүүлсэн эсэх нь тодорхойгүй байна. /тухайн үед мөрдөж байсан Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолын дагуу/. Ер нь Иргэний нисэхийн салбарын хэмжээнд нийтээр дагаж мөрдөх журмыг тогтоохдоо хуульд нийцүүлэх үүднээс Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар эрх үндсийг бүрдүүлж, баталгаажуулж, журамлан тодорхой болгох шаардлагатай байна.

Иймд Иргэний нисэхийн салбарт захиргааны хэм хэмжээ тогтоосон, нийтээр дагаж мөрдөхөөр гаргаж буй шийдвэрийг хуулиар тусгайлан эрх олгогдоогүй субъект гаргаснаас шалтгаалан ихээхэн сөрөг үр дагавар гарч, эрсдэл үүсч болзошгүй байдалтай байгааг анхаарч хууль журмын хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй байна.

Санхүүгийн хяналт шалгалтаар 1,758.4 сая төгрөг, 164.4 мянган ам долларын төлбөрийн акт тогтоож, 45,327.3 сая төгрөг, 136.2 мянган ам доллар, 21.2 мянган

австрали доллар, 55.7 мянган еврогийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлагыг бичлээ. /Төлбөрийн актын жагсаалтыг хүснэгтээр харуулбал/.

Д/д	Зөрчлийн утга	Хариуцах эзэн	Мөнгөн дүн		
			/мян.төгрөг болон ам доллар/		
			Нийт дүн	Улсын/төсөвт	Байгууллагад
<b>Улсын ахлах байцаагчийн актаар</b>					
1	Давхардуулан олгосон байрны хөнгөлөлтийг төлүүлэх болон хуулийн байгууллагад шилжүүлэх тухай	ИНЕГ	398,400.0	117,250.0	281,150.0
2	Аудитын дүгнэлтээр "Хязгаарлалттай санал дүгнэлт" авч үндсэн ажилдаа хариуцлагагүй хандсан 1 жил ажилласан хүнд "Онцгой амжилт гаргасан" үндэслэлээр байрны хөнгөлөлт олгосон болон 5 жил хүрээгүй хүмүүст байрны хөнгөлөлт олгосныг хуулийн байгууллагад шилжүүлэх тухай	ИНЕГ	60,000.0	60,000.0	
3	Гэрээний дүнгээс хэтрүүлэн сургалтын төлбөр төлсөн	Хавсралтад дурдсан 16 оюутан	92,241.29 \$		92,241.29 \$
4	"Чингис хаан" ОУНБ-д зорчигчийн бүртгэлийн систем суурилуулж, операторийн үүрэг гүйцэтгүүлэх ажлыг хуулийн байгууллагад шилжүүлж хохирлыг нэхэмжлэх	ИНЕГ	1,300,000.0		1,300,000.0
5	Гадаад томилолтыг төлүүлэх	ИНЕГ	72,225.45 \$	72,225.45 \$	
<b>Актын дүн /мянган төгрөг/</b>			<b>1,758,375.0</b>	<b>145,000.0</b>	<b>1,613,375.0</b>
<b>/ам доллар/</b>			<b>164,466.74\$</b>	<b>72,225.45 \$</b>	<b>92,241.29 \$</b>
<b>Улсын ахлах байцаагчийн албан шаардлагаар</b>					
1	Хан-Уул дүүргийн татварын актыг төсвөөс төлсөнийг холбогдох хүмүүсээс суутган авах	ИНЕГ	1,403,500.0		1,403,500.0
2	Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах	ИНЕГ	10,700,000.0		10,700,000.0
3	Олон жил болсон дуусаагүй барилгын ажлуудыг дуусгах, маргааныг шүүхээр шийдвэрлүүлэх	ИНЕГ	26,600,000.0		26,600,000.0
4	Салбарын яам болон байгууллага, иргэдийг ивээн тэтгэсэн, хандивласан зардлыг таслан зогсоох	ИНЕГ	313,698.0		313,698.0
5	Хөрөнгө мөнгийг баримтгүй зарцуулсан зардлын баримтыг бүрдүүлэх	ИНЕГ	397,997.0		397,997.0
6	ТБОНӨХБАҮХАТХуулийг зөрчин худалдан авалт хийсэн	ИНЕГ	5,725,700.0		5,725,700.0
			46,000\$		46,000\$
			21,200		21,200
			австрали \$		австрали \$
			55,700 евро		55,700 евро
<b>Албан шаардлагын дүн /мянган төгрөг/</b>			<b>45,140,895.2</b>		<b>45,140,895.2</b>
<b>/ам доллар/</b>			<b>46,000\$</b>		<b>46,000\$</b>
<b>/Австрали \$, евро/</b>			<b>21,200</b>		<b>21,200</b>
			<b>австрали \$</b>		<b>австрали \$</b>
			<b>55,700 евро</b>		<b>55,700 евро</b>

### Цаашид авах арга хэмжээний талаар

#### Зам тээвэр хөгжлийн яаманд:

-Зам тээврийн яам нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагаар зардлаа хариуцуулдаг байдлыг таслан зогсоох;

#### Иргэний нисэхийн ерөнхий газарт:

-Мөнгөн хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулах, гадны байгууллага, хувь хүмүүс, хэвлэл мэдээллийн байгууллагуудад өгдөг хандив, ивээн тэтгэх явдлыг таслан зогсоох;

-Холбогдох хууль тогтоомжийг зөрчин Зам тээврийн яамны зарим зардлыг санхүүжүүлдэг байдлыг зогсоож хууль журмыг мөрдөж ажиллах;

-Гадаад оюутны сургалтын үйл ажиллагааг зохицуулах журамтай болох, хугацаандаа төгсөөгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй оюутнуудын сургалтын төлбөрийг буцаан төлүүлэх, барьцааг чөлөөлөхгүй байх;

-Байгууллагын зардлаар орон сууц худалдан авах болон орон сууцны хөнгөлөлт олгох журамд орон сууцны үнэ болон хөнгөлөлт олгох үнийн дээд хэмжээг тогтоох;

-Боловсон хүчний хэрэгцээ шаардлага, тодорхой тооцоо судалгааны хүрээнд оюутнуудыг суралцуулан, эрх зүйн актын хүрээнд сургалтыг санхүүжүүлэх, үргүй зардал гаргахгүй байх;

-ИНЕГазрын тэтгэлэгээр гадаадын их дээд сургуулиудад оюутан суралцуулах журмыг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулах;

-Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль", "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай", "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулиуд болон бусад холбогдох хууль тогтоомж дүрэм журмыг мөрдөж ажиллах;

-Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны захиалгаар улсын төсвийн хөрөнгөөр сүүлийн 15 жилд хийж гүйцэтгүүлсэн "Газрын гадарга, саад болон аэродромын зураглалын өгөгдлийн сан бүрдүүлэх" ажлын гүйцэтгэлд олон иргэний нисэхийн байгууллагад хандаж хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар аудит хийлгэж дүгнэлт гаргуулах;

-Цаашид шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай байна.

-Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгасан тухай тайланг улирал тутам Сангийн яамны СХЭУГазарт ирүүлэхийг даалгав.

#### Шалгалтын тэмдэглэл

Бичсэн:

Сангийн яамны СХЭУГ-ын СХШХ-ийн  
улсын ахлах байцаагч  
О.Энхжаргал  
Н.Батбаатар  
Мэргэжилтэн  
Б.Гантулга  
Зам тээвэр хөгжлийн яамны ХШУДАГ-ын  
Санхүүгийн хяналт шалгалтын улсын  
ахлах байцаагч

Л.Оюунбилэг

Танилцсан:

Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга  
Л.Бямбасүрэн  
Санхүү, өдийн засгийн хэлтсийн дарга  
Ч.Нямсүрэн  
Ерөнхий нягтлан бодогч  
Н.Наранцэцэг





ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗАРТ

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2018.2.12 № 13-1/430  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Дотоод аудитын хорооны  
тогтоол хүргүүлэх тухай

Сангийн сайдын баталсан удирдамжийн дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнг Сангийн яамны Дотоод аудитын хорооны 2018 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн хурлаар хэлэлцэн 14 тоот тогтоолоор батлагдсан зөвлөмжийг хүргүүлж байна.

Тогтоолоор өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах төлөвлөгөө боловсруулан 2018 оны 3 дугаар сарын 05-ны дотор ирүүлж, төлөвлөгөөний биелэлтийг улирал тутам Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Санхүүгийн хяналт шалгалтын хэлтэст тайлагнаж ажиллана уу.

Жич: Дотоод аудитын хорооны тогтоолыг хавсаргав.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН  
УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГА



Н.НАРАНГЭРЭЛ



## САНГИЙН ЯАМНЫ ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 02 сарын 08 өдөр

Дугаар: 14

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.7, Дотоод аудитын хорооны 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн **ТОГТООХ нь:**

**Нэг.** Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүнг шийдвэрлэх хүрээнд:

1. Шалгалтаар илэрсэн 1,758.4 сая төгрөг, 164.9 мянган ам долларын төлбөрийн актыг болон 45,140.9 сая төгрөгийн, 46.0 мянган ам доллар, 21.2 мянган австрали доллар, 55.7 мянган еврогийн зөрчилд улсын байцаагчийн бичсэн албан шаардлагуудыг тус тус баталсугай.

2. Шалгалтын үр дүнгээр улсын байцаагчийн тогтоосон акт, албан шаардлагыг ханган биелүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, давтан гаргахгүй байх бүх талын арга хэмжээ авч ажиллахын зэрэгцээ төлөвлөгөө гарган, тодорхой албан тушаалтнуудад хариуцуулан дараах асуудлуудад анхаарч ажиллахыг зөвлөж байна.

### **Зам тээвэр хөгжлийн яаманд:**

-Зам тээврийн яам нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагаар үйл ажиллагааны зарим зардлаа хариуцуулдагийг таслан зогсоох;

### **Иргэний нисэхийн ерөнхий газарт:**

-Батлагдсан зардлын төлөвлөгөөг баримталж ажиллахын зэрэгцээ авлага, өглөгийг бууруулах талаар тодорхой арга хэмжээ авч, найдваргүй авлагын нөөц байгуулж ажиллах;

-Мөнгөн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, гадны байгууллага, хувь хүмүүс, хэвлэл мэдээллийн байгууллагуудад хандив өгдөг, ивээн тэтгэдэг сурталчилгаа хийлгэх нэрээр гэрээ байгуулдаг асуудлыг таслан зогсоох;

- Зам тээврийн хөгжлийн яамны зарим зардлыг санхүүжүүлдэг, хандив тусламж олгодог, суудлын авто машин хэрэглүүлдэг, гадаад томилолтын зардлыг



хязгуурлах талаар эрх бүхий байгууллагад /тодорхой баримт нотолгоог гарган өгч/ хандаж шийдвэрлүүлэх;

- Хяналт шалгалтын байгууллагуудаас актаар тогтоосон төлбөрийг холбогдох хүмүүсээс суутган авч төлүүлэхгүйгээр байгууллагаас төлүүлдэгийг таслан зогсоох;

Иргэний нисэхийн салбарт захиргааны хэм хэмжээ тогтоосон, нийтээр дагаж мөрдөхөөр гаргаж буй шийдвэрийг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлж бүртгүүлсний дараа мөрдөж хэвшүүлэх;

**Хоёр.** Аудитын хорооны тогтоолоор өгөгдсөн үүргийг хангах арга хэмжээний төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж улмаар зөвлөмжийн биелэлт хангагдах хүртэл улирал тутам Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт тайлагнахыг Иргэний нисэхийн ерөнхий газрын удирдлагад хариуцуулав.

**Гурав.** Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, дүн шинжилгээ хийж Дотоод аудитын хороонд эргэн танилцуулахыг Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт үүрэг болгосугай.

САНГИЙН САЙД, ДОТООД АУДИТЫН  
ХОРООНЫ ДАРГА



Ч.ХҮРЭЛБААТАР